

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
КҮНЗИЙН ИНСТИТУТ

ОРЧУУЛГАЗҮЙ

III

Эрхлэн нийтлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар 2014

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
КҮНЗИЙН ИНСТИТУТ

ОРЧУУЛГАЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ

№03

Ариутган хянах зөвлөл

Эрхлэгч:	М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор)
Нарийн бичгийн дарга:	Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)
Гишүүд:	Э.Равдан (ШУ-ны доктор, профессор) Го.Аким (доктор, профессор) С.Эрдэнэмаам (доктор, профессор) Л.Чулуунбаатар (доктор, профессор) Г.Буяннэмэх (доктор, профессор) О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч) Ш.Эгшиг (доктор, дэд профессор)

Зохион байгуулагч:	МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн профессорын хамтлаг
Хянан засварласан:	Г.Элдэв-Очир
Хэвлэлийн эх бэлдсэн:	П.Оргил
Хуудасны хэмжээ:	A4
Хэвлэлийн хуудас:	
Хэвлэсэн тоо:	250
Хэвлэлийн газар:	“Тоонотпринт” ХХК

ГАРЧИГ

Өмнөтгөл үг

ОРЧУУЛГАЗҮЙ

Го.Аким	“Яруу үгт, утга сайт бичиг”-ийг дуун хөрвүүлэх дуршил	6
Ш.Эгшиг	Орчуулгыг журамлах санал	22
Л.Чулуунбаатар	Ардын аман зохиолыг англи хэлэнд орчуулсан нэгэн бүтээлийн талаар	28
Б.Энхбаяр	Орчуулгын алдаа, түүний уршиг	35
Ц.Магсар	Орос яруу найраг дахь угсаа-соёлын нэрийн холбогдолтой зүйлийг орчуулах тухайд	43
А.Цэрэнчулуун	Нэр томъёог оновчтой хэрэглэх нь сайн орчуулгын нэг үндэс	50
Г.Элдэв-Очир	Буруу орчуулгаас үүдсэн буруу нэршлийн асуудал	54
Д. Цэдэнжав	Монгол хэлц үгийн орос орчуулгын асуудалд	57
Ц.Сүрэнжав	Хятадын эртний сонгодог шүлгийн орчуулгын зарим асуудалд	60
П.Уянга	Хятад зүйр цэцэн үгийг монгол хэлнээ орчуулах нь	64
М.Амартайван	Орчуулгын онолын зарим нэр томъёоны тухай	67
Н.Оюунзаяа	Монголын орчуулгын онолын уламжлал	73
Т.Нарангэрэл	Монгол Япон хэлний нийлмэл өгүүлбэрийн холбох нөхцөлийн тухай	77

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ

Л.Чулуунбаатар	“Өвгөн Жамбалын яриа”-г Ч.Бауден орчуулсан нь	88
Д.Бүрнээ	“Үлгэрийн далай”-н англи орчуулгын тухай	94
М.Чимэдцээ	“Улсыг засах жараахай шарах хоёр адилхан” Харин амархан уу? Хэцүү юу?	101
Г.Дэлгэрмаа	“Үлэмжийн чанар”-ыг нулимж болохгүй	107

ОРЧУУЛГАЗҮЙН САН ХӨМРӨГӨӨС

Ц.Дамдинсүрэн	Олег цэцний орчуулгын тайлбар	120
Б.Ринчен	Шүлэг орчуулах эрдэм	151

ОРЧУУЛГА

Д.Нацагдорж	Хуучин хүү	158
П.Наранбаяр	古き 青年	160
Э.Энхтуяа	Evvelki oğlan	162

ӨМНӨТГӨЛ ҮГ

Монголын уран зохиол мянган жилийн түүхтэй гэж манайхан ярьж бичигдэх дуртай. Чингэтэл, “Сүн далайг шалбааг байхад, Сүмбэр уулыг дов байхад...” гэж аман зохиолд нь дэлхий ертөнцийн үүслийн тухай хэлдэг ард түмэн дэлхий дээр хэд байгаа бол?! Алдарт Грекийн домог үлгэр, эртний Хятадын домог үлгэрийн Пань Гу, Нью Вагийн домгийн агуулга л дээрх өгүүлэмжтэй дөхөж очдог, тэгээд домогзүйн хувьд дээрх улсуудыг хамгийн урт удаан соёл иргэншилт улсууд хэмээн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, тэдгээр ард түмний урлаг, утга зохиолыг ноён оргил нь болгон шүтэн биширч, орчуулгаар дамжуулан эх хэлээрээ дунд сургуульд байхаасаа л уншиж, сурч хүндэлсээр ирсэн юм. Бид өөрийн ард түмний гайхамшигт соёлын өвөө мөнхүү монгол орчуулагчийн сайн орчуулгаар дамжуулан гадны ертөнцөд таниулах нь зүйтэй мэт санагддагаа энд дурдсу. Тэгээд бас болоогүй бид хятадын түүхийн сурвалжаас монголчуудын өвөг дээдэс болох Хүннүгийн хаад хэрхэн тухайн үеийн Хятадын хаадтай эн тэнцүү хэлмэрчээр дамжин харилцдаг байсныг мэднэ. Энэ бол одоогоор мэдэгдэж буйгаар 2000 гаруй жилийн өмнөх үйл явдал шүү дээ. Чингээд бодохоор манай аман орчуулгын түүх энэ хэрийн удаан түүхтэй хийгээд бүр хятадын эдүгээ хэрэглэж буй “орчуулах” хэмээх утгыг илтгэх ханзны анхны утга нь хойд зүгийн улстай харилцах хэлмэрч түшмэлийн нэрийдэл байгаад аажимдаа утга шилжсэн гэдгийг бид мэдэх болсон билээ.

Дэлхий даяаршиж, олон хэл эзэмшсэн соёлт хүн олширсон хэдий ч эх хэлний боловсролын асуудал тулгамдсан асуудал болсон нь сүүлийн үед илт мэдэгдэх болов. Тиймээс орчуулагч, дуун хөрвүүлэгчид хийгээд орчуулгын салбарт ажиллаж буй бүхий л байгууллагыг энэ чиглэлд хандуулахаар МУИС-ийн Орчуулгазүйн профессорын хамтлагаас “ОРЧУУЛГА: ОДОО, ИРЭЭДҮЙ” сэдэвт эрдэм шинжилгээний 3-р бага хурлыг зохион явуулсан нь бас ч үгүй зохих үр дүнгээ өгч, энэ салбарынхан нэгэн дор цугларч, хэлэлцсэн ярилцсан асуудал нь мөнөөхөн эх хэлний болон эдүгээ нийгэмд буй орчуулгын чанарын асуудлыг хөндсөн нь цаг үеэ олсон хурал болсныг илтгэлээ. Орчуулгын ажлыг цаашид өмнөх шиг урсгалаар нь, ямар нэгэн ашиг олох гэхээсээ илүү чанартай сайн хийх тэр хөшүүргийг олж, төр засаг, ард нийтээр санаачлагатай ажиллах нь зүйтэй болжээ гэдгийг дор бүрнээ мэдсэн нь сайшаалтай.

МУИС-ийн ГХСС-ийн Орчуулгазүйн профессорын хамтлаг хоёр жилийн хугацаанд чамлахааргүй ажил амжуулж, эдүгээ үүсгэн буй болгосон сэтгүүлийн маань гурав дахь дугаар гарч байна. Сэтгүүлийн хоёр дахь дугаарыг гаргахаас өмнө ариутган хянах зөвлөлийг албан ёсоор батламжлан, цаашид хийх ажлаа ч тодорхойлсон билээ.

Орчуулгазүйн салбарт нэрт орчуулагч, дуун хөрвүүлэгч нараас суралцсан шинэ залуу үе боловсрон гарч ирэхэд, орчуулгыг дэмжих олон талт ажлууд хийх нь ихээхэн сайн үр дүнтэй болох нь мэдээж юм. Монголын Орчуулагчдын Эвлэл (МОЭ)-ээс дэлхийн шилдэг өгүүллэг, хүүхдийн сонгодог яруу найргийн орчуулгын уралдааныг зарласан нь оюутан сурагчид, залуу орчуулагчдыг урмаар тэтгэсэн үйл явдал болсон юм. Сэтгүүлийн нэгдүгээр дугаарт нийтэлсэн шинэ үеийн уран зохиолын анхдагч Д.Нацагдоржийн “Хуучин хүү” өгүүллэгийн олон хэлний орчуулга дээр мөн япон, турк хэл рүү орчуулаад нэмж ирүүлсэн орчуулагч анд нарын орчуулга энэ дугаарыг маань бас чимж байна. Мөн МУИС-ийн орчуулгазүйн магистрантурт элссэн суралцагчдыг орчуулгын судалгаа хийхэд чиглүүлэн ажиллаж, сүүлийн үед тэдгээр магистрантууд маань эрдэм шинжилгээний хуралд илтгэлээ хэлэлцүүлж эхэлсэнд бид талархалтай байна.

Энэхүү “Орчуулгазүй” сэтгүүлийн гурав дахь дугаарт “Орчуулгазүй”, “Орчуулгын шүүмж”, “Орчуулгын сан хөмрөгөөс”, “Орчуулгын бүтээлээс” буланг багтаасан болно.

МУИС-ийн бүтцийг өөрчилсөн “шинэчлэл”-ээс үүдэлтэй зарим бэрхшээл сэтгүүлийг хэвлэхэд нөлөөлсөн хэдий ч, МУИС-ийн Күнзийн институтийн дэмжлэгээр энэхүү дугаараа гаргаж байгаагаа энэ дашрамд талархалтайгаар хэлье. Сэтгүүлийг үүсэн гарахаас нь эхлээд байнга тусалж дэмжиж ирсэн тус сургуулийн эрдэмтэн профессорууд, МОЭ, саяхнаас харилцаатай болж, бидний ажлыг дэмжиж байгаа Монгол Улсын Төрийн Хэлний Зөвлөлийн Ажлын албанд мөн гүн талархлаа илэрхийлье.

МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Орчуулгазүйн Профессорын хамтлагийн ахлагч Ш.Эгшиг (Ph.D)

2014 оны 5-р сарын 23-ны сайн өдөр

ОРЧУУЛГАЗҮЙ

“Яруу үгт, утга сайт бичиг”-ийг дуун хөрвүүлэх дуршил

**/Цахар гэвш “Мэргэд гарахын орон” дахь
дуун хөрвүүлгийн эшийн зарчмыг “Субашид”-ын
орчуулгад баримталсан нь/**

Го.Аким¹ (доктор, профессор)

**Огоот амраг сэтгэлийг баригч
Эхээс ургасан яруу үгсийн цэцгийн чуулганыг
Угаас баясан дуршихын хуруугаараа
Огоот авч сацах нь энэ мэт болой**

Цахар гэвш ЛУВСАНЧҮЛТЭМ

*Хэрэв номын утгыг мэдэхгүй хүн
Хэр мэт сайн шастирт хаанаас дурлах
Хэтэрхий эрдэнэсээр хэлхсэн алтан чимэг
Хэдий сайхан боловч үхэр үл дурлах мэт*

Цастын орны Саж Бандид Гунгаажалцан Бандида “Сайтар номлосон Эрдэнийн сан Субашид” хэмээх шастираа ийн айлджээ. Алтан нарны орны лам эрдэнийн гэгээн Цахар гэвш Лувсанчүлтэм гүүш ийн дуун хөрвүүлжээ.

“Номын утгыг мэдэж сайн шастирт дурладаг” эрхэм мэргэд та бүхэнд өлзий учрал бүрдсэн энэ өдрийн амгаланг өвгөн бичээч миний бие айлтгаж байна аа.

*Гайхамшигт дээд номын баясахуй цэцэглигт
Гайхамшиг номлох, сонсохын дуун эгшигийг машид дуурсган
Гайхамшигт бясалгал бүтээлийн амтат рашааныг
Гайхамшигтайяа гэр таалагсаар эдлэгсээрийн агаараас
Яруу үгт болоод утга сайт бичиг хийгээд
Ялангуяа хоёр зүйл сайн номлол тэнгэрийн хэв сэлтийг
Чиний хүрч ирэгснээр миний сэтгэл дор
Илэрхий бясалган дуршил цаглашгүй төөрөв (1.208)*

¹ МУ-ын соёлын гавьяат зүтгэлтэн, дуун хөрвүүлэгч

Цахар гэвштэн номын амтанд орсноо ийн шүлэглэжээ. Чингэж шүлэглэсэн Цахар гэвш гэж хэн байв аа? Ариун сүсгээр гэгцэл Лувсандорж, бичээч Жүрмэдданзан нарын туурвисан “Лам эрдэнийн гэгээний намтар оршвой”-гоор бол Цахар гэвш нь “Юн Хэ гүнд долоон жилийн нүүр үзэх болтол сууж, Цанидын дуйраагаас эхлэн далай мэт их гол ёснуудад сонсох, судлах сургууль хийгээд аврал дээд богд Ажаа гэгээнтний дэргэдээс хязгаарлашгүй олон судар тарнийн номыг олсон тэргүүтнээр сонсох санахын үйл нүгүүдээ сайтар төгсөөд гүн бөгөөд агуу их далай мэт гол ёснуудын чинад хязгаарт нь хүрч далай дор орсон Сартваахи бээр сэтгэлчлэн чандманийг олсон мэт...” (2.191) хүн байжээ. Энэ нь өөр үгээр хэлвээс билиг бэлгийн чинад хязгаарт хүрсэн гэсэн үг гэж молхи би мунхаглаж байна. Ийм хүн Монголд олон байсан гэж үү? Ээ дээ цөөн байсан байх аа. Улбируулан өгүүлбээс, “... Ялгуусны сайн зарлиг бүгдийг нэгэн бодгалийн зэрэг болгон эвлүүлсэн увдис Бодь мөрийн зэргийн оньс бүгдийг нэгэн нь сайтар сэтгэлдээ багтаан ...” (3.191) гэж өгүүлжээ. Эгүүнээс үзэх ахул Богд Зонховын “Бодь мөрийн зэргийг уг үндсээр нь судалсан байжээ. Энэ тухайтад нэгэн яриа буй нь, Цахар гэвш Богд Зонховын зохиосон “Ламрим” буюу “Бодь мөрийн зэрэг”-ийг Зонхов богдын жанч халсны дараа барласныг уншжээ. Гэтэл авцалдаат утгаар нь хөөн бодоход Зонхов богдын яавчиг тэгэж үл бичих зүйл уг номонд байж байлаа. Цахар гэвш энэ тухай төвдийн мэргэдэд айлтгажээ. Богдыг жанч халахад шарилыг суварганд залахдаа бичсэн жинхэнэ эхийг хамт оршоосон байлаа. Хэдийвээр төвдүүд Цахар гэвшийн айлдаж байгаад төдийлөн үл итгэсэн ч бас ч эргэлзэж, суваргыг нээн жинхэнэ эхийг үзсэнд Цахар гэвшийн айлдсан нь зөв байсан гэдэг. Чингэж “Бодь мөрийн зэрэг”-ийн тэр алдааг залруулсан нь монгол гэвш Лувсанчүлтэм байсан байна. Энэ тухай үл өгүүлэн өгүүлэхэд, ийм билиг танхай номч, билиг танхай зохист аялгууч бээр дуун хөрвүүлгийг дээдийн ном бясалгах, яруу найраг туурвихын дайнд үзэж, дөчин сүүдэр зооглох үес Нагаржуна гэгээнтний зохиосон “Ардыг тэжээхүй рашааны дусал”-ыг тайлбар сэлтийн хамт орчуулсан байна. Дөчин хоёр сүүдэр зооглосон үес Банчин эрднийн гэгээнтэн эрт цагт Сайн оюут лам хэмээгдэх болон төрөл авахын дүр үзүүлсэн намтар нууцын бошго хэмээгдэхийг орчуулсан байна. Энэ бүхнийг үл өгүүлэн өгүүлэхэд, “Яруу үгт болоод утга сайт бичиг...илэрхий бясалган дуршил цаглашгүй төрөв” гэсэн гэвштэний дээрх гайхамшигт мөрийг миний бие аймшиггүйеэ ялихгүй өөрчлөн “яруу үгт болоод утга сайт бичгийг илэрхий бясалган дуун хөрвүүлэх дуршил төрөв” гэж хэлмээр байна. Мэргэний үгэнд халдсаныхаа төлөө түмэнтээ уучлал гуйж, мянгантаа өршөөл эрээд цааш өгүүлсү. Ийнхүү их гүүшийн “сэтгэл дүр дуршил төрсөн”-ий эрхээр “Сайтар номлосон эрдэнийн сан Субашид”-ыг дуун хөрвүүлжээ хэмээн молхи би мунхаглаж байна. Тийм ээ, эрдэмт багш академич Д.Цэрэнсодном абугайн “Монголын бурханы шашны уран зохиол” бүтээлдээ хэвлүүлсэн “Лам эрдэнийн гэгээний намтар оршвой”-д “Гучин есөн сүүдэр зооглосон шар нохой жилд цамын завсарлага тайлаад төрсөн нутгийн энэ суманд урьд жил бүр Ялгуугсаны эх Билгийн чанад хязгаар хүрсэн зуун мянган шүлэгтийг нэжгээд гүйцэд уншсан...Бас энэ үеийн бараг дор заримууд бээр дурдатгасны ёсоор Сажийн сайн номлол Субашидын тайлбар сэлтийг гүйцдээр, монголын

хэлд орчуулав” (4.252) гэжээ. “Гүйцэд уншсан, гүйцэд орчуулсан...” Цахар гэвш зөвхөн гүйцэд орчуулаад зогссон бус юм. 1778 онд буюу ёстой л 40 гарсан эр, дөрөв дарсан ат гэж монголчуудын хэлдгээр жинхэнэ оюун гүйцэд тэгширсэн үедээ орчуулсан энэ зохиол уран сайхны хувьд ч гүйцэд болсон, одоо ч судлаач, уншигчдын дуршлыг гүйцэд татсаар байгааг хэлэх хэрэгтэй. Тэрхүү “дуршил төрсөн” гэдгийг молхи би бүр “онгод орсон” гэж урвуулан хэлмээр байна. Чингэхдээ их гүүш маань дуун хөрвүүлгийн эшийн ямар зарчим баримталсан вэ гэдэг асуулт зүй ёсоор гарна. Тийм ээ, ямар ч дуун хөрвүүлэгч, тэр тусмаа Цахар гэвш шиг эрдэмт гүүш эшийн зарчимгүйгээр орчуулах гэж үгүй биз ээ. Учир нь эшгүйгээр орчуулна гэдэг элчилгүй талд хазааргүй морьтой давхих лугаа агаар нэгэн бөлгөө. Чингэхлээр дуун хөрвүүлгийн эшийн ямар зарчмыг баримталж орчуулсан байж таарах вэ? Цахар гэвштэн “Сайн номлолт эрдэнийн сан “Субашид”-ын тайлбар чандманийн түлхүүр хэмээгдэх оршвой”-ын төгсгөлийн үгэнд бичихдээ: “Субашид”-ын тайлбар товчийн төдий өгүүлсэн чандманий түлхүүр гэдэг үүнийг “Субашид”-ын хоёр зүйл тайлбар тэргүүтэн судар шастируудаас түүж мэдэхэд хялбар болохыг эрхлэн шинжлээд өөрийн оюунд ургасны хэрээр Шахинлагуудын тойн Сумади нэрт бичив” (5. 196) гэжээ. “Энэ Сумади бол Цахар гэвш Лувсанчүлтэм мөн” гэж Монголын эрдмийн ноён оргилын нэг Ц.Дамдинсүрэн абугай баталсан нь буй. Үүнийг үл өгүүлэн өгүүлэхэд Цахар гэвштэн энэ төгсгөлийн үгийг Чандманий түлхүүрт зориулан бичсэн нь үнэн боловч ургуулан бодвоос бас “Субашид”-ын орчуулгад хамааруулан өгүүлсэн байхыг ч үгүй гэж няцаах аргагүй мэт. Өөрөөр хэлбэл “...мэдэхэд хялбар болохыг эрхлэн шинжлээд өөрийн оюунд ургасны хэрээр ...бичив” гэдгийг “мэдэхэд хялбар болгох үүднээс өөрийн оюунд ургасны хэрээр орчуулав” гэж ойлгож болмоор. Молхи би яагаад ингэж аймшиггүйяа хэлж байна вэ? Энэ тухайтад “ариун сүсгээр гэгцэл Лувсандорж, бичээч Жүрмэдданзан нарын бичсэн Аврал богд лам эрдэнийн гэгээний намтрын гуравдугаар бүлэг”-т “Орчуулга айлдсан энэ ч ...эхэн, дунд, адаг оюутан бүхний оюун дор мэдэхүйеэ хялбар...” (6. 252) гэж өгүүлсэн нь дээрх лүгээ утга уялдаж байна гэж хэлж болно. Түүнчилэн Хамгийг мэдэгч Жанжаа хутагт Ролбийдоржийн эрхэлснээр Монголын 40 орчим гүүш, хэлмэрч нарын зохион, 1742 онд модон бараар хэвлүүлсэн “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг”-ийн “Барамид”-ын аймгийн эхэнд өгүүлэхдээ: “...шударгуу оюунаар үг утгасын хувийг сайтар шинжлээд...мэдэхүйеэ хялбар үгээр утга лугаа үл харшлалдуулан сайтар орчуулбаас...олон чуулганыг аривтгаж чадах...” (7. 19a) гэжээ. Энэ хоёр, тэр ч байтугай дээрх гурав “хүртэхүйн орон нугуундаа” нэг л утгыг зааж байнам бус уу. Энэ нь “Субашид”-ыг Цахар гэвштэний орчуулсан гол зорилго гэж хэлж болно. Тэгэхлээр уг зорилгод хүрэхийн тулд орчуулгын эшийн ямар зарчим баримталсан вэ? Уг нь дэлхийн орчуулгын онол (практик)-д утгачилсан, махчилсан, чөлөөт гэж гурван урсгал бий. Гэтэл Дамдинсүрэн гүүш Пушкиний “Алтан загасны үлгэр”-ийг орчуулсан зарчмын тухайтад айлдахдаа “зохиомжлох” гэсэн нэгэн нэр томъёог дэвшүүлсэн байдаг. Энэ нь угтаа Дамдинсүрэн абугайн анх дэвшүүлсэн зүйл ч биш ерөөс уламжлалт монгол дуун хөрвүүлгэд аль эртнээс байсан зүйл бололтой. Үүнийг “оюунаараа найруулан

орчуулах” гэж нэрлэж байсныг Ш.Сонинбаяр ламтан дурдсан байна. (8. 97) Энэ нь дээрх “оюунд ургасны хэрээр” гэж Цахар гэвштэний өөрийнх нь бичсэнтэй ч авцалдаж байна гэж бардаагаар хэлж болно. Юу вэ гэвэл орчуулга гадаад үгэнд, гадаад хэлний өгүүлбэрийн бүтэцэд үл баригдан эх хэлнийхээ найруулах ёсноос эс гажсан байх учиртай. Цахар гэвштэн төвд үгэнд, төвд өгүүлбэрийн бүтэцэд огоот баригдаагүйн жишээг доктор Л.Хүрэлбаатарын судалгаанаас үзэж болно. Иш татруун:

Муу эм хийгээд муу амраг ба муу хааныг хэн нэгэн шүтэх

Төвд эхийг махчилан орчуулбал ийм гэнэ. Тэгвэл Цахар гэвш үүнийг

Адаг муу гэргийтэй амар явж үл болох

Атаа ихт нөхөртэй удаан ханилж үл болох

Уур ихт догшин хаанд ашид итгэж үл болох гэж буулгажээ. Төвд өгүүлбэрийг бүхэлд нь өөрчилсөнөөр үнэхээр эрдэмтэй эрдэмгүй, харц, ноён хэнд боловч мэдэхүйеэ хялбар болсон байна. Тэр байтугай 270 жилийн дараах бидний үеийнхэнд ч мэдэхүйеэ хялбархан байнам бус уу. Гэтэл яаж ийн мэдэхүйеэ хялбар болгов оо? Орчин үеийн орчуулгын эшээр бол хувиргалын бүхлээр нь өөрчлөх зарчмыг энд гарамгай хэрэглэснийг тайлбарлалтгүй тодорхой тул гагц төвд шүлгийн **муу** гэдэг үгийг авч үзье. Энэ нь ерөнхий утгатай үг юм. Тэгвэл Цахар гэвш тэрхүү гурван **муу**-гийн утгыг нарийвчилсан байна. Өөрөөр хэлбэл адаг муу, атаа ихт, уур ихт догшин хэмээн тодорхой утгатай болгон хувиргажээ. Энэ нь орчин үеийн орчуулгын онолын үүднээс бол дээр өгүүлснээр утгыг нарийвчлах гэдэг хувиргалын зарчим мөнөөс мөн. **Шүтэх** гэдэг ерөнхий утгатай үгийг ч мөн л утгыг нарийвчилж, **явах, ханилах, итгэх** гэсэн тодорхой утгатай болгожээ. Чингэхдээ **амар, удаан, ашид** гэсэн үгсийг нэмжээ. “Мэргэд гарахын орон”-д “зарим үе дур үгсийг өчүүхэн эс нэмбээс утгын чадал үл бүрдэх мэт ч буй” (9. 20а) гэж айлджээ. Цахар гэвштэн эдгээр үгсийг нэмснээр утгын чадлыг бүрдүүлж чадсан байна гэж бахархан хэлсү. Мөн тавд өгүүлбэр бол баталсан (шүтэх) өгүүлбэр юм. Гэтэл дуун хөрвүүлэгч үүнийг үгүйсгэсэн (үл болох) өгүүлбэр болгон хувиргасан байна. Энэ нь өнөөгийнхөөр бол эсрэг утгаар орчуулах зарчим юм. Билиг танхай дуун хөрвүүлэгч хүн ганцхан өгүүлбэрт ийм олон хувиргалын (бүхлээр нь өөрчлөх, утгыг нарийвчлах, нэмэх, эсрэг утгаар нь орчуулах) зарчмыг хэрэглэж, утгын чадлыг бүрдүүлэн мэдэхүйеэ хялбар болгочихсон байна. Чухамхүү энэ л учраас шавь нарынх нь дуу алдан бичсэнээр гэвштэний дуун хөрвүүлгийн “үг нь найртай бөгөөд яруу эелдэг” (10.252) болжээ. “МГО”-д “...шүлэглэсэн нүгүүдийг яруу найртай ...үйлдэх” (11.236) гэж айлдсан буй. Энэ нь хэдийгээр төвд шүлгийн тухай хэлсэн мэт боловч орчуулга нь мөн л тийм байх учиртай гэсэн үг мөн. Үүнийг гэвштэний шавь нарын өгүүлсэн хийгээд гэвштэний өөрийнх нь орчуулсан нуталж байна. Энэхүү “найртай бөгөөд яруу эелдэг” нь яруу найраг орчуулах гол зарчим мөн. Ганц яруу найраг ч бус. Чингэж “найртай, яруу эелдэг” болгохын тулд Цахар гэвштэн толгой холбох, сүүл холбох, авиа ижилсүүлэх, дотор нь холбох (дотоод холбоц) зэрэг монгол яруу найргийн айзам үүсгэдэг хэд хэдэн аргыг хэрэглэсэн байна. Толгой холбосон нь, **адаг,**

атаа, агуур (уур), сүүл холбосон нь, болох, болох, болох, авиа ижилсүүлсэн нь, **адаг-амар, атаа-удаан, агуур-ашид**, дотуур холбосон нь, **ихт-ихт**, нөхөртэй-гэргийтэй, явж, ханилж, итгэж, **үл-үл-үл** гэх мэт. Тэгвэл энэ мөрийг англи хэл рүү орчуулсан байдлыг авч үзсү.

Who would depend on a bad spouse,

A bad friend, or a bad king?

Үүнийг орчуулбал:

Муу эхнэр, муу нөхөр,

Муу хаанд хэн найдах юм бэ? болох бөгөөд энэ нь Хүрэлбаатарын үгчилсэн орчуулгатай яг таарч байгаагаас үзэхэд англиар эхийг яг барин буулгасан нь харагдаж байна. Гагцхүү асуух өгүүлбэр л болгосон байна.

Дахин нэг жишээ авсу.

Сайжрахын цагт бүгд садагнах

Доройтохын цагт бүхэн дайсагнах

Энэ бол Л.Хүрэлбаатарын үгчилсэн орчуулга. Тэгвэл Цахар гэвийн орчуулгыг толилуулсу.

Сайжран дээшлэхийн цагт бүгд эрэгцэн нөхөр болох

Сааран доройтохын цагт бүгд дутаан дайсан болох

Толгой холбохын тухайтад “МГО”-д өгүүлэхдээ “... магтаал хийгээд залбирал мэт зарим нугууд дур монгол хэлэн дур алдаршсан толгой холбох мэт үйлдвээс бээр харш үгүй...” (12.236) гэжээ. Энэ хоёр мөрийг үзвээс **дээшлэх, доройтох** гэдгээр толгой холбож болмоор байгаа боловч гэвштэн тэгсэнгүй, **сайжран, сааран** гэдгийг уг хоёр үгэн дээр нэмэн толгой холбожээ. Энэ нь учиртай болой гэж мунхагламуй. Нэгд, эхнийхэд нь д үсгээр толгой холбогдож байгаа боловч нэгд, авиа нь ижилсэхгүй байж, хоёрт үг нь ганцдаж сондгойроод чихэнд наалдаж өгсөнгүй. Харин **сайжран, сааран** гэдгээр толгой холбоход авиа ижилссэн төдийгүй эдгээрийг **дээшлэх, доройтох** лугаа хоршин хэрэглэснээр уг бадаг үнэхээр хөгжимлөг, “найртай” болохын үүд нээгдсэн байна. Үүний зэрэгцээ дотоод холбоцыг чадамгай ашигласнаар үнэхээр сонсголон яруу буюу “яруу эелдэг” болсон байна.

Сайжран дээшлэхийн цагт бүгд эрэгцэн нөхөр болох

Сааран доройтохын цагт бүгд дутаан дайсан болох

Тэгвэл англи орчуулгыг үзсү.

When one is wealthy, all are friends,

But if one is poor, all are enemies

Үүнийг монгол болговол:

Хүн баян байвал бүгд нөхөд болох

Харин ядуу бол цөм дайсан болох.

Энд манай дуун хөрвүүлэгч сайжран дээшлэх, сааран доройтох гэсэн үгээр оноосон бол англи орчуулагч баян, ядуу гэдэг үгийг сонгосон байна.

Шавь нарынх нь бичсэнээр Цахар гэвшийн “үгний чадлыг гаргасан ёсон тэргүүтэн нь бусдаас үлгэр ялгаатай” (13.252) ажээ. “МГО”-д өгүүлэхдээ: “Тэрхүү үгийн чадал гарахуй ёсыг сайтар шинжлэх хэрэгт болой” (14.196) гэжээ. Үгийн чадлыг гаргана гэдэг нь орчуулагч гадаад бичгийн үгэнд жин яг таарсан үгийг нь оноож тавихыг хэлдэг. Тэгвэл гэвштэн “үгийн чадал гарахуй ёсыг сайтар шинжлээд” “бусдаас үлгэр ялгалтай”-гаар хэрхэн гаргасан буй? Тэрхүү “үлгэр ялгалтай” гэдэг нь юун буй? Энэхүү “үлгэр ялгалыг тодруулахын үүднээс гэвшийн орчуулгыг бусад орчуулгатай нь харьцуулан жишвээс зохино. Цахар гэвшийнхээс гадна “Субашид”-ын зургаан орчуулга буй гэдэг. Их мэргэн Дамдинсүрэн абугай “Субашид”-ын гучин бадгийн гурван орчуулгыг “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой”-доо оруулжээ. Эдгээр нь тарнич тойн Соном-гара, мэргэн гэгээн Дамбийжалцан, номтын Ринчен нарын орчуулга юм. Орчуулгуудыг харьцуулсугай. Гэхдээ Соном-гарагийн орчуулга бол XIII зууны сүүл, XIV зууны эхэн үеийнх, Цахар гэвшийнх бол XVIII зууны дунд үеийн, мөн Дамбийжалцаных XVIII зууных, номтын Ринченийх XIX зууных тул Соном-гарагийн орчуулга нэг үеийн хоёр орчуулагчийнхаас арай өөр байх, харин Цахар гэвш, мэргэн гэгээн хоёрын орчуулга төстэй байж болох талтай гэж бодож болохоор боловч энэ тухайтад цэцэрхэн нуршихыг огоорч, жишин толилуулахыг эрхэм болгосу.

Тойн Соном-гарагийн орчуулсан нь:

Сайн үгсийг мэргэдийн оюунаар ухъяу

Мунхагууд хаанаас ухахуун

Нарны гэрэл ургаваас л

Элээсийн шувуу балран одмуй

Мэргэн гэгээн Дамбийжалцаны орчуулсан нь:

Номлолуудыг мэргэд оюунаараан мэдмүй за

Мунхагууд тийм бус буй.

Гэгээн гэрэл наран нь гарваас

Балайрмуй, элээсийн шувууд

Гэвш Лувсанчүлтэмийн орчуулсан нь:

Үнэн мэргэн ухаантан номын утгыг мэднэ за

Үтэл мунхагууд хаанаас мэдэх

Үлэмж гэрэлт нар ургаваас л

Үзтэл шар шувуу тэргүүтэн харин балайрах мэт

Номтын Ринчений зассан нь:

Үнэн мэргэн ухаантан сайн номлолын утгыг мэдмүй за

Үтэл мунхагууд хаанаас мэдэх

Үлэмж гаралт наран ургаваас л

Үзтэл, шар шувуу тэргүүтэн харин балайрюу

Эдгээрийг зэрэгцүүлэн үзвээс Соном-гара, Дамбийжалцан хоёрын орчуулга буюу дөрвөн зууны зөрөөтэй хоёр орчуулга бараг үг үсгээрээ нийлж байна. Харин Лувсанчүлтэмийн орчуулга ондоо байна. Түрүүчийн хоёр болон дөрөв дэх орчуулгад гараад байгаа **сайн үгс, номлол, сайн номлол** зэрэг нь бурханы шашны зарлиг сургаалын утгыг заасан тодорхой утгатай үгс юм. Тэгвэл гэвштэн түүнийг **ном** гэж орчуулснаараа дээрх үгсийн утгыг түүнд багтаан ерөөс ямар ч номын утгыг мэргэн хүн л ойлгоно хэмээн утгыг ерөнхийлөн буулгасан байна. Түвдэч Л.Хүрэлбаатарынхаар бол “шашин номын санааг иргэншүүлсэн” (15.110) байна. Тэрчлэн эхийн **элээ шувуу-г шар шувуу** болгон өөрчилжээ. Үнэндээ нар гарахад нүд балайрдаг нь шар шувуу юм. Элээ нартайд ч нисч л явдаг. Цахар гэвш үүнийг соргог анзаарчээ. Иймээс монголчуудын сэтгэхүйд ойртуулан элээг **шар шувуу** болгон өөрчилсөн байна. Харин Ринчен гэвштэний орчуулгыг засахдаа **ном** гэдгийн утгыг нарийвчилж, **сайн номлол** болгон шашны агуулга руу нь оруулсан мөртлөө **шар шувуу-г** хэвээр нь үлдээжээ. Үүнээс үзэхэд Номтын Ринчен бурханы зарлиг сургаалын үг үг үсгэд халдаж болохгүй гэсэн зарчмыг бариад иргэний талын зүйлийн орчуулга ийм байж болно гэж зөвшөөрч байсан, мөн нарны гэрэлд шар шувуу л юм харж чаддаггүй гэдгийг мэдэхийн учирт хэвээр үлдээсэн байж болох талтай. Энэ бүхнээс үзэхэд гэвштэн орчуулгадаа үгийн чадлыг бусдаас үнэхээрийн өвөрмөцөөр гаргаж байсан нь бэлхэнээ харагдаж байна. Чингэвэл англи орчуулгыг харьцуулсу.

Skilled in good advice, the wise know,

But foolish people do not.

When radiance of the sun appears

Owls became blind.

Энэ шадыг үгчлэн монгол болговол:

Сайн зарлигт нэвтэрсэн мэргэн нь мэднэ

Тэгвэл мунхаг хүмүүс үл мэднэ.

Нарны туяа тусахад

Ууль сохор болно.

Энэ англи орчуулгад owl буюу монголоор ууль гэдэг үгийг сонгосон тухайтад хэдхэн үг хэлмээр юм шиг. Ууль нь шөнийн идэшт шувуу. Нар гарахад мөн л нүд балайрдаг нь тодорхой. Англи орчуулагч үүнийг бодсон байж болох талтай. Гэтэл бас (as) wise as an owl /ууль шиг мэргэн/ гэдэг англи өвөрмөц хэлц үг бий. Уг эхэд нэгэнт мэргэн ухаант хүний тухай яригдаж байгаа болохоор англи орчуулгад утгыг улам тод болгох үүднээс ууль гэдэг үгийг сонгосон байж ч болзошгүй.

Цаашилбал:

Соном-гарагийн орчуулсан нь:

*Их ухаантан шантарваас бээр
Төлд ухаан нь хүчит болмуй заа
Гөрөөдийн хаан арслан өлсвөөс бээр
Зааны эхин мөн дээр хагальюу*

Дамбийжалцаны орчуулсан нь:

*Ухаантан хэдий мухардваас
Оюун нь хүчин төгс больюу
Гараагийн хаан өлсвөөс
Заан бүхийгийн тэргүүнийг хагалнам*

Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулсан нь:

*Асар сайн ухаантан эд мал доройтовч
Ашид ухаан нь сайнаар байх вий
Араатны хаан өлсвөөс л
Асар түргэнээр зааны толгойг хагальюу*

Ринчений засварласан нь:

*Асар их ухаантан хэр доройтовч
Асар харин оюун нь хүчин төгөлдөр больюу
Араатны хаан арслан өлсвөөс л
Асар түргэнээ зааны толгойг хагальюу*

Жон Т.Давенпортын англиар орчуулсан нь:

*When the very wise become destitute
Their intelligence grows even stronger.
When the king beasts becomes hungry
It swiftly attacks the elephant's head.*

Энэ англи шадыг үгчлэн буулгавал:

Үлэмж мэргэн хүн ядуурахдаа

Ухаан нь улам сайжирдаг.

Араатны хаан өлсөхдөө

Зааны толгой руу даруй дайрдаг.

Уг эхийг барьж буулгасан гэж миний дүгнэж байгаа англи орчуулгаар бол Цахар гэвш маань утгыг ягштал оножээ гэж бардаагаар хэлж болох. Учир юун гэвэл Соном-гарагийн шантрах, Дамбийжалцаны мухардах, Ринчений доройтох гэж оноосныг Цахар гэвштэн эд малаар доройтовч гэж дүйлгэсэн байна. Би яагаад Цахар гэвшийнхийг оносон гэж хэлж байна вэ гэвэл англи *destitute* гэдэг үг ядуурах, хоосрох, үгүйрэх гэсэн буюу өөрөөр хэлбэл эд хөрөнгөөр доройтох гэсэн утгатай тул гэвштэний эд мал доройтовч гэсэн нь түүн лүгээ цавхийтэл тохирч байна. Гэвш маань эд хөрөнгө гэсэнгүй, эд мал гэж, мал гэдэг үгийг нэмсэн нь өөрийн уншигчийг бодох гэж өдгөө хэлж байгаа зарчим, өөрийн уншигчийн сэтгэхүйд ойртуулах зарчим даруй мөн. Мөн Соном-гара, Дамбийжалцан нарын **гөрөөд** гэж буулгасныг Цахар гэвш **араатан** болгосон нь бас л оносон ажгуу. **Гөрөөд** гэдэг нь бүх ан амьтан гэсэн утгыг тэр үед зааж байсан. Тэгвэл Цахар гэвш утгыг нарийвчилж, зөвхөн араатан амьтан гэсэн утгаар авчээ. Англиар **beast** нь араатан гэсэн үг. **King of beasts** гэхлээр **Араатны хаан** гэсэн утга яахын аргагүй мөн. Гагцхүү Цахар гэвш **арслан** гэсэн үгийг нэмж монголчуудын хэвшин тогтсон хэллэгийг сонгосноороо дээрх хэллэгийг монгол хүний сэтгэхүйд ойртуулсан хэрэг мөн. Утгыг тодлох үүднээс үг өчүүхэн нэмэн үйлдэхийг МГО-д заасныг дээр би дурдсан бөлгөө. Цааш нь түвд судлаач Л.Хүрэлбаатар "...харийн ахуйг монголжуулсан нэг сонин юм нь, "Заан машид хүч төгс боловч өчүүхэн заанчин (зааныг сургагч) түүнийг сургаж ажилд зардаг" гэж түвд эхэд өгүүлснийг Цахар гэвш орчуулахдаа "Унаагүй эмнэг үхэр мориуд хүчтэй боловч удалгүй номхорч хүүхдэд ч унуулах мэт" гэж монгол ахуйд зохицуулсан юм" (16.114) гэж бичжээ. Энд амьтныг амьтнаар сольжээ. Тэгвэл бүр хүнийг үйлс болгосон нь ч буй.

Эрдэмтэй эрдэмгүй аранг

Авахуй гээхүйяа оюутанхүү орон

Тоосонд холилдсон төмөрийн үрэвтсийг

Соронзон гүр аван чадмуй гэж Соном-гарагийн хэт махчлан орчуулсан бадгийг Цахар гэвш орчуулахдаа:

Хортой тустай олон үйлсийн дотроос

Хойшид тустай сайныг ялгаж авагч мэргэн бөгөөд

Хог сагийн дотор байсан төмрийн үртсийг

Холимоггүй соронзон гүр бүр ялгаж татах мэт гэжээ. Энд эрдэмтэй эрдэмгүй хүнийг

хортой тустай олон үйлс болсон нь эхээс дэндүү холдсон мэт харагдана. Гэвч Оросын Гоголь “орчуулахуйд эхээс холдох тусам утга ойртоно” гэж цэцэлснийг санаваас Цахар гэвшийн чингэж орчуулсан нь яахын аргагүй зөв болоод явчихна. Мөн Л.Хүрэлбаатар бичихдээ: “Цахар гэвш...Энэтхэг түвдийн сургаалын шүлэгт уламжлал болсон лянхуа цэцэг тогос шувуу, заан, чандмани эрдэнэ зэргийг ердийн монгол ахуйд зохицуулж, үзэсгэлэнт цэцэг, уран дуут шувуу, мал адгуус эд өлгийн зүйлсээр орлуулсан байна” (17.115) гээд энэ бүхнээс ургуулан дүгнэхдээ уг орчуулгыг “...бие даасан бүтээлийн шинжтэй болжээ” (18.103) гэсэн байна. Энэ нь, нэг бодоход, зөв дүгнэлт мэт. Нөгөө бодоход?!...Ер орчуулагчийн орчуулга бүр бие даасан бүтээл байдгийг үл өгүүлбэ. Цахар гэвшийн орчуулгын жишээ лугаа тун төстэй нэгэн жишээг ХХ зууны Билгүүн номч Ринчен бээр “Жийдаан хуушаан”-ны намтраас иш татаад “Үүнд **гэр мал** гэсэн хоршоо үг бол даруй монгол орчуулагчийн хэрэглэсэн хоршоо үг болохоос зайлахгүй аж. Энэ зүйлд холбогдсон тэр баатар эр үе улиран Лин-ан хотод сууж, ан хийхдээ явган явдаг хүнд гэр мал гэж хоршин хэлэх МАЛ гэдэг хаанаас байх ажээ. Гагцхүү монгол орчуулагч монгол үзэгчийн сэтгэлд гэр гэхэд мал гэдэг нь санаанд орж, гэр мал хэмээн хоршин сэтгэдэг байдал нь үүнээ үзэгдэн буй заа. Үүнийг би бас асар буруушаан үл халдах болой. Учир юун хэмээвээс орчуулсан хүн нь монголоороо бодоод, монгол хэлээрээ эл орчуулгыг үзэн сэтгэх, сонирхон бодох монгол үзэгч олондоо зориулсан болох тул уг эх зохиолыг тэр зохиолын эх хэлээр нь үзэн бахдагч хүний сэтгэлд төрдөг санаа бахдал, баяр хорслын хөдөлгөөнийг монгол үзэгчийнхээ сэтгэлд төрүүлэх гэсэн орчуулагч хүн ухаанд нь орж, сэтгэлд нь тусахуй өөр соёл байдал бүхий өөр улсын үгийг махчлан хуулах гэсээр хэтэрвэл уг зохиогчийн санаа бодлыг өөр хэлээр үзэгч хүнд нэвтүүлэхэд нь замын садаа бартаа босгоно гэсэн үг шүү дээ” (19.154) гэжээ. Ринчен гүүштэний энэ санааг Цахар гэвштэний орчуулгад бүрнээ хамааруулж болно. Мөнхүү орос орчуулагч нар англи хэлнээс орос руу орчуулахдаа англи хүний бэлгэдэл **царс** модыг орос хүний бэлгэдэл **хусаар** орлуулсан нь элбэг байдаг. Энэ нь Ринчен абугайн хэлснээр эхийг үзэгч, орчуулгыг үзэгч хоёрын сэтгэгдлийг ойр болгох гэсэн хэрэг мөн. Үүнийг орхин өгүүлэхэд гэвштэнийг үндэсний онцлогтой үг бүгдийг ийм аргаар орлуулсан гэж бас болмооргүй байна. Тухайлбал, олон газарт зааныг заанаар нь (Үлгэрлэвэл, заан дайсныг дарж хандах тул, Сайн зааны хүчийг дайсанд тавибал мэдэх, Урьд нэгэн газар байсан олон хүчит заанууд гэх мэт), тогосыг тогосоор нь (Сайхан өнгөт тогос үргэлж өөрийн биеэр эргэцүүлэх), суурин ахуйг түүгээр нь (тариаланд урсах усыг дагасан загас тарианы сувагт орж үхэхтэй адил) орчуулснаас харагдана.

Чингэхлээр Цахар гэвш орчуулгадаа маш уян хатан хандаж, хэдийд нь монгол ахуйг үгээр орлуулах, хэдийд нь гадаад ахуйн үгийг хэвээр буулгах вэ гэдгийг тун нарийн сонгосон байна. Ялдар дурдахад, уншигчаа бодох энэ уламжлал 20-р зуунд ч үргэлжилж, их номч Б.Ринчен гүүш Гоголийн “Тарас Бульба”-г орчуулахдаа “зүрхэнд сум туссан хурга” гэдгийг “зүрхэнд зэв туссан янзага” гэж орчуулж **хургыг янзага** болгож байсан жишээ бэлхнээ буй. Гагц Ринчен гүүш ч бус! Үүнийг үл өгүүлэн өгүүлэхэд

Цаашилбал:

Соном-гарагийн орчуулсан нь:

*Асуулцан тэмцэлдэх инагсад
Мэргэнийг ухан үл чадъяу
Хөөргийг дохиураар эс дэлдвээс
Бусад тача ялгал нь юунаа аху*

Дамбийжалцаны орчуулсан нь:

*Мэргэн лугаа хэлэлцээгүйгээр
Тачаат угийг үл мэдмүй
Хэнгэргийг үл дэлдээгүйгээр
Бусад лугаа ялгал нь юун буй*

Лувсанчүлтэмийн орчуулсан нь:

*Сайтар эсэргүүцэж үл асуутал
Санаагаар хүний рэдмийг дэмий бүү цэнэ
Сайн дуут хэнгэрэг боловч эс дэлдвээс
Сац бас өөрөө дуу үл гарах мэт*

Ринчений зассан нь:

*Сайд мэргэд лугаа асууж хэлэлцэлгүй
Санаагаар хүний эрдмийг дэмий бүү цэнэ
Сайн дуут хэнгэрэг боловч эс дэлдвээс
Сац өөрөөн дуу үл гарам*

Жон Т.Давенпортын англиар орчуулсан нь:

*Until the learned are troughly questioned,
Their depth cannot be assessed
Until a drum is beaten by drumsticks
Its distinction from other drums is unknown.*

Үгчлэн орчуулбал:

*Эрдэмт хүнийг сайтар сонжихгүй бол
[Мэдлэгийнх нь] хэр зэрэг гүнзгийг цэгнэх аргагүй
Хэнгэргийг цохиураар дэлдэхгүй бол
Бусад хэнгэрэгнээс ялгаатайг нь мэдэх аргагүй*

Хүнтэй ярилцаж хэлэлцэлгүйгээр эрдмийг нь басан үнэлж болохгүй гэсэн санаа бүхий энэ бадгийн эхний хоёр орчуулгыг үзвээс түвд эхдээ хэт баригдсан тал байна уу гэмээр. “МГО”-д өгүүлснээр “... мэдэхүйеэ хялбар үгээр утга лугаа үл харшлалдуулан сайтар орчуулбаас...” гэж заасан буйг дээр дурдсан. Тэгвэл Цахар гэвш энэ бадгийг орчуулахдаа үнэхээрийн үг утгасын хувийг сайтар шинжлэн мэдэж утгыг харшлалдуулаагүйгээр үл барам мэдэхүйеэ хялбар үгээр ой тойнруу бүр оруулаад өгчээ. “МГО”-д заасан “утгын чадлыг бүрдүүлэх” (20.20а) гэгч бол чухамхүү энэ мөнөөс мөн. Энэ нь Номтын Ринчений зассан байдлаас бүр тод болж байна. Тэр ч байтугай мунхаг миний бодлоор бол Цахар гэвш түвд эхэд байгаа логикийн гэмээр зөрүүг засан орчуулсан байна. Жишээлбэл, Л.Хүрэлбаатарын үгчилсэн орчуулгыг үзвээс түвд эхэд ийм нэгэн өгүүлбэр буй. Ишлэсү.

Дээд хүн номхноор өөр бусдыг тэтгэх

Муу хүн хэдрээр өөр бусдыг зовоох

Энд дээд хүнд муу хүнийг сөргүүлэн тавьжээ. Гэтэл учир шалтгаанаар нь хөөн бодвоос дээд хүн сайн байх албагүй, муу ч байж болох. Дорно дахины арга билгийн ухаанаар бол дээдийн нөгөө тал нь доод, сайны нөгөө тал нь муу болно. Доод хүний дотор бас сайн ч байж болно, муу ч байж болно. “... Өөрөө ямар ёсоор эс мэдсэнээ **мэргэн хэмээн алдаршсан дээд доорд хэн** ч бологдохуунаас сайтар асууж сэжгээн таслаад ...” (21.19а) гэж “МГО”-д дурдсаныг энд ишилбэл бүр ч тодроод явчихна. Ингэхлээр хоёрдугаар шадад дурдагдаж байгаа нь муу хүн байна. Тэгвэл “номхоноор өөр бусдыг тэтгэж байгаа” болохоор тэр дээд хүн бол сайн хүн байна гэсэн логик утгаар нь гэвштэн хөөн, **дээд хүнийг сайн хүн** болгон хувиргаж, **мууд** нь харгуулсан байна.

*Үнэн **сайн** хүн номхон зөөлнөөр өөр бусдыг жаргуулах*

Өөдгүй муу хүн ширүүн хэдрээр өөр бусдыг зовоох

Үгийн чадал гарахуй ёсын “үлгэр ялгал” нь энэ мөн.

Жон Т.Давенпортын англиар орчуулсан нь:

Noble people gently care themselves and others

Bad people stubbornly torment themselves and others.

Үүнийг үглэн буулгавал:

Сайн хүн зөөлнөөр өөрийгөө ч өрөөлийг ч анхаарна

Муу хүн гэжүүдээр өөрийгөө ч өрөөлийг ч зовооно.

Англи хэлэнд **noble** гэдэг үг хоёр утгатай. Нэгдэх нь язгууртан, сурвалжтан гэсэн, хоёр дахь нь сайн чанартай, яс сайтай, хүн чанар сайтай гэсэн утгатай юм. Иймд Давенпортын тэр noble-тай Цахар гэвшийн **сайн** нь цавхийтэл дүйж байгаа нь харагдана. Мөн хүрэлбаатарын **тэтгэх** гэж үгчилсэн, Давенпортын **анхаарах, санаа тавих** гэсэн үгсийг гэвштэн **жаргаах** гэсэн. Яагаад гэвштэн ингэв ээ гэсэн асуулт өндийгөөд ирэхэд доод шадад нь **зовоох** гэсэн

үг байгаа шүү дээ гэж бат хариулж болно. Саж бандид өөрийн эл цэцэн үгийн чуулганаа арга билгийн зарчмаар буюу ер сайн мууг, авах гээхийг харгалдуулан бичсэн юм. Чингэхлээр нэгэнт дор нь **зовоох** гэж байгаа болохоор дээрхийг нь оноохдоо зовоохын эсрэг үг болох **жаргаах**-ыг сонгохоос аргагүй юм. Тийм ээ, дахиад хэлэхэд, үгийн чадал гарахуй ёсын “үлгэр ялгал” нь даруй энэ мөн. Англи орчуулгад байгаа өөрийгөө гэдэг үгийг Хүрэлбаатар ч, гэвштэн ч орхисон нь жаахан хачирхалтай мэт. Уг нь утгын цохилт тэр үгэнд ч оногдож байгаа бололтой юм.

“МГО”-д “... магтаал хийгээд залбирал мэт зарим нугууд дур монгол хэлэн дур алдаршсан толгой холбох мэт үйлдвээс бээр харш үгүй...” (22.23б) гэсэн тэр тэр зарчмыг ягштал баримталжээ. Өөрөөр хэлбэл “Субашид”-ын орчуулгыг монгол бичгээр нь үзвэл нийт 457 бадгийг цөмий (100%) нь зэргэд холбоцоор холбосон байна. Энэ нь Цахар гэвшийн урлах авьяасын гайхамшиг, мөн монгол бичгийн чадлын гаргуун лугаа зайлбаргүй холбоотой. Харин орос үсэгт буулгасныг үзвэл тэр байдал зарим үед эвдэрч алдагдсан нь харагдана. Жишин үзүүлбэл:

Yehet foeegeedea Merheoa frde[^] iie* foilO HeeheeO .

yerokkeI Kimoa NoiKoa Kise& iie* foilO HeeheeO

yehe_ Heoa oa Seeit fdA iie* foilO HeeheeO

yerO Deleh Nogooa fsoa iie* foilO HeeheeO

Ер далайнууд усаар үл ханах

Ихэс хаадын сан эдээр үл ханах

Ерөнхий хүнүүд хүслээр үл ханах

Их ухаантан мэргэд эрдмээр үл ханах

Орос үсгээр буулгасан энэ бадгийг үзвэл толгойг солбицуулан холбосон (солбио холбоц) мэт харагдаж байна.

Сүүл холбох нь монголшүлгийн урныг харуулдаг нэг онцлог юм. Цахар гэвштэн ч шүлгийн сүүлийг гайхалтай уран холбожээ. Үүнд сүүл бүтэн холбосны нэг жишээ дурдвал:

Seiime(Hegoreh Dogori[^] h hea cO Blbet forhieeO .

Seiia frdenidO Deleh iia Hoi(Do* folea Hodeldogecioa coeeteeeO

Segerea DoroiideeeO ce(Do* BiKda Dodegea Deiisoa BleeO

Seiijirea DehehsileKk ce(Do* BiKda frhecea NoiK* BleeO

Ийм бадаг 32 байна. Мөн солбиулан сүүл холбосон нь:

fKrida begesO Simekck bedege% t yerO foilO DoreleyO .

Frki[^] beldO ioihel ceceit Do* Dorelenoh h t

Fna Bloeesea Deneit ooa yerO foilO DoreleyO

Frdemdea yekt Merkeoa frde^ do* DorelemoI hT

Эрдэмтэн их мэргэд эрдэмд дурлана за

Эс болсон тэнэгүүд ер үл дурлаюу

Эрхэм балт цэцэгт зөгий дурлана за

Үүрд баас шимэгч батгана ер үл дурлаюу

Ингэж солбиулан сүүл холбосон бадаг 20 байна. Мөн нэг болон гуравдугаар мөрийг сүүл холбосон нь байна.

Heria femia bih t ba DebciijO yeht iobleit fdleK MedO .

Hera iorieedO ieri^ Deneit ooa hereit iiea fsa BidobesO

Heria foibe* oa felbedO bea Demeh cegejelea iobegeyO

HedegO yeBdeIdO MegO Noyeoa Deiisoa Lo) t focirebesO

Ийм бадаг 84 байна. Дөрөвдүгээр шадын эцэст мэт гэдэг үг заавал ороод байгаа учир уг бадгуудыг солбин сүүл холбоход саад болсон бололтой. Гэхдээ монгол бичгээр нь энэ бадгийн сүүл холбоцыг үзвээс бүгд “у” эгшигээр төгссөн нь харагдаж байна. Бичгийн үүднээс үзэхүл бүтэн сүүл холбожээ. Харин дуудлагаар нь бол гийгүүлэгчүүд дээр цохилт ногдож байгааг харгалзах хэрэгтэй болов уу гэж бодном. Хоёр, дөрөвдүгээр бадгийг сүүл холбосон нь 27 байна.

Бадгийн нэг, хоёрдугаар мөрийг эн зэрэгцүүлэн холбосон нь 30 байна.

Бас бадгийн эхний гурван шадыг сүүл холбосон нь ч байна.

Feit oa Modoa cO B;bet Kimoa DoreleeeO MedO .

FndO Meleh t fegola fca forgoeesea moia BlbesO

Fke& yego^ t foiheh Kimoa Seiiieea helebecO

fdA me& Deh beyea Kimoa O helehsea h SonoseeO

Ийм бадаг 5 байна.

Бадаг хоорондын холбоц ашигласан ч ажиглагдаж байна. Ийм холбоц 4 байна.

Гэтэл Соном-гара, Дамбийжалцан нарын орчуулга толгой болон сүүл холбосон зүйл огт үгүй аж. Үүгээрээ ч Цахар гэвшийн дуун хөрвүүлэг өрөөл бусдаас өөрийн эрхгүй ялгарч байна.

Гунгаажалцан зохист аялгууч бээр “Субашид”-ын төгсгөлийн үгнээ бичихдээ: “...Манзушрийн гэрлээр оюуны лянхуагийн навч өчүүхэн нээгдэж, дууны ухаан ба учир шалтгааны ухаан ба яруу аялгуу, холбон найруулах ба үгсийн чимэг ба бурханы сайн зарлигаас алдаршсан олонхи судруудыг сонсон мэдэж, дотроо багтаагаад дадан үйлдсэнээр

эш ухаан ба увьдсын утгыг алжаас буруу үгүйеэ мэдэх оюуны гэгээнийг олсон, номлох, зохиох, бясалгахад сайн самбаат...зохистойгоор өгүүлэгч Гунгаажалцанбалсансамбуу хэмээгдэх бээр...сайтар найруулсан..." (22.92) гэжээ. Чингэхлээр төгс эрдэмт, төгөлдөр билигт тийм хүн л "Субашид"-ыг дуун хөрвүүлнэ гэсэн үг юм. Тийм ч учраас монгол гүүш, дуун хөрвүүлэгч нар "Субашид"-ыг орчуулан авьяас чадлаа сорьж байсныг дээр цухас дурдсан долоон орчуулга гэрчилнэ. Гэвч эдэн дундаас чухамхүү Гунгаажалцаны цохон дурдсан эрдэм, авьяасаар цолгорсон нь Цахар гэвштэн, монгол түмний сэтгэл зүрхэнд хүрч түгэн дэлгэрсэн нь гэгээнийг олсон түүний дуун хөрвүүлэгч байлаа. "...Хэлмэрчлэгдсэн номлолд номхогдохуун эрхтэн...чихнээ сонсохуйд яруу, зүрхэнд буух тодорхой бөгөөд хуйлуулсан мэдэхүйеэ барилдлагын эв найр сайн бөгөөд эндүүрэх ба дахих, ба сандрах үгүй тэргүүтэн олон гайхамшиг ялгал лугаа төгссөнийг сайтар номлон зохиосноор шударга агч болоод шинжлэл лүгээ төгссөн ард нугуудын сэтгэлийн бат нь эрхгүй булаагаад сүсэглэх хийгээд баясах ба гайхамшигт болохын дүр байдал нугууд нааш цааш тэнцэлдэхүй мэт аригдах болсон..." (23.223) гэж мөнөөхөн намтарт өгүүлснийг тайлбарлалтгүй. "МГО"-д "...монголын хэлэн дүр хотлын алдаршсан бөгөөд их чадалт сэтгэлийг хөдөлгөн чадахуйг учир дур хүрсэн үгээр орчуулагдахуй" (24.21a) гэж буй. Эрдэнийн гэгээний намтрын энэ өгүүлбэр, "МГО"-ны энэ өгүүлбэр хоёрыг жишин үзэхэд Лувсанчүлтэм гэгээнтэн "Субашид" хийгээд бусад дээдийн номыг ард олныхоо сэтгэлийг хөдөлгөн чадахуйц дуун хөрвүүлсэн байна. Тийм чиг учраас хотол зоны зүрхний гүнээс "Сонсоё гэвэл Субашид" гэсэн сайхан хэллэг ундрал гарсан буй заа. Энэ бол дуун хөрвүүлгийн голт зүрхэн бөлгөө.

Буриадын Номтын Ринчен гүүш "Яруу хэлний хүрхрэл" зохиолдоо "Мэргэд гарахын орон"-г "...хойно орчуулагчин нугууд тур сайн зарилгийн дохионы утгасыг үзэхүй нүдэн болгов" гэж бичжээ. Бидний хэлмэрч орчуулагч хэмээн ойлгодог "лозава" гэдэг самгард үг үгчлэн орчуулбаас "ертөнцийн мэлмий" гэсэн үг юм байна. Үнэхээр ертөнцийн ард түмнүүдийг бие биенийх нь түүх соёл, урлаг утга зохиолтой танилцуулах нандин алба гагц дуун хөрвүүлэгч нарт л заяасан байдаг. Тиймээс тэднийг ертөнцийн мэлмий гэж өргөмжлөн дуудахаас ч аргагүй юм уу.

"Ертөнцийн мэлмий" "эрднийн гэгээн" Цахар гэвш Лувсанчүлтэм бээр "орчуулагчин нугуудын үзэхүй нүдэн" болсон "Мэргэд гарахын орон"-ы эшийн зарчмыг баримтлаж "яруу үгт, утга сайт бичиг"-үүдийг "дуршил төрсөн"-ий эрхээр оюунаараа найруулан дуун хөрвүүлж байсныг цухасхан өгүүлбээс ийм буюу.

Үүнийг бүтээснээс болсон хиргүй буян

Эрхэн тунгалаг колти сарны гэрэл нийлсэн мэт түүгээр

Эх болсон хамаг амьтаны мунхагийг арилгаад

Эрдэм билгийг хүсэгчдийн оюуны гумудаг дэлгэрүүлэх болтугай гэж "оюуны лянхуагийн навч...нээгдсэн" Гунгаажалцан ерөөн шүлэглэжээ. Нээрээ цоорхой эрдэмт Цахар гэвшийн энэ гайхамшигт дуун хөрвүүлэгч ч гурван зуу гаруй жилийн туршид монгол

түмний мунхагийн харанхуйг арилгаж, эрдэм билигт шамдагчдын оюуны гумуда цэцгийг дэлгэрүүлэн ирсэн агаад манай хойч үеийн үр саад ч мөнхөд тийн зохиох болмуй. Лам эрднийн гэгээнтэн Таны “өлмийг оройгоороо тахису”, молхи би.

Анхааран чагнасанд гялайлаа.

Ном зүй

1. Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, УБ, 2007
2. Мөн тэнд
3. Мөн тэнд
4. Мөн тэнд
5. Саж бандид Гунгаажалцан, Эрдэнийн сан Субашид, Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулга, Хэвлэлд бэлтгэсэн Ц.Дамдинсүрэн, Ж.Дүгэржав, УБ, 1958
6. Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, УБ, 2007
7. Ш.Сонинбаяр, Номын мэргэдийн өлмийд сөгдөмү, Яруу найргийн орчуулгын түлхүүр, Эрхэлсэн Г.Мэнд-Оёо, УБ, 2008
8. Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршивой, Буриад модон бар
9. Мөн тэнд
10. Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, УБ, 2007
11. Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршивой, Буриад модон бар
12. Мөн тэнд
13. Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, УБ, 2007
14. Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршивой, Буриад модон бар
15. Л.Хүрэлбаатар, Монгол орчуулгын товчоон, УБ, 1995
16. Мөн тэнд
17. Мөн тэнд
18. Мөн тэнд
19. Б.Ринчен, Сондгойруулахгүйг эрхэм болгохуй, Марк Твений минь махыг идэж дээ, УБ, 1991
20. Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршивой, Буриад модон бар
21. Мөн тэнд
22. Мөн тэнд
23. Саж бандид Гунгаажалцан, Эрдэнийн сан Субашид, Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулга, Хэвлэлд бэлтгэсэн Ц.Дамдинсүрэн, Ж.Дүгэржав, УБ, 1958
24. Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, УБ, 2007
25. Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршивой, Буриад модон бар
26. Ordinary Wisdom, Sakya Pandita's Treasury of Good Advice, Translated by John T.Davenport, Wisdom Publications, Boston, 2000

Орчуулгыг журамлах санал

Ш.Эгшиг² (МУИС, ШУС)

Товч агуулга: Эдүгээ даяаршин буй цаг үед эх хэлнийхээ асуудлыг хэвэнд нь оруулах гэж нэг үеэ бодвол мэрийцгээж байна. Энэ асуудалд өрөөсөн даль жигүүр нь мэт заавал анхаарч, эмхлэн сайжруулах нэг асуудал бол орчуулгыг эмхлэн журамлах тухай болно. Үүнийг хийхэд эхний ээлжинд хийгүүштэй ажлын санал бол орчуулгын ажлыг жишигжүүлэх тухай юм. Энэ мэтээр одооноос орчуулгын асуудлыг шат дараалалтайгаар цэгцлэх нь зүйтэй юм хэмээсэн санааг энэхүү илтгэлд дэвшүүлээ.

Түлхүүр үг: Орчуулгын стандарт, орчуулгазүй, орчуулгын жишиг, шалгалтын тогтолцоо, орчуулга захиалагч, мэргэжлийн зэрэг

Сүүлийн үеийн олон эрдэм шинжилгээний хурлын илтгэл сонсож, эрдэмтдийн бүтээлийг үзэхэд, тухайлбал, эх хэлний болон орчуулгын асуудал гарвал, эх хэл маань булингартаж байна, эх хэлээ хамгаалах юмсан, гадаад үг орж ирээд, эх хэлний үгийн орон зайг нь эзлээд, залуус нь бичиг соёлоо мэдэхээ болиод, гадны соёлд автлаа гэх болжээ. ‘Дээдэс нь суудлаа олохгүй бол доодос нь гүйдлээ олохоо больчихсон’ тэр цөвүүн цаг нь үнэхээр иржээ гээд суугаад байлтай нь биш. ‘Амьд хүн аргатай’ хэмээдэг шиг аргаа олох гэж хичээвэл яасан юм бэ гэж сүүлийн үед бодогдох болов. Ямар ч байсан зүгээр байснаас юмыг яаж мэдэх вэ, ‘олны хүч оломгүй далай’ гэдэг шиг олон сайхан санаа нийлж, эх хэлээ тунгалаг болгож, хүн төрөлхтний соёлын шавхагдашгүй өв сангаас эх хэлээрээ сайхан орчуулга уншдаг болно гэсэн сайхан хүслээр жигүүрлэн хэлсэн үг минь амилж, санаа нийлсэн гэгээлэг хүмүүсийн хүчин зүтгэлээр дээрх байдал сайжраасай хэмээн хүснэм.

Эх хэлний боловсролыг өнгөрсөн зууны жараад оноос сааруулж, сүүлийн хориод жил зөнд нь хаяж, гадаад хэлний сургууль байгуулцгааж, дур дураараа хэлний дүрэм зохиож, ‘ерөнхий’ хэмээх элсэлтийн шалгалтанд гадаад хэлээр шалгах болсоор, гадны соёлд шүтэн хошуурснаас монгол хэлээрээ зөв найруулгатай бичиж чаддаг албаны хүн нь хомс болоод, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ч эх хэлээр алдаа мадагтай бичих нь хэрээс хэтэрсэн үед төрийн зүгээс аргагүй анхаарахаас өөр аргагүй болж, ашгүй нэг энэ жилээс ерөнхий шалгалтыг монгол хэлээр шалгах болсон гэж дуулдаж байна. Засгийн газраас дэмжсэн зөв бичгийн дүрмийн толь зохиох төсөл ч хэрэгжих төлөвтэй. УИХ-ын гишүүн М.Батчимэг зэрэг 4 гишүүний санаачилсан “Монгол хэлний тухай хууль” одоо ид дуншиж байна. Энэ мэтээр эх хэлний асуудал нэг үеэ бодвол зөв гольдролдоо орж байх шиг байна. Үүний хамтаар хэлд нөлөөлөх гадны соёл ба орчуулгын хэлний асуудлыг бас журамлаж байж,

² МУИС-ийн ШУС-ийн ази судлалын тэнхим, дэд профессор, доктор

эх хэлний цэвэрших, тунгалагших асуудлыг бүрэн цогцоор нь шийдэх нь лавтай. Тэгэхээр орчуулгыг журамлах саналаа энд дурдсу.

Орчуулгын асуудлыг хэрвээ журамлах гэж байгаа бол яаж журам тогтоох вэ, тогтоосон дүрэм журмаа хэрэгжүүлэх, мөн хяналт тавих хамгийн зөв хувилбар юу байж болох вэ гэдгийг бодолцох нь зүйн хэрэг. Энэ дашрамд өгүүлэхэд, орчуулгын үйлчилгээний үйлдвэрлэл дэлхийн хэмжээнд ихээхэн үр дүнтэй үйлдвэрлэлийн нэг болоод байгаа аж. Тухайлбал, 2002 онд энэ салбарт дэлхий нийтээрээ 22.7 тэрбум ам.доллар, харин 2013 онд 38.1 тэрбум ам.долларын хэмжээтэй орчуулгын үйлчилгээ үзүүлсэн гэсэн тоо байна. Манай улсад энэ тооцоог хийсэн эсэх дээр мэдээлэл олдсонгүй, гэвч ямар ч байсан дэлхийн хандлага, жишгийг даган орчуулгын ажил ихэссэн нь мэдээж, ялангуяа сүүлийн үед хэвлэгдэн гарч буй орчуулгын ном зохиолоор л бодож үзэхэд илт өссөнийг бэлхэнээ мэднэ. Энэхүү өсөлтийн цаана чанар байгаа юу гэдэгт бид зүй ёсоор анхаарах нь зүй гэснээс саналаа тавьж байна. Дээрх орчуулгын асуудлыг улсын хэмжээнд журамлах ажлыг гүйцэтгэхэд ямар зөв хувилбар байж болох вэ гэдэгт анхаарвал зохилтой.

Дэлхий дахины хөгжингүй хэмээгдэх орнуудад орчуулгын жишгийг хэдийнээ тогтоожээ. Тухайлбал, Европын холбооны орнуудад орчуулгын чанарын стандартыг мөрддөг бөгөөд энэ нь тодорхой дэс дараалалтай үйл явц байдаг. Энэхүү чанарын стандартыг бичгийн орчуулгад голдуу хэрэглэдэг.

Стандарт нь **нэгдүгээрт**, орчуулгын үйлчилгээ үзүүлэх аль нэгэн хуулийн этгээдийн хүний нөөц ямар байх талаарх үндсэн шаардлага байна. Энэ шаардлагатай уялдан тэрхүү хүний нөөцийг сонгон шалгаруулах шалгалтын тогтолцоог мөн бүрдүүлэн тогтоосон байх ёстой болно. **Хоёрдугаарт**, орчуулга захиалагч ба орчуулагчийн хооронд үүсэх харьцааг зохицуулах асуудал, үүнд энэ хоёр хуулийн этгээдийн хооронд гэрээ хэлцлийн харьцаа үүснэ. **Гуравдугаарт**, орчуулах үйл явц орно. Эдгээрийг тус бүрээр нь тодруулбал, хүний нөөц ба орчуулгын үйлчилгээ үзүүлэгч компанийн шалгуур ба энэхүү үнэлгээг хийх, хаанаас үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгох зэргийг тогтооно. Мөн үүнд тохирсон шалгалтын тогтолцоо буй болсон байх нь зүй. Орчуулга захиалагч ба орчуулгын үйлчилгээ үзүүлэгч хоорондын харьцаа нь эхлээд орчуулга захиалагч тодорхой маягтын дагуу хүсэлт гаргах, үүний дагуу орчуулгын үйлчилгээ үзүүлэгч өөрийн чадварт тэрхүү хүсэлт, шаардлага нь нийцэх эсэхийг тогтоон, хэрвээ үйлчилгээ үзүүлэгч тал орчуулж чадна гэдгээ мэдэгдвэл үнийн санал дээр тохиролцоод, гэрээ хийнэ. Гэрээ хийх явцад хоёр талд шаардлагат мэдээлэл чухам юу болох талаар тодорхой зааж өгнө. Орчуулах гэдэгт

- Тухайн орчуулгын төслийг хийх
- Бэлтгэл үйл явц
- Орчуулах гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Төслийг хийсний дараа орчуулж эхлэхээс өмнө энэхүү төслөө орчуулгын чанарын үнэлэлт өгөх байгууллагад ийм төсөл хэрэгжих гэж байна гэдгээ бүртгүүлэх, тухайн төслийн

эх зохиол юм уу бичвэрт шинжилгээ хийх, шаардлагатай нэр томъёоны сан бэлдэх, утга зохиолын ямар төрлөөр орчуулга хийх зэргээ тодруулна. Орчуулах үйл явц нь,

- Орчуулах,
- Орчуулсан этгээд өөрөө шалгах,
- Ариутган шүүлгэх,
- Шүүмж хийлгэх,
- Хэвлэхийн өмнө унших,
- Зөвшөөрөл авах гэсэн үе шатаар явна.

Хамгийн сүүлийн шатанд зөвшөөрөл авах үйл явц нь анх орчуулгын төсөл хэрэгжих гэж буйгаа бүртгүүлсэн тэр байгууллагаас авдаг туршлага гадаадад дэлгэрмэл байгаа юм.

Гадаадын орчуулгын стандартын гол агуулга нь бүгд ерөнхийдөө дээрх мэт ижил агуулгатай, гагцхүү улс тус бүрийн жишиг тогтоох, хэмжилзүйн шалгуурын ялгаатай байдлаар нэршил, дугаарлалт нь өөр өөр байгаад байна. Европын холбооны бүх улс европын холбооны стандартын байгууллагаас гарсан 2006 оны EN15038 гэдэг жишгийг мөрдөхийн хамт мөн өөрийн оронд стандарт тогтоолгон мөрдөж байна. Тухайлбал, PKN EN 15038 Польш, BS EN 15038 Их Британи, DIN EN 15038 Герман, NF X50-670 Франц, OENORM EN 15038 Австри, SN EN 15038 Швейцарь, UNE-EN 15038 Испани, SFS EN 15038 Финлянд, UNI EN 15038 Итали, EVS-EN 15038 Эстони, MSZ EN 15038 Унгар, SS-EN 15038:2006 Швед, SR-EN 15038 Румын, BDS EN 15038 Болгар гэсэн стандарттай байна. АНУ-ын орчуулгын чанарын стандарт ASTM F2575-06 мөн 2006 онд анх хэвлэгдэн гарч, энэ салбарын компаниуд шаардлагын дагуу ажиллаж эхэлсэн байна. Чухамхүү стандарт тогтоох ажлыг бүр 1998 онд Вашингтонд болсон орчуулагчдын хурлын үеэр үндэсний орчуулгын нэгдсэн стандарт бий болгох талаар ярьж эхэлсэн үеэс эхэлсэн гэдэг байна. 2009 онд Канадын орчуулгын чанарын стандарт CAN/CGSB-131.10-2008-ыг тус улсын Стандартын хорооноос баталсан байна. Үүний бэлтгэл ажилд AILIA буюу Канадын хэлний нийгэмлэг, мэргэжлийн нийгэмлэг холбоод, Засгийн Газар, ШУА, орчуулгаар үйлчлүүлэгч байгууллага болон сонирхогч бүлгийнхэн оролцон боловсруулалцсан байна.

ОХУ-ын хувьд бичгийн орчуулгын чанарын стандарт гэж батлагдсан зүйл одоогоор байхгүй боловч, бусад стандартуудаар (ГОСТ 7.36-88. Неопубликованный перевод. Координация, общие требования и правила оформления, ISO 2384-77. Документация. Оформление переводов) зохицуулагдан явж иржээ. Харин энэ талд тухайлбал, Украинд орчуулгын стандарт (**СТТУ АПУ** 002-2000) хэдийн буй болсон байна.

БНХАУ-д орчуулгын стандарт тогтоох ажил³ 2001 онд эхэлжээ. Анх Хятадын КНТХ-ны Марксизм-ленинизмын сонгодог зохиолуудыг судлан орчуулах товчоо, Жянсу мужийн

3 张南军 “中国翻译行业首部国家标准的制订” 中国译协网 http://www.tac-online.org.cn/ch/tran/2009-09/24/content_3154380.htm

ШУТ-ийн орчуулагчдын нийгэмлэг, Тяньжин хотын “Энхтайван” лавлагаа орчуулгын компани, Жянсу мужийн “Жуншань” орчуулгын компани зэрэг байгууллагаас Наньжин хотод 2001 оны 8 сарын 23-нд зохион байгуулсан “Бүх Хятадын анхдугаар удаагийн орчуулгын ажлын эрхлэн хөтлөлт ба удирдлага” хэмээх зөвлөгөөнөөр орчуулгын ажил урсгалаараа, замбараагүй, тулгамдсан асуудал олон байгаа зэргийг хэлэлцэн, эхлээд энэ бүхнийг цэгцлэхийн тулд орчуулгын жишиг-стандарт тогтоох нь зайлшгүй болсон талаар зөвшилцөн, бэлтгэл хороог байгуулан, судалгааны ажлын баг байгуулагдан ажилдаа орсон байна. Мөн оны 11 сард “Орчуулгын үйлчилгээний стандарт”, “Орчуулгын ажлын үгийн тоо тооцох стандарт”, “Ариутган хянах чанарын стандарт” гэх мэт 13 стандартын санал боловсруулан хэлэлцүүлж, 2002 оны сүүлийн хагаст улсын стандартын байгууллагад өргөдөл гарган, бүртгүүлэх, хянуулах, зөвшөөрөл авах зэрэг олон үе шаттай ажлыг хийхийн зэрэгцээ 2002 оны 11 сард Шанхай хотод “Бүх Хятадын хоёрдугаар удаагийн орчуулгын ажлын эрхлэн хөтлөлт ба удирдлага” хурлаа мөн хийсэн байна. Энэхүү стандарт батлуулах шаардлага өндөр, олон шат дамжлагыг даван 2003 оны 11 сарын 27-нд Улсын Стандартжуулалтыг эрхлэх хорооноос “Орчуулгын үйлчилгээний нэгдэх бөлөг: Бичгийн орчуулгын дүрэм”⁴ (GB/T193.1-2003) улсын стандартын зөвшөөрөл олгож, улсын стандартаар нийтэд зарлажээ. Энэхүү стандарт нь “анхны стандартын дугаар нь хэвээрээ боловч, нэгдэх бөлгийн “бичгийн орчуулга” дээр хоёрдахь бөлөг “хэлмэрчлэхүй” гэсэн бөлөг нэмэгдэж, “Хятадын орчуулгын үйлчилгээний улсын стандарт” гэдэг нэртэйгээр одоо мөрдөгдөж байгаа юм. 2005 оны 3 сарын 24-нд “Орчуулгын үйлчилгээний орчуулгын чанарын шаардлага” хэмээх улсын стандарт мөн батлагдан гарчээ. Энд нэгэн маш сонирхолтой нэгэн зүйлийг дурдалгүй өнгөрмөөргүй байна. Дээрх “Хятадын орчуулгын үйлчилгээний улсын стандарт” хамгийн эхэндээ тэрхүү стандартыг гаргахад Германы DIN2345 гэдэг стандартыг жишиглэн ашигласан гэдгээ тодорхой дурдсан байна. Ерөөс, дэлхий дээр Европын холбооны орчуулгын чанарын стандарт гарахаас өмнө Италийн UNI105748, Германы DIN2345, Австрийн Цnorm D 1200 ба Цnorm D 1201 стандартууд шалгарсан шилдэг стандартууд байсан гэж үздэг. Чингэхээр Хятад улсын орчуулгын стандарт ч гэсэн өмнө өгүүлсэн Европын ба АНУ, Канадын жишигтэй үндсэн агуулга нь ерөнхийдөө адил гэсэн үг юм.

Мөн Их Британи, Умард Ирландын нэгдсэн Вант улсын хамтын нөхөрлөлийн орнуудад орчуулагч, хэлмэрчийг сургах, бэлтгэх хийгээд шалгалтын цогц бодлоготой тул энэ мэргэжлээр ажиллах хүсэлтэй хүн зайлшгүй эзэмших мэдлэг ба дадлыг эзэмшүүлдэг сургуульд нь сурч төгсөөд, мэргэжлийн зэргийн шалгалтыг шат ахин өгч, гэрчилгээг гардан авч чадсанахаа хойно ажилд орох, мөн ажлын байрны санал хүлээн авах эрхтэй болдог. Нэгэнт ингэж мэргэжлийн чадвараа баталгаажуулах нь хувь хүн болоод байгууллагын эрэлт ба нийлүүлэлтийг хангах чанарын баталгаа болдог тул тухайн орнуудад орчуулагч,

4 中华人民共和国国家标准GB/T 19363.1-2003

хэлмэрчдийн мэргэжлийн ба сайн дурын нийгэмлэг холбоодын нэр хүнд нь ч өсч, нөлөө нь ихэсдэг талтай.

Дэлхийн гол гол улсуудад орчуулгын чанарын жишиг тогтсон байгаа тул бид бас дотоодод энэ стандартыг тогтоох ажлыг гардан хийх шаардлагатай байна. Үүний тулд орчуулгын ажил хийдэг, хийлгэдэг аль ч тал нь оролцож нэгдсэн хүчээр хийгүүштэй байна. Үүнд, Засгийн Газрын төлөөлөх байгууллага, орчуулагчдын эвлэл, холбоо, нийгэмлэгүүд, орчуулгын үйлчилгээ эрхэлдэг компаниуд, орчуулгын судалгаа сургалт явуулдаг байгууллага болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, ТББ-ууд нэгдэн саналаа өгч хийгүүштэй байна. Орчуулга журамлах үйл явц гагц стандарт тогтоохоор хязгаарлагдахгүй, гэвч эхний удаа олон юм хөөцөлдөж сатааралгүй, энэхүү жишиг тогтоох асуудалд нэг хүчээр орвол ямар вэ.

Энэхүү жишиг тогтоох нь, хэнбэгуай нь ч орчуулгын үйлчилгээ эрхэлдэг, орчуулсан номоо ариутган шүүлгэхгүй, дур дураар хэвлүүлдэг тэр байдлыг халан цэгцлэж, нэгэн сувгийн орц гарцтай болгон, стандартаар зохицуулах боломжтой болох юм. Энэ тухай бид ярьж байгаа нь шинэ мэт боловч, угтаа монгол орчуулгын уламжлалд эртнээс байсан зүйл. Шинэ юм бол ихэд мартагдсан хуучин юм байдаг. Их бага таван ухааны хэдэн мянган зохиол бүтээлийг багтаасан “Ганжуур” (110 боть), “Данжуур” (275 боть)-ыг орчуулахын урьдал болгож, дуун ухаан, учир шалтгааны ухаан, урлахуй ухаан, тэжээхүй ухаан, дотоод ухааны бүх нэр томъёог нэгэн янзаар орчуулах зарчмыг буй болгосон бүтээл бол “Мэргэд гарахын орон” алдарт толь болно.

Эцэст нь тэмдэглэхэд, цаашид хийх ажил олон боловч гол ажлуудаа хийж, зөв чиглэл рүү нь хандуулаад дараа нь орчуулгазүйн чиглэл тус бүрт чиглэсэн ажлаа хийж явъя гэж хэлэх байна.

Номзүй

1. Ц.Шагдарсүрэн, Эх хэлээ эвдэхгүй юм сан, УБ, 2010
2. Б.Цэнддоо, Монгол үгээ монголоор бичих үү. Яах уу?, Монгол хэлбичиг, VIII боть, УБ, 2009
3. Э.Пүрэвжав “Монгол хэлний хэм хэмжээ судлал”, Mongolica, Vol.46, 2013 20-34-р тал.
4. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ-6, УБ, 2007
5. Н.Балжинням, Монгол хэлний хятад ормол үгийн судалгаа, УБ, 2011
6. Г.Аким, Нэр томъёо орчуулах асуудалд, Орчуулах эрдэм, УБ, 1986
7. Nigel Armstrong and Ian E. Mackenzie “Standardization, Ideology and Linguistics”, Palgrave Macmillan, NY, 2013

8. Steven M. Spivak and F. Cecil Brenner “Standardization Essentials: Principles and Practice” NY, USA, 2001
9. 翻译服务规范(第2部分):口译(GB/T 19363.2-2006) 北京, 2006
10. 翻译服务规范(第1部分):笔译(GB/T 19363.1-2008) 北京, 2008
11. European Standard, Final draft, prEN 15038, Translation services-Service requirements, European Committee for Standardization, Brussels, Ref. No. prEN 15038:2006:E

Summary

The author conducted the recent Mongolian mother language situation and translation quality to influence all Mongolian social life. Therefore she brings forward to develop translation quality standard that could be the key of the improvement action to over all education and media language. In the article mentioned about European standard for translation services, requirements and other standard developing experiences in the countries, as China, Russia, Canada and The Commonwealth as well.

Ардын аман зохиолыг англи хэлэнд орчуулсан нэгэн бүтээлийн талаар

Л. Чулуунбаатар⁵ (МУИС, ШУС)

Товч утга: Ардын аман зохиол эртнээс уламжилж ирсэн, өвөрмөц утга зохиол бөгөөд арвин баян сантай. Тийм болохоор бусад ард түмэн эртнээс нааш уншиж судлахыг эрмэлзсээр ирсэн билээ. Түүний нэг илрэл нь монголын эртний түүх, уран зохиолын дурсгал болох “Монголын нууц товчоо”-г дэлхийн олон орны хэлээр орчуулан судалсаар байна. Англи хэлээр 10 гаруй орчуулга байдаг. Мөн монгол ардын аман зохиолыг эмхтгэн орчуулж гаргах ажлыг нэг биш удаа хийж байна. Түүний нэг жишээ бол нэрт монголч эрдэмтэн Хангины Гомбожав нарын АНУ-д 1998 онд орчуулан хэвлүүлж гаргасан Монгол ардын аман зохиол нэртэй бүтээл юм.

Түлхүүр үг: Орчуулга зүй, монгол англи орчуулга, ардын аман зохиол, *Mongolian folklore*, Хангины Гомбожав

1328 оны орчим Билиг Цогт хэмээн хүний “Долоон өвгөний одонд даатгасан тухай шүлэг”-ийг монгол хэлнээс Алин Төмөр уйгараар, өөр нэг орчуулагч төвд хэлээр орчуулж байсан мэдээ байдаг.⁶ Төвдөөр орчуулсан хүнийг бандида Чойжи-Одсэр байсан хэмээх таамаг ч буй. Түүнээс хойш хэдий хирийн зохиол бүтээлийг монгол хэлнээс өөр бусад хэлэнд орчуулж гаргасныг тооцоолж гаргасан мэдээ энэ хир алга байна. Тийм болохоор энэ сэдвээр нэг докторын ажил байж л байна гэсэн үг юм. Энэ талаар судалсан судалгаа ч ховор байна. Гэхдээ таван нуруунд багтахар бас хэдэн юм байна. Монголын уран зохиолын бүтээлийг гадаад хэлэнд, тухайлбал англи хэлэнд хэрхэн орчуулсан талаар тухайлан судалсан ганц сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний бүтээл ганцхан байгаа бөгөөд Т.Гомбосүрэн 1979 онд “Монголоос англи хэл рүү орчуулах онол практик” хэмээх сэдвээр ЗХУ-ын ШУА-ын ДДС Тэнхимд хэл шинжлэлийн ухааны дэд докторын зэрэг хамгаалсан байна. Мөн Монголын уран зохиолыг орос хэлнээ яаж буулгасан талаар тусгайлан судалсан эрдэм шинжилгээний бүтээл хоёр байна. 2007 онд ХУИС дээр Ч.Жаргалсайхан “Д.Нацагдоржийн зарим зохиол, бүтээлийн зарим орчуулгын шинжилгээ” хэмээх сэдвээр хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Манай нэрт зохиолч Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романы орос орчуулгын материал дээр тулгуурлан 2008 онд ОХУ-ын Улаан Үүд хотод “Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романы монголоос орос хэлэнд орчуулсан орчуулгыг соёл хэлшинжлэлийн үүднээс авч үзэх нь” (Лингвокультурологические аспекты перевода с монгольского языка

⁵ МУИС-ийн ШУС, профессор, доктор

⁶ Л.Хүрэлбаатар, Монгол орчуулгын товчоон, УБ, 1995, х 5

на русский :на материале перевода романа Ч. Лодойдамбы «Тунгалаг Тамир) сэдвээр Д.Цэдэнжав хэмээх хүн хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хамгаалсан байна. 2012 онд манай нэрт орчуулагч Нацагдорж багшийн охин Оюун-Ундраа “Монгол яруу найргийг англи хэлнээ орчуулах асуудалд” нэртэй магистрын ажил⁷ бичиж Д.Данзанравжаагийн “Үлэмжийн чанар”, Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ”, “Туулын шугуй” шүлгүүдийг англи хэлэнд хэрхэн орчуулсныг задлан шинжилж, чамбай ажил туурвисан бөгөөд цааш нэг алхабал докторын ажил болоход бэлэн байгаа болой. Энэ магистрын ажлын эхэнд монгол өгүүллэг, шүлгийг англи хэлэнд орчуулсан орчуулгын тоймыг нилээд сайн бүртгэж гаргасан юм. Орчуулагчдын ихэнх нь монгол хүн байгаа болой. Монгол зохиол бүтээлийг англи хэлэнд хэрхэн орчуулсан талаарх эрдэм шинжилгээний бүтээл 1 докторын, 1 магистрын ердөө хоёрхон ажил байна. Гадаад хэлнээс монгол хэлэнд орчуулсан зохиол бүтээлийн талаар их анхаарахаас эх хэлнээсээ гадаад хэл рүү орчуулсан зохиол бүтээлийг шинжлэх талаар бага анхаардаг бололтой. Тийм болохоор манай орчин үеийн англи хэлт, авьяаслаг, эрдэмт сэхээтнүүд энэ хоосон орон зайг судалгаагаараа нөхөөсэй хэмээн хүсэх байна.

XX зуунд монгол зохиол бүтээлийг өөр хэлэнд орчуулж гаргасан мэдээнүүд нилээд бий. Үүнд хамгийн олон оронд олон удаа орчуулагдсан зохиол бол яахын аргагүй, монголчууд бидний бахархал болсон “Монголын нууц товчоо” хэмээх зохиол билээ. Одоогоор дэлхийн 30 гаруй хэлээр орчуулагдаад байна. Энэ дундаас ганцхан англи хэлээр орчуулсаныг цохон үзвэл 1950, 1957 онд Энэтхэгт хэвлүүлсэн Вей Куй Сун (Wei Kwei Sun) –ы орчуулга, 1963 онд Англид хэвлүүлсэн Артур Валэйн (Arthur Waley) хэсэгчилсэн орчуулга, 1965 онд Америкт хэвлүүлсэн Куо-Йи-Пао (Kuo-yi-Pao)-гийн орчуулга, 1971 онд АНУ-д хэвлэгдсэн П. Каан (P.Khan)-ы орчуулга, уг нь 50-иад оны сүүлээр орчуулж дууссан боловч 1982 онд АНУ-д хэвлүүлсэн Фрэнсис Вудмэн Клифс (Francis Woodman Cleaves) –ийн бүрэн орчуулга, 1990, 1993, 2001 онд Англид хэвлүүлсэн Английн монголч эрдэмтэн Онон Өргөнгөөгийн тайлбар сэлттэй хийсэн орчуулга, 2006 онд судалгаа, тайлбарын хамт хоёр ботиор Австралид гаргасан Игор дэ Рахэвилц (Igor de Rachewiltz)-ийн орчуулга, 2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулж гаргасан манай нэрт, ахмад орчуулагч Н.Доржготов, З.Эрэндоо нарын орчуулга гээд миний мэдэхийн 8 орчуулга байна. Манай хоёр ахмад орчуулагч гадаадын зарим эрдэмтэдийн алдааг залруулсан нь нэн сайшаалтай. Эдгээр 8 –аас дэлхийн монгол судлаачид иш татах дуртай орчуулга бол Фрэнсис Вудмэн Клифс болон Игор дэ Рахувилц нарын орчуулга байдаг. Монголын эртний уран зохиолын ноён оргил болсон Монголын нууц товчоог дэлхийн англи хэлтэн хүмүүст таниулахад эдгээр эрдэмтэдийн орчуулга нь үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэж байгаа буянтай сайхан үйлс гэдэгт хэн ч маргахгүй. Гэхдээ өрнөдийнхөнд Монголчууд XIII зуунд хүний мах идэж байсан гэх ойлголт өгөхөөр дээрх бүх орчуулгаас харагддаг юм. “Монголын нууц товчоо”-г шүүрдэж үзвэл зэрвэс харсан хүнд хүний мах иддэг гэсэн мэт мэдээлэл 7-р бүлгийн 195 –р зүйл,

7 Н.Оюун-Ундраа, Монгол яруу найргийг англи хэлнээ орчуулах асуудалд, Магистрын ажил, УБ., 2012 он

11-р бүлгийн 251-р зүйл хоёрт байна. Эхний 7-р бүлгийн 195-р зүйлд Найманы цэрэгтэй цуг морилж явсан Жамухаас “олон хонийг хотонд ортол хөөж ирэх мэт эд юун хүмүүс айсуй” хэмээн Таян хаан асуухад “Тэмүжин анд минь дөрвөн нохдыг хүний махаар тэжээж, гинжилж уяж байх бүлгээ”, “Алалдах өдөр амьтны мах иднэ, хүрэлцэх өдөр хүний мах иднэ” хэмээн хариулж байна. Мөн дараа нь Хасарын тухай асууваас “Өгэлүн эх нэг хүүгээ хүний махаар тэжээж бүлгээ” гээд тэр хүн нь “Хоромсогот хүнийг хотлоор нь залгиваас хоолойд нь үл торъюу, хөвчин эрийг үмхвээс өл үл залгъюу” хэмээн хариулаад Найманаас хагацан бултаж гарч Чингис хаанд Даян хааныг “амаар алагдан, айж мэгдэж байна, хатууж”⁸ хэмээн хэл өгүүлжээ. Энэ нь үлгэр домгийн хэтрүүлгийн дүрслэлийг зохиогч оруулж өгсөн эсвэл Жамух есөн өрлөг жанжин болон Хасар баатрын хүч чадлыг аугаа их болгож үзүүлэхийн тулд ийнхүү үлгэр домгийн хэтрүүлгийн дүрслэлийг ашиглан хэлсэн байж болох юм. Ер нь тэгсэн гэдэг нь эндээс аяндаа харагдах бөгөөд монгол хүний хувьд бол маш тодорхой ойлгомжтой зүйл юм. Харин энэ зохиолыг англи орчуулгаар уншсан өрнөдийн хүн хүний мах идэж байсан хэмээн ойлгож болох талтай байна. Учир нь “Монголын нууц товчоо”-г англи хэлэнд орчуулсан И.Д.Рахэвилц /Igor de Rachewiltz/⁹, Ф.В.Клиавез /F.W.Cleaves/¹⁰ болон Онон Өргөнгөө /Urgunge Onon/¹¹, Н.Доржготов, З.Эрэндоо нарын орчуулгад яг тэр хэвээр нь ямар ч тайлбаргүйгээр хүний мах иддэг (to eat human flesh) хэмээн орчуулсан байна. Тэгэхээр үүнийг уншсан өрнөдийн уншигч монголчууд XIII зууны үед хүний мах идэж байжээ хэмээн ойлгож болох талтай байна. Тэр ч бүү хэл монголч эрдэмтэн, монгол хүн Онон Өргөнгөө, Н.Доржготов, З.Эрэндоо нар ямар нэг тайлбаргүй тэр чигээр нь орчуулсан байна. Тэгэхээр өрнөдийнхөнд монголчууд хүний мах иддэг байсан хэмээх ойлголт төрүүлсэн нэг буруутан бол орчуулга байна гэж үзэх гээд байгаа юм. Энэ талаар би 2006 онд Улаанбаатар хотноо болсон Олон Улсын Монголч эрдэмтэдийн хуралд тавьсан “XIII зууны үед Монголчууд хүний мах иддэг байв уу?” хэмээх өгүүлэлдээ дурьдан бичсэн билээ.¹² Давхар тайлбар хийж орчуулсан бол ийм эндүүрэл гарахгүй байсан болов уу.

Манай нэр зохиолч Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” роман дэлхийн олон оронд орчуулагдсаны дотор англи хэлэнд орчуулагдсаныг нэг удаа уншиж байсан боловч одоо хир бүрэн эхээр нь олж үзээгүй байна. Орос хэлэнд орчуулсаны нь судалж шинжлээд эрдэм шинжилгээний бүтээл туурвисан байхад англи хэлэнд орчуулсаны нь судалж шинжлэх бүрэн боломжтой. Энд бас нэг докторын ажил эзнээ хүлээж байна.

Монгол ардын аман зохиолыг англи хэлэнд орчуулсаныг судлаачид тэр болгон хөндөн бичээгүй байна. Энэ удаад би өөрийнхөө үзсэн, уншсан 3 бүтээлийн талаар цухас дурдаад нэгийнх нь талаар бага зэрэг дэлгэрүүлэн ярих болно. Миний үзсэн анхны ном бол 1982 онд англи улсад Ричард Кавендиш (Richard Cavendish) –ийн эмхтгэж хэвлүүлсэн “Дэлхий

8 Монголын нууц товчоо, сонгомол эх, УБ., 2005, х 89-90

9 “The Secret History of the Mongols”, by Igor de Rachewiltz, The Australian National University, 1978, p 53-55

10 “The Secret History of the Mongols”, by F.W.Cleaves, London, 1982, p 125-127

11 “The Secret History of the Mongols”, translated, an noted and with an introduction by Urgunge Onon, London and New York, 2001, p 173-175

12 Л.Чулуунбаатар, “Буудуулаад эдгэнэ гэж үнэн үү?”, УБ., 2010, х 57- 68

дахины домог” буюу “Legends of the World” хэмээх ном юм. Уг номын Монголын хэсгийг Каралин Хамфри (Caroline Humphrey) бэлтгэсэн бөгөөд үүндээ “Гэсэр хаан”, “Чингис хааны домог түүх”, “Бух өвөг дээдэс”, “Домог болон өдөр тутмын амьдрал”¹³ хэмээх сэдвүүдийн дор домгийн үүсэл гарал, түүний бүтэц зэргийг домгуудаас иш татан тайлбарлах замаар бичиж оруулсан байгаа болой. Мөн өгүүллийн эхэнд “Монголын домог, шидэт үлгэр, аман түүх зэрэг нь Монгол соёлын салшгүй нэгэн чухал хэсэг байдаг” хэмээн үнэлэн бичсэн байдаг юм.

Хоёрдахь ном бол манай нэрт орчуулагч, Англи-монгол, Монгол-англи толь зохиогч Д.Алтангэрэлийн 1979 онд анх “Mongolian folktales and Stories” нэртэй орчуулгын бүтээлээ 1988 онд “How did the Great bear originate” хэмээх дахин гаргасанардын аман зохиолын орчуулгын түүвэр болой. Энэ бүтээлд нэрт монголч эрдэмтэн Оуэн Латимор (Owen Latimore) авгай өмнөх үг бичсэн бөгөөд “Аливаа ард түмний ардын аман зохиол бол тэр ард түмний түүхийн нэг хэсэг байдаг бөгөөд тэр ард түмний хэлний шижир алт нь энд байдаг” хэмээн онцлон дүгнэсэн бөгөөд монгол ардын аман зохиол бол энэ шижир алтны нэг бөгөөд энэ шижир алтыг орчуулж дэлхий дахинд монголчуудыг ойр дотно танилцуулж байгаад нь гүн талархал дэвшүүлэе”¹⁴ хэмээн онцлон сайшаасан байдаг юм. Энэ бүтээлд 25 домог, 23 амьтны тухай үлгэр, 19 тууль, 18 шидэт үлгэр, 15 хошин үлгэр оруулсан нь томоохон цар хэмжээтэй аман зохиолын орчуулгын бүтээл юм. Энэ бүтээл монгол ардын аман зохиол, монголын соёлыг дэлхийд танилцуулаад зогсоогүй монголын залуучуудыг англи хэл сурахад нь үлэмж тусласан гавъяатай нь маргаангүй юм.

Гуравдахь ном бол бас олон жилийн хөдөлмөрийн үр дүнд бүтсэн “Mongolian folklore” хэмээх ардын аман зохиолын орчуулгын бүтээл юм. Орчуулагч болоод эмхтгэн хэвлүүлсэн нь Жон Хангины Гомбожав (John Gombojav Hangin) бөгөөд туслан гүйцэтгэгчээр Жон Кругэр (John R. Krueger), Роберт Сервайз (Robert G. Service), Виллям Розиски (William V. Rozycki), Паул Буил (Paul D. Buell) нар болно. Уг орчуулгын төслийг 1977 онд эхэлсэн хийгээд төслөөсөө өмнө зарим хэсгийг орчуулж байсан бөгөөд 1974 онд судалгаа шинжилгээний ажлаар Монголд айлчлахдаа Багшийн Их Сургуулийн багш доктор Д.Цэндээс зөвлөгөө авч байжээ. Мөн хожим 1978 онд дахин судалгааны ажлаар ирэхдээ доктор, П.Хорлоо, У.Загдсүрэн, А.Лувсандэндэв нарт үзүүлж, зөвлөгөө авч орчуулгын ажилдаа тусгаж байжээ. Уг ажлаа 1979 онд дуусгасан боловч уг ном АНУ дахь Монгол судлалын нийгэмлэгийн цуврал болж 1998 онд хэвлэгдэн гарсан юм. Хангины Гомбожавын тэргүүлэн удирдаж олон жилийн хөдөлмөрөө зарж хийсэн энэ ажлаа хэвлэгдэхий нь үзээгүй боловч монголын ард түмний оюуны үнэт сан болсон ардын аман зохиолыг англи хэлт ард түмнүүдэд танилцуулах, монголын аман зохиолын судлалаар мэргэжиж байгаа гадаадын оюутнуудад харьцуулан уншиж, судалгаа шинжилгээндээ эх хэрэглэгдхүүн болгон ашиглах үнэт бүтээлийг туурвиж өгсөн юм. Өмнөх үгэндээ энэ тухайгаа дурдсан байгаа билээ. Энэ

13 “Legends of the World” edited Richard Cavendish, London, 1982, p 45- 51

14 “How did the great bear originate?” translated by D.Altangerel, Ulaanbaatar, 1987, p 5-6

номд ардын аман зохиолын төрөл зүйл болгоноос сонгон авсан нь аман зохиолын талаар өрнөдийн уншигчид бүрэн хэмжээний мэдлэг авах бүрэн боломжтой болсон юм. 4 хэсэгтэй бөгөөд эхний хэсэгтээ Өвөрмөц хэлц, зүйр үг, оньсогыг оруулж өгсөн байдаг. 2-р хэсэгтээ Ертөнцийн гурав, дөрвийн тухай болон тоглоом наадмын үг, дуу хийгээд бөөгийн тамлага, дуудлага, 3-р хэсэгтээ ерөөл магтаал, үлгэр, 4-р хэсэгтээ баатарлаг туулийг оруулж өгсөн байна.

3-р хэсэгт байгаа эрхий мэргэний домгийг Д.Алтангэрэлийн түүвэрт байгаа Эрхий мэргэний домогтой харьцуулж үзэхэд дээрх орчуулгын хэл нь англи хэлний ардын аман зохиолын яруу тансаг хэлбэр лүү илүү дөхүүлж орчуулсан болохоор Д.Алтангэрэлийн бичгийн хэлний найруулгаас хэл найруулга нь арай өөр байгаа юм. Жишээлбэл: Д.Алтангэрэлийн номд “Эрхий мэргэн”-ий домгийн эхний өгүүлбэр:

“Once upon a time there rose seven suns in the universe, and it was exposed to a burning drought. The earth was heated fiercely, the streams and rivers evaporated the plants and trees were parched. People and living beings suffered from intolerable heat, and horses and animals were tormented by painful thirst. It was dreadfully difficult to live or even survive”¹⁵ хэмээсэн байхад Хангины Гомбожавын “Mongolian folklore”-д “Many years ago, seven suns shone on this earth, and there came to be drought and misery. The earth’s crust turned red, water and rivers evaporated, plants and trees withered, creatures and men burned with heat, horses and livestock thirsted”¹⁶ хэмээн орчуулсан байна. Хангины Гомбожавын Булган аймгийн Хишиг-Өндөр сумын малчин ард Ш.Цэдэн-Ишээс сурвалжлан авсан нь бага зэрэг өөр байсан байж болох юм. Д.Алтангэрэл “rose seven suns in the universe” гэсэн бол Х.Гомбожав “seven suns shone on this earth” гэсэн нь Д.Алтангэрэлийнхээс арай оновчтой болсон байна. Учир нь Алтангэрэл rose гэсэн нь мандах гэсэн утгыг шууд авсан байна. Rise хэмээх үгийг голдуу өглөөний нар мандаж байгаа тохиолдолд хэрэглэдэг болой. Оксфордын англи хэлний тайлбар тольд “when the sun, moon, ets. rises, it appears above the horizon. The sun rises in the east”¹⁷ хэмээсэн байгаа бөгөөд өглөөний мандаж байгаа нар хоргүй илч багатай байдаг. Тийм болохоор зун 10 цагаас 11 цагийн хооронд наранд шарах нь хоргүй байдаг хэмээн эмч нар зөвлөдөг. Х.Гомбожавын shone хэмээн орчуулсан нь шарах, төөнөх гэсэн утгандаа илүү зохицож байна. Ардын аман зохиол орчуулж байгаа орчуулагчид утгыг нарийн харгалзах ёстой гэдэг нь эндээс харагдаж байгаа юм. Гарчигийн орчуулга ч өөр байгаа юм. Д.Алтангэрэл гарчгийг “Erkhii Mergen” хэмээсэн бол Хангины Гомбожавын номд “Erkhii the Marksman” хэмээн орчуулсан байна. Тэгээд уг үгээ “The best of the marksman” хэмээн тайлбарласан нь өрнөдийн уншигчдад хамгийн мундаг юмуу мэргэн харваач гэсэн ойлголтыг өгч байна. Харин Д.Алтангэрэл монгол уншигчидаа бодож орчуулсан байхаа.

15 *Mongolian folklore” Translated and Edited by John Gombojav Hangin with John R. Krueger, Robert G. Service, William V. Rozycki, Paul D. Buell, Indiana University, 1998, p 12*

16 *Mongolian folklore” Translated and Edited by John Gombojav Hangin with John R. Krueger, Robert G. Service, William V. Rozycki, Paul D. Buell, Indiana University, 1998, p 160*

17 *Oxford advanced learner’s dictionary, 7th edition, 2010, p 1312*

1-р хэсэгт байгаа өвөрмөц хэлцээс ганцыг тайлбарлая. Уг номын 23-р талд

Илжиг модон хударгандаа дуртай

Тэнэг магтаалд дуртай гэхийг

A donkey likes to be loaded

A fool likes to be praised¹⁸ хэмээн орчуулаад “Энэ зүйр үгийн хамгийн чухал хэсэг бол тэнэг магтаалд баясч байгаа нь юм. Харин илжиг ачаа ачуулахдаа дуртай, дургүй нь бол хамаагүй хэрэг. Монголчуудын хувьд илжигт нэг их ач холбогдол өгдөггүй боловч зөрүүд, тэнэг, мангарын билэг тэмдэг болгох нь буй” хэмээн тайлбарласан байгаа юм. Энэ тайлбар бол англи хэлт ард түмэнд энэ зүйр үгийг ойлгоход чухал зүйл болно. Монгол өгүүлбэрт “Илжиг модон хударгандаа дуртай” гэж байгаа бол англи өгүүлбэрт идэвхгүй хэвийн цагаар “A donkey likes to be loaded (Илжиг ачуулахдаа дуртай)” хэмээн орчуулсан нэгд англи хүний сэтгэхүйг бодож, нөгөөтэйгүүр модон хударга хэмээх зүйл байхгүйтэй холбоотой юм. Зарим тольд хэдийгээр хударгыг stupper хэмээн орчуулсан байдаг боловч утга нь арьсаар хийсэн адилавар зүйл боловч модон хударгатай огт дүйхгүй. Тийм болохоор англи уншигчдад ачуулахдаа дуртай хэмээн орчуулсан нь илүү ойлгомжтой болох юм. Дээрх хоёр жишээгээр үзэхэд монгол ардын аман зохиолыг өрнөдийн уншигчдад танилцуулах, мөн аман зохиол судалж эхлэгчдэд гарын авлага болгох гэсэн үнэнхүү сэтгэлээс хандаж, бас олон дахин нягталж аман зохиолын хэлбэрээр сайн орчуулга хийснийг нь цохон тэмдэглэхгүй байхын аргагүй юм. Ардын аман зохиолч орчуулагч нь энэ мэт хичээл зүтгэлтэй, үгийн утга сонголтод нарийн хандахын үлгэрийг эндээс бас суралцаж болох юм.

Resume

Mongolian folklore is tremendously rich in genres. Westerners, who study the Mongolian language, are interested in knowing Mongolian folklore in depth. For this reason, American scholars translated and published a collection book “Mongolian folklore” in 1998. They tried to include most genres of Mongolian folklore in it. This book has got four parts consisting of all genres of folklore. They have also presented an overall view of Mongolian oral tradition such as a view of the Mongol character, values, and aspirations. On the other hand, they introduced Mongolian folklore to the western readers with oral tradition in English.

Ном зүй

1. “Legends of the World” edited Richard Cavendish, London, 1982
2. Монголын нууц товчоо, сонгомол эх, УБ., 2005
3. “Mongolian folklore” Translated and Edited by John Gombojav Hangin with John R.

¹⁸ “Mongolian folklore” Translated and Edited by John Gombojav Hangin with John R. Krueger, Robert G. Service, William V. Rozycki, Paul D. Buell, Indiana University, 1998, p 23

- Krueger, Robert G. Service, William V. Rozycki, Paul D. Buell, Indiana University, 1998
4. Н.Оюун-Ундраа, Монгол яруу найргийг англи хэлнээ орчуулах асуудалд, Магистрын ажил, УБ., 2012 он
 5. Oxford advanced learner's dictionary, 7th edition, 2010, p 1312
 6. "How did the great bear originate?" translated by D.Altangerel, Ulaanbaatar, 1987
 7. Л.Чулуунбаатар, "Буудуулаад эдгэнэ гэж үнэн үү?", УБ., 2010
 8. "The Secret History of the Mongols", by Igor de Rachewiltz, The Australian National University, 1978
 9. "The Secret History of the Mongols", by F.W.Cleaves, London, 1982
 10. "The Secret History of the Mongols", translated, annotated and with an introduction by Urgunge Onon, London and New York, 2001
 11. Л.Хүрэлбаатар, Монгол орчуулгын товчоон, УБ, 1995

Орчуулгын алдаа, түүний уршиг

Б.Энхбаяр¹⁹ (МУИС, ОУХНУС)

Түлхүүр үг: Орчуулгын алдаа, уршиг, модон орчуулга, дипломат бариимт бичгийн орчуулга, орчуулагч

“Орчуулгын алдаа онооны тухайд” гэсэн сэдвээр илтгэл бэлдэж байх явцад орчуулгын оноо сайн талыг ярихаас өмнө өнөөдөр хэтрээд хэтийдээд байгаа орчуулгын алдаа түүнээс гарах хор уршгийн талаар товчхон ч болов ярилцах нь илүү шаардлагатай, чухал ач холбогдолтой гэдгийг ойлгож энэ талаар та бүхэнтэй санал бодлоо хуваалцахаар шийдлээ.

Орчуулгын асуудалд манай гүүш орчуулагчид хэзээнээс шүүмжлэлтэй хандаж алдсан гэсэнээ засаж сайжруулах арга замыг эрэн сүвэгчилсээр ирсний бэлэн жишээ тэртээ 18-р зуунд их хөлгөн судрууд болох Ганжуурын 108 ботийг орчуулсны дараа Данжуурын орчуулгыг эхлэхийн өмнө “Мэргэд гарахын орон нэрт даяг оршвой” хэмээх алдарт толь бичгийг нийтлүүлсэн явдал юм. Ганжуур орчуулах явцад гарсан алдааг залруулах, газар газрын гүүш орчуулагчид харилцан адилгүй нэр томъёо хэрэглэж байсныг жигдлэх зорилгоор энэхүү бүтээлийг гаргажээ.

Дараа дараагийн орчуулагчид, орчуулга судлаачид ч орчуулгын чанар алдаа оноонд анхаарлаа хандуулж үгээ хэлж шүүмжилсээр иржээ. Их эрдэмтэн, орчуулагч Б.Ринчен 1957 онд болсон Монголын зохиолчдын 2-р их хурал дээр “муу орчуулгын харгайгаар ардынхаа хэлийг эвдэх болно, одоо ч эвдэж байна гэдгийг анхаарууштай”²⁰ гэж хэлж байсан нь өнөө биеллээ бүрэн олоод байна.

Бидний хөндөж буй орчуулгын алдаа, модон чанаргүй орчуулга харамсалтай нь бүхий л салбарт элбэгших боллоо. Энэ удаагийн илтгэлээр судалгаа хийдгийн хувьд нийгэм улс төр, тэр дундаа олон улсын харилцаа, гадаад бодлогын асуудлаарх ном өгүүлэл, баримт бичиг дэх алдаа болон энэ салбарын бакалаврын түвшний төгсөх ангийн оюутнуудын гаргадаг нийтлэг алдаанд анализ хийж түүнээс гарч буй уршгийг хөндөх оролдлого хийлээ.

Аливаа орчуулга түүний дотор олон улсын харилцаа, дипломат баримт бичгийн орчуулга нь тухайн улсын гадаад бодлогын нүүр царай, бусад улс орон, олон улсын байгууллагуудтай харьцах гүүр болж байдгаараа бичлэг, найруулга, үг сонголт, хэлний хэм хэмжээ, мэдрэмж зэрэг үзүүлэлтүүдийг дээд зэргээр баримталж туйлын хариуцлагатай, чамбай ажиллахыг орчуулагчдаас шаарддаг

Дипломат баримт бичгийг боловсруулах болон орчуулахад хуумгай хандаж алдаа гаргавал улс хоорондын харилцаанд ч сөрөг үр дагавар авчрах уршигтай. “Тиймээс энэ

¹⁹ МУИС-ийн ОУХНУС, профессор, доктор

²⁰ “Орчуулгын онол практикийн тулгамдсан асуудлууд”, илтгэл өгүүллийн эмхтгэл, УБ, 2007, 114 -р тал.

төрлийн баримт бичгийн утга товч тодорхой, үг хэллэг нь элдэв хэтрүүлэггүй, агуулах санаа бүр нь урьд өгүүлснээс урган гарсан, гарцаагүй баримт нотолгоо, үндэслэл, үнэмшилтэй маш хянуур үйлдэгдсэн байхаас гадна сэтгэлийн хөдлөл, ундууцлаа шууд илэрхийлэхгүй, туйлын нухацтай боловсруулах шаардлагатай. Баримт бичгийн үг хэллэг нь бичгийн соёл, шинжлэх ухааны эш үндэслэлтэй байх ёстой бөгөөд баримт бичгийг тэрлэгч нь үндэснийхээ эх хэл, бичиг, олон улсын түгээмэл хэл бичгийг өндөр түвшинд төгс сайн эзэмшсэн байх учиртай.”²¹

Иймд тухайн орчуулгыг эх хэл, орчуулга хийж буй гадаад хэлний өндөр түвшний мэдлэгтэйн зэрэгцээ олон улсын харилцааны салбарт мэргэшсэн хүн хийх ёстой.

Харамсалтай нь, өнөө цагийн орчуулгын алдаа болон эмзэг асуудлууд нийгэм улс төрийн салбар, тэр дундаа олон улсын харилцаатай холбоотой орчуулгад ч гарсаар байгаа нь энэ чиглэлийн орчуулгыг харьцуулан үзэхэд харагдаж байна

Монгол, англи хоёр хэлний орчуулгын хувьд гаргадаг нийтлэг алдааг хэдэн үндэслэлээр авч үзье. Үүнд:

1. Үйлших, нэрших хандлагаас үүдсэн алдаа
2. Үйл үгийн идэвхтэй, идэвхгүй хэвээс үүдэлтэй алдаа
3. Нэр үгийн нэг болон олон тооноос үүдэлтэй алдаа
4. Өгүүлбэр дэх үгсийн байршил, дарааллаас үүдсэн алдаа зэрэг болно. Эдгээрийг дэлгэрүүлэн жишээгээр авч үзвэл:

1. Үйл үг – нэр үгээс үүдэлтэй алдаа, түүний уршиг

Англи, орос зэрэг Энэтхэг Европ гарлын хэлэнд нэрших хандлага элбэг тохиолддог бол монгол хэлэнд үйлших хандлага зонхилдгийг нэрт орчуулагч асан Д.Чойжил, гүүш орчуулагч, доктор Г.Аким нар нэгэнтээ тодорхойлжээ. Үйл үг монгол хэлний амин сүнс гэсэн гүүш, орчуулагч Г.Аким гуайн санааг нэрт орчуулагч асан Д.Чойжил гуай нээлтийн чанартай чухал санаа гээд сонирхолтой жишээгээр баталсан байдаг. Энэ нь: “Би од харвалтаар төрсөн болохоор од харвалтаар буцна” гэснийг “Би од харвахад төрсөн болохоор од харвахад буцна”²² гэх нь зүйтэй гэжээ.

Үүн лугаа алдаа нийгэм, улс төр болоод дипломат баримт бичгийн орчуулгад ч нэвтэрчээ. Тухайлбал, “...development of economic relations...” гэснийг “эдийн засгийн харилцааны хөгжил...” гэж орчуулах нь элбэг. Зүй нь “эдийн засгийн харилцааг хөгжүүлэх нь...” гэж үйлшүүлэх байж. “to give full credence...” гэснийг “бүрэн итгэмжлэл өгөх...” хэмээн үгчилжээ. Дээр дурдсан орчуулагчдын үзэж байгаагаар ч, монгол хэлний найрлага зүй, хэм хэмжээ талаасаа ч “бүрэн итгэх” эс бөгөөс “бүрэн итгэл хүлээлгэх” гэх маягаар

²¹ Ю.Сандаг. “Дипломат баримт бичиг тэдгээрийн түгээмэл хэлбэр”, УБ, 2011, 5-р тал.

²² Д.Чойжил. “Орчуулагчийн жаргал, зовлон”, УБ, 2005, 48-р тал.

орчуулсан бол илүү тохирсон, сонсголонтой орчуулга болох байж. “Oil countries..” гэсэн санааг оюутнууд шууд “нефтьийн орнууд” гэж буулгадаг. Энд “нефть импортлогч” эсвэл “нефть олзворлогч орнууд” гэх мэтээр тодруулах шаардлагатай. Түүнчлэн “I am confident that the conference will make its contribution to this noble cause.” гэсэн өгүүлбэрийн гол өгүүлбэрийн өгүүлэхүүнийг тэр хэвээр эв “Би итгэлтэй байна...” гэж хөрвүүлэх нь нийтлэг үзэгдэл. Үүнийг “Би итгэж байна...” гээд л заншмаар байгаа юм.

Хоёр хэлний энэхүү онцлогийг үл харгалзан орчуулсаар байтал ийм маягийн хэллэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрхтэн дархтан, нийт хүмүүсийн хэрэглээ болж хэвшсэн нь монгол хэлний яруу тансаг найрлагыг эвдэж буй нэг төрлийн уршиг юм. Тухайлбал, үндэсний болон арилжааны телевизийн олон сувгийн мэдээгээр “Хойд Солонгос Японы тэнгисийн зүг пуужингийн харвалт хийсэн”, “сэтгэл ханамж өгөх...”, “буудалцаан гарах”, “хүйтрэлт явагдах”, “хаваржилт явагдах”, “мал төллөлт явагдах”, “туршилт хийгдэх”, “гулсалт болох” гэх мэтээр ярих нь хэвийн үзэгдэл болсноор үзэгч сонсогчид ч анзаарахаа больж эх хэлээ хэдийнэ эвдэж амжжээ гэхэд хэтрүүлэг болохгүй.

2. Идэвхтэй – идэвхгүй хэвийн хэрэглээ, түүнээс гарах уршиг

Европ зүгийн тэр дундаа, англи хэлэнд үйл үгийн идэвхгүй хэв зонхилдог бол монгол хэлэнд идэвхтэй хэв зонхилдог байна. Англи хэлэнд өгүүлбэрийн үйлийн эзнийг тодотгох нь онц шаардлагагүй зөвхөн тухайн үйлдэл үйл явдал хэдийд хаа болсныг өгүүлэх зорилготойгоор болон эсвэл үйлийн эзнийг шууд бус тусагдахууны хэлбэрээр илэрхийлдэг. Үүнийг анхаарч орчуулаагүйгээс монгол хэлний найруулга зүйн хувьд тохиромжгүй, сонсголонгүй өгүүлбэр буудаг. “A conference organized by UN...: “НҮБ-ээр зохион байгуулагдсан хурал...” гэх жишээтэй. Монгол, англи хоёр хэлний орчуулгад тохиолддог үндсэн алдаа яах аргагүй энэ мөн. “Issues related to foreign investment have been touched upon.” “Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд хөндөгджээ.” Зүй нь “хурлаар гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг хөнджээ” гэх жишээтэй.

Харамсалтай нь энэ хэлбэрийн алдаа өнөөдөр хэтийдээд ийм маягаар ярьж бичих нь бүр хэвшил боллоо гэхэд болохоор байна. Үүнийг буруу орчуулгын бас нэг уршиг гэж үзэж болно. Мөнөөх л телевизүүдийн мэдээгээр “Киви хамтлагийн концерт ...сарын...өдрүүдэд тоглогдоно”, “Ажил зохион байгуулагдлаа.”, “Ахмад америк Хятадад танилцуулагдлаа.”, “Шүлэг яруу найраг нь орос, англи, франц, хятад хэлээр орчуулагдан нийтлэгдлээ.” гэх мэтээр ярих юм.

3. Нэр үгийн нэг болон олон тооны орчуулгын алдаа, уршиг

Англи, орос хэлэнд байх нэр үгийн олон тоог тэр хэвээр буулгах нь монгол хэлний найруулга зүйд мөн тохирохгүй. Өрнө зүгийн хэлэнд олон тоо ихээр хэрэглэдэг бөгөөд хэлний онцлогоос нь шалтгаалан хос зүйлийг зайлшгүй олон тоогоор илэрхийлдэг. Харин монгол хэлэнд нүд, чих, оймс, гутал гэх мэтээр нэг тоогоор л илэрхийлнэ Үүнээс гадна

нэр үгийн өмнө олон тоо заасан “бусад, зарим, ихэнх, хэдэн” буюу “some, many, few” зэрэг үгс байгаа тохиолдолд олон тооны –үүд, -ууд дагавар давхар хэрэглэх шаардлагагүй. Гэтэл энэ төрлийн алдааг эхлэн суралцагч байтугай туршлагатай орчуулагчид ч гаргасаар “худал юмыг мянга яривал үнэн болдог” гэдэг шиг болтлоо дасаж анзаарахаа больжээ

Олон улсын харилцаа, дипломат баримт бичгийн орчуулгын дадал хичээлийн явцад “achievements”, “efforts” зэрэг нэр үгс байнга тааралддаг, тэр бүхэнд оюутнууд шууд олон тоогоор нь “ололт амжилтууд”, “хүчин чармайлтууд”, удирдлагууд гэх зэргээр орчуулдаг. Гэтэл энэ алдаа мөн л даамжран нийтээр хэрэглэдэг ердийн хэллэг болоод удаж байгаа бөгөөд бид ч үүнээ алдаа гэж үзэхээргүй болтлоо дасжээ. Some students - зарим оюутнууд, many books - олон номууд, most of teachers - ихэнх багш нар гэх зэргээр орчуулдаг нь энгийн зүйл. Уг нь “зарим оюутан”, “олон ном”, “ихэнх багш” гэж олон тооны дагавар давхардуулалгүйгээр буулгах нь зүйтэй.

4. Өгүүлбэр дэх үгийн шууд дараалал

Монгол хэлнээс англи хэл рүү хөрвүүлэх явцад их гаргадаг алдаа. Бидний энд авч үзэж буй чиглэл буюу албан бичгийн орчуулгад зарим үед англи хэлний угтваруудыг нэг өгүүлбэрт давтан хэрэглэхээс зайлсхийж энэ аргаар орчуулдаг. Ер нь гадны хэвлэл мэдээллийн хэрэгсэл үзэхэд угтвар, артикль буюу ялгац гишүүдийг орхидог жишигтэй. Жишээ нь: “ноот бичгийн төсөл” гэснийг англи руу “A draft of note” гэж орчуулаад байх шаардлагагүй, “a draft note” гэхэд л болно. “Хотын гудамж” гэдгийг “street of town” гэлгүйгээр “town street” гэж үгийн шууд дэс дарааллын зарчмыг баримтлан орчуулах нь зүйтэй. Дараах жишээг харъя: “Монгол улсын их сургуулийн Олон улсын харилцааны сургуулийн Олон улсын харилцааны тэнхмийн эрхлэгч” гэсэн хаягийг “Head of Department of International Relations of School of Foreign Service of National University of Mongolia” гэж монгол хэлний харъяалахын тийн ялгалын дагаврыг англи хэлний “of” угтвараар орлуулаад байвал ямар орчуулга болох вэ. Дээр өгүүлсэнчлэн англи хэлээрх албан бичгийн хэл, хаяг, гарчиг зэрэгт ялгац гишүүн болон зарим угтварыг орхиж тухайн хэлнийхээ хэм хэмжээнд нийцүүлэн үгийн шууд дэс дарааллыг баримтлах нь тохиромжтой. Хаяг болон гарчгийн хувьд дараах байдлаар таслалаар зааглан шууд дэс дарааллаар орчуулах нь зүйтэй. “Head, International Relations’ Department, School of Foreign Service, National University of Mongolia”

Мөн өгүүлбэр дэх үгсийн дарааллын хувьд гаргадаг бас нэгэн нийтлэг алдаа бол тэмдэг нэр буюу тодотгол гишүүдийн дарааллыг буруу байрлуулж орчуулах явдал юм. Монгол улсын Их хурлын дарга асан Ц.Нямдоржоос Канад улсын Сенатын дарга болон Нийтийн танхимын дарга нарт 2007 онд илгээсэн нэгэн захидалд: Энэ завшааныг ашиглан Эрхэмсэг ноёдод эрүүл энх, аз жаргал, найрсаг Канадын ард түмэнд хөгжил цэцэглэлийн ерөөл дэвшүүлье” гэсэн өгүүлбэрийн доогуур нь зурсан хэсгийг уншвал Хойд Солонгос,

Өмнөд Солонгос гэдэгтэй агаар нэгэн ойлгогдохоор байна. Өөрөөр хэлбэл найрсаг ба найрсаг бус Канад гэсэн хоёр өөр улс байх нээ. Дараах жишээг харъя: “many national, regional and international fora...” Энд “fora” гэсэн үгийн тодотголдуудыг монгол хэл рүү буулгахад “many” гэсэн үгийн байршлыг сольж нэр үгийнхээ өмнө авчрах хэрэгтэй. “үндэсний, бүс нутгийн болоод олон улсын олон хурал чуулган” Мөн үүнтэй адилаар “long standing political and economic relations” гэхэд “улс төр, эдийн засгийн урт хугацааны харилцаа” хэмээн “урт хугацааны” гэсэн тэмдэг нэрийн байрыг солих шаардлагатай болно. “common strategic interests” – “стратегийн нийтлэг ашиг сонирхол” г.м.

Дээр өгүүлсэн зүйлс үндсэндээ хоёр хэлний найруулга зүйтэй холбоотой бөгөөд ингэж үгийн дарааллыг буруу байрлуулах нь монгол, англи хэлний аль алины найрлага, хэм хэмжээг алдагдуулах уршигтай.

Монгол, англи хоёр хэлний онцлогоос үүдэн гардаг дээрх алдаанаас гадна аливаа хоёр хэлний орчуулгад гардаг алдаа ч энэ хоёр хэлний орчуулгад давтагдаж байна. Үүнд:

-Үг буруу оноох болон сонгох

-Түвэг, бэрхшээлтэй санаа болон өгүүлбэрийг хаях

-Дүрмийн алдаа гаргах гэх мэт.

5. Үг буруу сонгосон буюу оноосон алдаа

Энэ нь орчуулгын практикт их гардаг алдаа юм. “Mr”, болон “Mrs” гэсэн үгсийг “ноён, хатан” гэж орчуулах нь хир оновчтой вэ гэсэн санааг хинди болон англи хэлний орчуулагч, гүүш, Соёлын гавъяат зүтгэлтэн Ж.Гэндэндарам²³ дэвшүүлснийг ч бодууштай. Мөн тэрээр “disarmament” гэдэг үгийг “зэвсэг хураах” гэж орчуулсныг буруу гэжээ. Үнэхээр ч англи хэлний “dis” гэсэн префикс эсрэг буюу үгүйсгэсэн утга заадаг. Гэтэл зэвсэг хураах гэхэд эсрэг утга байх нь байтугай Ж.Гэндэндарам гуайн тайлбарласныг ухаж ойлговол “хөрөнгө хураах”, “хөөг хураах” гэдэг шиг зэвсгийг бүр арвижуулан хураах гэсэн санаа илэрхийлээд байгаа бусуу. Уул нь “зэвсэггүйжүүлэх” гэж орчуулсан бол англи үгийн эх санаа нь илүү оновчтой буух байж. Монгол улсын “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д /1994 оны/ “бодит байдалд тулгуурласан гадаад бодлого...” гэдгийг “a foreign policy based on realism” гэж орчуулжээ. “зм”-үүд угтаа онол сургаал байдаг учир “Based on reality” гэж орчуулсан бол зөв байж. Түүнчлэн дипломат баримт бичгийн орчуулгын нэгэн сурах бичигт “Mr. Trevor Hughes, Counsellor will be in charge of the Embassy in the capacity of Charged’ Affairs a.i (ad interium)” – өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн гишүүнийг “Ноён консул Тревор Хугос...” хэмээн орчуулжээ. “Counsellor” гэсэн үгийн монгол хувилбар бэлхнээ “Зөвлөх” буюу “Элчин Зөвлөх” гэж үг байна. Энд орлуулсан “консул” гэдэг бол тэс өөр ойлголт, дипломат албанд гүйцэтгэх үүрэг, зэрэг дэвийн хувьд зөвлөхөөс доогуур зиндааны албан тушаал юм.

23 “Орчуулгын онол практикийн тулгамдсан асуудлууд”, илтгэл өгүүллийн эмхтгэл. УБ, 2007, 131-р тал.

6. Орчуулахад бэрхшээлтэй буюу хүнд өгүүлбэр санааг орхих

Дээр дурдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д *“In line with trends of advancing human society, in particular with requirements of economic and technological progress, the nations of the world are drawing closer together, and conditions for enhancing their relationship are taking shape.”* гэсэн англи өгүүлбэрийн монгол орчуулга нь *“Хэдийгээр дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор, түүний дотор эдийн засаг, технологийн хөгжлийн шаардлагаар ойртож, харилцан уялдаа холбоогоо бэхжүүлэх нөхцөл бүрэлдэж байгаа боловч улс орнуудын шаашин, үндэстэн хоорондын зөрчил нэмэгдэж үндсэрхэг үзэл газар авч, бүс нутгийн хэмжээнд болон тодорхой улс орны дотор зөрчил, мөргөлдөөн гарах магадлал багасахгүй байна.”* гэжээ. Өөрөөр хэлбэл англи хувилбарт *“Хэдийгээр..... улс орнуудын шаашин, үндэстэн хоорондын зөрчил нэмэгдэж үндсэрхэг үзэл газар авч, бүс нутгийн хэмжээнд болон тодорхой улс орны дотор зөрчил, мөргөлдөөн гарах магадлал багасахгүй байна.”* гэсэн бүхэл бүтэн санааг хаян орчуулжээ. Монгол улсын гадаад бодлогын тулгуур баримт бичигт орчуулгын онолын үндсэн зарчим болох үнэн зөвийн зарчмыг ийнхүү бүдүүлгээр зоригтой зөрчиж үг буруу оноосон, санаа орхигдуулсан зэрэг алдаа гаргасан нь туйлын харамсалтайгаар барахгүй гэмт үйлдэл гэхээр болжээ. Миний бие дээрх баримт бичгийн монгол, англи хоёр эхийг тулган үзэж анализ хийсэн бөгөөд энэхүү богино өгүүлэлд сунжруулахгүйн үүднээс цөөхөн хэдэн жишээ авсан нь энэ. Үүнээс үзэхэд Монгол улс ийм алдаа бүхий баримт бичгийг 20 гаруй жилийн хугацаанд тулгуур баримтаа болгон ашигласан болж байна уу.

7. Дүрмийн алдаа

Мөнхүү “Гадаад бодлогын үзэл баримтлал”-аас авсан нэгэн жишээг үзвэл: **“forming with influential countries in the region and in the world a network of relationships based on the interdependence of political, economic and other interests.”** гэсэн нийлмэл өгүүлбэрийн энээхэн хэсэгт уг нь “forming” гэсний араас түүнд хамаарч буй шууд тусагдахуун “a network” гэсэн үгийг оруулж “forming a network of relationships based on the.... with influential countries in the region and in the world” хэмээн орчуулсан бол ийм дүрмийн алдаа гарахгүй байх байсан. Түүнчлэн тэнд “олон улсын тавцанд” гэдгийн “in the international arena” хэмээн орчуулжээ. Зүй нь “in” – ийн оронд “at” буюу “on” угтваруудын аль нэгийг сонгосон бол оновчтой байх байсан. Ер нь англи хэлний угтваруудын хувьд тухайн угтварыг хэзээ, ямар тохиолдолд хэрэглэхийг тэр болгон дүрэмлэн заадаггүй тул энэ хэлийг эхлэн суралцагсад түвэг бэрхшээл учруулдаг. Гэвч орчуулга хийх хэмжээний хэлний мэдлэг эзэмшсэн хүнд энэ нь хүндрэл огтхон ч бишээ.

Ийм төрлийн алдаа нь яваа яваандаа эх хэлээ эвдэх, олон улсын харилцаанд үл ойлголцол гарах болон нийгэм улс төрийн чухал асуудлаар буруу ойлголт өгөх зэрэг уршигт хүргэх бусуу.

Алдаатай буруу орчуулга ихэсч буйн үндсэн шалтгаан нь нэн түрүүн орчуулагчтай холбоотой нь ойлгомжтой. Орчуулагч хүнд тавигддаг наад захын гурван шаардлагыг огт хангаагүй хүмүүс орчуулга хийж байна гэж үзэж байна. Үүнд:

-Орчуулагчид эх хэлээ мэдэхгүй байна. Тэдний ихэнх нь эх хэлээрээ найруулан бичих нь бүү хэл, зөв бичих чадваргүйгээс гадна үгийн баялаг муутай байна.

-Орчуулагчдын тухайн гадаад хэлний мэдлэг шаардлагын хэмжээнд хүрээгүй буюу албан бичгийн хэл эзэмшээгүй байна.

-Тухайн салбарын буюу орчуулж буй зүйлийн талаарх мэдлэг хомс буюу огт байхгүй.

Эдгээрээс гадна орчуулгын онолын талаар төсөөлөл байхгүй, энэ талын ном зохиол уншдаггүй, сонирхдоггүй, зөвхөн гадаад хэлний төсөрхөн мэдлэгтээ тулгуурлан орчуулга хийгсэд олширсон нь орчуулгын бүхий л салбарт, тэр дундаа, олон улсын харилцаа дипломат баримт бичгийн орчуулгад ч харагдаж байна.

Эцэст нь дүгнэхэд:

-Монгол улсын гадаад харилцаа өргөжин тэлж зөвхөн улс төрийн төдийгүй, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны зэрэг бүхий л салбарт хамтын ажиллагаа хөгжсөнөөр олон улсын түгээмэл хэл - англи хэлний хэрэгцээ түрэн орж ирж зарим байгууллага, компани төслийн хэмжээнд бичиг баримтаа хөтлөх албан ёсны хэл нь болжээ.

-Үүнтэй уялдан англи хэлний нөлөөнд хэт автаж эх хэл рүүгээ хөрвүүлж болохоор үгс, нэр томъёог тэр хэвээр нь хэрэглэх, мөн англи хэлний хэм хэмжээ найрлагад автаж монгол хэлнийхээ онцлог, найрлага зүйг үл харгалзсан үгчилсэн, модон орчуулга давамгайлах болжээ.

- Алдаа бүхий буруу орчуулга нь яв явсаар монгол хэлний яруу тансаг найруулга, хэм хэмжээг алдагдуулан эвдэж эх хэлээрээ ярьж бичихдээ ч хиймэл зохиомол үг хэллэг хэрэглэн төрөлх хэлээ үгүй хийхэд хүрэх уршиг аюул дагуулж байна.

Summary

In the paper, issues related to incorrect translation are highlighted, by the author, on the basis of examples of diplomatic documents. The author tries to explain main errors made by translators in seven ways due to distinction between Mongolian and English languages, as they are from completely different families. As the author considers, some factors as strong influence of English language in Mongolia and insufficient knowledge of both tongue and foreign languages by translators cause the main topic touched upon here. Bottom of Form

Ашигласан хэрэглэгдэхүүн:

1. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. 1994.
2. Р.Гүрбазар."Орчуулгын онол дадлагын үндэс", УБ, 1996.
3. "Орчуулгын онол практикийн тулгамдсан асуудлууд" ОУХС-ийн ДОТ-ээс эрхлэн гаргадаг эмхтгэл, УБ, 2007
4. "Орчуулах эрдэм-1" мөн эмхтгэл, УБ, 2009
5. Орчуулах эрдэм-2" мөн эмхтгэл, УБ, 2010
6. Орчуулах эрдэм-3" мөн эмхтгэл, УБ, 2011
7. Орчуулах эрдэм-4" мөн эмхтгэл, УБ, 2012
8. Ю.Сандаг."Дипломат баримт бичиг тэдгээрийн түгээмэл хэлбэр", УБ, 2011.
9. Д.Цолмон."Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг", УБ, 2010.
10. Б.Энхбаяр."Англи, монгол орчуулгын зарим асуудалд""Орчуулгын онол практикийн тулгамдсан асуудлууд" эмхтгэл, УБ, 2007, 107-112-р тал
11. Б.Энхбаяр."Монголын орчуулгын онол судалгааны асуудлын тухайд" Орчуулах эрдэм-3" эмхтгэл, УБ, 2011, 245-250-р тал.
12. Б.Энхбаяр. "Дипломат баримт бичгийн орчуулгын тухайд", "Орчуулах эрдэм-IX" илтгэл өгүүллийн эмхтгэл, УБ, 2013, 57-62 -р тал.

Орос яруу найраг дахь угсаа-соёлын нэрийн холбогдолтой зүйлийг орчуулах тухайд

Ц.Магсар²⁴ (МУБИС)

Товч утга: Энэхүү өгүүлэлд уран зохиол, тэр дундаа яруу найргийн орчуулгад өвөрмөц шийдлийг шаарддаг үндэсний онцлог үгс, угсаа-соёлын нэрийн холбогдолтой зүйлийг хэрхэн орчуулах талаар зарим үзэл бодлоо А.С.Пушкины “Руслан Людмила хоёр” найраглалын монгол орчуулгын жишээ баримтад тулгуурлан өгүүлэв. Уг өгүүлэл орос хэл дээр ОХУ-ын Найрамдлын их сургуулийн (РУДН) ЭШБичгийн 2014 оны №2-т орсон болно.

Түлхүүр үг: Яруу найраг; угсаа-соёлын нэрийн орчуулга; гоозүйн үнэлэмж; мэдээллийн агууламж; дүйцэмж.

Оросын яруу найраг, ялангуяа XIX зууны шүлэг, найраглалд элбэг тааралддаг слав-оросын язгуур соёлын уламжлалтай үндэсний онцлог үгс, угсаа-соёлын нэрийн холбогдолтой зүйлийг орчуулах нь багагүй ярвигтай ажил, тэр тусмаа огт өөр соёлын дэвсгэртэй монгол хэлэнд орчуулах орчуулгын тухайд энэ нь онцгойлон үзүүштэй нэгэн сэдэв юм. Үүнийг бид А.С.Пушкины “Руслан Людмила хоёр” найраглалыг монголчлон (монгол төрхтэй болгон) орчуулах муйхар оролдлогоосоо мэдрэв. Энэхүү сэдэв нь үүнээс үүдэлтэй бөгөөд сэдвийн хүрээ ч үүгээр хязгаарлагдана.

Шүлэглэсэн эхийн хэл хоорондын хувиргалд тавигдах шаардлагыг аль болох баримтлана гэдэг зүйн хэрэг боловч орчуулагчдад тулгардаг бэрхшээлүүд амаргүй тул уг найраглалыг орчуулсан бидний хувилбарт алдаа онооны аль аль нь байгаа нь мэдээж. Бэрхшээлийн зангилаа нь нэг талаас өөр маягийн угсаа-соёлын үнэлэмжтэй уншигч олон түмэнд хэр чинээндээ ойлгомжтой хөрвүүлэх зорилго, нөгөө талаас зохиолын хэлбэр агуулга, эхийн гоозүй, уран яруу чанарыг алдагдуулахгүй байх зорилгыг нэгэн зэрэг гүйцэлдүүлэхэд оршино. Угсаа-соёлын зүйлсээр баялаг яруу найргийн орчуулгын хувьд ийм зорилго тулгамдмал, биелэхийн тухайд ч ихээхэн хязгаарлагдмал шинжтэй бөгөөд эрэмбээрээ зохиол орчуулагдах ба эс орчуулагдах боломжийн дараа орохоор төвөгтэй асуудал юм. Иймээс ч уран зохиол орчуулгын онол, практикт шүлгийн үг утгасын оноолт ба уран чанарын аль алийг гээлгүй хөрвүүлэх гэдэг үл гүйцэлдэх нигууртай гэсэн үзэл бодол түгээмэл байдаг.

Иймэрхүү зөрчилдөөнт гэмээр шийдлийг ихээр агуулсан, тухайлан хэлбэл, үндэсний язгуурлаг буюу угсаа-соёлын чанартай, үүгээрээ соёлын болон сэтгэлгээний хувиргал хийхээс наана уран чанараа олж орчуулагдахааргүй тийм зохиолын тоонд “Руслан Людмила

хоёр” найраглал орно. Энэхүү найраглалыг орчуулах явцад тулгарсан асуудлыг шийдэл талаас нь болзолт байдлаар хэд гурван хэсэгт бүлэглэн үзэв. Нэгд, монгол соёлын дэвсгэрт нэрийг нь ямар нэгэн байдлаар хөрвүүлж болох үндэсний өвөрмөц үзэгдлүүд буюу эд юмс байна. Жишээ нь, *гусли*, *арфа*, *волынка* гэх мэт хөгжмийн зэмсгийн нэрийг хэдийгээр орос ба монгол хэлэндээ заагдагч денотат нь зөрөөтэй ч гэсэн дүйцэх монгол нэрээр (*гусли*, *арфа* – *ятга*; *волынка* – *цуур*) хөрвүүлж болно. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд зарим орос болон европ хөгжмийн зэмсгийн нэр аль хэдийн “*арфа*” – *морин ятга*; “*баян*” – *баян хуур*; “*аккордион*” – *найрал баян хуур г.м.* монгол нэртэй болжээ (Дашрамд хэлэхэд “баян” хөгжмийн нэр орос хэлэнд үүсэхдээ сэцэн Баян буюу Боян ерөөлчийн нэрээр нэрлэсэн түүхтэй. Харин үүнийг бичилт, дуудлагыг нь дагуулан морин хуурын жишгээр монгол хэлний “баян хуур” хэмээх утга төгөлдөр нэр үүсгэсэн нь сонин. Энэ нь цаашлаад “аман хуур”, “найрал баян хуур” гэх мэт нэрийн үүсэлд нөлөөлсөн бололтой). Тухайн тохиолдолд “*ятга*”, “*цуур*” гэх монгол нэрүүд яруу найргийн орчуулгадаа орос денотатын мэдээллийн үнэлэмжийг бүрэн хадгалж чадна.

Зохиолд баатрын нэр, оноосон нэр ямарваа үнэлгээний болон мэдээллийн агууламжтай байх аваас орчуулахыг зүйд үздэг(8,56). Тийм нэр үндсэндээ үгийн утга түшсэн, үүсмэл шинжтэй, тэр чанараараа орчуулагдах магадлалтай байдаг. Жишээ нь Н.Гоголийн “Амьгүй албат”, “Байцаагч түшмэл” зохиолуудын хэд хэдэн баатрын нэр тийм билээ. Бидний орчуулсан эхийн нэрүүдээс илт үнэлгээний агууламжтай Черноморын нэрийг энэ үүргээр нь бид “*Хар тахал*” гэж орчуулав. Мөн “*аран*” гэдгийг “*хар цэрэг*” гэж хөрвүүлэхдээ “*Арапов длинный ряд*” гэдгийн “*длинный ряд*” буюу “*урт цуваа*” хэмээснийг утгын төв болгов. Тухайн тохиолдолд “*хар цэрэг*” хэмээх монгол орчуулга мэдээллийн талаасаа хоёрдмол утгатай болж таарав. Хэрэв түүхэн утгаар нь тусгаж үзвэл анхдагч эхийн утгаасаа гуйвж, тэр хэмжээгээрээ зохиолын дүрийн сөрөг талыг илүү тодруулахуйц болсон байж мэднэ.

Хоёрт, монгол уншигчдад ямар нэгэн байдлаар танил орос үлгэрийн баатар, нийтлэг дүрийн нэрүүд байна. Нэлээн олон орос үлгэр эрт дээр үеэс монгол хэлэнд орчуулагдаж, тэдгээр нь дангаар хэвлэгдэн уншигчдын хүртээл болсноос гадна дунд сургуулийн сурах бичигт орсон тул баатруудын нэр нь олонд танил, хэрэглээнд түгээмэл болжээ. Тухайлбал, *Баба Яга* – *Нисдэг шулам*, *Василиса Прекрасная* – *Сайхан Василиса*, *Русалка* – *Лусын охин*, *мальчик-с-пальчик* – *чигчийн чинээ хүү*, *шапка-невидимка* – *далдын хар малгай*, *колобок* – *өнхрүүш* гэх мэт үлгэрийн дүр болон баатруудын нэр монголчуудад үндсэндээ ойлгомжтой тул орчуулахад бэрхшээл үүсэхгүй. Ийнхүү үндэсний соёлд орж нутагшсан, орчуулж буй эхийг бүтээгч харь үндэстний соёлын дэвсгэр болбоос уран зохиол, тэр дундаа яруу найргийн орчуулгадаа тааламжтай нэгэн хөрс суурь болдог байна(4,49). Гагцхүү тийм дэвсгэр өөр соёлын дотор бүрэлдэхдээ чухамдаа уран зохиолын орчуулгаар дамжиж бий болдог, үндэстнүүдийн оюун санааны харилцаа өргөжин хөгжиж ном зохиол орчуулах ажил үйлс дэлгэрэхийн хэрээр хүрээгээ тэлэх хандлагатай ажээ.

Гуравт, монгол дүйцэмжгүй эд юмсын нэр болоод дүр дүрслэгдэхүүн нь орчуулагчаас ихээхэн оновчтой шийдэл шаарддаг билээ. Тэдгээрийг орчуулах, хувиргах боломжийн тухай асуудлыг мэдээллийн агууламж ба үнэлэмжээс нь хамааран дотор нь мөн ялгаатай авч үзүүштэй. Мэдээллийн агууламж өргөн хүрээтэй, үнэлэмж нь ач холбогдолтой байх тусам таарч тохирсон дүйцэмжийн сонголт хомс, энэ хэрээр орчуулга хязгаарлагдмал байна. Харин мэдээллийн үнэлэмж нь төдийлөн их ач холбогдолгүй бол дүйцэмжийг ямар нэгэн байдлаар сонгох боломжтой байна. Жишээ нь, орос *котомка* ахуйн хэрэглээндээ байдаг утгаараа үүргэвчтэй дүйцнэ. Гэтэл эмээлд ганзгалсан *котомка*-г яруу найрагт богцтой дүйцүүлж орчуулах бүрэн боломжтой. Үүнтэй адил кафтан (урт хормойтой эртний орос хувцас) гэдгийг эхийн дотор гүйцэтгэж буй үүргээс нь хамааран дээл гэж орчуулж болно. Гэхдээ “*держаться за кафтан*” гэдгийн утгын төвийг бид “*держаться*” гэдэгт нь шилжүүлэн “*хормойдох*” хэмээн хөрвүүлэхэд цаад санаандаа кафтан монгол дээл болж хувирах тул үг оноож орчуулсангүй. Мөн “*Кругом курильницы златые поднимают ароматный пар*” гэснийг буддын сүм хийдээр төлөөлүүлэн дүрсэлж, монгол соёлд ойртуулж орчуулбал “*алтан бойпроос энд тэндгүй арц хүж анхилах*” гэсэн төвөггүй монгол ахуйн дүрслэл үүснэ. Эдгээр жишээ баримт нь заагдагч денотатын хувьд тэс ондоо нэршил үүсгэхүйц үгсийн сангийн нэгж яруу найргийн орчуулгад уран чанарын болон мэдээллийн үнэлэмжээ хадгалж чадаж байгаагийн илэрхийлэл болж байна. Гэхдээ иймэрхүү маягийн эд юмс болоод дүр дүрслэл цаанаа нэмэлт мэдээллийн утгатай бол тухайн аргыг тийнхүү зөвхөн юмсын төсөөтэй шинжээр нь хавтгайруулан хэрэглэх боломжгүй. Жишээ нь Ч.Лодойдамбын “*Тунгалаг Тамир*” романы орос орчуулгад монгол гутлыг орчуулахгүй, “*гутул*” хэмээн транслитераци ашигласан(7,56), энэ дагуу зүүлт тайлбар хийсэн байдаг нь ахуй соёлын танин мэдэхүйн үүргээсээ илүүтэй уг гутлыг өмсөөд идэр есийн хүйтэнд морьтой хэд хоногоор хээр явж болж байгаа нэмэлт мэдээлэлтэй холбоотой (өөрөөр хэлбэл, ердийн орос *сапог* гэдгээс илүү их мэдээллийн агууламжтай: монгол гутал ээтэн хоншоортой, өвдгөө хүртэл оймсон түрий бүхий эсгий дотортой, морь унахад тохиромжтой г.м.).

Дараагийн бүлэгт, монгол хэл, соёлд тохирох денотатгүй боловч хэлбэрийн хувьд таарах дүйцэмжийн сонголттой үгсийн сангийн нэгж, дүр дүрслэгдэхүүн байна. Нэгэнт дүйцэмжийг хэлбэр төдий үүргээр нь сонгож байгаа тул утгын хүрээг бүрэн шавхаж илэрхийлсэн орчуулга болж чадахгүй нь мэдээж. Жишээ нь, “*Одна, красавица младая на берегу плела венок*” гэдгийг “*Усны хөвөөд залуу бүсгүй өнгийн цэцэг сүлжиж суув*” хэмээн орчуулахад өнгөн дээрээ үгсийн сангийн дүйцлээ бүрэн олсон мэт харагдана. Гэвч “*плести венок*” (цэцгээр титэм сүлжих), ерөөсөө “*венки*” (цэцгэн титэм) гэх мэт ойлголт монгол хэл соёлд байхгүй, иймд хийх юмаа олж ядсан хүн л цэцэг сүлжиж суугаа төсөөлөл жирийн монгол уншигчийн санаанд бууж магадгүй. Үүнтэй адил “*венец*” гэдэг үг байна. “*Венец любви, венец желаньям*” гэсэн мөр бидний орчуулгад “*хүслийн зовлон*”, “*хайрын титэм*” хэмээн бараг л хоёрдмол утга санаагаар буув. Улс түмнүүдийн харилцаа, даяаршлын үрээр зарим ахуй соёлын зүйл шинээр орж ирэх, хөгжин дэлгэрэх үзэгдэл түгээмэл. Нэгэн цагт

“*русская баня*” гэдгийг монгол хэлэнд орчуулах боломжгүй байв. Харин сүүлийн үед финлянд саун, орос уур элбэг болж байгаа тул баня-г “*орос уур*” гэж орчуулахад болохгүй юм алга.

Монгол хэлэндээ оноолт дүйцэмжгүй, хэлбэр төдий сонгосон дүйцэмж нь огт өөр утгатай үгийн жишээ бол “*чёрная книга*” гэсэн нэр байв. Үүнийг бид “*хар судар*” хэмээн орчуулж байгаа маань дүрслэн илэрхийлж буй утга санаа нь уран сайхны үүргийн талаасаа боломжийн гэмээр. Гэхдээ соёлын үнэлэмж, мэдээлэл талаасаа хар судар буюу хар домын судар нь огт өөр зүйл болох нь ойлгомжтой. Иймд “*чернокнижный язык*” гэдгийг “*хар судрын тарни*” хэмээсэн маань зөвхөн уран сайхны үүргийн хувьд болно уу гэхээс мэдээллийн үнэн байдлын хувьд ихээхэн гажсан хэлбэр болно. Ийнхүү хэлбэрийн болон дан ганц уран сайхны үүргээр хийсэн сонголт өнгөн дээрээ дүйцүүлж орчуулах нэг гарц байж болох боловч мэдээллийн болон соёлын үнэлэмжийн түвшиндээ гарцаагүй алдагдалтай арга болж байгаа юм.

Орчуулахад нэлээн ярвигтай гэж үзүүштэй эцсийн бүлэгт үндэснийхээ болон соёлын онцлог шинжийг дагнан агуулсан, иймд орлуулахын тухайд хэлбэрийн төдий ч дүйцэмжгүй бүлэг үг утгас, ялангуяа шашин-соёлын агуулгатай оноосон нэр байна. Эдгээрийг нэрийн хувьд бараг л орчуулах боломжгүй бөгөөд хэвээр нь хадгаллаа гэхэд тэдгээрийг хэрэглэсэн зохиолчийн цаад санаа огт баригдалгүй өнгөрөх магадлалтай. Тухайлбал, “*Руслан Людмила хоёр*” найраглалд янз бүрийн эх үүсвэрээс авч ашигласан, түүний дотор шашин, домогзүйн холбогдолтой нэрүүдийг (*Диана, Орфей, Дорида, Дельфира г.м.*) зохиолч тодорхой зорилгоор хэрэглэсэн байх нь олонтаа(5,268;6,14). Жишээ нь *Орфей* бол энд хэрэглэснээр зөвхөн эртний герег домогзүйн дүр, дуу хуурын охин тэнгэрийн бэлгэдэл төдий биш, “*Умрын Орфей*” гэж Пушкин өөрийн халамжлагч, хүндэлж явдаг дотны нөхөр, яруу найрагч В.Жуковскийг хэлжээ. Ер нь домогзүйн дүрийн үүргээр нь Орфейг монгол яруу найргийн охин тэнгэр Янжинлхамаар дүйцүүлэн хөрвүүлэх боломж байж болно. Гэтэл найраглалд тийм биш байгаа. Зохиолч найраглалдаа В.Жуковскийн “*Арванхоёр нойрсч буй гүнж*” зохиолын өгүүлэмжийг ашиглахдаа түүний найруулгын аяс маягт автсаныхаа төлөө өршөөл гуйсан (“...в повести моей забавной теперь вослед тебе лечу”) илэрхий тодорхой хандлагууд нь Орфейтэй холбоотой нэмэлт мэдээллийг тайлбарлахаас өөр аргагүй нөхцөлд оруулж байгаа юм. Ийнхүү тайлбар зүүлтээр орчуулгын зохиолыг дүүргэх нь тийм таатай хэрэг биш хэдий ч зохиолын цаана байгаа мэдээллийн агуулгыг хадгалах, ялангуяа оюутан сурагчдад танин мэдэхүйн үнэ цэнийг нь хүргэх ач холбогдол талаасаа ингэхээс өөр аргагүй. Мэдээллийн ач холбогдол нь давамгайлах тохиолдолд зарим нэрийн хэрэглээ тухайн хэлбэрээрээ тийм ч чухал биш байж мэднэ. Жишээ нь, бид хувилбартаа “*Рыцари парнасских гор*” гэхэд “*рыцари*” (*яруу найрагчдыг заан нэрлэсэн эпитет*) гэсэн үгийн орчуулгаар үүний цаана агуулагдаж буй мэдээллийн өчүүхэн хэсгийг ч илэрхийлж чадахгүй, илэрхийлэх боломжгүй тул тухайн үгийг үлдээж, харин мэдээллийн голыг гаргах үүднээс “*Хэзээний цуут Парнас уулын хэл амаараа тэрслэгчид*” гэсэн тайлбар маягийн

хувиргал хийж орчуулав. Үүн лүгээ Мильпомены нэрийг (*“Плохой питомец Мильпомены”* бидний хувилбарт *“Эмгэнэлт дүрийн муу жүжигчин”* болов) мөн орхиж орчуулав.

Яруу найргийн орчуулгад, тэр тусмаа үндэсний онцлог зүйлс, түүхэн зүйлс, угсаа-соёлын элементээр арвин эхийн орчуулгад тулгарч байдаг хамгийн адармаатай асуудал бол зохистой (буюу тухайн) хэлбэрт нь агуулгыг “багтаах” оновчтой шийдэл юм(3,134). Ийнхүү багтаах зорилгын үүднээс орчуулгын олон янзын арга хэрэглэх хэрэгтэй болдог. Бидний хувилбарт, жишээ нь, агуулгын мэдээллийн талыг хавсралт тайлбарын хэлбэрээр өгснөөс гадна зарим нэг угсаа-соёлын зүйлийг заасан үг утгасыг өөрийн бодол шийдлээр хөрвүүлэв. Эдгээрийн дотор утга агуулгаасаа гажиж орчуулагдсан тохиолдол ч гарсныг тэмдэглэх хэрэгтэй. Ийм нэг тохиолдол бол *“пустынные рыба́ри”* (цөлийн загасчид) хэмээх нэрийн орчуулга байсан бөгөөд тухайн хэлбэртээ багтаж орчуулагдах боломжийн хувьд туйлын хомс байсан тул *“аглаг хөвчийн даяанчид”* гэсэн зохиолын агуулгад огт холбогдолгүй нэрийг хэрэглэж, харин хавсралтад тухайн нэрийн тайлбарыг өгөв. Учир нь “цөлийн загасчин” гэсэн холбоо үг монгол уншигчид нэн ойлгомжгүй сэтгэгдэл төрүүлэх тул *“рыба́ри”* гэдгийг орхиж зөвхөн *“пустынный”* (цөлийн, аглаг) хэмээх үгээр утгын төв бүрдүүлж орчны үйл явдалд нь дүйцүүлэх маягаар тийн хувиргаж хөрвүүлэв.

Үүнээс гадна онцгойлон авч үзүүштэй нэг зүйл бол ардын зан үйл, ёс заншил талаасаа зөрүүтэй нэр, үйл тэргүүтнийг орчуулах асуудал байна. Европ ба дорнын гэх мэтээр эсрэгцүүлэн ангилж болох заншил зуршил, зан үйл дэх илэрхий зөрөөний зарим нь соёлын харилцаанд ойлгомжгүй байдал үүсгэдэг ч явдал байдгийг судлаачид тэмдэглэсэн байдаг(1,54). Бидний хувилбарт *“в радости лобзает руку”* (баярласандаа гарыг нь үнсэх), *“присвистнул коня”* (морио исгэчин дуудах) зэрэг заншил зуршлын зүйлс, мөн *“перчатки”* (цэргийн бээлий) мэт ахуйн зүйлийн нэрийг орчуулалгүй үлдээв. *“Прижать к устам перст”* гэдгийг мөн хоёр тохиолдлоос нэгэнд нь орчуулалгүй үлдээв.

Аман зохиолын найруулгын маягаар бүтсэн мөр бадгийн орчуулга онцгой шийдэлтэй байхаас өөр аргагүй. Жишээ нь, бидний хувилбарт *“Повеселись, мой верный меч! Повеселись, мой конь ретивый!”* гэсэн мөрийг орчуулалгүй үлдээсэн бол *“Я еду, еду, не свищу, А как наеду, не спущу!”* гэсэн мөрийг *“Мөрөөрөө яваа намайг оролдвол Мөхлөө ёрлох чинь тэр иүү!”* хэмээн найруулгын маягийг саармагжуулж орчуулав.

Энд авсан жишээ баримтууд хэдийгээр ганц нэг тохиолдлын шинжтэй, нэгтгэх ангилах боломжоор хомс (бидний ангилал болзолт чанартай) боловч уран зохиол, тэр дундаа яруу найраг орчуулагчдад байнга асуудал үүсгэж байдаг, гаргалгаа, шийдлийг тэд л өөрийн зөн совин, мэргэн оюундаа даатган “аргалж” байдаг онцлогтой билээ. Орос, монгол хэл соёл хоорондын хөрвүүлэг, хувиргалын тухайд гэвэл эдгээр хэл соёлууд нь түүхэн харилцааны болоод харилцан нөлөөллийн өргөн шижимтэй тул угсаа-соёлын нэрийн холбогдолтой зүйлсийн орчуулгын хамаарах хүрээ сэдвийн болон хугацааны хүчин зүйлээсээ шалтгаалан их бага янз бүр ч, зарим бусад хэлтэй харьцуулахад харьцангуй цомхон гэж үзэхээр бөгөөд

энэ нь нэг ёсондоо орчуулгадаа таатай зүйл юм. Мэдээж даяаршлын явцад үндэстнүүдийн оюун санааны харилцаан дахь саадтай зүйлс аль болох элэгдэнэ, энэ хэрээр угсаа-соёлын нэрийн орчуулга ч шийдлүүдээ олоод явна. Гэхдээ асуудлын шийдэл, арга хэлбэрүүд орчуулга судлаач, соёл судлаачдын нэг анхаарах сэдэв байсаар байх нь дамжиггүй. Ер нь ч яруу найраг, уран зохиолын орчуулгын онцлог тийм билээ. Энэ тухайд Г.Гачечиладзе: “Уран сайхны орчуулгын ажил нь үг утга оновчтой боловч уран чанар дутмаг орчуулга, уран чанар сайтай боловч анхдагч эхээсээ холдсон орчуулга гэсэн хоёр туйлшралын дунд хэлбэлзэж байдаг. Онолын хувьд бол энэ хоёр зарчмыг нийлэгжүүлээд анхдагч эхээсээ ч хэлбийгээгүй, уран чанараа ч гээгээгүй туйлын төгөлдөр орчуулга гаргаад ирж болохсон. Гэвч амьдралд ингэж нийлэгжүүлэх боломжгүй. Учир нь нэг ижил санааг илэрхийлэх хэрэглэгдэхүүн хэл хэлэнд өөр өөр байх зүй тогтолтой. Ингэхлээр үг утгын оновчтой чанар, уран чанар хоёр бие биентэйгээ байнгын зөрчилт нөхцөл байдалд оршдог”(2,344) гэж бичжээ. Ер нь бол зохиолын зорилго, зорилгоо дагаад орчуулгад тавигдах шаардлага нь анхдагч эхийг уншаад авах таашаал, мэдлэг мэдээлэл зэрэг үзүүлэлтийг орчуулгад нь аль болох бүрэн дүүрэн хадгалах орчуулагчийн хүсэл тэмүүлэлтэй уялдаж байх нь гарцаагүй. Чухам үүний тулд хэлний уран яруу хэрэглүүр, хэл болоод сэтгэлгээний метафорчлал төдийгүй боломжтой газар нь угсаа-соёлын зүйлийн нэрийг хувиргах нь зохиолын гоозүйг хадгалах чухал зорилт болно.

Ном зүй

1. Виноградов В.С. Перевод: общие и лексические вопросы. М., 2006
2. Гачечиладзе Г.Р. Художественный перевод и литературные взаимосвязи. М., 1980 (пересыл. В.Сдобников. Теория перевода. М., 2006)
3. Львовская З.Д. Современные проблемы перевода. М., 2008
4. Магсар Ц. Место Пушкина в истоке монгольской поэзии нового времени. “Вопросы изучения русского языка, истории и культуры России” // выпуск 19 Уч. зап. Государственного университета Чжэнчжи. Тайбэй, 2012
5. Небольсин С.А. Пушкин и европейская традиция: писатель-классик как фактор самоопределения национальной литературы (дисс. д-ра филол. наук). М., 2002
6. Шапир М.И. Эволюция стилей в русской поэзии от Ломоносова до Пушкина // Шапир М.И. Статьи о Пушкине. “Языки славянских культур” М., 2009
7. Цэдэнжав Д. Лингвостилистические аспекты перевода с монгольского языка на русский. Улан-Удэ, 2010
8. Эрдэнэмаам С. Зарим орчуулгын тухай (шүүмж, эргэцүүлэл), МУБИС-ийн ЭШБичиг “Лавай”, 2012, №8

Резюме

Перевод русских реалий и этно-культурных явлений из поэтических текстов XIX века, присущих традиционной славяно-русской культуре, является одной из трудных задач для переводчика, особенно когда речь идет о переводе с русского языка на монгольский, которые имеют совершенно разные культурные фоны. В данном случае имеются в виду проблемы, с которыми мы сталкивались при переводе поэмы А.С.Пушкина “Руслан и Людмила” на монгольский язык.

Несмотря на соблюдение всех требований к межкультурной трансформации стихотворного текста, при переводе наблюдаются некоторые явные потери, т.к. перед переводчиком стоят довольно сложные задачи. Они были обсуждены с ведущими российскими специалистами в области лингвострановедения проф. В.М.Шаклеином и проф. С.А.Хаврониной, по предложению которых и появилась эта статья (Статья включена в Вестник РУДН, №2 за 2014 г.).

Нэр томъёог оновчтой хэрэглэх нь сайн орчуулгын нэг үндэс

А.Цэрэнчулуун²⁵

Алив нэг хэлнээс нөгөө хэлнээ орчуулагч тухайн хоёр улсын хэлийг сайн эзэмшсэн, зан заншлыг сайн мэддэг байхаас гадна орчуулгатаа нэр томъёог зөв зохистой хэрэглэдэг байх нь чухал.

Товч агуулга: *Хэл яриа бол хүмүүн төрөлхтний бусдаас ялгарах гол зүйл, хэл яриа гэдэг ойлголт, утга санааг илэрхийлэх, хоорондоо харилцах, хэрэгслийн тогтолцоо. Хүний гурав хүртэлх насандаа ямар нэгэн хичээлд тусгайлан суулгүйгээр аяндаа сурсан хэлийг **төрөлх хэл** буюу эх хэл гэнэ. Тухайн хэлийг сурч байгаа хүмүүсийн эргэн тойронд байгаа эцэг, эх; ах, дүү, цуг тоглодог найз нар, радио, телевизийн нэвтрүүлэг зэрэг нь **хэл сурах орчин**, аливаа хэлийг хэрхэн сурахад хэлний орчин онцгой үүрэгтэй.*

Улс хөгжиж, эдийн засгийн шинэ салбар буй болж, шинэ техник, технолог нэвтрэхийн хэрээр, хүн ард нь нарийн мэргэжлийг гүнзгий судлах бүр тухайн хэл ярианд харийн үг орж ирж, шинэ нэр томъёо буй болж эх хэл маань шинэ үг, хэллэгээр баяжиж байдаг нь жам ёс буюу.

Эх хэлний хатуу бодлого байхгүйгээс хэл булингартан, харь хэлний дүрмээр ярьж бичих, харь үгийг адил дуудлагтай монгол үгтэй хольж хутгах, төрөлх хэлний үгийнхээ утгыг алдагдуулан эх хэлээ булингартуулж байна гэвэл тийм ч их дэгсдүүлэг биш болох биз ээ?

Хүүхдийг хар багаас нь харийн хэл сургах гэж шамдаад эх хэлээ хоёрдугаарт тавьдаг болсноос сүүлд монгол хэлээ сурсан нь гадаад хэлний дүрмээр монгол үгээ хэлхэн ярих, хоёр хэлний дүрмийг хольж хутгах болж байна. Ийм хүмүүсийн өсөхөөс сурсан харийн хэл нь төрөлх хэл нь болж байна. Эдгээр хүмүүс харийн хэлээр хэдий цэвэрхэн ярих ч, монгол хэлээ сайн мэдэхгүйгээс орчуулах, хэлмэрчлэх чадвар мөхөс хүмүүс буй болж байна.

Эх хэлээ аврахын тулд нэр томъёоны комиссыг зохих ёсоор нь ажиллуулан, харь үгийн алийг нь орчуулах, алийг нь хэвээр авч хэрэглэхийг зохицуулах, нарийн мэргэжлийн хүрээний тайлбар толь гарах, кирилл монгол хэлний дүрмийг нэг мөр болгон бүх сургууль, яам, албан байгууллага, үйлчилгээний газарт мөрдүүлэх, хаягийг журамлах хэрэгтэй байна.

Мөн монгол хэлээ авч үлдэе гэвэл харь хэлийг ерөнхий боловсролын сургуулийн дунд ангиас хүүхэд эх хэлдээ зүгширч эхлэхээр заадаг болбол зүгээр мэт санагддаг. Эх хэл дээрээ дөрөөлж, харийн хэлийг сурах нь зүй.

25 Орчуулагч, судлаач

Түлхүүр үг: *Хэл яриа, төрөлх хэл, хэл сурах, хэл сурах орчин, нэр томъёоны комисс, нутагших, ондооших, харь үг, үгийн утга ондооших*

Хэл яриа бол хүмүүний бусад амьтнаас ялгарах гол зүйл.

Хэл гэдэг нь хүний ерөнхий ойлголт, үзэл бодол, утга санаа зэргийг илэрхийлж хоорондоо харилцахад хэрэглэдэг дохио зангаа, дүрэм зүй, тэмдэглэгээ, дуудлага, үг зэргийг бүхэлд нь хамруулсан систем юм. **Фердинанд де Саушюр** нь анхлан хэл судлалыг кодчилон судалж, шинжлэх ухааны түвшинд авчран нийтэд хүргэсэн байна.

Төрөлх хэл

Эх хэл буюу төрөлх хэл гэдэг нь өсөхөөс ямар нэгэн хичээлд тусгайлан суулгүйгээр сурсан хэл болой. Тухайн хүүхдийг хэлд ороход түүний орчны хүмүүсийн ярьж байсан хэл нь түүний төрөлх хэл болмой. Төрөлх хэлээ хүн ямар ч зовлонгүйгээр аяндаа сурна. Тэгэхдээ тэр орчныхоо хүмүүсийн нэгэн адил хэмжээнд сурна. Төрөлх хэлийг хүн гурав хүртэлх насандаа сурна. Эцэг эх яаж ярьж байна, хүүхэд тийм л хэмжээнд хэл сурна, багш нарын ярих урлагийг суралцагч даган дууриаж эзэмшинэ.

Хэл сурах

Хүүхэд эцэг эх, том хүмүүсийн яриа, телевизийн нэвтрүүлгийг чагнан байж, дууриан хэлж, ярьж байж, өөр хоорондоо ярьж, бичиж дадал олж, сурснаа бататгах журмаар хэлийг сурна. Аливаа хэлийг сурахад тухайн хүний сурах арга барил, оролдлого, авъяаснаас гадна **хэл сурах орчин** чухал нөлөөтэй.

Хүүхэд бүр юм бүхний учрыг олох, юм бүхнийг сурах хэмээн ид хичээж байдаг гурав хүртэлх насандаа төрөлх хэлээ сурна. Хүүхэд эхлээд үг бүрийн учрыг ухаж ойлгохгүй шууд л цээжлээд зөв буруу хэрэглэж эхэлнэ. Яваандаа үг, хэллэгийн учрыг ойлгон, зөв газар нь хэрэглэж, зөв хэлж сурна.

Зарим харь үг манай хэлэнд орж ирж он цагийн уртад нутагшаад эх хэлний үгнээс ялгарахгүй болжээ. Тухайлбал: **гарагуудын нэр** хийгээд **байшин, чийдэн, саван, рашаан гэх мэт** болой.

Гэтэл зарим үг монголд орж ирээд харьцангуй удаж байгаа ч гэсэн нэг л монгол төрхөнд орж өгөхгүй, сандрах ажээ. Тухайлбал: **граж, компьютер, сканер, нөүтбүүк** гм байна.

Аливаа орны залуучууд этгээд хэллэг үүсгэн чамирхан хэрэглэх боловч тэр нь төдий л удалгүй тэр үеэсээ ч өмнө хэрэглэгдэхээ больдог байна.

Харь хэлний зарим үг цагийн урсгалаар орж ирээд, мөн цагийн урсгалаар нутаг буцах нь буй. Жишээ нь өтгөрүүлж, лаазалсан чихэртэй сүүг **“молоко”** хэмээн хэлээд заншиж байснаа орос дэлгүүртэй цуг молоко ч алга болж, түүнтэйгээ цуг **“молоко”** хэмээх үг ч алга болсон билээ.

Оросууд жижиглэн хэрчиж амтлаад өлөн гэдсэнд хийн утаж болгосон мах оруулж ирсэн нь **“колбаса”** хэмээх нэрээ авч ирээд нэгэн хэсэг манай хэлэнд нутагшин **“долоо**

хорийн галбааса” болж айл гэрийн зоогийн ширээнд залардаг байснаа манай улс өөрснөө тэр хүнсний зүйлийг янз бүрээр нь хийдэг болсноос хойш галбааса доош болж, **“хиам”** дээгүүр суух болжухуй.

Нэгэн төрлийн удаан хадгалж болдог давсалсан бяслаг орж ирэхдээ **“сыр”** хэмээх орос нэрээ хөтлөн ирсэн боловч манай хүмүүс нэгэн төрлийн бяслаг байна хэмээн мэдээд **бяслаг** гэх болов.

Үүнээс үзэхэд аливаа хэлэнд харийн үг түүхэн тодорхой үеийн нөхцөл байдал, шашны урсгал, шинэ бүтээгдэхүүнтэй орж ирээд тухайн цаг үе өнгөрөх, тэр бүтээгдэхүүнийг тэр улс үйлдвэрлэдэг болсон үеэс өөрийн оноосон нэртэй болж, нөгөө **“гийчин үг”** маань нутаг буцдаг байна.

Бас хөгжлийн аясыг дагаад төрөлх үг анхны утгаа алдан өөр утгатай болох нь ч буй. Аливаа ажлыг гүйцэтгэх, төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх явцыг зохион байгуулдаг бүлэг хүмүүсийг **“удирдлага”** хэмээн нэрлэж байсан бол одоо хөтөлбөрийн дагуу тодорхой ажлыг гүйцэтгэдэг машиныг нэг хөтөлбөрөөс нөгөөд шилжүүлэх түлхүүрийг **“удирдлага”** гэх болжээ.

Өшөө гэдэг үг хорсол, занал гэсэн утгатай агаад өшөө авах, өшөө бодолцох гэсэн утгаар хэрэглэдэг.

Харин орос хэлний **“еще”** гэдэг үг нь ахиад байна уу, өөр байна уу? гэсэн санааг илэрхийлдэг.

Энэ хоёр үг адил төстэй дуудлагатай. Хүмүүс монголоор ярихдаа **“өшөө”** гэдэг үгээ орос хэлний **“еще”** гэдэг үгийн утгаар хэрэглэх болжээ. Ийнхүү монгол хэлний **“өшөө”** гэдэг үг утга нь оросжин **“өөр, ахиад”** гэсэн утга авчээ.

Зохиогч, орчуулагч, хэлмэрч хүн юуны өмнө яруу найртай ярьж, бичих шаардлага тулгарч байна. Сайн орчуулагч, зохиолчийн бичсэн ном уншихуйяа **яруу найртай**, уншихад хээр талаар салхи татуулан мориор давхих лугаа адил болж, бичсэн зүйл нь **утга төгс** нэг уншаад л ой тойнд буух бөгөөд хэрэглэсэн үг, өгүүлбэр хоёрдмол утгагүй **мэдэхүйеэ хялбар** байх болой. Тэгээд сайхан бичвэр ой тойнд амархан бууж, цээжлэхэд амархан байх болой.

Манай зарим сэтгүүлч нар үгийг онож хэлэхгүй, түүнийгээ засаж залруулахгүй болсоор удаж байна. Зүй нь **“харин”** гэдэг үгийг хэлж байгаа санаанаас өөр эсрэг санааг илэрхийлэхэд хэрэглэдэг байтал тухайн санааг өөр зүйлээр бататган илэрхийлэхэд хэрэглэдэг болоод удаж байна. Зүй нь **“Харин ч явсны үрээр овоо юм бүтлээ, яваагүй бол зуун задгай, жаран хагархай хэвээр л байх байлаа. Дорж хичээл таслах нь хэвийн үзэгдэл болжээ. Харин бат хичээлээ огт таслахгүй болсон.”** гэх утгаар хэрэглэдэг.

Анагаах ухааны номыг анх махчлан орчуулснаас эмнэлгийн мэргэжлийн хүмүүсийн дунд монголжоогүй үг хэллэг буй болоод **“өгөх”** гэдэг үгийг газар сайгүй нэмж хэлж хэрэглэдэг болоод удаж байна. Тухайлбал:

Өвдөхийг - өвдөлт өгөх; туурах – тууралт өгөх; хутгах – хутгаж өгөх; холих – хольж өгөх; дарах – дарж өгөх; төөнөх – төөнөж өгөх гэх зэрэг үгийг өгөх гэдэг үгтэй хамтатгаж хэрэглэх болжээ.

Өвдөж байна уу? гэхийг “Өвдөлт өгч байна уу?” Сайн хутгах хэрэгтэй гэхийг “Сайн хутгаж өгөх хэрэгтэй” гэх хэрэгтэй гэх мэтээр хэрэглэж байна.

Мөн тогооч нар ч “хольж өгч”, “хутгаж өгч”, “тавьж өгч байна”.

Алив хэл хөгжлийнхээ явцад тухай орны гадаад харилцаа хөгжиж, алив хувьсгал гарч, шинэ бараа таваар орж ирэхийн хэрээр тухайн оронд харь үг хэрэглэх явдал хэвийн үзэгдэл болдог бөгөөд зарим үг нутагшин тухайн хэлний үг мэт болох нь байдаг аж. Тэгэхдээ “усыг увал ёсыг нь дагана” гэгчийн үлгэрээр монгол хэлнээ хялбар дуудагдах үг л үлддэг ажгуу.

Мянга гаруй жилийн түүхтэй, монгол бичгээ их гүрний удирдагчийн шаардлага, шахалтаар хаяад, кирилл бичиг авч хэрэглэснээр зарим үгийг яаж бичих учраа ч олохоо больжээ. Яв явсаар зарим үгийг хүн бүхэн үзэмжээрээ бичиж, дур дураараа тайлбарлах болжээ. (**зөвлөгөө, зөвлөлгөө, больё, болоё, сурагч, суралцагч** г.м.)

Даяарчлалаар гадаад орноос хэрэгтэй, хэрэггүй олон зүйл үерийн ус мэт хаалт, боолтгүй орж ирэх болсон орчин үед хэлээ булингартуулалгүй, авч үлдэхийн тулд бид дараах гурван зүйлийг хийж, даруй мөрдөх шаардлагатай мэт санагддаг.

Үүнд:

1. Хэлний нэр томъёоны комиссыг зохих ёсоор нь ажиллуулан давын өмнө шинээр орж ирээд байгаа харь үгийн алиныг орчуулах, алиныг хэвээр хэрэглэхийг ялгаж салган тогтоох, цаашид шинээр орж ирж байгаа үгсийг ямар үгээр орлуулахыг тогтох, оноосон үгийн тайлбар толь гарган нэр томъёоны комиссын гаргасан оноолттой нийцүүлэн шинэчилж байх. Нарийн мэргэжил, шинжлэх ухааны нэр томъёог нэг мөр болгон нэгдмэл нэг үгээр нийтээр хэрэглэж хэвшүүлэх нь алив нэг үгийг хоёрдмол бус утгаар ойлгох болж, оюутан, суралцагч, судлаачдад амар, орчуулагч хэлмэрч нарын ажилд, ялангуяа нарийн мэргэжлийн номыг орчуулахад хялбар болох болой.

2. Кирилл монгол бичгийн дүрмийг нэг мөр болгон бүх шатны сургуулийн хичээлд заан, сонин хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, албан бичиг баримт, уран зохиол, орчуулгын номонд мөрдүүлэх шаардлага нэн дуруй гарч байна.

3. Бүх л газар, яам, албан байгууллага, боловсролын байгууллага, компанийн бичиг баримт, зар сурталчилгааг нэгдсэн нэг дүрмээр бичүүлж, бүх газрын хаягийг хэвшүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Буруу орчуулгаас үүдсэн буруу нэршлийн асуудал

Г.Элдэв-Очир²⁶ (МУИС, ШУС)

Товч утга: *Хэл сэтгэхүйн шүтэлцээ нь нарийн нягт уялдаатай байдаг бөгөөд энэ нь орчуулгад туйлын чухал ач холбогдолтой билээ. Буруу орчуулга нь тухайн хэлэнд таашаа ойлголт бий болгож, хэлний хэм хэмжээнд нөлөөлөн, тэр нь эцэстээ хэвшил болж тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний сэтгэлгээг өөрчилдөг байна.*

Түлхүүр үг: *Хэл сэтгэхүй, буруу орчуулга, буруу нэршил*

Хэл нь сэтгэхүйн тусгал бөгөөд тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний сэтгэлгээний онцлогийг харуулж байдаг. Сэтгэхүй нь хүний танин мэдсэн бодит байдлын тусгал бөгөөд зөвхөн хэлээр бүрэн гүйцэд илэрхийлэгдэнэ. Хэлийг сэтгэхүйгээс салгавал хий хоосон дуу авиа болох төдийгүй авиа утга уялдсан харилцааны хэрэгсэл болж чадахгүй билээ. Хэл нь сэтгэхүйн оршин тогтнох үндэс, сэтгэхүй нь ч хэлний оршин тогтнох үндэс болох буюу хэл сэтгэхүй нь туйлын нягт шүтэлцээтэй юм. Энэ талаар XX зууны эхэн үеэс судлаачид үе шаттай судласаар өнөө үетэй золгож байна.

Хэл сэтгэхүйн шүтэлцээ орчуулгазүйд чухам ач холбогдолтой бөгөөд аливаа орчуулга нь зөв, буруу болох аваас тухайн орчуулгын хэлдээ тодорхой хэмжээгээр нөлөөлж байдаг. Зөв сайхан, яруу тансаг орчуулга нь тухайн хэлээ баяжуулан хөгжүүлдэг бол, болхи буруу орчуулга нь хэлээ гутааж, улмаар сэтгэхүйд муугаар нөлөөлж, тэрхүү буруу орчуулгаар хүмүүс ярьж, ойлгох явдал газар авсаар хэвшил дасал болж, ийм л байсан, ийм л байх ёстой мэтээр сэтгэхэд хүрдэг ажээ.

Энэхүү үзэгдэл монгол хэлэнд ч байгаа төдийгүй нэлээд архагшсан шинжтэй болсныг бид бүхэн сайн мэдэж байгаа билээ. Иймд энэхүү илтгэлдээ цөөн хэдэн жишээ татан тайлбарлахыг оролдлоо.

Ерөнхийдөө орчуулгад гаргаж буй зарим алдааг үгийн сан болон хэлзүйн утгын талаас нь авч үзлээ. Үүнд:

1. Үгийн сангийн буруу дүйцэл буюу үг оноолтын алдаа

Аливаа орчуулгад, ялангуяа нэр томъёоны орчуулга, нэр оноох тал дээр тухайн үгийн үгийн сангийн утгыг төдий л хайхраагүйгээс алдаа гаргах явдал байна. Тухайлбал,

“Дэд бүтэц” – infrastructure – инфраструктура – 基础设施

Энэхүү ойлголт нь угтаа тухайн орны хөгжлийн үндэс суурь болсон зам тээвэр, эрчим хүч, дулаан зэрэг салбарыг хамардаг. Гэтэл нэр томъёоноос харахад “дэд” буюу хоёрдугаар, хоёр дах (дэд сайд, дэд хурандаа, дад гарчиг) гэсэн утга бүхий үгээр орчуулан

26 МУИС-ийн ШУС-ийн ази судлалын тэнхим, дэд профессор, доктор

хэрэглэсэн нь тун оновчгүй болжээ. Харин энэхүү үгийг хятад хэлэнд “基础设施” буюу “суурь байгууламж, суурь бүтэц” хэмээн оноосон байдаг. Үүнээс үзэхэд, тухайн улсын амин сүнс болсон салбараа “дэд” хэмээснийг засч залруулах шаардлагатай болжээ.

“Хүүхдийн автобус” –school bus

Одоо бараг бүх сургууль сурагчдаа зөөдөг ийм нэртэй унаатай болжээ. Миний бодлоор, энэхүү нэрний “хүүхдийн” гэдэгт гол учир байна. Учир нь “хүүхдийн ор, хүүхдийн хувцас, хүүхдийн тоглоом” гэх мэт хүүхдэд зориулсан жижиг эд, эдлэлийг нэрлэсэн үг хэллэг бий. Гэтэл “хүүхдийн автобус” гэхэд нэг л тохиромжгүй санагдах юм. Үүний оронд “ажилчдын автобус” гэдэг шиг “сурагчдын унаа/автобус”, эсвэл, “сургуулийн унаа/автобус” гэвэл арай дээр болох болов уу гэж бодогдоно.

“Халтар царайт”

Ийм нэртэй олон ангит кино 1990-ээд оны дундуур нэг хэсэг зурагтаар гарч монголчуудыг хуйлруулж байсан билээ. Хэдийгээр одоо гарахаа больсон ч гэсэн санаа авах үүднээс энэхүү жишээг татлаа. Учир нь, “халтар царай” байж болох уу гэдэг бодол төрж байна. Яагаад гэвэл, “царай” нь хүний нүүрний өнгө зүс: царай барайлгах, царай алдах, царай орох, царай муутай (Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, УБ, 1966) гэх зэргээр жишээ татаж болно. Өөрөөр хэлбэл, царай гэдэг эхээс төрмөл бөгөөд хүн царайлаг, царай муутай гэх мэт байхаас халтар царайтай лав байхгүй нь. Нүүрээ угаах гэж хэлэхээс, царайгаа угаах гэддэггүй билээ. Ийм ч учраас Я.Цэвэл гуайн тольд, халтар гэдэг үгийн 5 дах утга нь, цэвэр биш, хир буртагтай, алаг тарлан болсон нь гээд, халтар болох, дээл халтар болгох, халтар нүүртэй гэх мэт жишээ татаж тайлбарлажээ. Үүнээс үзэхэд, энэхүү киноны нэр уг нь “Халтар нүүрт” байх ёстой байжээ.

2. Хэлзүйн алдаа

Сүүлийн үед орчуулга сүрхий хөгжиж олон хэлнээс төрөл бүрийн ном, зохиол орчуулах болсон нь сайшаалтай боловч хэлзүйн алдаа нь энэ хэмжээгээр нэмэгдэж байна. Тухайн хэлзүй нь хэлний амин сүнс буюу хүн хүн дураараа өөрчлөөд байж боломгүй нэг ёсны хууль дүрэм юм. Гэтэл орчуулгад хэлний хууль дүрэм болсон хэлзүйн зарчмыг зөрчиж байгаа нь монгол хэлний зүй эвдэрч, улмаар монгол хүний сэтгэхүй өөрчлөгдөхөд хүргэнэ. Энэ бол харь үг хэллэг нэвтэрэхээс ч илүү хор хөнөөлтэй юм. Өөрөөр хэлбэл, харь үг орж ирэх нь хэдий гэмтэй ч буруу орчуулга нь түүнээс илүү аюултай байх болно. Тухайлбал,

- “...Манай улсад ойролцоогоор **40 орчим мянган ажилгүй залуучууд** байна...” Энэ нь хэдийгээр орчуулга биш, нэгэн сэтгүүлчийн бичсэн мэдээ ч гэлээ хэлзүйн алдаатай байна. Ийм алдаа одоо хэвийн зүйл мэт болсон. Монгол хэл олон тооны утгыг ийнхүү давхцуулан хэрэглэдэггүй. Гэтэл орос, англи зэрэг хэлнээс хийсэн алдаатай орчуулгын балаг ийнхүү монгол хүний бичсэн өгүүлбэрт ч тохиолдож, бүр хэвшил болж, ийм байх ёстой мэт болжээ.

“Хүн аалз” – Spiderman, 蜘蛛人

Энэ нь хүүхэд, залуучуудын сайн мэдэх киноны нэр. Энэхүү нэрийг ухаж бодвол, хүн шиг (оюун ухаан, гаднах байдал г.м) аалзны тухай гардаг кино мэт ойлгогдоно. Өөрөөр хэлбэл, хүн нь тодотгол болж, аалз нь гол гишүүн болсон байна. Гэтэл уг кино нь аалз шиг болсон хүний тухай гардаг. Англи хэлзүйгээс харахад ч “spider” нь хүн, юмыг тодотгогч нэр үгээр илэрсэн тодотгол болох бөгөөд “man” нь гол гишүүн буюу тодотгуулагч болох аж. Харин монгол хэлэнд орчуулахдаа, “аалзан хүн”, эсвэл, “аалз хүн” гэдэг юм уу иймэрхүү байдлаар буух ёстой байсан санагдана. Үлгэрлэвэл, **Төмөр хүн – хүн төмөр, 33 модон хүний үлгэр – 33 хүн модны үлгэр** гэсэнтэй ижил болжээ.

“Нийгмийн хэл шинжлэл” – Sociolinguistic – социоллингвистика, 社会语言学

Манай хэл шинжлэлийн зарим ном бүтээл, толь бичигт энэхүү нэр томъёо ийм байдлаар тааралддаг. Миний бодлоор, энэхүү нэр томъёоны гол учир нь “нийгмийн” хэмээн харъяалахын тийн ялгалын “-ийн” нөхцөл авсанд байгаа юм. Энэ нэр томъёо англи, орос, хятад хэлэнд ч хамаатуулсан нөхцөл аваагүй байна. Ингэж ижил түвшиний, ижил үүрэгтэй буюу бие биетэйгээ нөхцөлдсөн хоёр ойлголтыг нэгийг нь нөгөөд хамаатуулснаар хэлзүйн утгыг алдаа гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, хэлбэрийн хувьд харъяалахын тийн ялгалын ганц нөхцлийн асуудал мэт харагдавч ухаж бодвол цаанаа цтга ялгаж байгаа юм. Үлгэрлэвэл,

Хот айл – хотын айл

Хөвсгөл нуур – Хөвсгөлийн нуур

Хөдөө арал – хөдөөний арал гэх мэт болох ажээ.

Дээрхээс дүгнэж үзвэл, орчуулга нь гагцхүү тухайн хэлээр буй үг хэллэгийг нөгөө хэлээр солих төдий биш бөгөөд ялангуяа орчуулж буй хоёр хэлний үгийн сан, хэлзүйн бүтэц, утга зүйн түвшиний мэдлэг ойлголт тун чухал юм. Үүнээс гадна, манайд гадаад хэлний үгийн сан, хэлзүйн судалгааны ном, сурах бичиг нэлээд байх боловч зэрэгцүүлсэн хэл шинжлэлийн бүтээл ховор төдийгүй, энэ чиглэлийг орчуулгазүйд хамруулан нийтийн хүртээл болгож, үгийн сангийн зэрэгцүүлэл болон орчуулгазүй, хэлзүйн зэрэгцүүлэл болон орчуулгазүй, өгүүлэмжийн зэрэгцүүлэл болон орчуулгазүй зэрэг чиглэлээр судалгаагаа өргөжүүлэн хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ашигласан ном

1. Оюунцэцэг.Ж, Англи хэлний зүй, УБ, 2007
2. Ринчен.Б, Марк Твенний минь махы нь идэж дээ, УБ, 1991
3. Цэвэл.Я, Монгол хэлний товч тайлбар толь, УБ, 1966
4. Энхбат.Д, Хэл шинжлэлийн англи-орос-монгол толь бичиг, УБ, 2003
5. 许余龙, 对比语言学, 上海, 2003
6. 王德春, 语言学新视角, 上海, 2011

Монгол хэлц үгийн орос орчуулгын асуудалд

Д. Цэдэнжав²⁷ (МУБИС, ГХС)

Товч утга: Зохиогч энэхүү өгүүлэлд монгол түмний ахуй амьдрал, сэтгэлгээний эв маягтай нягт холбоотой байдаг хэлц үгийг орчуулах асуудлыг хөндсөн юм. Монгол хэлц үгийг орос хэлэнд орчуулахад тохиолдох бэрхшээлийн талаар өөрийн бодлоо илэрхийлжээ.

Түлхүүр үг: Суурин иргэншил, нүүдлийн иргэншил, сэтгэлгээний хэв маяг, бодит утга, монгол үндэстний өвөрмөц онцлог.

Нүүдлийн соёл иргэншлээ хадгалан үлдсэн сүүлчийн орнуудын нэг болох Монгол орон, өөрийн үндэсний соёл, заншил, амьдрал ахуйнхаа олон зүйлээр суурин иргэншил голлон хөгжсөн бусад орноос онцгой ялгагдах тул судлаачдын анхаарлыг татаж байдаг билээ. Хүрээлэн байгаа орчиндоо хандах хандлага, сүсэг бишрэл, түүхэн уламжлал, ард түмний ёс заншил нь монгол түмний сэтгэлгээ, хэл ярианд нь илэрч байдаг.

Ард түмний ёс заншил, ухаан бодол, сэтгэлгээний хэв маяг, ертөнцийг үзэх үзэл хэлц үгэнд онцгой тод тусгалаа олдог. Уран сайхны зохиол, бүтээлийг нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулах үед ард түмнүүдийн хоорондох ёс заншил, сэтгэлгээний хэв маяг, ертөнцийг үзэх үзэл бодлын ялгаа тод харагддаг. Монгол түмний цайлган цагаан сэтгэл, даруу зочломтгой зан, сэтгэлийн хөдлөлөө ил гаргахгүй байдал, оросын ард түмний тэвчээр зориг, шулуун шудрага зан зэрэг чанарууд тухайн ард түмний хэлц үг, зүйр цэцэн үгэнд тусгалаа олсон байдаг.

Монголын үндэсний өвөрмөц онцлог, тухайлбал малчин ардын ахуй амьдрал, шашин шүтлэг, түүх соёлын өвөрмөц үзэгдлийг тусгасан зан заншил, хувцас хунар, орон гэр, цаг хугацаа, хоол хүнс, сав суулга унаа хөсөг гэх зэрэг баялаг реалийг тусгасан роман бол Ч. Лодойдамбын “Тунгалаг Тамир” юм. Энэ романыг орос хэлээр зөвлөлтийн /хуучнаар/ нэрт монголч эрдэмтэн, орчуулагч А.Дамба-Ринчинэ орчуулжээ. Монгол түмний үндэстний гэх шинж чанарыг тусгасан зарим хэлц үгийг тус романы орос орчуулгад хэрхэн орчуулсныг авч үзье.

Хэлц үгсийг хадмал байдлаар орчуулах нь зүйд нийцэхгүй нь мэдээж хэрэг. Гэхдээ зарим хэлц үг орчуулж байгаа хэлний тодорхой хэлц үгтэй утга, найруулгын хувьд таарч тохирох явдал байдаг. Жишээ нь: *Галсан бол Итгэлт Дулмаагийн явдлыг сайн мэдэвч нүд балай, чих дүлий мэт явдаг байлаа* [Т.Т. 61]. “Галсан знал о связи Итгэлта и Дулмы, но старался на это **смотреть сквозь пальцы**” [П.Т. 52]. Энд хоёр хэлний хэлц үгэнд орсон үг, үгчилсэн утга нь өөр өөр боловч, эдгээр хэлц үгсийн илэрхийлж байгаа утга нь ижил байна.

27 МУБИС, ГХС, ОХУЗТ, доктор, дэд профессор

Тухайн хэлц үгтэй дүйх орос хэллэгийг олж чадвал утга нь уншигчдад илүү ойлгомжтой болдог нь энд харагдаж байна.

Алив зүйлд тэвчээртэй хандах чанарыг монголчууд дээдлэн үздэг учир энэ чанарыг илэрхийлсэн хэлц үг монгол хэлэнд элбэг тохиолддог. “*Үнэн явбал үхэр тэргээр туулай гүйцнэ*” гэдэг зүйр үгийг монголчууд байнга хэрэглэдэг бөгөөд, бидний авч үзэж байгаа романд ч олон тааралдана. Жишээ нь, зохиолын гол баатрын нэг шудрага зантай Төмөр: *Больё доо. Үнэн явбал үхэр тэргээр туулай гүйцнэ гэдэг. Юу л болбол болог. Би энэ засгийг байгуулахад бага боловч оролцсон нь үнэн юм даг гэж Төмөр хэлэв* [Т.Т. 576] гэснийг: “Не буду! Говорят, **если правильно поедешь, и на быках зайца догонишь**. Будь что будет! А в установлении этой власти я по-своему участвовал, - сказал Тумэр” [П.Т. 473] гэж орчуулсан байна. Энэ монгол зүйр үгийг орчуулагч маань үгчлэн орчуулж утгыг дамжуулсан нь утга, найруулгын хувьд учир дутагдалтай болсон шиг санагдана.

Монгол хэлэнд таван хошуу малыг оролцуулсан зүйр цэцэн үгнүүд олон байдаг. Тэдний заримыг орос орчуулгад хэрхэн буулгасныг харья. “*Тэмээчин хүн буурынхаа занг андахгүй*” гэгчээр Должин нөхрийнхөө завхайг сайн мэддэг боловч яаж ч чаддаггүй” [Т.Т. Х. 48]. “Она знала обо всех проделках своего распутного мужа. *Так пастух знает все повадки табунного жеребца*” [П.Т. 48]. Орос руу орчуулахад орос хүний сэтгэхүй, ахуйн онцлогийг харгалзахгүй, үгийг үгээр солин махчлан буулгаж болохгүй нь мэдээж. Гэвч орчуулагч буурыг азарагаар солин буулгаснаар монгол хэлц үгийн бодит утга орос хэлээр илэрч гарсангүй.

Монгол утга зохиолын хэл бол маш баялаг, дүр дүрслэл нь нарийн өвөрмөц, зүйр цэцэн үг ихтэй учраас тэр болгоныг орос хэлнээ буулгах нь тийм ч амар ажил биш. Жишээ нь: *Гэвч Эрдэнэ “Уухай, хашир чоно, чи бидний дотор орж авья гэж бодож байна уу? Хэн нь хэнийхээ хөлд нь суухаа үзье” гэж бодоод...* [Т.Т. 438] гэснийг орчуулагч А. Дамба-Ринчино: “Что ж, волки добровольно идут к нам. Ладно, пусть идут! Еще посмотрим, **кто у чьих ног будет сидеть**” [П.Т. С.344] гэж буулгажээ. Энэ тохиолдолд орчуулагч хэлц үгийн утгыг “хөлд суух” гэдэг хэлц үгийг “хөлийн доор орох, бөхийх” гэсэн утгаар/ ташаа ойлгон орчуулсан байна. Эдгээр жишээ “... орчуулж байгаа зүйлийнхээ нарийн ширийн утгыг сайтар ухан ойлгохгүй... алдаа мадаг гаргах нь зохиолчийн хэлэх санааг гуйвуулах, тэс өөр утгатай болгох, уран сайхны дүр дүрслэлийг бүдгэрүүлэх, улмаар давс хужрыг нь тунгаан гаргаж чадахгүйд хүргэх осолтойг...”/ Эрдэнэмаам С., Х. 150/ тод харуулж байна.

Ч. Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы орос орчуулгад монгол хэлц үгээр илэрсэн реалийг буулгахдаа орчуулагч олон арга ашигласан нь харагдаж байна. Үүнд: монгол хэлц үгийг утгаараа таарч тохирох орос хэлц үгээр буулгах, орос хэлээр шууд буулгаж болохгүй хэлц үгийг утга дүйх үгээр орчуулах, үгчлэн орчуулахад ойлгомжтой монгол хэлц үгийг

шууд хуулбарлан буулгах зэрэг олон арга хэрэглэжээ. Гэвч монгол үндэстний өвөрмөц онцлогийг тусгасан зарим цөөн хэлц үгийн утгыг нь ойлголгүй орчуулсан нь цаашид анхаарах зүйлийн нэг болжээ.

Резюме

Автор статьи затрагивает проблемы перевода монгольских фразеологизмов, тесно связанных с бытом и образом мышления народа и делится своим мнением по поводу их передач на русский язык.

НОМ ЗҮЙ

1. Будилова Е. А. Социально-психологические проблемы в русской науке / Е. А. Будилова. - М.: Русский язык, 1983. – 248 с.
2. Дамдингийн Цэдэнжав. Лингвостилистические аспекты перевода с монгольского языка на русский / Дамдингийн Цэдэнжав // - Улан-Удэ: изд-во БГУ, 2010. -160с.
3. Лодойдамба Ч. Тунгалаг Тамир / Ч. Лодойдамба // Монголын уран зохиолын дээжис, - Улаанбаатар. 1997. - Т. 30. – 632 с.
4. Чадраабалын Лодойдамба. Прозрачный Тамир / Ч. Лодойдамба. - М.: Прогресс, 1981. – 496 с.
5. Эрдэнэмаам С. Ойлгох нь орчуулахын амин сүнс // Орчуулгазүй, 2013, № 01, - Улаанбаатар, "Удам соёл" ХХК, 2013.

Хятадын эртний сонгодог шүлгийн орчуулгын зарим асуудалд

Ц.Сүрэнжав²⁸

Удиртгал

Хятадын эртний шүлгээс орчуулж олон бүгдийн таашаалд хүргэж, эртний хятадын яруу сэтгэлгээний охь дээжээс олны хүртээл болгох гэсэн дуун хөрвүүлэгч, яруу найргийг шимтэн сонирхогчид болон хэлний мэдлэгийнхээ шандасыг соригчид өдрөөс өдөрт олон болж байгааг юуны өмнө онцлон хэлмээр байна. Үүний хамгийн сүүлчийн жишээ гэвэл сүүлийн үед Соёл яруу найргийн академиас эрхлэн хэвлүүлсэн “Хятадын яруу найраг” эмхэтгэл, “Гурван зуун шүлэгт” хэмээх дэлхийн шилдэг яруу найргийн түүврийг нэрлэж болно. Эртний Хятадын яруу найраг, яруу сэтгэлгээний нэрд гарсан гол төлөөлөл нь Тан гүрний үед хамаарах бөгөөд тэр үеийн гол төлөөлөгчид Дү Фү, Ли Бай, Ван Вей, Бай Жү И нар байсныг та бүхэн гадарлах ёстой. Хятадын урлаг, утга зохиолын түүхэнд “Тан улсын шүлэг, Сун улсын үглэл, Юань улсын дуулал” гэсэн нэг тогтсон хэллэг байдаг бөгөөд Хятадаар Тан ши, Сун цы, Юань чү гэхүл мэдэхгүй хүн бараг байхгүй билээ. Энэ бол Тан улсын үед яруу сэтгэлгээ туйлдаа хүрсэн, Сун улсын үед хүүрнэл зохиол ихэд хөгжсөн, Монголын Их Юань гүрний цагт дуу дуулал мандан бадарсан гэсэн утга болно.

Хуучин цагт, өөрөөр хэлбэл, өнгөрсөн зууны 90-ээд оноос өмнө манайд Хятадын эртний шүлэг дууллыг орчуулан буулгагчид төдий олон биш, байсан ч гэсэн орчуулснаа нийтэд хүргэхэд амаргүй, утга зохиолын хяналтыг давахад хэцүү байсан гэдгийг шударгаар хэлэх ёстой. Манай ахмад үеийн дуун хөрвүүлэгчдээс энэ талд хамгийн эхэлж мөр гаргаж шан таталцсан хүн бол та бидний их багш Ц.Базаррагчаа гэдгийг бид мэднэ. Өнгөрсөн зууны 60-аад оны үед их найрагч Б.Явуухулан, Ч.Чимид нар орос хэлээр дамжуулж Хятадын их найрагчдын бүтээлээс харгуулан буулгаж олны хүртээл болгосныг хэлэхгүй өнгөрч бас болохгүй билээ.

Гэвч Хятад шүлгийг тэр дундаа эртний шүлгийг өөр гуравдагч угсаатны хэлээр дамжуулж буулгана гэдэг нэгд гол эхээс тэр мэтээр холдох, нөгөө талаар арга ядсан хэрэг гэдгийг хэлэх хэрэгтэй боловч ийм нарийн чимхлүүр ажлыг зориглон буулгасан нь аргагүй л цэцэн цэлмэг авьяас билэгтээ түшиглэсэн хэрэг байж таарна. Нэг үгээр хэлэхүл тэдгээр ахмад дуун хөрвүүлэгчдэд бид талархаж явах ёстой гэх гэсэн хэрэг.

Харин өнөөдөр байдал өөр боллоо. Манайд хятад хэлийг сурч судлах, хөрш ард түмнийхээ хэл соёл, урлаг утга зохиолыг сурч судлах, орчуулж буулгах энэ нэн чимхлүүр,

нөр хичээнгүй буянтай үйлсэд санаа шулуудан зүтгэгчид олноор гарч ирж байгаа нь онц сайшаалтай байна. Манай эдгээр дуун хөрвүүлэгчдийн жагсаалын эхэнд Монгол улсын СГЗ Ц.Базаррагчаа, доктор Я.Ганбаатар, М.Чимидцэеэ, Д.Болдбаатар нар толгой цохиж, хошуу өлгөж явааг хэлэхэд бахтай байна.

Манай монголчуудын нэг үеийнхэн Хятадын эртний шүлэгтэй өвөрлөгч нарын ачаар танилцсан гэвэл хэтрүүлсэн болохгүй. Үүнд өнгөрсөн зууны 60-аад онд Монгол худам үсгээр хэвлэгдэж тарсан “Тан улсын шүлэг, гурван зуун бадаг” гэдэг эртний шүлгийн түүвэр ихээхэн хэрэг тус болсон байдаг. Гэвч өвөрлөгчдийн хэлний хүрсэн түвшин дутахгүй ч Монголын шинэ үеийн яруу найргийн хүрсэн түвшингээс баахан хоцорч асан болохоор яруу дуурсал, цэц оновч дутагдаж байсныг ч хэлэх хэрэгтэй.

Дуун хөрвүүлэхүй:

Шүлэг орчуулна гэдэг бол тун ч хүнд хөдөлмөр, дуун хөрвүүлэгчээс хэлний өндөр мэдлэг, яруу сонсголон, нарийн мэдрэмж, уран сэтгэмжийг шаарддаг зүйл. Хэн хүн харь хэл халтартуулж өчүүхэн сураад шүлэг найраг, тэр дундаа Хятадын эртний шүлэг найргаас дуун хөрвүүлэг хийе гэвэл “намгийн мэлхий нар сарыг зүүдэлсэн үлгэр”-тэй агаар нэг зүйл болох нь лав. Зориг гаргаж зүрхлээд толь эргүүлсээр хадаж орхиё гэхүл тэр бол сайн орчуулга биш, саархан оролдлого төдий болно. Шүлэг орчуулахад, ер аливаа дуун хөрвүүлэг хийхэд ямар нэг жор байхгүй, томъёолж тогтоосон онол арга зүй гэж юм байхгүй. Хэрэв тийм зүйл байх хэрэгтэй гэвэл тэр нь онгод, ойлголт, мэдрэмж, сэтгэмж л байж таарна. Тийм болохоор нэг шүлгийг хэдэн ч хүн өөр өөрийнхөөрөө орчуулан буулгасан байж болох бөгөөд харин нэвтрэн гарах санаа нь зөрөхгүй бол илтгэн гаргасан арга нь өөр байхыг үгүйсгэж болохгүй билээ. Өнөөдөр тийм ч байгаа билээ. Дуун хөрвүүлэгчдийн арга барил өөр өөр, тэдний уран сайхны шүүлтүүр ижилгүй болохоор илтгэн харуулах чадвар нь ч өөр өөр байж болно.

Хятадын эртний шүлгийг эх хэлэндээ буулгая гэвэл юуны өмнө түүнийг уншаад ухаарч ойлгох хэрэгтэй нь мэдээж. Ойлгоогүй хүн орчуулна гэвэл мэдээж энэ нь эрүүл хүний ажил биш. Бас дээр нь бичиж буулгасан үсэг нь эртний үг үсэг, ханз нь хэдэн мянган жилийн өмнөх “хуучин” ханз, хэрэглэсэн үг утга нь өнөөгийнхөөс онхийн өөр, тэр цаг үе нь тэс өмнөө байх тул ёстой л мянган бэрхшээл, түмэн тарчлаан болох ч бий.

Дү Фү-гийн “Мөрний тосгон” мөчлөг шүлэгт

Тунамал мөрөн тахирлаж тосгоныг тэврэн урсму

Ченся мөрний суурин түмэн явдалдаа түүртмү

Түүчээлэн ирж гүүрнээ үүрлэх хараацай шувууд

Төрөлсөн шагшаад голын уснаа элэгдэн нисэлдмү

Өтөл эмгэн зурагт цаасыг эвлүүлэн шатрын хөлөг болгому

Өлчир хөвгүүн уран үйлийн зүү матаж гөх дэгээ үйлдмү

Өвчин эмгэгийг засахад хэрэгтэй ховор живэр эмийн ургамал

Өнөөх газарт сэмхэн ургах нь өөр бусдад хичнээн их тустай бол!

хэмээсэн нь тухайн үеийн нийгмийн амьдрал, хүмүүний явдлыг маш урнаар дүрсэлсэн хэрэг юм. Ядахдаа л Тан гүрний үед шатар наадаад сурчихсан байж шүү гэдгийг мэдээд авмаар.

Хятад хэл бол хөг ая дантай хэл. Эртний их найрагчид хятад хэлний энэ өвөрмөц хөг аялгууг нягт нарийн зохируулж, хөгжим шиг хөглөн тааруулж үгийн тоог алдалгүй, илүү ч үгүй, дутуу ч үгүй хайрцаглан бичсэн нь үзтэл илт байдаг. Ерөөс шүлэг гэдэг бол хамгийн гүн гүнзгий санаа, дүрслэлийг хамгийн цөөн үгээр илтгэхийн урлаг гэж болно. Өөрөөр хэлбэл, “мини махс” зарчим буюу “минимальный хэрэгслээр максимальный санааг” гаргана гэсэн үг болно.

Гэтэл манай Монголын хэлний илтгэх арга өөр, Хятад шүлгийн мөр, шадын ая даныг тааруулах боломж ховор дутмаг, гол арга нь толгой сүүл холбох аргыг зохилох болохоор мөр хоорондын холбоосыг зөв сонгож, эгшиг ижилсүүлж, гийгүүлэгч хоршуулан хэрэглэж, санааг оновчтой, дуурсалтай болгох өөр байж болох бололцоонуудыг өргөн ашиглана гэсэн үг болно.

Ли Бай-гийн “Хаврын санаашрал” шүлэгт:

Ян газрын өвс ногоолин утас мэт
Ялмын модны навч намиа гэмээр
Ямбат ноён эргэн ирэх тэр өдөр
Янтгар эхнэр яаядаа гэх цагаар
Хаврын салхин хэн билээ хэмээн
Хамаг явдлыг хайцаалан далдалж
Халхавч асрын дотор тас нуугаад
Харагдах юм юу байна гэх гээ юу тэр?

гэсэн нь байгалийн төрх байдал хүний сэтгэлийн санаашрал, тэр цаг үеийн ханш, дээдсийн явдлыг дэлгэн тавьсан сонирхолтой атлаа гүн утгыг агуулсан зохиомж болжээ.

Бай Жү И “Лю Ши Жю-гаас асууруун” гэх мөчлөгтөө:

Ногоон шоргоолж шиг цэхэлзэх түүхий нэрмэл дарс шимж
Улаан шавар зууханд дүрэлзэх шүрэн галын хэлэнд дулаацаад
Намар оройн буурал тэнгэрээс манаран буух ариг цасыг ширтэн
Ууж суухуу даа яахав? хоёул ганц нэгэн хундага дарсны охийг...

хэмээсэн нь цаг улирлыг хүний сэтгэлтэй нийтгэсэн сонин содон дүрслэл болжээ гэмээр.

Ван Вей “Уулсын дунд” мөчлөг шүлэгтээ:

Цахир цагаан чулуун дороос эмнэг горхи бургилна

Цантай тэнгэрийн хээлэнд улаан навч санжганана

Уулын замаар замнахад ус бороо угаас байхгүй атал

Улс амьтны хувцас хунарыг ууршуулан чийгтүүлэх нь хачин

гэсэн нь манай Монголын уул хөвчид ч мөн л иймэрхүү юм тохиолддогийг харж байгаад хэлж орхисон шиг санагддаг авай.

Орчуулга гэдэг дуун хөрвүүлэгчийн өөрийн дархан эрх бөгөөд зөвхөн миний буулгасан л туйлын зөв бусад нь юу ч биш гэвэл баахан балмад бас өчүүхэн ичгүүрийн хэрэг болно. Хэнийх нь арай дээр болсныг хэлээд өгдөг нь өргөн олон уншигчид байдаг.

Энэ мэтээр цааш олон зүйлийг өгүүлж, олон шүлэг хэлж болох авч огсойж байхаар орчуулж сурвал дээр гээд энэ мэтсийг энд хүргэе.

Шүлгийн орчуулгад анхаарууштай хэдэн зүйл

1. Хятад шүлэг найраг, ялангуяа эртний шүлэг орчуулахдаа манай хүмүүс хялбарчлах, хуулбарлах, хүнээр хэлүүлж хадуулах, өөр хэлнээс харгуулах зэргээр орчуулсан болж буулгадаг явдал нилээд газар авч байх шиг байна. Хүн бүхэн хятад хэл сурах албагүйтэй адилхан хятад шүлэг орчуулах гэх албагүй билээ. Шуудхан хэлэхэд хэн дуртай нь хятад шүлэг орчуулахад хүрвэл мэргэд мэрийж суугаад ч яах билээ.
2. Хэлний хүрсэн түвшингээс гадна яруу сайхны мэдрэмж гэж юмаар дульхан бол олигтой сайн орчуулга хийнэ гэхэд ахадсан явдал болно. Орчуулга оролдлого хоёр арай өөр зүйл болохоор оролдсоноо орчуулга гэж бодоод хэвлүүлэх гэвэл осол цалгар болж байгаа хэрэг болно.
3. Нэр томъёо, яруу найрагчдын нэрийг нь ядахдаа зөвөөр галиглаж баймаар байна. Жишээ нь Бай Жү И гэдэг их найрагчийн нэрийг дандаа Бай Зүй И гэж бичиж байгаа нь буруу юм. Энэ бол Оросын бичлэг дуудлагыг дагасан хэрэг. Үнэндээ бол Бай Жү И гэх ёстой. Өмнө нь тэгээд тогтсон гээд байвал шинэчлэлийн утхай яриа байж таарахгүй билээ.
4. Шүлэг дуулал орчуулахад ямар нэг хэмжээүр стандарт тавихад хэцүү ч гэлээ шүүмж судлалыг орхигдуулж боломгүй юм. Эдүгээ энэ талаар идэвх зүтгэл гаргаж байгаа хүн бол манай Я.Ганбаатар байна. Харин энэхүү үйлсэд залуу багш нар, хятад хэлний оюутан сурагчид идэвх гаргаасай билээ гэж хэлмээр санагдаж байна.
5. Эцэст нь нэг санал тавихад хятадын түүхэн богино хэмжээний хүүрнэл “Лантингийн оршил” өгүүллийг орчуулах уралдааныг оюутнуудын дотор зарлаж дүгнэвэл маш зохимжтой гэмээр байна. Сайн хүүрнэл муу шүлгээс яруу сайхан байдаг ч тал бий билээ.

Хятад зүйр цэцэн үгийг монгол хэлнээ орчуулах нь

П.Уянга²⁹ (МУИС, ШУС)

Товч утга: Хятад зүйр цэцэн үг нь бусад улс үндэстний аман зохиолын нэгэн адил тухайн орны үндэстний онцлогийг илтгэн гаргадаг, хэмжээгээр бяцхан атлаа оновчтой, уран дүрслэлтэй, гүн утгатай тул зохиогч, бичгийн хүмүүсийн судалгааны нэгэн хэрэглэгдэхүүн болдог билээ.

Аливаа хэлний зүйр цэцэн үг нь тухайн ард түмний түүх соёл, зан заншил, аж байдал, бодол сэтгэлгээнээс үүдээд нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулагдахдаа маш өвөрмөцөөр буудаг.

Иймд хятад хэлний зүйр цэцэн үгийг монгол хэлнээ орчуулахдаа үүсэл гарал, зүйрлэл, үндэстний онцлог, хэл найруулгын онцлог болон хэвшиж хэлбэржсэн шинж болон сэтгэх, илэрхийлэх аргын тал дээр сайн анхаарвал зохино. Өөрөөр хэлбэл зүйр цэцэн үгнийхээ утгыг зөв гаргаж, монгол хэлний утга, уран дүрслэл өнгө аястай тохирох үг хэллэгээр дүйлгэн орчуулах хэрэгтэй юм.

Түлхүүр үг: Хятад хэл, Монгол хэл, зүйр цэцэн үг, үндэстний онцлог, орчуулга

Хятад хэлний хэвшмэл хэллэгт хууч үг (俗语), зүйр цэцэн үг (谚语), өвөрмөц хэллэг (成语), домог яриа (典故), орхимол үг (歇后语) зэрэг багтдаг.

Эдгээрийн нэг хятад хэлний зүйр цэцэн үг нь бусад улс үндэстний аман зохиолын нэгэн адил тухайн орны үндэстний онцлогийг илтгэн гаргадаг, хэмжээгээр бяцхан атлаа оновчтой, уран дүрслэлтэй, гүн утгатай тул зохиогч, бичгийн хүмүүсийн судалгааны нэгэн хэрэглэгдэхүүн болсоор ирсэн юм.

Иймд хятад хэлний зүйр цэцэн үгийг монгол хэлнээ орчуулахдаа дараах хоёр асуудлыг онцгойлон анхаарууштай.

1. Тухайн зүйр цэцэн үгний үүсэл гарал, зүйрлэл, үндэстний онцлог, хэл найруулгын онцлог болон хэвшиж хэлбэржсэн шинжийг анхаарвал зохино. Жишээ нь “靡不有初，鲜克有终” хэллэг нь “Шүлэглэлт ном”-оос үүсэлтэй. Энэхүү хэллэг нь хэрэг явдал бүрт эхлэл байвч төгсгөл цөөн гэсэн утгатай. Хэрвээ түүний хэл найруулгын онцлогийг гүйцэд анхаарахгүйгээр зөвхөн утгыг барьж “Эхлэл байвч төгсгөл цөөн” гэж монгол хэлнээ орчуулах юм бол оновчгүй бөгөөд үндэстний онцлог, хэвшсэн шинжийг бүрэн алдагдуулах болно. Иймээс монгол хэлэнд тус зүйр цэцэн үгтэй утга ижил бөгөөд хэл найруулгыг гүйцэд илэрхийлж чадах хэллэгийг сонгож олох хэрэгтэй. Тухайлбал “Сонин дээрээ соохолзож, сониноо буурахаар гоохолзох” гэсэн монгол хэлний зүйр цэцэн үгээр дүйлгэн орчуулж болно. Мөн “一犬吠影，百犬吠声” гэсэн хэллэгийг нэг нохой хуцахад чимээнээр нь бусад

²⁹ МУИС-ийн ШУС-ийн ази судлалын тэнхим, доктор, дэд профессор

нохой хуцах хэмээн утгачилан орчуулж болох ч монгол хэлний “Сохор нохой дүйвээнээр, соотон халтар чимээнээр” гэсэн хэллэгээр дүйлгэн орчуулбал илүү оновчтой. “一佛出世, 二佛升天” гэдэг нь “мэдээ сэхээ алдтал, үхэж унатар” гэсэн утгатай. Үүнийг “Нэг бурхан мэндэлж, нөгөө бурхан нь тэнгэрт дэвших” гэж монголчилбол өнгөн дээрээ зөв юм шиг боловч үнэндээ түүний зүйрлэх шинжийг алдагдуулдаг тул “Цээлийн усыг ширгэтэл, цэгээн чулууг хагартал” гэж зүйрлэвэл болох юм.

2. Сэтгэх арга ба илэрхийлэх аргын тал дээр анхаарвал зохино.

Хоёр хэлний зүйр цэцэн үгсийг утга зүйн талаас нь судлахад хоёр үндэстний зан заншил, аж байдал, шашин шүтлэгээс хамааран ертөнцийн юмс үзэгдлийг өөр өөрөөр төсөөлж, үнэлж цэгнэсэн сэтгэхүйн онцлогоо зүйр цэцэн үгээр илэрхийлэн гаргадаг учир зүйр үгийн утгыг оновчтой орчуулан буулгах нь нэн шаардлагатай юм. Хятад зүйр цэцэн үгийн нэгэн гол онцлог нь түүний утгын хийсвэрлэл болно. Монгол хүмүүс ерөнхийдөө дүрслэх сэтгэхүйтэй учир хятад хэлний зүйр цэцэн үгийн хэлбэрт баригдаад цаад утга санааг буруу ташаа орчуулдаг үзэгдэл олон байдаг. Жишээ нь: Хятад хэлэнд “正月十五贴门神一晚了半月” гэх хэллэгээр “цаг тохиолыг алдсан” утга санааг илтгэдэг. Үүнийг монгол хэлнээ орчуулахдаа “Цагаан сарын арван таванд үүдэн бурхан наах” гэсэн энэхүү хэлбэрийг анхаараад “цаг тохиолыг алдсан” гэх хийсвэрлэсэн гол утгыг орхигдуулж “цагаан сарын арван таванд үүдэн бурхан наахтай адил хагас сар оройтов” гэж орчуулж болохгүй. Энэ нь орчуулга дахь сэтгэх аргын асуудал юм. Өөрөөр хэлбэл сэтгэх аргыг чөлөөтэй байлгавал монгол хэлнээс “цаг тохиолыг алдсан” гэх утга санааг зүйрлэсэн “Өдөр алдаад шөнө тэмтрэх”, “Наранд эрсэнгүйгээн саранд эрж, намар хийсэнгүйгээн өвөл хийх” гэх мэт үг хэллэгээр зүйрлэж болно. Хүн бүрийн дур сонирхол өөр өөр байдаг гэсэн санааг “萝卜青菜, 各有所爱” гэж зүйрлэн хэлдэг. Хэрэв энэ хэллэгийн үг үсэгт баригдаад “Лууван цагаан ногооноос аль дуртайгаа сонгоно” гэж монголчилбол утга нь бүрэн гарахгүй тул монгол хэлэнд үүнтэй утга тохирсон “Сонирхвол сонгино сайхан, сольж идвэл мангир сайхан” гэсэн хэллэгээр зүйрлэж болно.

Хятад хэлний зүйр цэцэн үгийг монголчлоход түүний үг үсэг ба хэлбэрт баригдахгүйгээр цаад гол утга санааг гүйцэд ойлгон, монгол хэлэнд тохирсон хэлбэр хэллэгээр оновчтой сайхан илэрхийлэх хэрэгтэй гэдгийг дээрх жишээнүүдээс харж болно. Энэчлэн хятад хэлний хэвшмэл хэллэг болон зүйр цэцэн үгийг монгол хэлнээ орчуулах үндсэн гурван зүйлийн арга байдаг. Тухайлбал: Үгчлэн орчуулах, утгачилан орчуулах ба тэнцүү утгатай хэллэгээр дүйлгэн орчуулах арга юм. Тэгвэл ямар үед үгчлэн орчуулах, ямар үед тэнцүү утгатай хэллэгээр дүйлгэн орчуулах болон утгачилан орчуулах вэ гэвэл ихэвчлэн зүйр цэцэн үгийн бүтэц ба хэрэглэгдэх байдал, тухайн хэллэгийн хураангуйлан зүйрлэсэн гол утга санаа зэргийг үндэслэн тогтооно.

1. Хятад хэлний зарим зүйр цэцэн үгийг бүрэлдүүлсэн үгс нь утгын талаар тус тусдаа биеэ даасан шинжтэй бөгөөд ихэвчлэн үгийн утга шилжсэн шинж байдаггүй. Ийм хэллэг нь утгын талаар тодорхой тул монгол хэлэнд шууд үгчлэн орчуулж болдог. Жишээ нь: “少

壮不努力，老大徒伤悲” гэвэл “Өсөх насандаа чармайхгүй бол өтөлсний хойно гэмшинэ” ; “男大当婚，女大当嫁” гэсэн хэллэг нь “Хүү өсвөөс бэр буулгах, охин өсвөөс хадамд гарах”; “拿得住的是手，掩不住的是口” гэсэн хэллэг нь “Гарыг барьж болно, амыг барьж болохгүй”; “不当家不知柴米贵” гэсэн хэллэг нь “Тэрийн эзэн болохгүй бол цагаан будааны үнийг мэдэхгүй”; “没有高山，不显平地” гэвэл “Уул өөд авирахгүй бол газрын тэгшийг мэдэхгүй” гэх мэт.

2. Хятад хэлний зарим зүйр цэцэн үгийн бүрэлдүүлсэн үг тус бүрийн бодит утга нь алдагдаад ерөнхий нэг утга санааг илтгэдэг. Иймэрхүү зүйр цэцэн үгийг утгын талаар үг тус бүрт оногдуулан ойлгож болохгүй тул монгол хэлэнд тэр хэвээр нь үгчлэн орчуулж болохгүй, харин тус хэллэгт тохирсон тэнцүү утга бүхий монгол зүйр цэцэн үгээр дүйлгэн орчуулвал зохино. Жишээ нь: “宰相肚里能撑船” гэсэн хэллэгийг монгол хэлэнд “Зайсангийн гэдсэнд онгоц сэлж болно” гэж үгчлэн орчуулваас монголчууд ойлгохгүй тул монгол хэлэнд бэлэн байгаа “Эр хүний дотор эмээлтэй хазаартай морь багтана” гэсэн тэнцүү утгатай хэллэгээр, мөн үнэн байдлыг төсөөлөхүйеэ бэрх гэсэн санааг “葫芦里卖的是什么药” гэх хэллэгээр илтгэдэг бол монгол хэлний “Могойн эрэн гаднаа, хүний эрэн дотроо” гэсэн зүйр үгээр утга дүйлгэн орчуулвал зохино. “羊毛出在羊身上” гэх хэллэг нь түүнээс олсон ашгийг түүний биед нь хэрэглэх гэсэн утгатай болохоор монгол хэлний “Чихийг нь авч аманд нь үмхүүлэх” гэсэн хэллэгээр, “头是头，脚是脚” гэх хэллэгийг монгол хэлний “царай ч гэж царай, бие ч гэж бие” гэсэн хэллэгтэй утга дүйлгэн орчуулж болно. “心急吃不上热豆腐” гэх хэллэгийн гол утга санаа нь “дүфү”-тэй ямарч хамаагүй, харин ажил явдлыг хэт сандруу хийвэл бүтэмжгүй болно гэсэн утгатай тул монгол хэлний “Бушуу туулай борвиндоо баастай”, “Яарвал даарна, даарвал давсага чинэнэ” гэх мэт хэллэгээр дүйлгэн орчуулвал зохино.

3. Утгачилан орчуулах гэдэг нь тухайн хэлний зүйр цэцэн үгийг орчуулж буй хэлний мөн тийм утгатай бэлэн зүйр цэцэн үгээр орчуулах арга юм. Ийм тохиолдолд хоёр хэлний зүйр цэцэн үгийн үг бүр нь заавал тохирч байх албагүй. Өөрөөр хэлбэл хятад хэлний зүйр цэцэн үгийн утгыг үндэслэн монгол хэлэнд тохирох найруулгын арга хэлбэрээр илэрхийлж болно. Жишээ нь: “老健春寒秋后热” гэсэн хэллэг нь ахмад настанг эрүүл тэнхлүүн байна гэж тайвшран сууж болохгүй гэсэн утгатай тул монгол хэлний “Найман сарын тариаг хөх гэж бүү бод, ная хүрсэн хүнийг тэнхлүүн гэж бүү сана” гэсэн хэллэгээр, “到什么山上唱什么歌” гэх хэллэг нь “Аль газар очино тэр газрынхаа ёсыг нь дагах” гэсэн утгатай тул монгол хэлний “Усыг нь уувал ёсыг нь дагана” гэх хэллэгээр, боломж олдсон дээр нь цаг алдалгүй хийж дуусгах гэсэн санааг “趁热打铁” гэсэн хэллэгээр илэрхийлдэг тул “Ямааны мах халуун дээрээ” гэсэн монгол хэллэгээр утгачилан орчуулж болно. “人是铁，饭是钢，一日不食见阎王” гэсэн хэллэг нь хүн

Орчуулгын онолын зарим нэр томъёоны тухай

М.Амартайван³⁰ (МУБИС)

Түлхүүр үг: нэр томъёо, орчуулгын нэр томъёо, хэлмэрчлэх, зэрэгцээж хэлмэрчлэх, дагаж хэлмэрчлэх, хадмал орчуулга

Цахим сүлжээ улс орны хил хязгаарыг чөлөөтэй давж, цагаас цагт цаасан ном сониноос холдож байгаа зарим нэгэн байвч, цаасан ном сонины эринд ч цахим сүлжээний энэ эринд ч үнэ цэн нь унаагүй үргэлж л үгүйлэгдэж байгаа нэг зүйл бол сайн орчуулга мөн. Сайн орчуулгыг заяамал авьяастнууд хийнэ гэж зарим нэг нь хэлж магадгүй. Гэвч үнэндээ мэдлэг туршлага, уйгагүй хөдөлмөрийн үр дүн гэдэгтэй бид санал нэгдэх учиртай. Нэн ялангуяа практиктай нягт уялдсан онолын мэдлэгийг эрж, нягталж, хөгжүүлж явах нь энэ нарийн мэргэжлийн зовлон жаргалыг бусдаас илүү мэддэг мэдэрдэг орчуулагч хэлмэрч нарын нэг чухал үүрэг билээ.

Орчуулгын нэр томъёоны толиос олдож байгаа ганц нь 2001 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуулиас хэвлүүлсэн Го. Даваасамбуугийн “Орчуулга, түүнтэй холбоотой нэр томъёоны тайлбар толь” ажээ. Энэ толь хэрэглээ нь нэгэнт тогтворжсон нэр томъёо, бусдыг нь цаашид аажмаар тогтворжуулах үүднээс монгол үгээр толгойлуулж, бичгийн орчуулга төдийгүй аман орчуулгын нэр томъёог ч багагүй хамруулсан нь олзуурхууштай. Толийн ард орчуулгатай холбоотой зарим баримт сэлт(жишээлбэл, аман орчуулгад бичвэрийг товчлон тэмдэглэхэд түгээмэл хэрэглэгддэг тэмдгийн жагсаалтын хураангуй тайлбарын хамт) хавсаргажээ.

*Нэр томъёо нь өдөр тутмын хэрэглээний жирийн үгтэй харьцуулахад ганц утгатай, сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлдэггүй гол онцлогтой*³¹.

Дээрх толийг зохиогчийн дурдсанчлан, “Орчуулга, түүнтэй холбогдох монгол нэр томъёоноос хэрэглээ нь зүгширсэн нэг хэсэг байхад бас хэвшиж тогтворжоогүй, өөр өөрөөр ойлгогдох нэг хэсэг байна. Мөн нэг мөр болгомоор ч нэр томъёо ойлголтууд байна.”³² гэжээ. Үнэхээр бид орчуулгын онолын нэр томъёог нэр мөр болгох цаг нэгэнт болсон санагдана. Ингээд Го. Даваасамбуугийн толийн өмнөх үг болон толгой үг, монгол тайлбарыг голлон орчуулгын тухай зарим нэр томъёоны талаар өгүүлэе. Цаашид уг толийн нэрийг товчлон “толь” гэнэ.

Зохиогч өмнөх үгэндээ хэд хэдэн жишээ хэлжээ. Эхлээд Монголд “... орчуулах үйл ажиллагааг төрөл бус нэг хэлснээс нөгөө хэлэнд бичгээр үйлддэг хүнийг дуун

30 МУБИС, ССТ, магистр

31 Р. Гүрбазар, Орчуулгын онол, дадлагын үндэс, ШИА, ХЗХ, УБ, 1996

32 Го. Даваасамбуу, Орчуулга, түүнтэй холбоотой нэр томъёоны тайлбар толь, ХУИС, УБ, 2001

хөрвүүлэгч(эрхэмсэг найруулга) буюу орчуулагч, амаар үйлдэгч хүнийг хэлмэрч, уг үйл ажиллагааг төрөл нэг хэлнээс нөгөө хэл рүү бичгээр үйлдэгчийг хөрвүүлэгч гэж тус тус заагтай хэрэглэх хандлага төлөвшиж байгааг анзаарахгүй байж боломгүй санагдана³³ гэжээ. Энд төрөл хэл гэдэг нь халх, буриад зэрэг нэг монгол хэлний олон аялгуу, эртний бичгийн хэл ба орчин цагийн хэл зэргийг өгүүлж байна. Тиймээс ч “монгол бичгээс кирилээр хөрвүүлнэ” гэж ярихаас “орчуулна” гэдэггүй. Дуун хөрвүүлэгч хэмээх үгийн тухайд хэлбичгийн ухааныг “дуун ухаан” гэж нэрлэж байсан үетэй холбогдоно. “Хөрвүүлэх” гэсэн үгийг МУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 5 ботиор 2008 онд гаргасан “Монгол хэлний дэлгэрэнгүй толь”-д, 1. Урвуулах, эргүүлэх, хөлбөрүүлэх, 2. Орчуулах, 3. Нэг бичгээс мөн хэлний нөгөө бичигт буулгах гэж тайлбарлажээ. Эхний хоёр утга Я.Цэвэлийн “ногоон толь” буюу “Монгол хэлн ий товч тайлбар толь”-д байдаг бол гурав дахь утгыг нэмж оруулсан байна. Нэгийг сонордуулахад, Монголын Орчуулагчдын Эвлэлээс 1994 оноос хойш «Дуун хөрвүүлэгч» цол, тэмдэг(Зураг1)-ийг өнөөг хүртэл гучаад шилдэг орчуулагчид олгожээ.



Ерөөс аман орчуулга, бичгийн орчуулга нь угтаа нэг юмны хоёр тал мөн боловч хоорондоо зарчмын ихээхэн ялгаатай, бие даасан шинжтэй, тус тусын өвөрмөц онцлогтой ойлголт ухагдахуун юм. Аман орчуулга хийдэг хүнийг “хэлмэрч” хэмээн нэрийдэж, мэдэхгүй хэлний үгсийг өөрийн хэлээр нэвтрүүлэх эс бөгөөс өөрийн хэлний үгсийг тэр хэлний үгээр ярилцагч сонсогчдод нэвтрүүлдэг хүнийг заан нэрлэж ирсэн байна.³⁴ “Хэлмэрч” гэсэн үгнээс үүссэн “хэлмэрчил”, “хэлмэрчлэх”, “хэлмэрчилхүй” гэсэн үгсийг эдүгээ багагүй хэрэглэж хэвшиж байна. Хүмүүс хэлмэрчилхүйг хэлмэрчлэхүй гэж буруу бичиж хэвшжээ. Зүй нь “хэл” гэсэн нэр үгнээс бусдад үг яриа дамжуулж хүргэх чадвартай хүн буюу “хэлмэрч” гэсэн нэр үүсч, үйл үг бүтээх –л дагавар залгаснаар “хэлмэрчил” гэсэн үг үүссэн бөгөөд, дахин –хуй/хүй хэмээх хоёр хэлбэрт нэршүүлэх дагавар залгаснаар “хэлмэрчилхүй” гэж үг бүтэж байгаа учир “хэлмэрчилхүй” гэж залруулах ёстой гэж үзэж байна. Тэгэхээр энд аман орчуулгыг “хэлмэрчлэх”, “хэлмэрчилхүй” гэж нэг үгээр оновчтой хэлж болж байна. Үүнээс улбаалан аман орчуулгатай холбоотой бусад нэр томъёог ч эдгээр хэлмэрч, хэлмэрчил, хэлмэрчлэх, хэлмэрчлэхүй гэсэн үгийг ашиглан нэрлэх нь зүйтэй санагдана.

Дараа нь, “Синхронный перевод” гэдгийн оронд “шууд орчуулга”, “хам цагийн орчуулга” гэсэн нэр томъёог ашиглаж байна. Байдлыг ажиглавал аман орчуулга гэж “синхронный перевод”, “последовательный перевод” гэж хоёр хуваагдах бөгөөд орчуулах үйл ажиллагааг үйлдэж байгаа хугацааных нь байдлаас хамааруулж “синхронный перевод”

33 Дээрх толь

34 С. Гансүх, Судар орчуулах эрдэм, УБ, 2013, 25, 27-р тал.

гэдгийг “зэрэгцмэл орчуулга”, “последовательный перевод” гэдгийг “дагамал орчуулга” гэж дүйлгэх нь боломжтой мэт санагдана” гэсэн байна. Ийнхүү аман орчуулгын хоёр үндсэн төрлийг дурдаж, оноох хувилбараа хэлсэн нь сайн хэрэг боловч тольд зэрэгцмэл орчуулгыг толгой үгээр оруулсангүй, “зэрэгцмэл орчуулгын загвар”, “зэрэгцмэл орчуулгын тасалдалт шинж”, “зэрэгцмэл орчуулгын үргэлжлэх шинж” гэсэн салбар ухагдахуунуудыг тайлбарлажээ. Үндсэн ухагдахууныг орхигдуулсан нь тоогүй. Аман орчуулгын нөгөө нэг үндсэн төрөл “дагамал орчуулга”(последовательный перевод, consecutive interpretation)-ыг “Тухайн бичвэрийг сонссоны дараа, эсвэл унисаны дараа гүйцэтгэх аман орчуулга. Дагамал орчуулга нь аман орчуулгын нэг хэлбэр юм. Түүнийг дотор нь тэмдэглэл бүхий дагамал орчуулга, догол мөрт-хэлцийн орчуулга, өөрөөр хэлбэл, анх дахь хэлээс хоёр дахь хэл рүү орчуулах орчуулга гэж хуваана” гэж оруулжээ. Үүнийг Чулуунбаатар³⁵ дүгнэхдээ, “Го. Даваасамбуу “зэрэгцмэл орчуулга” хэмээх нэр оноосон нь таримал мод, матмал сандал, зүймэл ширээ гэх мэттэй адилтган үзвэл хэлзүйн маш зөв хэлбэржүүлэлт болсон бөгөөд утга агуулгыг ч бас дээрх хүмүүсийн адил бүрэн илэрхийлж байна. Гэхдээ эдгээр олон хувилбараас нэр томъёог нэгэн мөн болгон шийдэх хэрэгтэй” гэсэн байна.

Харин Р. Гүрбазарын “Орчуулгын онол, дадлагын үндэс” номд³⁶ орчуулгын онол, дадлагын ухагдахууныг ухааран ойлгох, улмаар түүний нэр томъёог жигдлэн нэг мөр болгохын үүднээс орчуулга судлалын монгол, англи, франц, герман, орос 700 шахам нэр томъёог судалгааны явцад оноосноо хавсаргажээ. Уг хавсралтад “зэрэгцсэн орчуулга” synchronous translation синхронный перевод гэж байгаа боловч нөгөө төрлийг орхигдуулсан нь мөн л харамсалтай.

В.Н. Комиссаровын “Орчуулгын онол” номыг Л.Үржиндорж 2008 онд орчуулан сурах бичиг болгож гаргасан билээ. Орчуулагч Үржиндорж consecutive oral interpretation хэмээх ойлголтыг “Аман яриаг догол мөр, өгүүлбэрээр нь дагаж орчуулахыг дараалсан орчуулга гэдэг” гэжээ. Тэгээд МУИС-ийн ОУХДС-ийн Дипломат орчуулгын тэнхмээс гаргадаг Орчуулах эрдэм сэтгүүлийн 2009 оны дугаарт С.Дугармаа, Д.Батжаргал нар “Олон улсын хурал зөвлөлгөөний орчуулгын талаар” хэмээх өгүүлэл бичиж аман орчуулагчдыг бэлтгэх чухал санаа хэлсэн бөгөөд дээрх ойлголтыг “цувраа орчуулга” гээд Л.Үржинлхүндэвийн “дараалсан орчуулга”, С.Дугармаа, Д.Батжаргал нарын “цувраа орчуулга” хэмээхийн аль аль нь consecutive oral interpretation хэмээх ойлголтын агуулгыг оноогүй байна. Угтаа бол нүүр тулсан орчуулга буюу “шууд орчуулга”-ыг энэ ухагдахуунд хамруулан үзэх ёстой³⁷ гэсэн байна. Цааш нь өгүүлэхдээ, “С.Дугармаа, Д.Батжаргал нар “Зэрэгцээ орчуулгыг тусгай бэлтгэсэн бүхээгт сууж зэрэгцэн орчуулах бөгөөд чихэвчээр сонсоно” хэмээн тодорхойлсон байна. Л.Үржиндорж болохоор зэрэгцэн нэгэн цагт хийдэг “хам цагийн оруулга”, С.Дугармаа, Д.Батжаргал нар болохоор “зэрэгцээ орчуулга” хэмээн

35 Л. Чулуунбаатар, Орчуулгын үндсэн салбар, “Орчуулга болон бас бус зүйлийн тухай өгүүллүүд”, УБ, 2012, 31-р тал

36 Р. Гүрбазар, Орчуулгын онол, дадлагын үндэс, ШУА, ХЗХ, УБ, 1996

37 Л. Чулуунбаатар, Орчуулгын үндсэн салбар, “Орчуулга болон бас бус зүйлийн тухай өгүүллүүд”, УБ, 2012, 31-р тал

хоёр өөр нэр томъёо оноосон боловч угтаа *simultaneous* хэмээхийн агуулгын утгыг гаргасан ойролцоо утгат үгсээр нэрлэсэн нь утгад харилцахгүй байна. “Орчуулах эрдэм” сэтгүүлд “Харилцааны онол, орчуулга” хэмээх өгүүлэл бичсэн Я.Хишигт, Ж.Баянсан нарынхаар бол энэ нь “дам орчуулга” бөгөөд нүүр тулан хийхгүй техник хэрэгсэл ашиглан нэгэн цагт далдаас дам байдлаар орчуулж байгаа болохоор ингэж бас хэлж болох талтай³⁸” гэж үзжээ.

Я.Хишигт, Ж.Баянсан нар “Аливаа хэлээр харилцахад наанадаж хоёр хүн оролцдог бөгөөд харилцагчид нүүр тулж харилцахыг шууд харилцаа, харилцагчид нүүр эс учран, ном зохиол, бичиг болон радио телевиз зэрэг техник хэрэгслээр дамжуулж харилцахыг дам харилцаа гэдэг. Шууд болон дам харилцах үйл ажиллагаа нь өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Шууд буюу тулж харилцахад харилцагчдын сэтгэл хөдлөлийн байдал нь дуу хоолойны өнгө аяс, гар, биеийн хөдөлгөөн, нүүр царайны байдал, нүдний харцанд ч илэрч байдаг. Аман орчуулгын дараагийн нэг төрөл бол *simultaneous interpretation* бөгөөд, “Хамгийн их идэвхтэй хөдөлмөр шаардсан, хүн техник хоёулыг оролцуулдаг орчуулга юм. Энэ нь яригчтайгаа нэгэн зэрэг орчуулаад явж болдог аман орчуулгын онцгой нэгэн төрөл.”³⁹” хэмээн тодорхойлсон байна. Харилцааны талаас авч үзвэл яах аргагүй толинд дурдсан “зэрэгцмэл орчуулга” дам орчуулга болж, “дагамал орчуулга” шууд орчуулга болно. Гэтэл зарим хүмүүс өнөө хэр нь зэрэгцмэл орчуулгыг шууд орчуулга гэж эндүүрдэг. Энэ нь шууд зэрэгцээд хэлмэрчилдэг болохоор “шууд” гэж ойлгодогтой холбоотой. Мэдээж хэдий зэрэгцэвч нэгээс хоёр өгүүлбэр өгүүлсний дараа орчуулж эхлэх нь ойлгомжтой. Харин Я.Хишигт, Ж.Баянсан нар тайлбарлахдаа *Шууд орчуулгад илтгэгчийн ярианы дундуур тасалж юмуу эсвэл дууссаны дараа орчуулдаг...* гэснээс ярианы дундуур тасална гэдэг нь тун зохимжтой тайлбар болжээ. Учир нь ярианы дундуур таслах нь хэлмэрчийн ёс зүйд нийцэхгүй. Илтгэгчийн яриаг хэлмэрчлэхэд төвөгтэй сунжрах вий гэхээс эмээж байгаа бол хэлмэрчлэх агуулгыг зохих хэмжээгээр тасалж хэлэхийг илтгэгчээс урьдчилан хүсэх нэг арга бий.

Ингэхээр нэг ухагдахууныг синхрон орчуулга, хам цагийн орчуулга, шууд орчуулга, зэрэгцээ орчуулга, зэрэгцмэл орчуулга, зэрэгцсэн орчуулга, нөгөөг нь цуваа цагийн орчуулга, цувраа орчуулга, шууд орчуулга, дараалсан орчуулга, дагамал орчуулга гэх мэт маш олон янзаар нэрлэж байгааг нэг мөр болгох зайлшгүй шаардлагатай байна.

Аман орчуулгын нэр томъёог⁴⁰ “хэлмэрчлэх” гэсэн нэрийн дор нэгтгэх нь бичгийн

38 Дээрх номын 32-33-р тал

39 Дээрх номын 34-р тал

40 Тольд аман орчуулга(устный перевод, oral translation)-ыг “Нэг хэлнээс нөгөө хэлэнд тухайн мэдээллийн агуулгыг бичиж тэмдэглэхгүйгээр дамжуулан буулгах үйл явц. Мөн зэрэгцмэл орчуулга, дагамал очруулга, хуудаснаас хийх орчуулга зэрэг бие даасан очруулгын төрлийг нэгтгэсэн ухагдахуун гэж хэлж болно. Аман орчуулгыг өөрөөр “цээж орчуулга” гэж нэрлэх нь бий.” гээд, сонссон зүйлийн аман орчуулга(устный перевод, interpretation), сонссон зүйлийн бичмэл орчуулга(писменный перевод наслух, aural written translation), аман ярианы аман орчуулга(устно-устный перевод, oral-oral translation), аман ярианы бичмэл орчуулга(устно-писменный перевод, oral-written translation), бичмэл эхийн аман орчуулга(писменно-устный перевод, written-oral translation), бичмэл эхийн бичмэл орчуулга(писменно-писменный перевод, written-written translation), харааны аман орчуулга(зрительно-устный перевод, visual-oral translation), харааны бичмэл орчуулга(зрительно-письменный перевод, visual-written translation) зэрэг олон хэлбэр байдгийг тус тус толгой үгээр оруулж тайлбарлажээ.

орчуулга, аман орчуулгыг хялбар ялгах нэг үндэс болно. Учир нь зэрэгцмэл орчуулга, хам цагийн орчуулга гэхчилэн нэрлэх нь бичгийн орчуулгад ийм ухагдахуун байдаг мэт төөрөгдөл үүсгэж болзошгүй тул анх харж сонсоход аман орчуулгын тухай юм байна гэж мэдэгдэхээр “хэлмэрчлэх” гэсэн үгийг хэрэглэх нь зохистой болов уу. Нөгөө талаар бид “хэлмэрчлэл”, “хэлмэрчилгэ” гэсэн үг үүсгэж хэлэлцдэггүй учир “хэлмэрчлэх” гэсэн үгийг сонгож болох бөгөөд, гагцхүү энэ үгээр хэллэг үүсгэхдээ “зэрэгцмэл хэлмэрчлэх”, “зэрэгцээ хэлмэрчлэх”, нөгөөг нь “дагамал хэлмэрчлэх”, “цувраа хэлмэрчлэх” гэх нь хэлний зүйд төдийлөн нийцгүй тул миний бие хэлмэрчлэх энэхүү үндсэн хоёр төрлийг “зэрэгцэж хэлмэрчлэх”, “дагаж хэлмэрчлэх”⁴¹ гэж оноох саналтай байна.

Бас нэг эргэлзээтэй нэр томъёо бол “хадмал орчуулга”. Энгийн хэрэглээнд энэ хэллэгийг голдуу орос хэлний титр, англи хэлний subtitle гэсэн үгийг орчуулахдаа хэрэглэж байна. Гэтэл тольд *Хадмал орчуулга(пословный перевод, подстрочный перевод, literal translation, verbal translation, word by word translation) – Эх бичвэрт байгаа үгсийг тэдгээрийн өгүүлбэр зүйн болон утга зүйн холбоог харгалзалгүйгээр байгаа дарааллаар нь механикаар оноох орчуулга. Хадмал орчуулга гэдэг нэр томъёоны оронд “үг бүрчилсэн орчуулга”, “үг дараалсан орчуулга” гэсэн нэр томъёог хэрэглэх нь бий.* гэж тайлбарласан нь мэргэжлийн нэр томъёо, энгийн хэрэглээ хоёрын хооронд “том ангал” буюу үл ойлголцол үүсгэж болзошгүй байна. Тольд тайлбарласныг “үгчилсэн орчуулга” гээд, харин эртний уламжлалаар үүнийг үгийг үгээр нь хадаж орчуулсан “хадмал орчуулга” хэмээх нь ч бий гэж нэмж тайлбарлаж болох юм.

Түүнчлэн орчуулгын онолд орц хэл, гарц хэл гэж нэр томъёо байх бөгөөд, тольд *орц хэл(входны язык, input language) – 1. Машинаар орчуулахаар цахим тоолуурт оруулж байгаа хэл. 2. Хоёр хэлний тольд эхлэн өгсөн үг, үгийн сангийн нэгж. Өөрөөр хэлбэл, толийн зүүн гар талын хэл. Жишээ нь “Монгол-орос хэлний толь”-ийн монгол нь орц хэл болно.*

Гарц хэл(выходной язык, target language) output байх ёстой. – 1. Машинаар орчуулж гаргасан хэл. 2. Хоёр хэлний тольд нэг хэлний үг, үгийн сангийн нэгжийг нөгөө хэлний үг, үгийн сангийн нэгжээр утга оноон орчуулсан хэл. Өөрөөр хэлбэл, толийн баруун гар талын хэл. Жишээ нь, “Монгол-орос толь”-ийн орос нь гарц хэл болно гэжээ.

Үүнээс гадна бас нэг тохиолдол буюу орчуулгын ерөнхий онолд орчуулах бичвэрийн хэлийг “гарц хэл”, орчуулгын хэлийг “орц хэл” гэж бас хэлж болохыг⁴² миний бие солонгос зохиогчийн “Хэлмэрчлэх, орчуулах үндэс” номыг орчуулахдаа тусгасан бөгөөд, тольд тайлбарласнаас юугаараа ялгаатайг сайтар ойлгуулж тайлбарлах, эсвэл зүгээр “орчуулах бичвэрийн хэл”, “орчуулгын хэл” гэдгээр авч болох талтай.

41 Дагаж хэлмэрчлэх, зэрэгцэж хэлмэрчлэх хоёр арга байдаг бөгөөд, дагаж хэлмэрчлэхдээ илтгэлийг сонсонгоо тэмдэглэл хөтлөөд тэмдэглэсэн агуулгаа ашиглан хэлмэрчилдэг. (Чвэ Жонхва, Хэлмэрчлэх орчуулах үндэс, 2004, 85-р тал) Энэ нь хэлмэрчлэх явцад агуулгыг тэмдэглэн ашиглаж болох тухай хэсэгт орсон тайлбар бөгөөд, тэмдэглэлийг заавал хийх ёстой гэсэн үг биш, хэрэглэх эсэх нь тухайн хэлмэрчийн сонголт гэдгийг анхаарах ёстой.

42 Машинаар орчуулах тохиолдол болон толь бичгээс монголоос солонгосоор орчуулбал монгол хэл орц хэл, солонгос хэл гарц хэл болно. Харин эх бичвэрийг монголоос солонгосоор орчуулж байгаа бол монгол хэл гарц хэл, солонгос хэл орц хэл болно гэсэн үг.

Түүнчлэн оросоор эквивалент гэдэг нэр томъёог монголоор тольд “дүйлт⁴³”, Гүрбазар “дүйх үг⁴⁴, дүйц⁴⁵”, зарим номд “оноолт” гэсэн байдаг бол, миний бие “тэнцэл” гэж орчуулж байв. Эдгээрийг ч нягталж нэр томъёог нэг мөр болгох хэрэгтэй. Энэ мэтчилэн олон нэр томъёог цэгцлэх шаардлага зүй ёсоор бий болсныг орчуулга сонирхон судлагч хэн бүхэн анхааралдаа авууштай.

Эцэст нь дүгнэхэд, орчуулгын тухай нэр томъёо олон бийг нухацтай судалж, сайтар монголчлон, оновчтой тайлбарлаж, зөв зааж сургах нь нэн чухал байна.

Resume

There's a just one dictionary about translation terms, in Mongolia. Translators and interpreters have to discuss on translation terms, and have to make an effort to unite these terms. In my opinion terms about interpretation should be united in Mongolian language like 'khelmerchlekh', not 'aman orchuulga', 'yarianii orchuulga' and others, to avoid not to be confused with terms.

Ашигласан ном:

С. Гансүх, Судар орчуулах эрдэм, УБ, 2013

Р. Гүрбазар, Орчуулгын онол, дадлагын үндэс, ШУА, ХЗХ, УБ, 1996

Го. Даваасамбуу, Орчуулга, түүнтэй холбоотой нэр томъёоны тайлбар толь, ХУИС, УБ, 2001

Орчуулах эрдэм V, “Орчуулгын онол арга зүйн асуудалд: Орчин үе, чиг хандлага, онцлог”, МУИС, ОУХС, Дипломат орчуулгын тэнхим, 2013

Чвэ Жонхва, Хэлмэрчлэх орчуулах үндэс, УБДС, 2004

Л. Чулуунбаатар, Орчуулга болон бас бус зүйлийн тухай өгүүлүүд, УБ, 2012

43 Дүйлт(эквиваленты, equivalent) – Эх бичгийн хэл, орчуулгын хэлний нэгжүүд хоорондоо хам бичвэрээс үл хамааран байнга, адил тэнцүү утгаараа тогтмол тохирох үзэгдэл.

44 Дүйх үг, тохироо үг equivalency эквивалент

45 Орчуулгын дүйц equivalency эквивалентность перевода

Монголын орчуулгын онолын уламжлал

Н.Оюунзаяа⁴⁶ (МУИС, ШУС)

Товч утга: Энэхүү өгүүлэлдээ миний бие монголын орчуулагчид судар бичиг, утга зохиол, шүлэг, яруу найргийг ямар хэлнээс хэрхэн монгол хэл рүү буулгаж байсныг цухас дурьдахыг зорилоо.

Түлхүүр үгс: Орчуулгын онол, чиг орчуулга, утгачилан орчуулах, орчуулгын хэлбэр, утга, найруулга зүй

“Монголчууд бичиг үсэгтэй болсон цагаас орчуулга хийж эхэлсэн” гэж Мэргэд өгүүлжээ. Тухайлбал XX зууны нэрт эрдэмтэн Зава Дамдин⁴⁷

“Арвис мэргэн багш нар (Согдын) бээр Уйгар хийгээд Монголчууд дор

Аливаа үсэг хийгээд унших бичих тэргүүтэй

Аугаа бурханы номлолын зарлиг, шастир, сайн айлдал нугуудыг

Аливаа өөр өөрийн хэл лүгээ орчуулахуйн ёсыг заан сургав ”

гэж айлджээ. Энэ өгүүлбэрээс үзвэл монголчууд согдоос бичиг үсэг авч, бурханы ном зохиолыг орчуулж эхэлжээ. Цааш нь

...Тэгш босоо согтаг үсгээр Энэтхэг хийгээд өөр өөрсдийн хэлийг хольж орчуулан

Тийн номлол, сонсгол, уншлага тэргүүтнийг үйлдсэн нь үзэгдэнэ⁴⁸

гэснээр уг санаа батлагдаж байна. Иймд Монголын орчуулга, орчуулгын онолын сэтгэлгээ асар арвин түүхтэй. 1740 орчим онд Хамгийг Мэдэгч Жанжаа Ролбийдоржийн удирдлагаар Монголын дөч орчим гүүш нарын хамтарч зохиосон “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршвой” номын оршилд XIV зууны үеийн Чойжи-Одсэр бандидаг “орчуулгын журам” гаргасан гэж бичжээ. Харамсалтай нь, тэр нь ямар журам байсан тухай баримт өнөөг хүртэл хадгалагдаж ирсэнгүй. Гэвч Чойжи-Одсэрийн бүтээлийг судалсан доктор Д.Цэрэнсодном “орчуулгын зарим шүлгийг эхтэй нь тулгаж үзээд дууны болон чиг орчуулгын зарчмыг харгалзсан шинжтэй байнам”⁴⁹ гэж бичсэнээс үзвэл чиг орчуулгын буюу үгчилсэн орчуулгын зарчмыг тогтоосон бололтой. Хувилай сэцэн хаан Бээжинг нийслэлээ болгосон хойноо “Ном зохиол орчуулах, ба түүх бичих хороо”-г байгуулж, хятад, төвд, араб, самгарди хэлээс “Засаг түр туслах нэвтэрхий толь”, “Сонгомол хасын тэмдэглэл”-н орчуулга, “Субашид”-ын дөрвөлжин үсгээр барласан орчуулгын тасархай болон монгол үсгээр барласан орчуулга үлджээ.

⁴⁶ МУИС-ийн ШУС-ийн ИБАСТ, магистр

⁴⁷ Зава Дамдин. Хор чойнжун, УБ, 2007 он

⁴⁸ Мөн тэнд

⁴⁹ Д.Цэрэнсодном. XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. УБ., 1969 он

Хайсан Хүлэг хааны үед Төрийн Төв Захиргааны баруун гарын Чинсан түшмэл Бултөмөр “Ачилалт ном”-ыг нанхиад хэлнээс орчуулжээ. Бриазаншири “Долоон өвгөн од”-ны судрыг 1328 онд нанхиадаас монгол хэлээр орчуулсныг хожим нь монголоос уйгар, төвд хэл рүү орчуулсан байна. Есөнтөмөр хааны үед алдарт орчуулагч Шаравсэнгэ “Алтангэрэл” судар хийгээд Чойжи-Одсэрийн “Бурхны арван хоёр зохионгуй”-г төвдөөс орчуулжээ.

Шаравсэнгэ “Алтангэрэл” судрын орчуулгын төгсгөлийн үгэндээ: “Хутагт дээд Алтангэрэлт эрхэм энэ номыг хойно аху их монголжин улсаа рашаан болтугай хэмээн Эсэн Төмөр даяда дуратхан өгүүлэгдэж, шахинлигуудын тойн Шаравсэнгэ” түвэджин, уйгаржин бичгүүдээс монголчлон орчуулж, бурхан бодисун хийгээдийн нэрийг монголчлон аялгуу дор үл найрахын тулд уйгурын ёсоор энэтхэгчлэн орчуулаад, бас бээр энэтхэг, төвд тил мэдэгч Буниа Шири Шиду лугаа энэтхэгжин, төвджин, уйгаржин аялгуутан бичгүүд лүгээ тохиолдуулж аялгуу утгасыг үл эндэн орчуулбай” гэж бичсэнээс хэд хэдэн дүгнэлт хийж болох боловч орчуулгын онолтой холбоотойг нь дурдвал, бурхан бодьсадын нэрийг төвд, уйгараас үгчлэн монголчилбол ойлгомжгүй болохыг анхаарч, энэтхэг нэрээр нь тавих буюу орчуулгад үндэсний онцлогийг харгалзсан төдийгүй сонсголон яруу бөгөөд утгыг барьж (аялгуу, утгасыг үл эндэн) орчуулснаа дурдсан байна.

Монголын орчуулагчид орчуулгынхаа төгсгөлд хэний дурдтагснаар, хаана, хэдийд, хэрхэн орчуулснаа шүлгээр бичдэг соёлтой байжээ. Ялангуяа хэрхэн орчуулснаа бичдэг нь өдгөө үзвэл орчуулагч, орчуулгын онолын зарчим байна. Жишээлбэл, Ширээт Гүүш Цорж / XIV зууны сүүлч/ “Үлгэрийн далай”, “Бромын цадиг”, “Бүчой” буюу “Хөвүүн ном”, Халхын Цогт хун тайж, Хун Тайжийн эх Чин Тайху нарын дуртагснаар Төвдийн яруу найрагч Милрайбын “Мялын намтар”-ыг орчуулжээ. “Мялын намтар”-ын төгсгөлийн шүлэгт гүүш Цорж,

Бас сайтар урнаа найруулж

Баршгүй номын чанарыг төгсгөж

Бэлэн монголын аялгуугаар сайтар тохиолдуулж

Бандит Ширээт Цорж орчуулбай, монголчлон найруулж

гэж бичсэн нь орчуулгын онолын үүднээс авч үзвэл их сонин юм. Үүнд “сайтар тохиолдуулж” гэсэн нь утгыг нь ягштал гаргаж, нөгөө “урнаа найруулж” гэсэн нь уран сайхнаар буюу уншигчийн сэтгэлийг хөдөлгөх чадалтайгаар орчууллаа гэсэн үг гэж ойлгож болно.

Үүнээс үзэхэд орчуулгад үгчлэх зарчим зонхилж байсан тэр үед утгачилахыг баримталж байсан орчуулагч бол Ширээт гүүш Цорж байжээ гэж хэлж болно. Зуун найман боть Ганжуурыг орчуулан барлаж дуусаад хоёр зуун хорин таван боть Данжуурыг орчуулж эхлэхийн өмнө түүнийг орчуулах онолын зарчим боловсруулж, нэр томьёог нарийвчлан тогтоож өгөх шаардлага гарсан байна.

Ингээд Хамгийг Мэдэгч алдрыг олсон их эрдэмтэн Хоёрдугаар Жанжаа хутагт

Ролбийдорж тэргүүтэй төвд, монгол хэл хийгээд дуун хөрвүүлэх эрдэмд нэвтэрхий 40 орчим гүүш, орчуулагч нар нийлж “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршив” хэмээх дохионы бичгийг туурвиж, 1742 онд модон бараар хэвлүүлжээ.

Уг толийн “Барамидын аймаг” хэмээх эхний хэсгийн оршилд бурхны шашны ном зохиолыг төвд хэлнээс монгол хэлрүү орчуулах онолын зарчмуудыг нягтлан тогтоосон байна. “Мэргэд гарахын орон”-д боловсруулсан эдгээр зарчим тэр үеийн монгол орчуулгын сэтгэлгээний хөгжлийн түвшинг тод харуулж байна.

“Мэргэд гарахын орон”-ы оршилд шашны ном судрыг орчуулах онолын олон зарчмыг тогтоож өгсөн нь, зөвхөн шашны ном судар орчуулах бус, ерөөс орчуулгын ерөнхий онолын зарчим байна. Үүнд: “шударгуу оюунаар үг утгасын хувийг сайтар шинжлээд... тодорхой бөгөөд мэдэхүйеэ хялбар үгээр утга лугаа үл харшлалдуулан сайтар орчуулах” буюу утгыг алдагдуулахгүй орчуулах зарчим, “урьд хойд үгийг солиулбаас утга нь тод мэдэгдээд... үргэлжилсэн үгсийг нэгэн үг ба хоёр ба гурван тэргүүтэн тэдгээр үгсийн утга алин дор хүрэхүйгээс дээш аль амраар солиулж орчуулахуй” буюу хувиргал хэрэглэх зарчим, “бас бус магтаалын үг хийгээд муутгахын үг ба гайхахын үг хийгээд уйтгарлахын үг ба айхын үг мэтэс дор нь монголын хэлэн дор хотолдоо алдаршсан бөгөөд их чадалт сэтгэлийг хөдөлгөн чадахуйг учир дор хүрсэн үгээр орчуултугай” гэсэн найруулгын өнгө аясыг буулгах зарчим, түүнчлэн олон салаа утгатай үгийг орчуулах, үгийн чадлыг буулгах, үндэсний онцлогтой үгийг орчуулах, үгийн утгыг гаргах, үг нэмэх хасах зарчим хийгээд шүлэг орчуулах зарчмыг нэгд нэгэнгүй нарийвчлан тогтоосон юм. Ер нь энд дуун хөрвүүлгийн нийт хориннэгэн зарчмыг өгүүлсэн байна. “Эдгээр зарчим орчин үеийн орчуулгын зарчимтай ч яг авцалдаж байна” гэж орчуулагч, орчуулгын онолч Г.Аким дүгнэжээ.

Монголын их зохиолч, В.Инжинаш ч “Гурван улсын үлгэр” зэрэг нилээд ном орчуулж, “Хөх судар” романыхаа “Товчит толь”-д орчуулгыг үзэх өөрийн үзлийг илэрхийлжээ.

Үүнд тэрвээр “Эе эвийг эрхэмлэх” зарчмыг дэвшүүлсэн нь Ширээт гүүш Цоржийн “урнаа найруулах”, Дай гүүш Агваандампилын “утгын найрыг дагах” зэрэг зарчимтай дүйж буй билээ.

Ийнхүү орчуулгад утгачилахын чухлыг заагаад үгчлэн орчуулахыг шоолж “Онц үсгийг баримтлаваас одоо чухам хулгайчийн хүү онц эцгээ мөрдмүй хэмээгдсэн лугаа адил болмой”⁵⁰ гэж бичжээ.

Манай эртний орчуулгын онолчдын орчуулгын сэтгэлгээг үргэлжлүүлж, хорьдугаар зуунд Европ зүгийн хэлнээс орчуулах онолын эх үүсвэрийг тавигчид бол Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен нар гэж хэлж болно.

Ц.Дамдинсүрэн “Ямарваа шүлэгт, ямарваа уран зохиолд хүний сэтгэлийг хөдөлгөх чадал бий. Энэ нь уран зохиолын гол сүнс болно... Энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг эрхбиш орчуулах хэрэгтэй. Шүлгийн үг өгүүлбэр ба хэв журмыг хэдийгээр нарийн нягт орчуулж

50 Инжинаш. Хөх судар. УБ., 2006 он, 83 дахь талд

чадавч энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг орчуулж эс чадвал амьд морийг үхсэн мориор арилжсантай адил хэрэг болно... Иймийн тул энэ шүлгийн чадлыг сайнаар орчуулах нь шүлгийн үг өгүүлбэр ба хэв журмыг орчуулахаас илүү чухал зүйл юм. Энэ нь даруй шүлгийн аминд холбогдсон хэрэг мөн ” гээд “Монгол орчуулгыг монгол хүн уншихад уран сайхны талаар орос эхийг орос хүний уншсанаас доргүй байвал сая шүлгийн уран чадлыг орчуулж чадсан гэж болно”⁵¹ гэж бичсэн нь одоо европ зүгийн орчуулгын онолд үүргээр дүйлгэх гэж нэрлэж байгаа үзэл юм.⁵² Ийнхүү Ц.Дамдинсүрэн дөч гаруй жилийн тэртээ манайд үүргээр дүйлгэх үзэл баримтлалын үндсийг анхлан тавьсан байна. “Тэгээд ч энэ зарчмаар түүний орчуулсан А.С.Пушкиний “Олег цэцний дуулал”, “Алтан загасны үлгэр” зэрэг найраглалыг уншигч олон ихэд таашаан хүлээж авсан юм. Б.Ринчен хэм хэмжээ-агуулгыг тохируулах үзлийн тухай өгүүлж⁵³, үүнийгээ “адбиш орчуулах зарчим ”⁵⁴ гэж нэрлээд “Зохиолын орчуулгын үг хэлийг эх хэлнийхээ хэл зүй, найруулга зүйн шаардлагад нийцүүлэх нь эрхэм болж байна”⁵⁵ гэжээ.

Тэгвэл Н.В.Гоголийн “Тарас Бульба”, А.К.Толстойн “Мөнгөн ноён”, А.М.Горькийн “Салхич шувууны дуун”, Шолоховын “Хүний хувь заяа”-г орчуулсныг нь үзэхэд чухамхүү адбиш орчуулгын зарчмыг баримталж байсан нь харагддаг билээ.

Өнгөрсөн зууны орчуулгын онолын сэтгэлгээнд Г.Дашдаваа, Р.Гүрбазар, Ц.Сүхбаатар нарын хүмүүс өөр өөрийн хувь нэмрийг оруулсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Энэ бүхэн нь Монголын орчуулгын онолын сэтгэлгээ олон улсын орчуулгын сэтгэлгээний түвшинд байсан гэж баттай хэлэх боломжийг олгож байгаа юм.

Ном зүй

1. Зава Дамдин. Хор чойнжун, УБ, 2007 он
2. Зава Дамдин. Хор чойнжун, УБ, 2007 он
3. Д.Цэрэнсодном. XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. УБ., 1969он
4. Инжинаш. Хөх судар. УБ., 2006 он, 83 дахь талд
5. Ц.Дамдинсүрэн. Олег цэцний орчуулгын тайлбар. “Монгол хэл бичгийн тухай” 1957. УБ
6. Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр дэвтэр, УБ. 1967 он, 66дахь талд
7. Б.Ринчен. Сайхан санаачлага, Сургамжтай дүн, “Орчуулах эрдэм”. Эмхэтгэл.УБ,1972, 194дэх талд
8. Б.Ринчен. Шүлэг орчуулах эрдэм. , “Орчуулах эрдэм”. Эмхэтгэл.УБ,1972, 95дахь талд
9. Б.Ринчен. Шүлэг орчуулах эрдэм. , “Орчуулах эрдэм”. Эмхэтгэл.УБ,1972, 95дахь талд

51 Ц.Дамдинсүрэн. Олег цэцний орчуулгын тайлбар. “Монгол хэл бичгийн тухай” 1957. УБ.,

52 Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр дэвтэр, УБ. 1967 он, 66дахь талд

53 Б.Ринчен. Сайхан санаачлага, Сургамжтай дүн, “Орчуулах эрдэм”. Эмхэтгэл.УБ,1972, 194дэх талд

54 Б.Ринчен. Шүлэг орчуулах эрдэм. , “Орчуулах эрдэм”. Эмхэтгэл.УБ,1972, 95дахь талд

55 Б.Ринчен. Шүлэг орчуулах эрдэм. , “Орчуулах эрдэм”. Эмхэтгэл.УБ,1972, 95дахь талд

Монгол Япон хэлний нийлмэл өгүүлбэрийн холбох нөхцөлийн тухай /Шалтгааны утгат нөхцөлийн хүрээнд/

Т.Нарангэрэл⁵⁶(МУИС, ШУС)

Товч утга: Гадаад хэл сурч буй хүн хэлэхүйн дөрвөн чадвар болох сонсох, ярих, унших, бичих чадварыг нэгэн жигд хөгжүүлэх шаардлагатай. Үүний тулд зайлиггүй судлах ёстой зүйл бол тухайн хэлний хэл зүйн дүрэм юм. Дүрмийн хэрэглээг зөв ойлгож, хэрэглэж хэвшээгүйгээс өөрийн үзэл бодлоо буруу илэрхийлэх, харилцагчтайгаа үл ойлголцох, найруулгын алдаа гаргах гэхчилэн олон бэрхшээл тулгардаг. Энэхүү өгүүлэлд монгол хэлний үйлийн тийн ялгалын шалтгааны утгат нөхцөл, япон хэлний үйлийн холбох нөхцөл “-to, -ba, -tara”- г хоёр хэлнээ хэрхэн дүйж орчуулагддаг болохыг утга зохиолын жишээнд тулгуурлан гаргаж ирэхийг зорьсон юм.

Түлхүүр үг: Монгол хэлний нийлмэл өгүүлбэр, япон хэлний нийлмэл өгүүлбэр монгол хэлний үйлийн тийн ялгал, япон хэлний болзох нөхцөл, япон хэлний туслах үйл үг, 助詞-joshi、副助詞-fukujoshi、条件表現 - Jōken-hyōgen

Монгол хэлэнд нэрийн болон үйлийн тийн ялгал хоёул байдаг бол япон хэлэнд зөвхөн нэрийн тийн ялгал байна. Харин үйл үгийн нөхцөлийг **үйлийн холбох нөхцөл, холбоос үг** гэнэ. Хэдийгээр япон хэлний үйлийн холбох нөхцөл “-to, -ba, -tara”- г олон эрдэмтэд холбоос, холбоос үг гэж үздэг боловч 砂川有里子 “日本語の文法の辞典”、沖森卓也—林義之 “図解日本語” зэрэг бүтээлд “Эдгээр нөхцөл нь үйл үгийн хувилгах нөхцөл юм” гээд үйл үгийн “-to, -ba, -tara” хэлбэр хэмээн тэмдэглэсэн нь холбох нөхцөл мөн гэдгийг баталж байна.

Япон хэлний өгүүлбэрийг монгол хэлний адил энгийн ба нийлмэл гэж ангилна. Өгүүлбэрт хэдэн өгүүлэхүүн байгаагаар өгүүлбэрийн тоог тодорхойлно. Япон хэлний нийлмэл өгүүлбэрийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, хавсарсан нийлмэл өгүүлбэр гэж⁵⁷ ангилах ба гишүүн өгүүлбэрүүд адил тэгш эрхтэй бол **зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр**,

〔並立節〕 үйл үг нь араасаа“**の-no, こと-koto**” зэрэг үгсийг авч нэр үгийн үүргээр орсон бол **нэрлэсэн өгүүлбэр**〔名詞節〕, гол өгүүлбэрийг тодотгох үүргээр орсон гишүүн өгүүлбэрийг **тодотгол гишүүн өгүүлбэр**〔連体節〕, хэл, бодол санааг илэрхийлсэн гишүүн өгүүлбэрийг **байц гишүүн өгүүлбэр**〔引用節〕 гэнэ. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрээс бусад бүх гишүүн өгүүлбэр нь өгүүлэгдэхүүн гишүүндээ захирагдах бөгөөд нийтэд нь **хавсарсан нийлмэл өгүүлбэр** (従属節) гэж нэрлэнэ.

⁵⁶ МУИС-ийн ШУС, Ази судлалын тэнхим, магистрант

⁵⁷ 村田水恵 “入門日本語の文法”

Япон хэлний тодотгол гишүүн өгүүлбэрт гадаад холбоо хамаарал, дотоод холбоо хамаарал гэсэн хоёр зүйл байх ба гадаад холбоо хамаарал нь аливаа нөхцөл байдлыг шууд илэрхийлэх бол дотоод холбоо хамаарал нь цаанаа ямар нэгэн далд утгыг агуулж байдаг байна.

- Дагалдах нөхцөл байдал илэрхийлэхэд “*ながら*-nagara、*て*-te、*たまま*-tamama” гэх мэт нөхцөл, холбоос үгийг
- Зорилго, хүчин зүйлийг илэрхийлэхэд “*ために*—tameni”, мөн зорилго илэрхийлэхэд “*ために*—tameni, *ように*—youni” холбоос үгийг ашиглана.
- Болзол буюу нөхцөл байдлыг илэрхийлэхэд “*と*-to、*ば*-ba、*たら*-tara、*なら*-nara” холбох нөхцөлийг ашиглана.

Япон хэлний үйлийн холбох нөхцөл “*と*-to、*ば*-ba、*たら*-tara” -ийн тухай

市川保子 (2009)

小川誉子美口三枝令子 (2004)

小川誉子美口三枝令子 (2001)

Ц.Онон (2011), Р.Баттогтох, Б.Болормаа (2009) зэрэг эрдэмтэн, судлаач нар судалж шинжлэн өөр өөрийн дүгнэлтээ гаргажээ.

Энэ удаа монгол хэлний үйлийн тийн ялгалын шалтгааны утгат нөхцөл, япон хэлний үйлийн холбох нөхцөл “to”, “ba”, “tara”- г хоёр хэлнээ хэрхэн дүйж орчуулагддаг болохыг утга зохиолын жишээнд тулгуурлан гаргаж ирэхийг зорьсон юм.

Япон хэлний үйлийн холбох нөхцөл “-to, -ba, -tara” нь япон хэлний тодотгол гишүүн өгүүлбэрийн нөхцөл байдал заасан гишүүн өгүүлбэрийг холбодог ба монгол хэлнээ орчуулагдахдаа монгол хэлний үйлийн тийн ялгалын нэлээд хэдэн нөхцөлтэй утга хэрэглээний хувьд тохирдог боловч япон хэлийг сонирхон судалж байгаа хүмүүс тэр бүр яг ямар тохиолдолд, ямар утга илтгэхэд тухайн нөхцөлүүд хэрэглэгддэг болохыг мэддэггүйгээс үгчлэн, тааж орчуулах явдал цөөнгүй тохиолддог. Тийм учраас япон хэлний уг гурван нөхцөлийн салаа утга, хэрэглэгдэх нөхцөл байдал зэргийг бага зэрэг тодрууллаа.

Хүснэгт 1: “-to, -ba, -tara”-ийн хэрэглээ

用法-Хэрэглээ		条件表現- Нөхцөл	用例-Жишээ
Ижил нөхцөл байдал Х байвал дагаад заавал Y гардаг.	Хууль, дүрэм журам	ば	春が来れば、花が咲く。Хавар болвол цэцэг дэлгэрдэг.
		と	春が来ると、花が咲く。Хавар болонгуут цэцэг дэлгэрдэг.
Таамагласан, төсөөлсөн нөхцөл байдал Хэрвээ х байхын бол у гарна.	Хэлэх, ойлгуулах, гуйх хүсэх	たら	もし、いい雑誌があったら、買ってきてください。Хэрвээ сайн сэтгүүл байхын бол худалдаж аваад ирээрэй.
		ば	もし、聞きたければ、貸してあげますよ。Хэрвээ сонсмоор байвал түр зээлүүлэе.
	Хэвшил, заншил болсон зүйл	と, たら	兄は冬になると、毎年スキーに行く。Ах өвөл болохоор жил бүр цанаар гулгахаар явдаг.
Баталсан шийдвэрлэсэн нөхцөл байдал Аль хэдийн болж өнгөрсөн зүйлийг илэрхийлэхэд хэрэглэнэ.	Ололт, нээлт	たら	今朝外に出たら、雨が降っていた。Өнөө өглөө гадаа гаргал бороо орж байсан.
		と	部屋の窓を開けると、海が見えた。Өрөөний цонх онгойлгонгуут далай харагдсан.
	Үргэлжилсэн үйл явдал	と	男は部屋に入ると、友達に電話した。Эрэгтэйг өрөөнд ортол утас дуугарсан.
	Урьдын зуршил, зан үйл	と	彼はお酒を飲むと、暴力を振るった。 Тэр эрэгтэй
		ば	父は東京に行けば、必ずお土産を買ってくれた。Аав токио явбал заавал авчирч өгдөг.

Монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөлийн талаар Ш.Лувсанвандан (1939он) “Монгол хэлний зүй”, П.Бямбасан “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд”, эрдэмтэн Ш.Лувсанвандан 1951, 1956 онд, профессор Г.Д.Санжеев 1958 онд, доктор С.Галсан 1975, 1966 онд хэвлүүлсэн “Орчин цагийн монгол хэлний зүй”, 1973онд хэвлэгдсэн “Дунд сургуулийн сурах бичиг”, М.Базаррагчаа “Монгол хэлний үйлийн тийн ялгал ” зэрэг бүтээлдээ монгол хэлний тийн ялгалын утга үүрэг, тоо, онцлогийн талаар судалгаа хийсэн байна. Ингэхдээ нөхцөл үйл, үйлийн тийн ялгал зэргээр нэрийдсээр ирсэн бөгөөд тооны хувьд 16, 15, 11 гэх мэтээр олон янзаар ангилсан ба М.Базаррагчаа орчин цагийн монгол хэлний үйлийн тийн ялгалын 18 нөхцөл байна гэж үзээд утга, хэрэглээний онцлогийг нэг бүрчлэн гаргасан байна. Эдгээр 18 нөхцөлийг мэдэгдэхүүний талаас шалтгааны утгат, шалтгааны бус утгат⁵⁸ гэж ангилсан бөгөөд шалтгааны утгат үйлийн тийн ялгал нь тухайн 2

58 М.Базаррагчаа “Монгол хэлний үйлийн тийн ялгал”

үйлийн учир шалтгааны холбогдлыг зааж ихэвчлэн дараагийн үйл нь эхний үйлийн үр дүн болох утгатай. Харин шалтгааны бус утгат тийн ялгал нь тухайн 2 үйл нэг нь нөгөөгөөс шалтгаалахгүй, сүүлийн үйл нь өмнөхөө эсрэгцсэн шинжтэй байдаг. Шалтгааны утгат нөхцөлүүд нь япон хэлний болзол заасан холбох нөхцөл to, ba, tara- тай хэрхэн утга дүйж орчуулагдаж болох вэ гэдгийг уран зохиолын жишээн дээр харьцуулан үр дүнг графикаар товчлон харууллаа.

Судалгаанд ашигласан зохиолын зарим жишээг түүвэрлэн орууллаа.

- *Сүүлийн үеийн байнгын дадал хэвилийг илэрхийлэх утгатай.*

しかし、その日はまだ一日、鼻がまた長くなりはいしないかと云う不安があった。そこで内供は誦経する時にも、食事をするときにも、暇さえあれば、手を出して、そっと鼻の先にさわって見た。/A.P/

Гэвч тэр өдөр бүхэл өдөржингөө хамар нь дахин урт болчих вий хэмээх зовиурт автсан хамбатан уншлагынхаа үед ч тэр хоол идэх үед ч тэр сав л хийвэл хамрынхаа үзүүрт гараа хүргэн үзчихээд байлаа. /Ц.О/

- *Өгүүлэгчийн аливаа үйлд хандаж буй хандлагыг илтгэх утгатай.*

それを真にうけて仕出しを頼みに来られたらどうするか。/A.P/

Хэрэв хэн нэгэн хоол захиалах гээд хүрээд ирвэл яах юм болоо?/O.A/

- *Эхний үйлээс дараагийн үйл шалтгаалах утгатай.*

“あたしがだまってたら、どうやって暮らしていくんですか、” /X.И/

-Би дуугүй болчихоор тэгээд яаж амьдрах болж байна? /Ц.О/

- *Өгүүлэгчийн бодол санаа, мэдрэмж, хандлагыг илтгэх утгатай.*

Эрэгцүүлэн санавал, эдгээр хэдэн үсэг нь түүний бие надаас салахад миний дэвтэр дээр тэмдэглэж өгсөн, сануулга лав мөн хэмээн сая мэдэвч, юу хэмээсэн утга нь басхүү далд амой. /Д.Н/

よくよく考えて見れば、これらの文字は彼女が私と別れるときに、手帳に書き記したに間違いなことが分かったが、しかし、そこに隠された意味が何なのかはまだ、わからない。/O.K/

- *Эхний үйл нь дараагийн үйлийн шалтгаан болох утгатай.*

—Одоо түүнийгээ санахаар тэр үеийн зүүдэлж байсан сайхан зүүд шиг санагдах юм. /Ч.О/

—今、そのことを考えると、当時の夢を見つづけた美しい夢のように思える。/O.Ш/

- *Эхний үйл нь дараах үйлийн зорилгыг заах утгатай.*

Жамба: -Одоо хариад л хуримаа хийнэ. /Ч.О/

ジャムバ: -今帰ったら、式をあげるんだ。/O.Ш/

- *Тухайн хоёр үйл дараалан болох утгатай.*


За хүүхэд минь сайн сайхан яваарай гэж хэлээд удалгүй нас баржээ. /Ц.Д/

それではおまえたち達者でなこう言うと父親はまもなく亡くなった。/O.K/

- *Эхний үйл нь болзох утга илтгэж, дараагийн үйл нь өгүүлэгч этгээдийн магадласан утгыг илтгэнэ.*

Эмээлээ бухандаа тохвол үс нь халцрах магадгүй гэж өөрөө үүрч харьсан гэж хүн ярих юм. /Ц.Д/

人々の話によれば、鞍を種牛に置くと背中の毛が。。け落ちるかもしれないと思ったので、自分で鞍を担いで帰ってきたのだそうだ。/O.K/



Энэхүү судалгаанд 6 зохиолоос (Ном зүй хэсгийн **Эх хэрэглэгдэхүүнээс харах**) жишээ болгон авсан 115 өгүүлбэрт япон хэлний үйлийн холбох нөхцөл “to”-60, “ba”-28, “tara”-30, монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөлийн “-бал, -вал, -ваас”-72, “-тал, -тэл, ”-10, “-аад”-14, “-хаар”-9, “-магц”-2, “-ж”-4, “-ч”-1, “-н”-2, “-нгуут”-1 тус тус гарчээ. Эдгээр нөхцөлүүд нь хоёр хэлнээ орчуулагдахдаа хоёр үйлийг холбох, үйлийн шалтгаант холбоог илэрхийлэх үндсэн утгаа хадгалан буусан байна. Уран зохиолын эхээс авсан жишээнээс үзэхэд монгол хэлний үйлийн тийн ялгалын эдгээр нөхцөл нь япон хэлний үйлийн холбох нөхцөлийн утгуудтай дараах байдлаар дүйж байна.

Үүнд монгол хэлний үйлийн тийн ялгалын 18 нөхцөлийн 1. болзох “-бал, -вал”, 2. Угтах “-тал”, 3. Урьдах “-хад, ход” 4. Урьдчилах “-аад”, 5. Дагалдах “-хаар”, 6. Бэлтгэх “-магц”, 7. Зэрэгцэх “-ж, -ч” 8. Хам “-н”, 9. Далимдах “-нгуут” гэсэн 9 нөхцөл Япон хэлний үйлийн холбох нөхцөл “to, ba, tara”-тай утга үүргийн хувьд тохирч байна. Мөн хоёр хэлний эдгээр нөхцөлүүд нь ерөнхийдөө бүгд хоёр үйлийн шалтгаант холбоо хамаарал, цаг хугацааны уялдаа холбоог илэрхийлдгээрээ ижил төстэй байгаа бөгөөд утгын хувьд хэрхэн дүйж буйг харгалзуулан тайлбарлая.

Япон хэлний үйлийн холбох нөхцөл “ba”-нь

- Өмнөх өгүүлбэрийн өгүүлэхүүн нь нөхцөл байдлыг илэрхийлэх утга нь Монгол хэлний үйлийн тийн ялгалын дагалдах нөхцөл “-хаар, хлаар”-ын -Эхний үйлээс дараагийн үйл шалтгаалах утгатай,
- Бодит үнэн, эсвэл өөр өөр үйл явдлыг таамаглах утга нь -Дараагийн үйл нь эхний үйлтэй эсрэгцэх утгатай
- Таамаглах, төсөөлөх, хүсэл сонирхол,энгийн нөхцөл байдлыг илэрхийлэх утга нь Болзох нөхцөл “-бал, -вал” –ын -Өгүүлэгч этгээдийн санал бодол, мэдрэмж, үнэлэлт дүгнэлт, хандлагыг илэрхийлэх утгатай,
- Сүүлийн үйл нь хүсэл сонирхол илэрхийлсэн утгатай байх бөгөөд түүнийгээ биелүүлэхийн тулд юу чухал болохыг илэрхийлэх утга нь -Эхний үйл нь болзох утга илтгэж дараагийн үйл нь өгүүлэгчийн баталсан, дүгнэж шийдвэрлэсэн, -Эхний үйл нь дараагийн үйл үүсэх шалтгаан болох, -Эхний үйл нь дараагийн үйл болох нөхцөлийг бий болгох утгатай,
- Энгийн нөхцөл байдал, зүй тогтол, учир шалтгаан зэргийг илэрхийлэх утга нь - Хоёр үйлийн шалтгаант холбоог заах утгатай тус тус тохирч байна.
- Харин “Тага”-ийн Санал бодол, хүсэл зорилго, тушаал, захиас, заавар, харилцаа холбоо зэргийг илэрхийлэх утга нь монгол хэлний үйлийн тийн ялгалын болзох нөхцөл “-бал, -вал”-ын -Өлгүүлэгчийн санал бодлыг илэрхийлэх утгатай,
- Эхний өгүүлбэрээс дараагийн өгүүлбэрлүү гол утга шилжих утга нь -Урьдчилах нөхцөл “-аад”-ын эхний үйл нь дараах үйлийн зорилгыг заах утгатай тохирч байна.

Мөн “to”-ийн• Эхний үйлийн үр дүнд дараагийн үйл бий болох утга нь- Монгол хэлний үйлийн тийн ялгалын болзох нөхцөл “-бал, -вал”-ын

Хоёр үйлийн шалтгаант холбоог заах , Эхний үйл нь дараагийн үйл үүсэх нөхцөлийг бий болгох, -Эхний үйл нь дараагийн үйлийн хэр хэмжээг заах, Эхний үйл нь дараагийн үйл үүсэх шалтгааныг заах утгатай,

- Эхний үйл дуусмагц дараагийн үйл даруй эхлэх утга нь-Хоёр үйл цаг хугацааны хувьд бараг давхцах утгатай,
- Эхний үйл болж дуусмагц дараагийн үйл даруй болох утга нь- Бэлтгэх нөхцөл“-магц”-ын -Эхний үйл дуусмагц дараагийн үйл залгах утгатай,
- Хоёр үйлийн шалтгаант холбоог заах утга нь Угтах нөхцөл “-тал, -тэл, -тол,-төл”-ийн –Эхний үйл нь дараах үйлийн шалтгааны утгатай,
- Эхний үйл болж дуусмагц дараагийн үйл даруй болох утга нь □ Эхний үйл дөнгөж дуусмагц нөгөө үйл даруй эхлэх утгатай бөгөөд тэр нь санамсаргүй гэнэт болох утгатай (зарим тохиолдолд),

- Өмнөх үйл явдал болсны дараа үргэлжлээд дараагийн үйл заавал болох утга нь-Нэг үйл үргэлжилж байтал нөгөө үйл гэнэт хоромхон зуур таслан үйлдэх(цөөн тохиолдолд) , -Эхний үйлийн үр дүнд дараагийн үйл болох утгатай,
 - Эхний үйл болж дуусмагц дараагийн үйл даруй болох утга нь (хэдийгээр эхний үйл болж дуусна гэж байгаа боловч цаг хугацааны хувьд давхцах утгыг мөн илэрхийлнэ.) -Урьдчилах нөхцөл “-аад”-ын -Хоёр үйл зэрэг болох,
 - Нэг өгүүлэгдэхүүний үргэлжилсэн үйл хөдлөлийг ч мөн илэрхийлэх утга нь -Нэг үйлийн эзний үргэлжилсэн олон үйлийг илэрхийлэх,
 - Ерөнхий, бодит нөхцөл байдал, үр дүнг илэрхийлэх утга нь -Зэрэгцэх нөхцөл “-ж” ийн •Бодит байдал үнэн дүр төрх илтгэх,
 - Эхний үйл болж дуусмагц дараагийн үйл даруй болох утга нь “-ч”-ийн □Тухайн хоёр үйл цувж болох утгатай,
 - Эхний үйл болж дуусмагц дараагийн үйл даруй болох утга нь -Хамжих нөхцөл “-н”ийн -Эхний үйлийн үр дүнд дараагийн үйл болох утгатай тус тус дүйж байна. “tara” –ийн• Хоёр үйлийн зэрэг болох утга нь -монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөл “-нгуут”-ын хоёр үйл хам цагийг илэрхийлэх утгатай ,
- “to”-ийн• Эхний үйлийн үр дүнд дараагийн үйл даруй эхлэх утга нь –монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөл “-нгуут”-ын хоёр үйл цуван үйлдэгдэх буюу нэг үйл нөгөөгийнхөө шалтгаан болох утгатай тохирч байна.

Дүгнэлт

Монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөл нь зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, холимог нийлмэл өгүүлбэр гээд бүх нийлмэл өгүүлбэрийн гишүүн өгүүлбэрүүдийг холбодог бол Япон хэлний үйлийн холбох нөхцөл нь япон хэлний тодотгол гишүүн өгүүлбэр тэр дундаа болзох буюу нөхцөл байдал заасан өгүүлбэрийг л холбох үүрэгтэй.

Ингэхдээ ихэвчлэн болзол заах боловч “tara”-нь ярианы хэлэнд , “-ba”-албан бичгийн хэлэнд , “to”-нь хүүрнэл зохиол, бодит байдал зэргийг илэрхийлэхэд хэрэглэгддэг бол монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөлүүд нь бүгд яриа болон бичгийн хэлэнд адилхан хэрэглэгддэг.

Монгол хэлний үйлийн тийн ялгалын 18нөхцөлийн 1.болзох “-бал, -вал”, 2.Угтах “-тал”, 3. Урьдчилах “-аад”, 4.Дагалдах “-хаар”, 5.Бэлтгэх “-магц”, 6.Зэрэгцэх “-ж, -ч” 7. Хам “-н”, 8. Далимдах “-нгуут” гэсэн ,шалтгааны утгат нөхцөл /шалтгааныбус утгат – нгууттай мөн тохирно/ япон хэлний үйлийн холбох нөхцөл “to, ba,tara”-тай утга үүргийн хувьд тохирч байна. Мөн хоёр хэлний эдгээр нөхцөлүүд нь ерөнхийдөө бүгд хоёр үйлийн шалтгаант холбоо хамаарал, цаг хугацааны уялдаа холбоог илэрхийлдгээрээ ижил төстэй юм.

Харьцуулсан жишээнээс харахад “ba–бал, вал; to-ж,-ч; to-тал; tara-бал, -вал; to-аад; гэсэн нөхцөлүүд нь утгын хувьд 2 хэлнээс тооны хувьд тэнцүү хэмжээнд орчуулагдсан бөгөөд дүрмийн номонд ихэвчлэн гардаг to-г -нгуут² нөхцөлөөр , tara-г -тал⁴ –нөхцөлөөр орчуулсан тохиолдол ганц ганц гарч байгаа нь эдгээр нөхцөлийг зөвхөн энэ нөхцөлөөр орчуулна гэж явцуу хүрээнд оноож болохгүйг харуулж байна. Гэхдээ энэ судалгаа нь зөвхөн утга зохиолын жишээн дээр авсан учир учир дутагдалтай байхыг үгүйсгэх аргагүй бөгөөд цаашид албан бичиг, ярианы хэлний жишээн дээр судлах хэрэгтэй юм.

Япон хэлний үйлийн холбох нөхцөл “to, ba,tara”, монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөлд ялгаатай хэд хэдэн зүйл байна.

-Хэрэглээний хувьд япон хэлний үйлийн холбох нөхцөл“to, ”-нь үүргэлжилсэн ,үгийн зохиол, бодит байдлыг илэрхийлэхэд , “ba” нь ихэвчлэн бичгийн хэлэнд (албан ёсны утга илэрхийлсэн) , “tara” нь ярианы хэлэнд хэрэглэгдэнэ гэсэн тогтсон хэрэглээний сэдэв байдаг бол монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөл нь “-руун, -рүүн”-ийг эс тооцвол бүгд яриа болон бичгийн хэлэнд аль алинд нь хэрэглэгддэг байна.

-Япон хэлний үйлийн холбох нөхцөл“ ba,tara”-нь өгүүлэгчийн бодол санаа, сэтгэлийн өнгө аясыг илэрхийлэх зарим тохиолдолд өгүүлбэрийн төгсгөлд сул үгийн үүргээр ордог бол монгол хэлний үйлийн тийн ялгалын нөхцөл бүгд сул үгийн үүрэг гүйцэтгэдэггүй.

Ном зүй

Нэг: Эх хэрэглэгдэхүүн

1.1 Монгол хэлнээс япон хэлрүү орчуулагдсан бүтээл:

1. Дамдинсүрэн. Ц. “Бух Гомбо”(япон хэлрүү орчуулсан Окада Казүюүки “種牛ゴンブ”) モンゴル文学への誘い、株式会社、2003.
2. Нацагдорж. Д. “Харанхуй хад”. (Япон хэлрүү орчуулсан Шибаяама Ютака. “黒い岩”) モンゴル文学への誘い、株式会社、2003.
3. Ойдов.Ч “Зам”(Япон хэлрүү орчуулсан Озава Шигэо “道”) 株式会社、1966.

1.2 Япон хэлнээс монгол хэлрүү орчуулагдсан бүтээл:

1. Акүтагава Рюносүкэ.“Хамар”.– Япон хэлнээс орчуулсан Ц. Онон “Хамар”. УБ., 2010.
2. АкүтагаваРюносүкэ “Аалзны шүлс” -Япон хэлнээс орчуулсан О.Амгалан УБ.,2011он
- 3.Хигүчи Ичиёо “Булингарт булан” – Япон хэлнээс орчуулсан Ц. Онон “Булингарт булан”. УБ.,2010. 8-68 тал.

Хоёр: Судалгааны бүтээл:

1. Бадрал.Ч “ Монгол- Япон, Япон- Монгол хэлний Хэл шинжлэлийн нэр томъёоны

- тайлбар толь ” Улаанбаатар 2009 он
2. Базаррагчаа. М “Монгол хэлний үйлийн тийн ялгал” Улаанбаатар 1999 он
 3. Базаррагчаа. М “Монгол хэлний өгүүлбэр” Улаанбаатар 2005 он
 4. Баттогтох. Р “Япон хэлний дүрэм” Улаанбаатар 2009 он
 5. Бямбасан. П “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд” Улаанбаатар 2006 он
 6. Лувсанвандан. Ш “Хэл шинжлэлийн асуудлууд” Улаанбаатар 1981 он
 7. 市川保子 (2009) “初級日本語文法と教え方のポイント” スリーエーネットワーク
 8. 小川譽子美口三枝令子 (2004) “日本語文法演習ことからの関係を表現—複文”
 9. 小川譽子美口三枝令子 (2001) “セルフマスターシリーズ7 条件表現”
 10. ツルバートル オノン (2011) 発見と協働を取り入れた翻訳授業の試み—「と」「ば」「たら」の使い分けをめぐる— . Journal of Japanese Language and Culture, Tom 7, page 59-84, The Japanese-Language Institute and National Graduate Institute for Policy Studies.
 11. 国際交流基金日本語国際センター “教師用日本語教育ハンドブック 3—文法 1”
 12. 村田水恵 “入門日本語の文法—日本語を一から学び直したいひとへ”
 13. 砂川有里子... “日本語の文法の辞典”
 14. 沖森卓也—林義之... “図解日本語”

Resume

People who are learning foreign languages ought to acquire four skills such as listening, speaking, writing and reading equally. To do so, it is vital to learn the grammar of the language that you are learning. There are many problems which can be occurred like misunderstanding, wrong expression and so on due to the misunderstanding and misuse of a grammar. In this paper, I aim to show the way of translation of Mongolian verbal suffixes of cause and Japanese verbal suffixes as “-to, -ba, -tara” based on the literature examples.

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ

“Өвгөн Жамбалын яриа”-г Ч.Бауден орчуулсан нь

Л.Чулуунбаатар⁵⁹ (МУИС, ШУС)

Товч утга: Английн нэрт монголч эрдэмтэн Чарльз Баудены Монгол судлалаар дагнан хийсэн олон бүтээлийн дотор монгол хэлнээс англи хэлэнд орчуулсан зохиол нилээд хэд байдаг юм. Түүний нэг бол Ц.Дамдинсүрэн гуайн Өвгөн Жамбалаас сурвалжлан эмхэтгэж, 1959 онд хэвлүүлсэн “Өвгөн Жамбалын яриа” нэртэй бүтээл юм. Энэ бүтээлийг монголч эрдэмтэн Магадбүрэн Халтод (Галт-Од)-ын тусламжтайгаар анх уншсан боловч 1969 оны Ц.Дамдинсүрэнгийн түүвэр зохиолд хэвлэгдсэн зарим нэгэн засвар хийсэн эхийг эх болгон орчуулсан байдаг юм. Энэ бүтээлийг орчуулахад Монголын болон гадаадын монголч эрдэмтэдийн 59 бүтээлийг уншиж ашигласан байна. Уг орчуулга болон Монгол-Англи толио 1963 онд зэрэг эхэлсэн шигээ 1997 онд зэрэг дуусгаж, хоёр бүтээл нь зэрэг энэ онд хэвлэгдсэн байдаг.

Түлхүүр үг: Орчуулга зүй, Монгол англи орчуулга, Өвгөн Жамбалын яриа, Ч.Бауден, Бурхны шашин

Олон улсын монголч эрдэмтэдийн анхдугаар хурлын төлөөлөгч, монгол судлалын гарамгай эрдэмтэн, Английн Хатан хааны академийн хүндэт профессор Чарльз Баудены 90 насны ой хэдхэн хоногийн өмнө болж, энэ аугаа хүний ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол судлалын хүрээлэнгээс зохион байгуулан хийлээ.⁶⁰

Аугаа хөдөлмөрч энэ хүн 1924 оны 4-р сарын 22-ны өдөр дулаан зөөлөн уур амьсгалт, Английн өмнөт эргийн хот болох Веймоут (Weymouth) хотод Чарльз Роскеллийнхний гэр бүлд хоёр дахь хүү нь болон төржээ. Аав, ээж хоёр нь хоёулаа дунд сургуулийн багш байсан болохоор хоёр хүүгээ эрдэм номтой, хүний дайтай хүн болгон өсгөжээ. Тийм болохоор Ч.Бауден Лондонгийн Их Сургуулийн монгол судлалын гавьяат профессор, Британийн Академийн жинхэнэ гишүүн, дэлхийд нэртэй монгол судлалын эрдэмтэн, ах нь далайн цэргийн нэр хүндтэй офицер, инженер хүн болсон байна. Ч.Бауден дэлхийн II дайны гал ид дүрэлзсэн 1943-1946 оны хооронд 3 жил Британийн усан цэрэгт алба хаажээ. Дараа нь Кембрижийн Их Сургуульд орж суралцан төгсгөөд, 1955 онд “Алтан товчийн цаг тооллын бичиг” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. 1950-иад оны эхээр монгол бичгийн хэлээр монгол хэл сурсан болохоор 1955 оноос сонгодог монгол бичгийг сонгох хичээл маягаар зааж эхэлжээ. Тэрээр монгол судлалын нэрт эрдэмтэд Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Г.Сэр-Оджав, О.Намнандорж, Ц.Дорж, Я.Цэвэл гуайтай танилцаж, уулзаж

⁵⁹ МУИС-ийн ШУС, профессор, доктор

⁶⁰ “Монгол судлалын шинэ чиг хандлага II”, Их Британы нэрт монголч эрдэмтэн Чарльз Баудений мэндэлсний 90 насны ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, УБ., МУИС, 2014-03-21-22

хуучилж явжээ. Б.Ринчен багштай 1954 онд анх захидлаар холбоо тогтоосон болохоор миний анхны багш нарын нэг хэмээн хэлдэг байсан. Б.Ринчен багшаас хүлээн авсан 12 захидал болон ил захидал байдаг бөгөөд нэг удаа тэдгээрээ надад авчирч үзүүлсэн билээ. 1967 оны 8 сараас 1968 оны 2-р сар хүртэл Монголд байхад нь Э.Вандуй, Ж.Цолоо нар монгол хэлний багш хийж байжээ. Ж.Цолоог залуухан 20 настай, эхнэртэй хийгээд багш болон хөтөч хийдэг байсан хэмээн хуучилж байсан билээ.⁶¹

Лондоны Их Сургуульд багшаас эхлэн салбар сургуулийн захирал, проректорын алба хүртэл амьдралынхаа ихэнх хувийг хашиж явсан тэрбээр дэлхийн монгол судлалд нэр алдраа дуурсгасан олон бүтээл хэвлүүлсний дотор монголын эртний уран зохиол, хуучин сурвалж эх бичгээр дагнан ажиллаж олон бүтээл туурвисны дотор орчуулгын том бүтээл хэд хэд байдаг юм. Үүнд:

“**Алтан товч**” (*The Mongol Chronicle Altan Tobci*. Wiesbaden: Otto Harrassowitz, 1955)

“**Хүрээний Жавзандамба хутагт**” (*The Jebtsundamba Khutukhtus of Urga; text, translation, and notes*. Wiesbaden: O. Harrassowitz, 1961),

“**Өвгөн Жамбалын яриа**” (*Tales of an old lama, Translated by C.R.Bawden, UK, 1997*)

“**Монголын уламжлалт утга зохиолын дээжис**” (*Mongolian Traditional Literature: An Anthology*. London: Kegan Paul, 2003)⁶² хэмээх дөрвөн бүтээл байдаг юм. Check date values in: |date= (help)

Эдгээр бүтээлийн дотроос Ц.Дамдинсүрэн гуайн Жамбал өвгөнөөс сурвалжлан тэмдэглэж, ном болгон гаргасан “**Өвгөн Жамбалын яриа**” номын орчуулгын талаар ярих гэсэн юм. Уг номыг Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний хэвлэлийн Газраас 1959 онд хэвлэн гаргасан 93 хуудастай ном юм. Хэдийгээр энэ номын нэр “**Өвгөн Жамбалын яриа**” хэмээх нэртэй боловч Ч.Бауден гуай шууд үгчилж орчуулсангүй өрнөдийн хүмүүсийн анхаарал татах болон гарчигийг илүү утга агуулгатай болгож “*Tales of an old lama*” хэмээн нэрлэсэн байна. Орчуулгыг бүхэлд нь дэлгэрэнгүй яривал их урт зүйл болох учир энэ өгүүлэлд гол онцлогийн тухай хэдэн зүйл дээр яримаар байна. Энэ орчуулгын онцлог хэдэн зүйлд байгаа юм.

1. Энэ ном бол Богд хаант Автономит Монгол улсын үеийг харуулсан, түүх соёл, хэлний чухал дурсгал болохынх нь хувьд хийгээд 1961 онд орчуулж гаргасан “**Хүрээний Жавзандамба хутагт**” хэмээх номтой нь агуулга, сэдэв ойр дөт болоод тэр номд ороогүй олон сонирхолтой зүйлс энэ номд байсан болохоор онцгойлон сонгож авсан нь мэдээж хэрэг юм. Тэгэхдээ 1959 оны хэвлэлээс бус 1969 оны Ц.Дамдинсүрэнгийн түүвэр зохиолд хэвлэгдсэн зарим нэгэн засвар хийсэн эхийг эх болгон орчууллаа хэмээн онцолсон байдаг. Зарим нэгэн засвар хийсэн эх хэмээн өмнөх үгэндээ дурьдсан явдал бол 1959 оны хэвлэсэн эхийг ч бас уншсан гэдгээ тодотгож байгаа хэрэг юм. Өрнөдийн түүхчид Их Монгол улс

61 Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлалын эрдэм шинжилгээний бүтээл”, № 30 (318), 2009, 135-139 дэх тал

62 www.Charles Bawden - Wikipedia, the free encyclopedia

болон ХХ зууны эхэн үе хүртэлх түүхийн зохиол бүтээлийг нилээд туурвисан боловч Роберт Рупен, Ч.Бауден хоёрын Монголын түүх болон Виллиам Браун, Онон Өргөнгөө нарын орчуулсан БНМАУ-ын түүхийн 3-р боть-иос өөр автономитийн үеийн түүхийг оруулан бичсэн зохиол англи хэлээр ховор билээ. Хэдий тийм боловч тэр үеийн сүм хийд, шашин номын жаяг ёс, Богдын засгийн үед болж байсан олон сонин үйл явдлын тухай огт байхгүй билээ. Тийм болохоор өрнөдийн уншигчдад бодит хүний домог яриагаар үзүүлсэн тэр үеийн түүхийг тодорхой танилцуулах гэсэн хэрэг юм. Орчуулагч өмнөх үгэнд “Энэ ном хоёр удаа хэвлэгдсэн боловч Монголоос гаднах орны уншигчдад төдий л танил биш”⁶³ хийгээд “Их хэлмэгдүүлэлтийн өмнөх Монгол оронд бурхны шашин ямар байсныг мэдэхэд үнэлж баршгүй тодорхой дүр зургийг өгөх болно”⁶⁴ хэмээн онцлон дурдсан байдаг.

2. Энэ номыг орчуулахын тулд асар их хөдөлмөр, тэвчээр, 34 жилийн уйгагүй чармайлт гаргасан байдаг. Анх энэ номыг 1963 онд Магадбүрэн Халтод гуйн тусламжтай уншсан байдаг. Боннын Их Сургуулийн багш Магадбүрэн Халтодыг Лондонгийн Их Сургуулийн Ойрх дорнот болон Африкийн судлалын сургуульд 3 сарын хугацаагаар ажиллахаар ирээд байсан үе юм. “Үг олдож үхэр холдлоо” хэмээн Магадбүрэн гуай их хэлдэг байсан хэмээн хуучилдаг байв. Энэ зохиолыг Магадбүрэн гуйтай уншчихаад “Монгол-Англи толь” хамтран хийхээр тохироод хийж байсан боловч 1978 онд Магдбүрэн гуай нас барж, хэцүү хүнд байсан боловч “Би түүний аугаа их судлаачийн байр сууринд хүрэхгүй боловч толио дуусгахыг амьдралын зорилго болгосон”⁶⁵ хэмээн өөртөө тангараглаж толио энэ орчуулгын номтой хамт 1997 онд хэвлүүлж гаргасан билээ. Энэ нь манай нэрт эрдэмтэн Б.Рэнчин багш шиг нэгэн зэрэг олон зүйлд төвлөн ажиллаж чаддаг бүтээлч хүн байсан гэсэн үг юм.

3. Энэ номыг орчуулахын тулд Позднеевийн “**Монгол ба Монголчууд**” (*Mongolia and the Mongols*), С.Пүрэвжавын “**Хувьсгалын өмнөх Их хүрээ**” (*Pre-revolutionary Urga*) номыг⁶⁶ уншсан минь их тус болсон хэмээн дурьдсан байдаг. Түүнд бас “**Алтан товч**” (*The Mongol Chronicle Altan Tobci*. Wiesbaden: Otto Harrassowitz, 1955), “**Хүрээний Жавзандамба хутагт**” (*The Jebtsundamba Khutukhtus of Urga; text, translation, and notes*. Wiesbaden: O. Harrassowitz, 1961)⁶⁷ номуудыг орчуулсан арвин баян туршлага байсан билээ.

4. Уг номд орсон шашин бурхны холбоотой болон монгол судлал, түүхийн олон үг, үйл хэргийг тайлбарлахын тулд дээрх номуудаар тогтохгүй өөрийн хийгээд Өрнөдийн болон Монгол улсын эрдэмтэдийн түүхийн, судалгааны зохиол бүтээлээс гадна олон толь бичиг зэрэг 57 бүтээл⁶⁸ ашигласан байдаг юм.

63 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p X

64 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p X

65 Charles Bawden, *Mongolian-English dictionary*, London and New York, 1997, p I

66 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p IX

67 www. Charles Bawden - Wikipedia, the free encyclopedia

68 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p XI-XIV

5. Энэ номд орсон төвд үгнүүдийг боломжийн хирээр орчуулан тавьсан байдаг. Хамгийн эхэнд байгаа Жамбал тойн гэдгийг “Jambal the Chaplain” гэж орчуулаад хуудасны доор Mo. Donir, probably Tib. *Dkon gnyer*, as in Das, p. 55 “a priest who is in charge of a Buddhist chapel or temple and performs the daily services to the deities contained in it” хэмээн Чандра Дасын толиос иш татан тайлбарласан байдаг. Манай судлаач эрдэмтэн Н.Балжиннямын “Монгол хэлний гадаад үгийн толь”-д “Сүм хийдийн харийн бичиг”⁶⁹ хэмээн тайлбарласан нь Ч.Дасын дээрх тайлбартай бараг ижил байгаа болой. Ийм байдлаар бараг хуудас болгон дээр 1-9 хүртэлх тайлбар зүүлтийг хийсэн байгаа юм. Манай нэрт эрдэмтэн, академич Б.Ринчен багш орчуулсан номдоо ингэж тайлбар хийдэг байсан билээ. Энэ талаар манай профессор Ж.Баттөр багш нэг сонирхолтой илтгэл тавьж байсан билээ.

6. Зарим үгийн нэг хоёрдугаар хэвлэлийн зөрөөг ч нарийн ажигласан байдаг.

Жишээ нь 3-р хуудсанд “Би хогийн шавхруу болсон хүн дээ” хэмээх өгүүлбэрийг “*I just some left-over rubbish*”⁷⁰ хэмээн орчуулаад доор тайлбарт Mo. *Khogiin shavhruu is an improvement on khogiin shahuu in the first edition* хэмээн тайлбарласан байгаа юм.

7. Монголын зан заншил, үндэсний онцлогтой олон үгийг шууд орчуулах буюу тайлбарлан орчуулсан байдаг. Жишээлбэл: ““Лам нарын гэдэс” цайлгана гэж хавар хоормог тараг их өгнө” хэмээх өгүүлбэрийг “*In spring the people would give a lot of khoormog and yoghurt to “whiten the lamas’ guts”*”⁷¹ хэмээн орчуулаад доор хоормогийг a type of fermented milk drink хэмээн тайлбарлаад миний орчуулсан тараг ч бас a type of fermented milk drink гэж тайлбарласан байдаг. Өрнөдийн хүнд өөрийн биеэр ууж үзэж, харж мэдрээгүй бол хоормог таргийн ялгааг гаргах хэцүү байх л даа. Гэхдээ л тарагийг болохоор *yoghurt* хэмээн орчуулаад хоормогийг болохоор нэгэн төрлийн эсгэсэн сүүний ундаа хэмээн тайлбарласан нь өрнөдийн хүнд хоёр өөр ялгаатай зүйл гэдгийг нь ойлгуулахаар байгаа юм. Харин айргийг *kumis* хэмээн орчуулсан боловч доор бас *fermented mares’ milk* хэмээн тодруулж тайлбарласан байна.

8. Сүм хийдийн үйлчилгээтэй холбоотой монгол хэлэнд орсон зарим үг болон зүйр үгийг шууд орчуулсан байдаг. Жишээ нь: 4-р талд “Манж сүлэх сүүний үнээг сүрэгчнээс авчруулж саадаг байсан” хэмээх өгүүлбэрийг “*They used to have milch cows brought in from herders to get milk for their tea*”⁷² хэмээн орчуулсан байна. Өгүүллийг тэрлэгч молхи миний бие 1989-1991 оны хооронд Лондонгийн Их Сургуулийн зочин багшаар ажилласан азтай завшаанаар Ч.Бауден гуайтай танилцаж хоёр жилийн турш 7 хоногт хоёр удаа хичээллэн иймэрхүү үгс олныг тайлбарлан ойлгуулж өгдөг байж билээ. Мөн 6-р талд “Муу билүүний баас их, муу ламын багш олон” хэмээх зүйр үгийг “*A bad whetstone makes a lot of swart, an bad lama has a lot of teachers*”⁷³ хэмээн орчуулсан байгаа болой. 8 –р талд “Богдын шавдан

69 Н.Балжинням, Монгол хэлний гадаад үгийн толь, УБ., 2008, 89-р тал

70 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p 3

71 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p 4

72 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p 4

73 Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p 6

батдахад зориулан түйлэхэд 12 лам үргэлж ном уншиж байдаг” хэмээх өгүүлбэрийг “*At the anniversary service for the “strengthening of the feet” of the Holy One twelve lamas read the scriptures continuously*”⁷⁴ хэмээн орчуулсан байдаг. Шавдан батдахад түйлэх гэдэг нь нас буяныг уртатгахад тусгай зан үйл байдаг учраас Баудений орчуулга ерөнхийдөө таарч байгаа боловч “*strengthening of the feet*” хэмээн шууд орчуулсан нь утгыг арай бүдэгрүүлсэн талтай байна. Гэхдээ өлмий бат оршиг хэмээх утгыг илтгэж байгаа болохоор буруутгаж үл болно.

9. Хүний хоч нэрийг тэр чигт нь буюу утгачлан орчуулсан байдаг. Нэг жишээ татахад 46-р талд “Ямаан Чимэдийн хүү” гэхийг “*Goat Chimed's son*”⁷⁵ хэмээн орчуулсан байна. Манай хэл шинжлэлийн нэрт судлаач профессор Б.Пүрэв-Очир “Хуучин үг” хэмээх өгүүлэлдээ “Энэ номд ийм үгсийн бүлгийг Жамбал донир, Ц.Дамдинсүрэн нар эзэнтэй нь, түүхэн хүний нэртэй нь тов тодорхой тэмдэглэн үлдээсэн нь хожмоо боддог ухаантай хүмүүсийн сайн ажил үйлс гэж хэлж болох байх. Үүнд: “амьд хууч ярианууд”-д байгаагаар жагсаан сонирхъя: Жамбал донир, Баажав донир, Мөрдоной нярав, хогч лалга Мөржав, тахилч Мөрням, гомбоо лам Дүгэржав, галч Дугаржав, Сандуй бичээч, хаалгач Цэвээнжамба, сангай лам Догсом, дэргэдийн бараа бологч, Жагар зодч, Дагва дунхар, Пунцаг хиа, Дарлан банди, Сэрээтэр туслагч, Балдан хачин, Арцаа тайж, Хүрлээ бэйс, Ахай бээс, Агваан зочи, Нэрэнпун галдаа, Соном гэсгүй, Содном занги, өвгөн ноён Дашдорж, Сэрээнэн оточ, Бандид ловон, Намжил тунсаг соёг, Цэвээн тэргүүн, Рааш захирагч, Гимпэл хүнд, Цэнд залан, Аюур зайсан, Цэнд гавж, Жасаа түшмэл, Лэгцэг сойвон, Мөрлэгцэг сэмбэн, Жигжид тойн, Нинж долбий, Гомбодоной гүен, Манзушир хутагт, Дамдин чухал, Чойжин лам, Чойнхор ван, Балданцэрэн гүн, сул гүн Санжмятав, Даваа мэйрэн, Шагж гэвш, Лувсандондог цорж, Бат-Очир шадар, Галсан умзад, цогчин умзад Чимэд, Гэлэгжамц дооромбо, Эрдэнэ маарамба, Агваан лхарамба, Ширнэн жонон, Өндөр гэгээн, Наваан рабжамба, Норов хамба, Дамбий шавран, Жалханз хутагт, Бадамдорж шанзав, Цэрэнчимэд даа лам, Ханд чин ван, Агваан хамба, хүрээ хамба Балдан чоймбол, Түвдэнжамц далай лам гэх мэт”⁷⁶ хэмээн бүгдийг тоочин оруулсан байгаа бөгөөд эд бүгдийг үгчлэн болон утгачлан орчуулсан байна. Хоч нэрийн талаар манай Н.Нансалмаа докторын хэдэн сайхан өгүүлэл бас бий.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Ч.Баудений “Өвгөн Жамбалын яриа” номын орчуулга бол өөрийнх нь цохон тэмдэглэснээр Их хэлмэгдүүлэлтийн өмнөх Монгол оронд бурхны шашин ямар байсныг мэдэхэд үнэлж баршгүй тодорхой дүр зургийг болон Монголын түүх соёлтой холбоотой олон ухагдахууныг Өрнөдийн англи хэлт уншигчдад өгч чадсан үнэхээр сайн орчуулгын бүтээл болсон байна. Мөн нөгөө талаар монгол заншил, бурхны шашинтай холбоотой зүйлийг хэрхэн орчуулах, орчуулахын тулд яаж шургуу хөдөлмөрлөх, утгыг эрж хайх үлгэр жишээг монголын залуу орчуулагчдад сургамжлан байгаа хэрэг юм. Тийм болохоор орчуулга хийе хэмээн сэтгэж байгаа манай залуу орчуулагчид Ч.Баудений дээр

74 Charles Bawden, “*Tales of the Old Lamas*”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p 8

75 Charles Bawden, “*Tales of the Old Lamas*”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997, p46

76 Б. Пүрэв-Очир, “Хуучин үг” өгүүлэл, www.dayarmongol.com/index.php?option=com

нэр дурдсан орчуулгын бүтээлүүдийг тулган унших хэрэгтэй бөгөөд түүнээс их зүйлийг суралцана хэмээн хэлэх байна.

ON THE TRANSLATION OF “TALES OF AN OLD LAMA”

BY CHARLES BAWDEN

Charles Bawden is a world-famous Mongolist, who compiled dictionary and translated many books in his lifetime. Among his valuable translation works, “Tales of the Old Lamas” played an important role. First, he read this book in Mongolian with the help of Magadburen Hal-tod. He has translated it for 34 years. His translation introduced a unique picture of religious life in Mongolia just before the catastrophic period of the early revolutionary time to the westerners. Numerous essential words related to Mongolian customs, tradition, history, nomadic life style, Mongolian Buddhism and shamanism have been explained in detail. This translation can be useful for the Mongolian young translators.

Ном зүй

1. Н.Балжинням, Монгол хэлний гадаад үгийн толь, УБ., 2008
2. Charles Bawden, “Tales of the Old Lamas”, Published by The Institute of Buddhist Studies Tring, UK., 1997
3. Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997
4. “Монгол судлалын шинэ чиг хандлага II”, Их Британы нэрт монголч эрдэмтэн Чарльз Баудений мэндэлсний 90 насны ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал,-ын абстракт эмхтгэл, УБ., МУИС, 2014-03-21-22
5. Э.Чинбат, Англи-Монгол толь, УБ., 2009
6. Ш.Чоймаа, Л.Тэрбиш, Д.Бүрнээ, Л.Чулуунбаатар, Буддын шашин соёлын тайлбар толь, I, II боть, УБ., 2000
7. Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлалын эрдэм шинжилгээний бүтээл”, № 30 (318), 2009
8. Robert Allen, Consultant editor, The New Penguin English dictionary, Penguin books, 2000
9. **Б. Пүрэв-Очир**, “Хуучин үг” өгүүлэл, www.dayarmongol.com/index.php?option=com
10. **www. Charles Bawden** - Wikipedia, the free encyclopedia

“Үлгэрийн далай”-н англи орчуулгын тухай

(Оноосон нэр болон хуучирсан үгийн орчуулгын жишээн дээр)

Д.Бүрнээ⁷⁷ (МУИС)

Товч агуулга: Монгол Ганжуурын 90 дүгээр ботиор уламжилж ирсэн “Үлгэрийн далай” судрыг 17 зууны үед Хөх хотын Ширээт гүүш төвд хэлнээс монгол хэлнээ орчуулсан бөгөөд тус орчуулгын 1714 оны барыг С.Фрай англи хэлнээ орчуулж, 1981 онд хэвлүүлжээ. Ширээт гүүшийн орчуулга худам монгол бичгээр уламжилж ирсэн бөгөөд дуун хөрвүүлэгчээс монгол бичгийн хэл, монгол орчуулгын уламжлалын талаар зохих мэдлэг эзэмшсэн байхыг шаардсан, ялангуяа буддын шашин гүн ухааны холбоотой үг хэллэг, нэр томъёог орчуулах талаар ихээхэн эрэл хайгуул хийж орчуулах эх байсныг тэмдэглэх хэрэгтэй. Монгол эхэд санскрит гаралтай оноосон нэр нэлээд хувийг эзэлж байх учир бид энэхүү өгүүлэлдээ С.Фрай оноосон нэр болон хуучирсан үг хэллэгийг хэрхэн орчуулсаныг ажигласан болно. С.Фрай монгол орчуулгын уламжлалыг судалж үзсэний үндсэн дээр оноосон нэрийн нэлээд олон хувийг санскритаар сэргээн буулгахын сацуу, өнөөгийн уншигчид тэр бүр сайн мэдэхгүй хуучирсан үг хэллэгийг ганц нэг эндүү ташаа хөрвүүлж, зарим нэгэн газар товчилж хураангуйлсныг эс тооцвол хуучирсан үгийн утгыг төвд эх судраас эрж, үнэн зөв орчуулсан байна. Өөрөөр хэлбэл С.Фрай монгол бичгийн хэл төдийгүй төвд эхийг дамаа судалж үзсэний үр дүнд дэлхийн дахины уран зохиолын сан хөмрөгт нэгэнтээ байраа эзэлсэн энэхүү алдартай зохиолын агуулгыг англи хэлнээ бүрэн дүүрэн орчуулж, гадаад улс орны уншигчдад хүргэж чаджээ.

Түлхүүр үг: Хэл дамнасан орчуулга, төвд эх, худам монгол бичгийн эх, оноосон нэр, хуучирсан үг, англи орчуулга.

“Үлгэрийн далай” бол монголчуудын дунд бар хэвлэл болон гар бичмэлээр өргөн тархсан, монгол түмний олон үеийн туршид шүтэн биширч, амтархан уншиж ирсэн дурсгал юм. Академич Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен нарын тэмдэглэсэнчлэн энэхүү дурсгал монголын ард түмний оюун санааг эзэмдэж, урлаг утга зохиолд ул мөрөө үлдээсэн билээ.

“Үлгэрийн далай” бол зөвхөн монголчуудын дунд төдийгүй буддын шашин соёлт Ази тивийн олон оронд түгэн дэлгэрчээ. Ийнхүү дэлхий дахины утга зохиолын баялаг сан хөмрөгт хүндтэй байрыг эзлэх болсон эл зохиолд буддын шашны гол сургаал болох үйлийн үрийн тухай номлолыг үлгэр домог, адилтгал зүйрлэлийн хэлбэрээр тайлбарлаж, хүн төрөлхтний сайн сайхан, аз жаргалтай, энх тунх амьдрахын мөнхийн хүсэл эрмэлзлэлийг бахдан дуулсан, аливаа сайн бүхний саад тотгор болсон мунхаг сэтгэл, шунал тачаал, уур

77 МУИС-ийн ШУС, профессор, доктор

хилэнг огоорон тэвчихийг уриалан дуудсан байна. Амьдралын утга учирьг танин мэдүүлсэн, сурган хүмүүжүүлэх гүн утга агуулгатай энэхүү зохиолыг төвд хэлнээс монгол хэлнээ Хөх хотын Ширээт гүүш 17 дугаар зуунд орчуулсан нь гар бичмэлээр өргөн тархсанаас гадна хэд хэдэн удаа хэвлэгдэж олон түмний хүртээл болжээ. “Үлгэрийн далай” судрын хамгийн эртний бар болох 1714 оны хэвлэлийг С.Фрай англи хэлнээ орчуулжээ. 1981 онд хэвлэгдэн гарсан энэхүү орчуулгын талаар зарим ажиглалт хийснээ та бүхэнд толилуулж, санал бодлоо хуваалцахыг зорилоо.

“Үлгэрийн далай”-г барууны эрдэмтэд эртнээс судалж орчуулж иржээ. Тухайлбал тус судрыг Орос Дани улсын эрдэмтэн Я.Шмидт герман хэлнээ, Ю.М.Парфионович орос хэлнээ, Ч.Дас, Х.А.Ешке нар толь бичиг зохиохдоо ашиглаж байсан бол Ж.Крюгер 1967 онд англи хэлнээ хэсэгчилж орчуулжээ. Харин англи бүрэн орчуулгыг эрдэмтэн С.Фрай хийжээ. Орчуулагч С.Фрай энэхүү орчуулгын эх болох 1714 оны бар хэвлэлийг МУИС-ийн проф. Ш.Лувсанвандангаас хүлээн авч ашигласан тухайгаа орчуулгынхаа оршилд тэмдэглэжээ. Орчуулагч оршил өгүүлэлдээ монголын буддын шашны нэр томъёоны сайн толь бичиг байхгүй байснаас саад бэрхшээл тулгарч байсныг дурдаад орчуулахдаа баримталсан арга зарчимынхаа талаар дурдсан байна. Тэр бээр олонхи оноосон нэрийг санскритаар хөрвүүлэхийг чармайжээ. Ийнхүү санскрит хэлээр хөрвүүлэх аргыг бүр 14 дүгээр зуунаас монгол гүүш нар бүтээлчээр хэрэглэж ирсэн билээ. Монголын буддын уран зохиол энэтхэгээс гаралтай учир энэтхэгийн бичгийн хэл болох санскрит хэлнээс монгол хэлнээ нэвтэрсэн буддын шашны нэр томъёог ийнхүү зээлдэн авч орчуулах нь оновчтой зөв арга болохыг бусад хэлний хөрвүүлэг тухайлбал орос орчуулгаас ч харж болох байна.

Оноосон нэрийг орчуулсан нь

“Үлгэрийн далай” судрыг төвд хэлнээс орчуулсан Ширээт гүүш оноосон нэрийг орчуулах, санскрит нэрээр нь сэргээн буулгах, галиглах аргыг хэрэглэсэн байх бөгөөд түүний энэ аргыг ч С.Фрай судалжээ. Учир нь хэл дамнасан орчуулга хийхэд зайлшгүй орчуулгын эхийг ямар нэг хэмжээгээр судалж үзэх, орчуулгын уламжлалыг судлах шаардлага тулгардаг. Үүнийг дараах жишээн дээр авч үзье.

Нэг. Санскритаар сэргээн орчуулсан нь

1. “Үлгэрийн далай” төдийгүй буддын утга зохиолд олонтаа тааралддаг оноосон нэр бол Итгэл Үгүй Идээн Өглөгт болно. Домогт өгүүлснээр тэр бээр бурхан Будда-г ивээн тэтгэж байснаараа алдаршсан баян гэрийн эзэн юм. Түүний жинхэнэ нэр нь Судатта боловч итгэл авралгүй болсон үгээгүү ядууст идээ зоог өргөн барьж байснаараа алдаршжээ. **Mgon med zas sbyin** хэмээх төвд нэрийг Итгэл Үгүй Идээн Өглөгт⁷⁸ хэмээн Ширээт гүүш үгчлэн орчуулж тус гэрийн эзний өгөөмөр зан төрхийг монгол уншигчдад хүргэжээ. Энэхүү нэрийг С.Фрай орчуулалгүй Анаатхапиндика (Anathar-indika) хэмээх санскрит нэрээр буулгажээ. Ингэж санскритаар буулгах нь буддын

78 Тус нэрийг С.Дас “Төвд англи толь”-доо “n. of a certain house holder who accomodated Buddha in the Jetavana grove of Sravasti. He was the chief house holder devotee of Buddha” хэмээн тайлбарлажээ.

утга зохиолыг англи хэлээр уншигчдад илүү ойлгомжтой хэмээн үзсэн бололтой. Нөгөөтэйгүүр төвд-монгол орчуулгын түүхээс үзвэл энэтхэг гаралтай оноосон нэрийг санскритаар сэргээн буулгаж байсан уламжлал ч бий. Тухайлбал 14 зууны Сономгарагийн орчуулгад Олноо өргөгдсөн хэмээх хааны нэрийг Махасбади, Хүрдэн эргүүлэгч хэмээх нэрийг Чагирварда хэмээн буулгаж байсныг бид мэднэ. “Үлгэрийн далай”-н өөр нэгэн хөрвүүлэг болох Тойн гүүшийн орчуулгад ч дээрхи оноосон нэрийг Anandabindaki⁷⁹ гэж буулгасан байдгийг дурдаж болно.

2. Бурхан Будда-гийн заларч ном сургаалаа айлдаж дияан бясалгал хийж байсан газар бол Ялгуугч хан хөвгүүний цэцэглэг (тө. Rgyal bu rgyal byed kyi tshal) болно. С.Фрай энэхүү оноосон нэрийг Jetavana monastery, Jetavana grove гэж хоёр янзаар буулгажээ⁸⁰. Jetavana бол ялгуугч хан хөвгүүний цэцэглэг хэмээх үгийн хөрвүүлэг болно. Ялгуугч хан хөвгүүн бол энэтхэгийн Прасенажит хэмээх хааны хүү байсан бөгөөд уг нэрийн санскрит хөрвүүлэг нь Jeta болно. Домогт өгүүлсэнээр тэр бээр өргөн уудам ой шугуй бүхий газар нутгийг Итгэл Үгүй Идээн Өглөгт нэрт гэрийн эзэнд худалдсан ажээ. Тойн гүүш бээр Īd kōbegün ü seḥeglig⁸¹ гэж санскрит нэрээр буулгасан буй. Ийнхүү санскритаар сэргээн буулгасан жишээ цөөнгүй байх бөгөөд тэдгээрээс заримыг авч үзье.

Монгол бичлэг	Англи орчуулга	Монгол бичлэг	Англи орчуулга
Хүлцэгч (арш)	Ksāntivādin	Хормуст (тэнгэр)	Indra
Гэгээнээ Ялгуугч (хаан)	Prasenajit	Эсэр (тэнгэр)	Brahma
Тэмцэгч (хаан)	Kalinga	Гөрөөс (түшмэл)	Mrgara

Оноосон нэрийн монгол орчуулгын уламжлалд үгчлэн орчуулах бас санскритаар хөрвүүлэх уламжлал аль аль нь байжээ. С.Фрай санскритаар хөрвүүлэх аргыг сонгосон бөгөөд энэ нь “Мэргэд гарахын орон” толь бичигт дэвшүүлсэн орчуулгын зарчимтай ч таарч байна⁸².

Хоёр. Галиглан буулгасан нь

Ширээт гүүш болон Тойн гүүшийн монгол орчуулгад олон арван санскрит оноосон

⁷⁹ Le Damatikonamasutra texte Mongol du Toyin guisi par Ce.Šagdarsüren, Budapest, 1989, 23.

⁸⁰ Ийн хэмээн миний сонссон нэгэн цагт Ялж Төгс Нөгчсөн бурхан Ялгуугч хан хөвгүүний цэцэглэг Итгэл Үгүй Идээн Өглөгтийн хотол баясгалангийн хүрээнд суун авай гэж Ширээт гүүшийн орчуулсаныг англи хэлнээ Thus have I heard at one time: The Enlightened One was residing in the city of Sravasti at the Jetavana monastery in Anathapindika's park гэж буулгажээ. Монгол эхэд Шравастид хот дахь Ялгуугч хан хөвгүүний цэцэрлэг дэх Итгэл Үгүй Идээн Өглөгт гэрийн эзний хийдэд Бурхан заларсан гэж буй. Хотол баясгалангийн хүрээ (төвдөөр kun dga'ra ba) бол “цэцэрлэг”-ээс гадна “сүм хийд” гэсэн утгатай. Бурхан багш Ялгуугч хан хөвгүүний цэцэрлэгт биш харин хийдэд заларсан гэж С.Фрай буулгажээ.

⁸¹ Le Damatikonamasutra texte Mongol du Toyin guisi par Ce.Šagdarsüren, Budapest, 1989, 23.

⁸² Оноосон нэрийг орчуулах тухайд “Мэргэд гарахын орон” толь бичигт өгүүлсэн нь “бас бандид шидтэн ба хаан түшмэл тэргүүтэн бодгалисын нэр хийгээд орон цэцэг жимс мод тэргүүтний нэрийг орчуулаас мэдэхүйеэ бэрх бөгөөд өгүүлэхүйеэ амар үгүй болох тул нэрийн эх сүүл аль зохистод бандид ба хаан хийгээд цэцэг хэмээх тэргүүтэн алинаа өгүүлэх нэгэн нэрийг нэмж мөнхүү энэтхэг буюу төвд нэрээр талбигдахуй” гэж бичжээ. Ширээт гүүшийн орчуулга нэг талаар уг толийг зохиохоос өмнө гарсан, нөгөөтэйгүүр оноосон нэрийг үгчлэн орчуулах төвд уламжлалыг баримталсан байна.

нэр тааралдана. Тэдгээр нэрийн бичлэг жинхэнэ санскрит бичлэгээсээ ямар нэгэн байдлаар хазайсан байгаа нь төвдөөс дамаа буулгасан, хуулан бичигч, бар сийлэгчийн ялгаатай тэмдэглэсэнтэй холбоотой байж болох ч төвд, монгол дуудлагын нөлөөгөөр тийнхүү өөрчлөгджээ. Тухайлбал “Үлгэрийн далай”-н монгол орчуулгуудад Варанаса гэдэг оноосон нэрийг монголоор Varanasa, Varanasi, Varanase (төвдөөр Baranasi) гэх мэт зөрөөтэй тэмдэглэсэн байх жишээтэй. Тиймээс газар орон болон хүний нэрийг С.Фрай санскрит жинхэнэ дуудлага, бичлэг рүү ойртуулж буулгахыг зорьсон болохыг дараах жишээнээс харж болно.

Монгол бичлэг	Англи хөрвүүлэг	Монгол бичлэг	Англи хөрвүүлэг
Варанаси (орон)	Benares	Сүмбэр (уул)	Meru
Удияана (орон)	Udrayana	Очир (охин)	Vajra
Замбутив (тив)	Jambudvipa	Удвал (шамнанц)	Udpala
Ананд (бурханы шавь)	Ānanda	Дэвадад (бурханд тэрслэгч)	Devadatta
Майдар (бурхан)	Maitreya	Гашиб (бурхан)	Kāsyapa
Судодана (бурханы эцгийн алдар)	Śuddhodana	Махамаяа (бурханы эхийн алдар)	Mahāmāya

Зарим оноосон нэрийг буулгахдаа төвд галигаас дамаа буулгажээ. Тухайлбал Жилингарли, Жүндэ хэмээх оноосон нэрийг Byin-ling-kar-li, Kyunte гэж төвд бичлэгийг үсгийн галигаар сийрүүлсэн ч тааралдана.

Гурав. Орчуулсан нь

“Үлгэрийн далай” судар дахь оноосон нэрийн дотор зохиолын баатрын дүр, газар орны онцлог шинжийг заан тодотгосон нэр цөөнгүй бий. Тэдгээр нэрийг хэрхэн орчуулсаныг дараах хүснэгтээс харъя.

Монгол нэр	Англи орчуулга	Монгол нэр	Англи орчуулга
Ялж Төгс Нөгчсөн бурхан	Victorious Perfectly Departed Enlightened One, The Enlightened One	Их Өглөгт (хөвгүүн)	Virtuous
Сайн Эрэгч (хөвгүүн)	Good Searcher	Алтан Эрдэнэт (хөвгүүн)	Golden Gem
Муу Эрэгч (хөвгүүн)	Evil Searcher	Тэнгэрийн Цэцэг (хөвгүүн)	Flower of the Gods
Их Өглөгт (хөвгүүн)	Great Charity	Гөрөөсөнд Аюул үгүй өгтсөн орон	Deer Park

Ийнхүү орчуулах нь зохиолд гарч буй дүрүүдийн зан төрхийг тодруулж буй давуу талтай. Зохиолын дүрийн шинж чанар, сэтгэл хөдлөлийн өнгө аясыг харуулах талаар

ямар эрэл хайгуул хийснийг Муу Эрэгч хэмээх нэрийн орчуулгаас харж болно. Орчуулагч зохиолын баатрын хорон муу санааг тод томруун дүрслэн гаргах зорилгоор Мууг Эрэгч хөвгүүний нэрийг Гай Зовлонг Эрэгч (Evil Searcher) хэмээн орчуулжээ. Зарим оноосон нэрийг ерөнхийлөн орчуулах аргаар буулгасан тал ч бий. Тухайлбал, Гөрөөсөнд Аюул үгүй Өгтсөн Орон хэмээх газар бол орчин цагийн Энэтхэг орны Варанаса хот дахь Сарнатх хэмээх газрын нэр бөгөөд тус газар Бурхан багш Дөрвөн Үнэний сургаалаа айлджээ. Домог ёсоор тус орны эзэн олон гөрөөс агнажээ. Түүнийг үзсэн гөрөөсний хаан ихэд гашуудан зовж, гэмгүй олон гөрөөс хөнөөх үйлээ нэгмөсөн зогсоовол хариуд нь өдөр бүр нэг гөрөөс өгөхийг амлажээ. Нэгэн удаа хээлтэй гөрөөсний ээлж таарахад мөнөөх гөрөөсний хаан түүнийг энэрч нигүүлсэн, оронд нь өөрийн биеэ өргөх болжээ. Түүний энэ энэрэнгүй үйлийг тус орны харгис эзэн үзэж уяран зөөлөрч гөрөөс агнахаа бүрмөсөн зогсоосон учир тэр оронд буга гөрөөс айх аюулгүй нутаглах болсон гэсэн домгоос үүдэж Гөрөөсөнд Аюул үгүй Өгтсөн Орон хэмээн Ширээт гүүшийн орчуулсаныг С.Фрай Deer Park гэж хөрвүүлжээ. Энэ нь уг оноосон нэрийн утгыг ерөнхийлөн орчуулсан хэрэг юм.

Хуучирсан үгийг орчуулсан нь

“Үлгэрийн далай” судрын үгийн санд өнөөгийн уншигчид тэр бүр ухааж мэдэхгүй, хуучирсан үг хэллэг цөөнгүй бий. Тиймээс ийм үг хэллэгийг хэрхэн орчуулсаныг цөөн жишээн дээр авч харьцуулсанаа толилуулъя.

1. Сүмбэр уулыг гич лүгээ яахин адилтгаж болму.

How can a pile of sand compare with Mt. Meru?⁸³

Энэ өгүүлбэр дэх “гич” хэмээх үгийг хэрхэн орчуулсаныг авч үзье.

Гич (тө: yungs kar) бол “иш нь өндөр, навч нь ногоон, цэцэг нь хурц шар, шар будаа мэт тослог үртэй, амт аагим ургамал, юнгар ч гэж нэрлэх” энэ үгийг “элсэн овоо” (a pile of sand)-гоор сольж орчуулжээ. Ингэснээр монгол орчуулга дахь Бурхан багшийг эгэл жирийн хүнтэй харьцуулсан дүрслэлийн хүчийг сулруулсан байна. “Гич” бол шар будаа шиг өчүүхэн жижиг үр бөгөөд эгэл ардыг Ширээт гүүш өчүүхэн будаатай, Бурханыг Сүмбэр уултай жишин харьцуулж ямар их харьцуулашгүй ялгаа зөрөөтэй болохыг дүрслэн харуулахыг зорьжээ⁸⁴. Харин англи хэлнээ өчүүхэн будааг “элсэн овоо”-гоор сольсноор харьцуулан жишиж буй хоёр зүйлийн онцлог ялгаа, дүр дүрслэлийн хүч харьцангуй сул болжээ.

2. Их далайг үхрийн харины усан (qarin-u usun) лугаа яахин адилтгамуй?

How can a cow-hoof puddle compare with the great ocean?⁸⁵

“Харины усан” гэсэн үгийг хэрхэн орчуулсаныг авч үзье.

83 Sutra of the wise and the foolish (mdo bdzans blun) or the ocean of narratives (üliger-ün dalai), translated from the Mongolian by Stanley Frye, Library of Tibetan works and archives, Daramsala, India, New Delhi, 1981. pp.234.

84 Тө: ri rab lhun po yungs dkar dang bsgrun pa'am

85 Sutra of the wise and the foolish (mdo bdzans blun) or the ocean of narratives (üliger-ün dalai), translated from the Mongolian by Stanley Frye, Library of Tibetan works and archives, Daramsala, India, New Delhi, 1981. pp.234.

Сумадираднаа “Төвд монгол толь”-доо *ba rmig* гэдэг үгийг “Үхрийн гарин, үхрийн туурай” гэжээ. Тэгэхээр “гарин” гэдэг үгийг туурай гэж ойлгож болох байна. Гэтэл Субашидийн Сономгарагийн орчуулгад “үхрийн туурайн гариныг усаар дүүргэх хялбар” (71 дүгээр бадаг)⁸⁶ гэсэн мөр буй. Тэгэхээр Сономгара туурай биш харин туурайн гишгэсэн мөр гэж буулгажээ. Үхрийн харины(гарины)ус гэдэг хуучин үг хэллэгийг “үхрийн туурайн тогтонги ус” буюу “үхрийн гишгэсэн мөрт тогтох ус” гэж С.Фрай зөв буулгасан байна. “Харины ус” хэмээх хэллэгийг орчуулахдаа С.Фрай “үхрийн туурайн ус” хэмээх төвд хэллэгийг (тө: *ba rmig gi chu*) дам буулгажээ.

3. Тэр цагт тэр балгасанд нэгэн хуурч эм нэгэн зардсандаа жалам өгч Убагубдагаас цэцэг худалдахаар илгээв.

At that time there lived in that city a certain courtesan. One day she gave money to one of her servant girls and sent her to Upagupta to buy flowers...”⁸⁷

Энэ өгүүлбэр дэх “жалам” хэмээх үгийг хэрхэн орчуулсаныг ажиглая.

“Хорин наймтын тайлбар толь”-д “жалам- овоо, мод, хэнгэрэг зэрэг шүтээний зүйлд уясан бүч залаа, бөс зангиа тэргүүтэн” гэж тайлбарласан байх бөгөөд энэ үгийг С.Фрай “мөнгө” гэж буулгасан байна⁸⁸. Энэ нь ямар нэгэн шүтээн тахилын зүйлийг илгээж цэцэг авсан гэсэн монгол эхийн санааг европ хүний хүний сэтгэлгээгээр мөнгө өгч авсан гэж хөрвүүлсэн нь ямар нэг зүйлийг хүнээс зүгээр авч болохгүй, заавал үнэ хөлсийг нь өгч байж авах учиртай гэсэн европ хүний сэтгэлгээгээс үүдсэн бололтой. Нөгөөтэйгүүр төвд сударт энэхүү “жалам” хэмээх үгтэй дүйх хэллэг байхгүй, толь бичгээс тус үгийн тайлбарыг олж харах боломжгүй байсан тул тийнхүү ургуулан бодож хөрвүүлжээ.

4. Нөгчсөн ба ирээдүй ба эдүгээгийн гурван цагийг гарын алган дахь имиди мэт тодорхойяа мэдмү.

...he clearly knows the three times: the past, the present, and the future, like a *myrobalan fruit* in the palm of his hand”⁸⁹.

Имиди гэдэг түрэг уйгар гаралтай үг. Төвдөөр “жүрүр” хэмээсэн байх бөгөөд эл үгийг *a myrobalan fruit* буюу “арүрийн үр” хэмээн орчуулжээ. Арүр бол “дотроо ястай, ясны дотор тослог идээтэй, амт эхүүн, хэлбэр гонзгойвтор бөөрөнхий, хоёр үзүүр нь шовгор, чийгэрхэг, дулан оронд ургадаг нэгэн зүйл модны үр”. Жүрүр бол эмнэлэгт хэрэглэдэг нэгэн зүйл долоогоны үр юм. Арүр, барүр, жүрүр гурвыг гурван үр (тө: ‘*bras bu gsum*) гэх бөгөөд орчуулагч С.Фрай чухам *a myrobalan fruit* (арүр)

⁸⁶ Цахар гэвш энэ мөрийг “үхрийн гишгэсэн мөрийг усаар дүүргэх хялбар” гэж орчуулжээ.

⁸⁷ *Sutra of the wise and the foolish (mdo bdzans blun) or the ocean of narratives (üliger-ün dalai)*, translated from the Mongolian by Stanley Frye, Library of Tibetan works and archives, Daramsala, India, New Delhi, 1981. pp.232.

⁸⁸ Харин “Үлгэрийн далай” судрын төвд эх болох “Занлүндө” сударт “тэр цагт тэр хотод нэгэн хуурч эм шивэгчнээ Убагубда-гаас цэцэг худалдан авхуулахаар зарав” гэж байх бөгөөд ямар нэгэн зүйл өгсөн гэсэн санаа байхгүй.

⁸⁹ *Sutra of the wise and the foolish (mdo bdzans blun) or the ocean of narratives (üliger-ün dalai)*, translated from the Mongolian by Stanley Frye, Library of Tibetan works and archives, Daramsala, India, New Delhi, 1981. pp.229.

гэж орчуулахдаа ‘bras буюу “үр” хэмээх төвд үгийг эх болгож, гурван үрийн дотроос эмийн хаан гэгдэх “арүр”-ийг сонгожээ. Энэ нь орчуулгын хувиргалын талаас авч үзвэл ерөнхий ойлголтыг нарийвчилж орчуулсан хэрэг мөн боловч утгаа европ хүний сэтгэлгээ тодруулбал англи хэлээр илэрхийлэх онцлогтой ч холбоотой байж болох юм.

5. Хаан нь үлэмж баясан бишрээд тэндээс нэгэн хүнийг зуун мянган дуун сонсдох газарт хүрэгч тийм нэгэн заанд унуулж Замбуутивийн хамаг улсад ийн хэмээн тунхаг тархаав.

The emperor .. sent a courier with a mighty voice to all the continent of Jambudvipa.

“Дуун сонсдох газар” хэмээх үг бол “rgyang grags” хэмээх төвд үгийн орчуулга бөгөөд санскритаар krośa, монгол бичгээр “хөрс” (kōrüsü) хэмээн бичнэ. Энэ үг хол ойрын хэмжээ заасан үг бөгөөд нэг газар (360 алд буюу 576м)-ыг найм хуваасны нэгтэй тэнцэнэ⁹⁰. Тойн гүүш энэхүү төвд үгийг “зуун мянган нумын туршийн чинээт газар” гэж утгачилж орчуулжээ. Харин С.Фрай “Маш том дуутай элчийг илгээсэн” гэж ташаа хөрвүүлсэн байна.

Ийнхүү ганц нэг үгийг эндүү ташаа буулгасан, зарим газар орчуулгыг хураангуйлж товчилсон зэрэг нь орчуулагч С.Фрай-н орчуулгын үнэ цэнийг бууруулахгүй. Монголын ард түмний шүтээн төдийгүй нийт ард түмний хүртээмж болж, урлаг утга зохиолд ул мөрөө үлдээсэн “Үлгэрийн далай” хэмээх 300 жилийн өмнө хэвлэгдэн гарсан эртний уран зохиолын энэхүү гайхамшигт дурсгалын агуулгыг дэлхий дахины уншигчдад хүргэж, монголын шашин соёлыг таниулан мэдүүлсэн С.Фрай-н ач тусыг онцлон тэмдэглэвэл зохино.

Резюме

Сутра “Үлгэрийн далай” (Сутра о мудрости и глупости) включённая в 90-ый том монгольского Ганжура является переводом Ширэгэту гуши из Хухэ-хото. Данный перевод, изданный в 1714 году был переведён на английский язык и был опубликован в 1981 году С.Фраем. Перевод Ширэгэту гуши, написанный старописьменным монгольским языком в 17 веке был переведён с тибетского языка на монгольский, который в свою очередь тоже был переведён с китайского и санскритского языков. В тексте монгольского перевода преобладают санскритские заимствования, буддийские термины, которые были успешно переведены С.Фраем на английский язык. В данной статье нами рассмотрены переводы собственных имен, а также некоторые архаизмы встречающиеся в монгольском тексте. В результате лексикологического анализа английского перевода мы пришли к выводу, что содержание английского текста полностью соответствует содержанию монгольской сутры, за исключением единичных недоразумений, и некоторых сокращений, которые не могут умалить значение данного перевода.

90 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2013.

“Улсыг засах жараахай шарах хоёр адилхан”

Харин амархан уу? Хэцүү юу?

(Орчуулахуйн нэгэн зарчмын үүднээс шинжсэхүй)

М.Чимэдцэеэ⁹¹ (МУИС)

Товч агуулга: Өдгөө дэлхий дахинаа бараг нэг мөр баримталдаг орчуулгын онолын тулгын гурван чулуу гэлтэй үндсэн чиг баримжаа болох “яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар” хэмээх үндсэн гурван жаяг зарчим, чиг баримжааг Монголын эрдэмтэн гүүш нар “Мэргэд гарахын орон” нэртэй төвд монгол нэр томъёоны толь бичгийг 1740-өөд онд зохиохдоо анх томъёолж, “үг дор үл итгэн, утга дор итгэхийн үүднээс сайтар мэдэн үйлдэх”-ийг сануулан дурдсан байдаг.

Энэ гурван чиг баримжаа болбоос өнөөдөр орчуулагч хүний сэтгэлдээ хатангадтал сахин мөрдөх үндсэн жаяг зарчим юм. Түүний дотор “утга төгс” хэмээх нь алив зохиолыг өөрийн хэлнээ орчуулахдаа уг эх зохиолд чин үнэнч байх, утга санааг нь өөрчилж засах буюу олтгойлж гажуудуулахыг эрс цээрлэх, гүн далд утгыг нь төгс нээж илэрхийлэх зарчим юм.

Түлхүүр үг: “Мэргэд гарахын орон”, “яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар”, Лаоз, Күнз, улсыг засахуй, биеэ засахуй

Аугаа их эрдэмтэн, билгүүн номч Бямбын Ринчен “Бид түмэн түмэн улсын нэрт эрдэмтэн мэргэдийн гайхамшиг шинжлэлийн ойллого, дөрвөн зүгийн эрт өдгөөгийн бичгийн утгач нарын зохиосон сэтгэлийг булаах мэт яруу сайхан найруулалт бичгийг бахдан үзэцгээж, эрдмээр хүмүүжин, соёлоор цэнгэлдэхүйд их төлөв орчуулан хөрвүүлснийг үзнэм бус уу” хэмээн яруу сайхан өгүүлсэн байдаг. Тэрхүү “эрдмээр хүмүүжин, соёлоор цэнгэлдэх” их үйл хэрэгт “дээгүүрхэн суудалтай, дээж амсах” хувьтай хүний нэг бол орчуулагч, хятад судлаач, зорилго нэгт журмын нөхөр Доржсүрэнгийн Болдбаатар мөнөөсөө мөн. Хятад хэл бичигт суралцсан нь олон боловч, чухам орчуулах дуун хөрвүүлэх “тамын ажилд” сэтгэлээ чилээн, чөмөгөө царцаан зүтгэж яваа хуруу дарам цөөхөн хүний нэг нь тэр билээ. Хятад хүний төр улсын үзлийг таньж болох толь хэмээн үздэг их түүхэн туульс “Гурван улсын үлгэр” томоохон хүүрнэл зохиолыг ойрмогхон монголчлон хэвлүүлж, түүний өмнө Хятадын зохиолч Зян Руны “Чоно тотем” буюу монголоор “Чонон сүлд” нэртэй хэвлэгдсэн ном хийгээд өөр бусад хэд хэдэн номыг монгол хэлнээ орчуулсан билээ. [Даширамд өгүүлэхэд “Чонон сүлд” номын нэр нь “сүлд үү? “шүтээн үү?” гэдэг тухайд бичгийн мэргэд санал зөрөлдөж буй. Монголын өдгөө цагийн их бичгийн мэргэн хүмүүн, эрдэмтэн гүүш, Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн Го. Аким “Зян Руны номны нэр бол угтаа “Чоно шүтээн”

91 МУИС-ийн Күнзийн Институт, профессор, доктор

юм шүү дээ. Манайхан “Чонон сүлд” гээд буруу орчуулчихсан. Сүлд гэдэг чинь бэлгэдэл. Тотем гэдэг чинь шүтээн, шүтээж явдаг зүйлийг нь хэлж байгаа юм”, (Го.Аким “Зян Рун монгол хэл мэдэхгүй юм чинь яаж миний номыг хуулдаг юм”) өчүүхэн биднийг орчуулах хөрвүүлэхүйн замд залж хөтөлсөн ачит багш, эрдэмтэн зохиолч, орчуулагч, Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн Ц.Базаррагчаа “Сүүлхэн үед Хятад улсаар барахгүй бөмбөрцөгийн олон орноо орчуулагдан машид цууд гарч буй манайд “Чонон сүлд” нэрээр хэвлэгдсэн, хятадаараа “Чоно тотем” номыг уул нь сүлд гэснээс шүтээн, шүтлэг гэсэн нь илүү онох байсан болов уу” (Ц.Базаррагчаа “Хөх монголын хөх чоно”) гэхчлэн дурдсан байдаг.]

Энэ тухай үл өгүүлэн өгүүлэхэд эрдэмт нөхөр маань ойрмогхон “Үндэсний шуудан” сонинд хоёр ч удаа ярилцлага өгч, эртний хятадын их сэтгэгч Лаозын “Их улсыг засахуй нь өчүүхэн жаргахуйг чанах хуурах лугаа адил” хэмээх нэгэн номлол хийгээд бас өөр нэгэн сэтгэгч Күнзийн хэд хэдэн сургаал үгсийг эш татан тайлж өгүүлжээ.

Өдгөө дэлхий дахинаа бараг нэг мөр баримталдаг орчуулгын онолын тулгын гурван чулуу гэлтэй үндсэн чиг баримжаа болох “яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар” хэмээх үндсэн гурван жаяг зарчим, чиг баримжааг Монголын эрдэмтэн гүүш нар “Мэргэд гарахын орон” нэртэй төвд монгол нэр томъёоны толь бичгийг 1740-өөд онд зохиохдоо анх томъёолж, “үг дор үл итгэн, утга дор итгэхийн үүднээс сайтар мэдэн үйлдэх”-ийг сануулан дурдсан байдаг.

Энэ гурван чиг баримжаа болбоос өнөөдөр орчуулагч хүний сэтгэлдээ хатангадтал сахин мөрдөх үндсэн жаяг зарчим юм. Түүний дотор “утга төгс” хэмээх нь алив зохиолыг өөрийн хэлнээ орчуулахдаа уг эх зохиолд чин үнэнч байх, утга санааг нь өөрчилж засах буюу оmtгойлж гажуудуулахыг эрс цээрлэх, гүн далд утгыг нь төгс нээж илэрхийлэх зарчим юм. Чухам тиймийн учир Монголын шинэ үеийн орчуулгын онолын тулгыг тулалцсан аугаа их эрдэмтэн Цэндийн Дамдинсүрэн “Миний санахад үгийг нэмж хасах гайгүй хэрэг. Утгыг нэмж хасвал гэмтэй хэрэг. Үг ба өгүүлбэрт халдаж болно. Гол утгад халдаж болохгүй” (Цэндийн Дамдинсүрэн. Бүрэн зохиол III 286-р тал) хэмээн дурдсан нь хойчийг залгамжлах орчуулагч дуун хөрвүүлэгчдэд захиж хэлсэн хатуу сануулга гэлтэй. Орчуулгын онолын тухайт олон жаяг зарчим, арга маяг байх боловч тэрхүү “эх зохиолын утга санаанд үнэнч байх” явдал бол орчуулга оролддог, бүтээдэг хэн хүний эн тэргүүний эрхэм зорилго, алтан дүрэм нь байх ёстой юм.

Эртний хятадын сэтгэгч Лаозын дээр өгүүлсэн эш номлолыг чухам энэ үүднээс нягтлан үзэж, илт өгүүлэхүй-далд утгыг нь илэрхийлэн гаргах учиртай билээ. Аль ч үндэстэн угсаатны их сэтгэгчдийн хэлсэн үг сургаал, эш номлол нь ил шууд илэрхийлсэн нь бараг үгүй, илт өгүүлэх давхар утга, далд гүн санаа нэвт шингэсэн байх тул өнгөн талыг барин мөчид тайлбаас эндүүрлийн мананд төөрөлдөх гэмтэй. Өрнөдахин дэлхий ертөнцийг шулуун, зэрэгцээ шугамаар таньж мэдэрдэг, харж сэтгэдэг бол, хятад хүн эсрэгээр нь муруй

тойрог шугамаар харж, сэрж сэтгэдэг. Тиймийн учир Күнз, Лаоз, Мэнз, Жуанз гэхчлэн эртний хятадын сэтгэгчдийн сургаал номлолыг шууд тайлж өгүүлэхэд туйлын бэрхтэй байдаг нь чухамдаа тэрхүү хятадын уламжлалт “дотогшоо хандсан” далд сэтгэлгээтэй нь холбоотой юм.

“Их улсыг засахуй нь өчүүхэн жараахайг чанах хуурах лугаа адил” хэмээсэн тэрхүү үг нь 2500 орчим жилийн тэртээгээс уламжилж ирсэн Лаозын алдарт “Лаоз” буюу “Даодэжин” хэмээн бас нэрлэдэг тэрхүү номын жардугаар бөлөгт байх агаад харин амархан уу? хэцүү юү? гэдгийн тухайд Лаоз шууд ил хэлсэн зүйл үгүй.

Түүнээс хойш 200-гаад жилийн дараа буюу өдгөөгөөс 2300 орчим жилийн тэртээ хятадын өөр нэгэн гүн ухаантан, сэтгэгч Хань Фэйз дээрх номлолыг анх түрүү тайлж, “*Жам ёсны үүднээс үзэхүл, олон иргэнийг дайчлахуйд үйл ажлыг нь олонтаа хувиргаваас үр шим нь бага болох, өвлөж хадгалсан үнэтэй эд юмыг олонтаа зөөж хөдөлгөвөөс эвдэрч сүйдэх нь их болох, өчүүхэн жараахай хуурах чанахад олонтаа хутгаж хөндвөөс өнгө юугаан алдаж шалзрах, их улсыг засахуйд бошог зарлигийг олонтаа өөрчилбөөс олон иргэн зовлон гамшигт унах, тиймийн учир улсыг засахуйд мэргэн хүмүүн болбоос тайван тогтууныг эрхэмлэх агаад буулгасан зарлиг цаазыг босон суун эс өөрчлөх бөлгөө. Тиймээс Лаоз “Их улсыг засах өчүүхэн жараахай чанах хуурах хоёр адилхан” хэмээн сургажээ.*” (Хань Фэйз: *Лаозыг тайлсан бөлөг*) гэхчлэн өгүүлсэн байдаг.

Энэ бол Лаозын дээрх номлолын тайлал нь юм. Түүнээс хойш уг номлолыг тайлж өгүүлсэн зүйл олон гарсан ч дээр өгүүлснээс зөрж гажсан зүйл үгүй ажээ.

Ер нь Күнз, Лаоз хийгээд тэднийг залгамжлагч эртний сэтгэгчдийн үг сургаалын дотор хятадын эрдэмтэд, мэргэд одоо болтол нэг мөр тайлж чадаагүй, өөр өөрөөр тайлбарласан тийм номлол сургаал цөөнгүй буй. Харин дээр өгүүлсэн сургаалын тухайд санал зөрөлдсөн зүйлгүй, “Их улсыг засахуй хийгээд өчүүхэн жараахай чанах болгох аль алин нь амархан бус, бэрх хэцүү, эвдэрч сүйдэх нь хялбархан, тиймийн учир няхуур нямбай ур ухаан, хичээл болгоомж чухал” гэсэн утгатай хэмээн нэгэн мөр нэгдсэн тайлалд хүрч чадсан байдаг. Тийм болохоор эрхэм нөхрийн “Улсыг засах жараахай шарахаас амархан” “... ядах юмгүй амархан ажил”, (“Үндэсний шуудан” сонин 2013 он №248 “Улсыг засах жараахай шарахаас амархан”) “...эвийг нь олох юм бол улсын засна гэдэг угтаа амархан юм гэдгийг дээрх Лаозыгийн үг хэлээд байгаа хэрэг...” “Улсын засах мэргэн аргыг олоход жараахай шарахаас илүү хэцүүгүй” байх нь тодорхой” (“Үндэсний шуудан” сонин 2014 он №023 “Гурван улсын үлгэрийг жилдээ ядаж нэг уншдаг”) гэхчлэн тайлж тайлбарлаад байгаа нь уг үндсээрээ буруу болж таарч байна.

Элдэв ном бичиг үзэж байхад “Улсыг засах амархан” гэж хэлсэн нь бараг тааралддаггүй. Харин төр улсыг төвхнүүлэх нь амархан хялбархан зүйл хэмээн мөчид сэтгэж, улс гэрээ мөхөөсөн түүх өдий төдий байдаг. Нэгэн бяцхан инээдэмтэй атлаа эмгэнэлтэй түүх өгүүлье.

Хятадын Хавар Намар Байлдаант улсын (НОТӨ 770-476) үед олон ханлиг улс эрх мэдлийн төлөө арцалдан тэмцэлдэж байжээ. Чи хэмээх улс ихээхэн хүчирхэгжиж, Жинь, Лу, Вэй, Цао зэрэг бусад зэргэлдээ улсыг эрхшээн дагуулж, тэдгээр улс жил бүр ихээхэн өргөл барьц өргөн барьдаг байжээ. Нэгэн жил дээрх дөрвөн ханлиг улс нэгэн зэрэг дөрвөн элч томилон, Чи улс руу илгээж гэнэ. Гайхалтай нь дээрх дөрвөн улсын элч бүгд зэрэмдэг хүмүүс байж. Жинь улсын элч нүд өрөөсөн, Лу улсын элч толгой хожгор, Вэй улсын элч хөл доголон, Цао улсын элч нуруу бөгтөр байж гэнэ. Чи улсын эзэн Чин Гүн хэмээх ойворгон нэгэн өөрийн эхийг баясгасугай хэмээн сэтгэж, элч нараар зориуд доог тохуу хийхээр шийджээ. Тийнхүү сохор, хожгор, доголон, бөгтөр хүн тус бүр нэгийг зориуд ирүүлж, элч нарт бараа болгон, асруулж харгалзуулжээ. Хатан эх хийгээд ордны эмс тэднийг хараад ихэд хөхин баясч, элдвээр элэглэн шоолж гэнэ. Дөрвөн улсын элчис нүүрийг нь түлж, ихэд доромжлон гутаасанд машид уурлан хилэгнэж, Чи улсыг дайлан мөхөөх тухай зөвшин хэлэлцжээ. Тийнхүү гурван жилийн дараа дөрвөн улс нэгдэн, холбоо сүлбээ байгуулан, Чи улсыг их хүчээр дайлж, Чи улс ч ихэд ялагдан мөхөж, дахин ер сэхээгүй гэдэг. Улсыг засах амаргүй гэдгийн энгийн нэгэн үлгэр ийм ажгуу.

Их бага алив зохиол бүтээл, үг сургаалыг орчуулах, дуун хөрвүүлэхдээ эх бичвэрийн уг санааг сайтар үзэж мөрдөлгүйгээр, гүн ухаан, уламжлалт соёл, сэтгэлгээний хэв маяг зэргийг нь ухаж бодолгүйгээр, үгийн өнгөн талд шүтэн, илт өөрийн санааны дураар өнгөцхөн тайлж, хэт эдүгээчлэн өгүүлбээс эндүүрэл болох гэмтэй. Дээр өгүүлсэн “Утга төгс” хэмээх зарчмын чухам учир утга үүнд оршино.

Ярилцлагад “Күнз ч гэсэн өөрийгөө *“Би тийм их эрдэмтэй хүн биш шүү. Зөвхөн аливаа хэрэг явдлын ерөнхий төлөвийг л ойлгочихсон хүн шүү дээ”* хэмээн *“Шүүмжлэл өгүүлэл”* бүтээлдээ *шавь нартаа хэлж байдаг шүү дээ”* (*“Үндэсний шуудан” сонин 2013 он №248 “Улсыг засах жараахай шарахаас амархан”*) гэж өгүүлжээ. Тэгвэл “Луньюй” буюу “Шүүмжлэл өгүүлэл” номд юу гэж өгүүлсэн байдаг вэ? Күнз хэд хэдэн бөлөгт энэ тухай номлосон байх бөгөөд тухайлбал, *“Надад эрдэм буй гэж үү? Хэдүй их эрдэм үгүй буюу. ...Хэрэв надаас хэрэг учир асууваас би хэлж эс мэднэм. Асуусных нь эх хийгээд адаг хоёр туйлыг нягтлан байж аль чадахаараа таниулнам.”* (Күнз *“Шүүмжлэл өгүүлэл”* Есдүгээр бөлөг) гэх буюу *“...эгэл дороос суран сурсаар эрхэм дээдэд нэвтрэв.”* (Күнз *“Шүүмжлэл өгүүлэл”* Арван дөрөвдүгээр бөлөг) гэх маягаар хэлсэн байдаг.

Тэгвэл “Дашү” буюу “Их суртахуй” номд *“Түмэн бодос дур эх язгуур буй, эцэс адаг буй, тэнгэрийн доор хэрэг үйл дур эхлэл буй, төгсгөл буй, алив хэрэг үйлийг уг язгуураас нь үүдэн, эцэс адагт нь хүргэвээс их суртахуй ёсонд илт ойртон нийцэх бөлгөө”* (Зэнз *“Их суртахуй”* Судар бичиг хэмээх бөлөг) гэх маягаар өгүүлсэн байдаг нь дээрх номлолын тайлал нь болох юм.

2500 орчим жилийн өмнө хэлж, олон зууныг дамжин шүүгдсээр өдгөө үед уламжлан ирсэн сургаал номлолыг ухааны цараа, үгийн ураар ядруухан бичгийн бядгуу түшмэл

өчигдөрхөн хэлчихсэн үг мэтээр хэт эдүгээчлэн эгэл хар үгээр илэрхийлж буулгах нь тийм ч зохимжтой бус аа.

Эрхэм нөхөр “Күнзийн сургаалаас манай хүмүүсийн хувьд танил өөр нэг мэргэн үгийг энд дурдъя” хэмээгээд “Төрөө засахын тулд гэрээ зас, гэрээ засаад биеэ зас, биеэ засаад эрдэм сур, эрдэм сурахын тулд сэтгэлээ тогтоо” гэсэн үг байдаг” гэжээ. (“Үндэсний шуудан” сонин 2014 он №023 “Гурван улсын үлгэрийг жилдээ ядаж нэг уншдаг”) Хашилт тэмдэг дотор хийж бичиглэснийг үзвээс Күнзийн үгийг өөрчилж найруулалгүй шууд эш татжээ гэлтэй. Тэгвэл эх бичвэрт чухам юу гэж өгүүлсэн байдаг вэ? Энэхүү номлол нь Күнзийн суртлын “Дашүэ” буюу “Их суртахуй” хэмээх судар номд байх агаад хятад эхийг нь барин орчуулбаас “Түмэн хэрэг бодосын учир ёсыг ухааж тайлсны хойно эрдэм дур хүрмүй, эрдэм дур хүрвээс бодол санаа бат үнэн болмуй, бодол санаа бат үнэн болбоос сэтгэл тэгширмүй, сэтгэл тэгширвээс бие засармуй, бие засарваас гэр төвширмүй, гэр төвширвөөс төр засармуй, төр засарваас тэнгэрийн дор түмэн амгалан тогтмуй” (Зэнз “Их суртахуй” Судар бичиг хэмээх бөлөг) гэсэн утгатай юм.

“Биеэ засаад эрдэм сур” хэмээсэн нь үгүй, “эрдэм сурахын тулд сэтгэлээ тогтоо” гэж шууд өгүүлсэн нь бас үгүй. Харин “эрдэм сурваас бодол санаа бат тогтуун болж, тэгснээр сэтгэл тэгширэх, сэтгэл тэгширснээр бие засрах” тухай номлосон ажгуу.

Уг ярилцлагад мөн “Күнз богд “Ном үгийг гүйцэхгүй, үг утгыг гүйцэхгүй” гэж айлдсан” хэмээжээ. Күнзийн суртлын ном бичиг далай мэт арвин их юм болохоор тэрхүү номлол нь чухам ямар бичиг зохиолд байдгийг эс мэднэ. Харин Күнзийн сургаал номлолын гол цөм нь болсон Луньюй” буюу “Шүүмжлэл өгүүлэл” номд “Үг утгыг нээвээс болох буюу” гэсэн утгаар хэлсэн сургаал буй. Бас “Үг хэлэлцэж бологсод лугаа эс хэлэлцвээс хүмүүнийг алдьюу, үг хэлэлцэж үл бологсод лугаа хэлэлцвээс үг алдьюу, мэргэн хүмүүн болбоос хүмүүнийг ч үгийг ч үл алдьюу” (Күнз “Шүүмжлэл өгүүлэл” Арван тавдугаар бөлөг) гэсэн утгатай сургаал байдаг.

Орчуулга болбоос олон талтай, их бага алив нэгэн бичиг зохиолыг хэдэн ч хүн, хэдэн ч удаа орчуулж болдог, тэрхүү өөр өөрийн өнгө төрхтэй бүтээл нь орчуулгын их сан хөмрөгт хувь хандив болж байдаг нь орчуулгын түүхнээ түгээмэл нэгэн үзэгдэл билээ. Харин тийнхүү өөр өөрөөр орчуулах, хөрвүүлэхүйд “Үг ба өгүүлбэрт халдаж болно. Гол утгад халдаж болохгүй” хэмээсэн тэрхүү зарчим нэвт шингэсэн байх учиртай юм.

Энэхүү “Лаоз” буюу “Даодэжин” номыг монгол хэлнээ дуун хөрвүүлсэн лавтайяа гурван өөр орчуулга байх бөгөөд Д.Наранжаргал хятад хэлнээс, Гүн овогт Г.Аюурзана, Ж.Ванчинхүү нар дам хэлнээс тус тус орчуулж, уншигч түмнээ өргөн барьсан билээ.

Орчуулга бол шинжлэх ухаан мөн, бас урлаг мөн хэмээдэг. Эдүгээ хэл шинжлэл, соёл судлал, хэлний соёл судлал, гүн ухаан, гоо зүй, орчуулгазүй зэрэг олон ухааны уулзвар зааг дээр соёлын орчуулга судлал хэмээх шинэхэн салбар ухаан үүсэн хөгжиж байна. Тэрхүү онол, үзэл баримтлалын гол цөм нь аливаа бүтээлийг орчуулахад соёл судлал, хэлний соёл

судлалын үүднээс хандах, үг хэлний өнгөн бүтэц төдийгүй, түүний гүн чанадад орших соёлын утга агуулгыг нь бүрнээ нээж илтгэхийг чухалчилдаг билээ. Энэ нь мөнөөх “Утга төгс” хэмээх зарчимд яв цав нийцдэг бөлгөө.

Аль ч үндэстэн угсаатны эртний мэргэд, сэтгэгчдийн хэлсэн онч мэргэн үг сургаал нь он цагийн урсгалд олон зууны өртөөлсөөр хүрч ирэхдээ улам бүр боловсорч ширээгдсээр чухам шижир алт мэт болсон байх тул болхи толхи байдлаар бүдүүн хадуун, буруу зөв тайлах нь чухамдаа “алтыг гуулиар бүрэх” лүгээ адил хэрэг болох бус уу.

Энэхүү өчүүхэн бодрол санааг холбож хэлхэхдээ эрхэм журмын нөхрийн эрдэм чадлыг олтгойлж, дорд үзэн, дооршоох атгаг санаа сэдлэг огт агуулаагүй бөгөөд тэртэй тэргүй олонд танигдсан нэртэй дуун хөрвүүлэгч, нангиадч мөн тул “хүн хэдий сайн ч” хэмээхийн үлгэрийг бас бодолцон, бас Монголын шинэхэн үеийн орчуулгын түүхнээ тун саяхан өнгөрсөн зууны наяд оны дундуур орчуулгын “дүйх, дүйлгэх, дүр бүтээх” гэсэн нэгэн сэдвээр өргөн мэтгэлцээн өрнүүлж байсан уламжлалыг санагалзан, нангиад монгол орчуулгын хэрэгт нэмэр тус болуужин хэмээн сэтгэж бичсэн учрыг өчье.

Засаг төрийг засах ч хэцүү

Жараахай жарамгай чанах ч хэцүү хэмээмэй.

“Үлэмжийн чанар”-ыг нулимж болохгүй

Г.Дэлгэрмаа ⁹²

Ноён хутагт Данзанравжаа:

Агсан галзуу миний дууг эс мэдвэл

Амьдрал үхлийн нууцыг тайлах нь бэрх ээ.

“Бясалгал дунд нь ургасан дуу”

2006 онд тохиосон Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн дүрст лагшинг номын агаарт хураасны 150 жилийн ой, мөн Дэлхийн Яруу найргийн 26-р их хурал манай улсад зохион байгуулагдах үеэр Эрдэнэ мэргэн ноён хутагтын оюуны хур, билгийн цацраг болсон яруу найргийн цоморлигийг англи хэлнээ буулган “Perfect Qualities” нэрт ном болгон гаргасан билээ. Орчуулагч миний бие тэр номыг дараа жил нь харчихаад “Төгөлдөр чанарууд” гэж арай ч хэлэхгүй байх аа, гэхдээ өөрөө хийгээгүй байж юу хэлэх вэ?” гэсхийгээд орхисноос хойш 7 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд бусад дуун хөрвүүлэгч нарын монгол хэлнээс харь хэлрүү буулгасан болон харь хэлнээс монгол хэлнээ хөрвүүлсэн орчуулгууд бишгүй олноор гарч, дэлхий даяар түгэх болсон өнөө цагт Монгол шүлэг, яруу найргийн орчуулгын тооны тухай биш харин чанарын талаар нухацтай ярилцах цаг хэдийнээ болжээ.

Орчуулга гэдэг бол онолын хувьд:

“Эх хэлээр илэрхийлсэн бичвэрийн утга агуулгыг өөр хэлний адил утга агуулгад дүйцүүлэн буулгах” явдал юм.

Орчуулгын талаар өрнө дахинд анх эртний Грекийн гүн ухаантан Цицерон аль НТӨ 1-р зуунд анх бичсэнээс хойш маш олон онол, туршиц гарсан нь буй. Бичиг соёлын эртний их түүхэн уламжлалтай Монголчууд ч мөн өөрсдийн хэл бичгийг, орчуулгын онол, дэгийг томъёолон гаргаж, өрнүүлэн хөгжүүлсээр ирсэн нь хэдэн зуунаар байтугай тоологдоно. Гэвч онол нуршихыг түр азнан, товчхон хэлбэл эдгээр өрнө, дорны бүхий л орчуулгын онол нь:

- **“Эх хэлний утга санааг үнэн зөв, бүрэн төгс дамжуулах”,**
- **“Орчуулгын дүрслэх арга, хэлбэр нь эх хэл дээрээ илэрхийлсэн байдалтай ерөнхийдөө адил байх”** үндсэн хоёр шаардлагыг хангахад чиглэсэн, өөр өөрийн аргачлалыг

⁹² Орчуулагч, сэтгүүлч

боловсруулсан томъёолууд юм. Үүнд орчуулагчаас урлаг, уран сайхны мэдрэмж илүүтэй шаарддаг уран зохиолын орчуулга ч хамаарна.

Улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, шашин, гүн ухаан, шинжлэх ухааны салбарын орчуулгууд мэдлэгт суурилдаг, үг үсгийн зөрүүгүй байхыг тулгадаг бол уран сайхны буюу уран зохиолын орчуулга дуун хөрвүүлэгчээс “мэдлэг”, “мэдрэмж”-ийг нэхэж, “үнэн” байх, “уран” байх үндсэн шалгуурыг тавьдаг. Тэр тусмаа яруу найргийн орчуулга бол амар биш адармаатай учир уран зохиолын орчуулагчид цөөн байдаг биз. Орчуулгын алдаа эндэгдлийг өмөөрөх, “Төгс орчуулга хэзээ ч байдаггүй” гэж хаацайлах хүмүүс бишгүй байдаг ч хүн ярьж, бичиж л байгаа цагт орчуулах л болно, орчуулгыг “сайжруулах тухай” ярих ч болно, ялангуяа хил хязгаарыг хормын зуур давж харилцдаг болсон мэдээлэл технологийн өнөө цагт.

Яруу найргийн орчуулгын тухайд чанарын тухайд бичихдээ, уншигчдад онолоо багасгаж, учрыг тайлбарлахыг эрхэмлэн, “үнэн” байх, “уран” байх үндсэн энэ хоёр шалгуураас “үнэн” байх шалгуураар нь л энэ удаад авч үзье. Үнэн санааг нь орхигдуулбал “утгагүй” хоосон уянгалаад ч яах билээ дээ. Орчуулгын хэр “үнэн” болсныг шалгах нэгэн арга нь “Back translation” буюу орчуулгыг эх хэлрүү буцаан буулгах явдал. Үүнээс “эх хэлний утга санааг үнэн зөв, бүрэн төгс дамжуулж уу?, дүрслэх арга, бүтэц, хэлбэр, зохиомж нь хэр төстэй болж, зохиолчийн илэрхийлсэн утга уянга хэр бууж вэ?” гэдгийг тойм харж болно.

“Үлэмжийн чанар” номын оршилд дурдсанаар Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн 230 гаруй найргийг 5 жил нухаад, 5 сар цахим шуудангаар холбогдон орчуулж чадсан орчуулагч С.Смит Англи дахь Бурхны шашны очирт хөлгөний хийдэд хоёр жил шавилан суусан аж. Гэхдээ эхнээсээ ноён хутагтын тухай ташаа ойлголттой байсан нь орчуулагч С.Смит өөрийн өмнөх үгэндээ “Яруу найргаас нь Данзанравжаа “архины лүү”, “авгай хүүхний эрлэг” байсан гэдэг нь андашгүй... Ууж согтуурах, үүлэн борооны ажил, унаа мал, их говь, анд нөхөд, амраг садангийн явдлаараа эдгээр нь алиа наадаан, амьдралын өнгө, баясал төдийгүй худал хуурмаг гэдгийг (биеэр?) үзүүлж байгаа хэрэг” (That he was clearly a heavy drinker and highly sexed is also obvious from his poetry... Drink, sex, horses, the Gobi, one's own friends and relative – these are all fair game, both to show the color and excitement of human life, but equally to show its falseness. P15-16.) гэснээс харагдана.

Уншигчдад харьцуулж харахад хялбар байх үүднээс уг гүн ухаан-бясалгалын шүлгийг бадаг бадгаар нь, орчуулагч С.Смитийн орчуулга, буцааж монголруу хадаж буулгасан болон үүнийг бичигчийн дэвшүүлж буй жишээ орчуулга, мөн хадмал орчуулгын хамт харьцуулан тавив:

“Үлэмжийн чанар”**Эхний бадаг:**

Үлэмжийн чанар төгөлдөр¹

Өнгө тунамал толь шиг²

Үзэсгэлэнтэй царайг чинь³

Үзвэл лагшин төгс маань⁴

Үнэхээр сэтгэлийг булаанам зээ⁵

Бичигчийн загвар орчуулга

Insight qualities perfected¹

Like the mirror with colors so clear²

Beautiful face of yours, I see³

The body of manifestation⁴

Does truly capture the soul⁵

С.Смитийн орчуулга

Your perfect qualities¹

Are like colors reflected in a mirror²

I see your shining face, my dear³

And truly you have captured⁵

My entire mind and body⁴

Загвар орчуулгын хадмал

Үлэмжийн чанар төгөлдөржсөн¹

Өнгө тунамал толь шиг²

Үзэсгэлэнт царайг чинь үзвэл³

Лагшин төгс нь⁴

Үнэхээр сэтгэлийг булаана⁵

С.Смитийн орчуулгын хадмал:

Төгс төгөлдөр чанарууд чинь¹

Толинд туссан олон өнгө шиг²

Гийх царайг чинь үзвэл дээ, хонгор минь³

Бие, сэтгэлийг минь үнэхээр⁴

Бүхлээр нь булаасан юм шүү⁵

¹ Бурхны шашны Үлэмж үзэл, үлэмж үзэхүйн билэг

² Таван тахилын нэг “гийгүүлэгч толь”

³ Таван мэдрэхүйн “харахуй”

⁴ Бурханы лагшингийн олон хувийн нэг. Лакшана нь самгардиар “бэлгэ тэмдэг” гэсэн утгатай, дотоод сайхныг гадна илэрхийлэгч шинж.

⁵ Зовлонгоос гэтэлгэх зөв зам мөрийг оносон тухай баясан өгүүлжээ

Мөн шүлгийн мөр тулгахаас гадна үг бүрийг тоогоор дугаарлан харьцуулж үзвэл, аль үг англиар буусан, хаана утга гээгдсэн нь тодорхой харагдана:

Үлэмжийн¹ чанар² төгөлдөр³

Өнгө⁴ тунамал⁵ толь⁶ шиг⁷

Үзэсгэлэнтэй⁸ царайг⁹ чинь¹⁰

Үзвэл¹¹ лагшин¹² төгс¹³ маань¹⁴

Үнэхээр¹⁵ сэтгэлийг¹⁶ булаанам зээ¹⁷

Бичигчийн загвар орчуулга

Insight¹ qualities² perfected³
 Like⁷ the mirror⁶ with colors⁴ so clear⁵
 Beautiful⁸ face⁹ of Yours¹⁰, I see¹¹
 The¹⁴ body¹² of manifestation¹³
 Does truly¹⁵ capture¹⁷ the soul¹⁶

1-2-3
 7-6-4-5
 8-9-10-11
 14-12-13
 15-17-16

x-3-2
 x-7-4-5x-6
 11-10-8x-9-x
 15-x-17
 x-x-16-13

С.Смитийн орчуулга:

Your^x perfect³ qualities²
 Are^x like⁷ colors⁴ reflected^x in^x a mirror⁶
 I see¹¹ your¹⁰ shining^{8x} face⁹, my dear^x
 And truly¹⁵ you^x have captured¹⁷
 My^x entire^x mind¹⁶ and body¹³

Үгийн тоогоор харьцуулан үзвэл аль утга хаана яаж гээгдсэн, хутгалдсан нь тодорхой. С.Смитийн орчуулгад “Үлэмжийн” гэдэг үгийг ор мөргүй, огт байгаагүй мэт гээжээ. Харин энэ үг нь шүлгийн хамгийн чухал эхлэл, оньс бас тайлал үг юм. Бурхны шашны “Үлэмж үзэл-ийг самгаридар “Mahamudra“ гэх ба “ариун хайрын үрээр тунгалаг оршихуйн толинд өөрийн дотоод дүрийг (мөн чанар) танихыг хэлжээ^{IV}. Үүнийг англиар ‘Insight’ гэсэн энгийн атлаа утга төгс дүйсэн үгээр оноож орчуулах ба цаад илэрхийлэх утга нь “үнэн мөн чанарыг олж танин барих” буюу үлэмж үзэхүйн билэг, мөн “магад шинжлэхүй”, “гэгээрэх зам мөрийн “харахуй” болно. Энэ бадгийн чинад утга нь “Үлэмж үзлээр мандаж өөрийн аяар болсон сэтгэл төгс төгөлдөр юм, яг л буртаггүй толь хамаг бүхнийг тод тунгалагаар тольдох шиг, үдшийн бүрий уудам огторгуйн цэнгэг мандалд сэтгэл ууссан мэт, амгалан дүр байдлын амирлалыг харах шиг. үзэхэд сэтгэл ханах аргагүй”^V гэсэн утгатай. Хэлэлцээд буй орчуулга үүнийг илэрхийлсэнгүй, харин ч “төгс чанар нь толинд ойсон өнгө шиг хуурамч тусгал болчихоод; “лагшин төгс маань” гэсэн мөрийг “сэтгэлийг булаанам” гэдэгтэй хольж хутгаснаар “бие, сэтгэлийг минь бүхэлд нь булаан эзэмдлээ” гэсэн утгатай болж, ийн эндүүрэгдсэнээрээ хутагтыг хөөрхөн хүүхэн хараад ухаанаа алдчихсан, үүнийгээ шүлэглэсэн төдий болгож байгаа хэрэг. “Лажин төгс” гэдэг нь бурханы төгс лагшинг ёгт хэлж байгаа бөгөөд англиар “Manifestation Body” гэж тогтоон нэрлэдгийг, ‘Body of Manifestation’ гэсэн маань хутагт шүлэглэхдээ яруу сонсголонгийн учирт үгийн байрыг сольсныг мөн баримталсан болно. Ийн хэлснээр англи нэршил нь арай зөөлөн бууж, учрыг мэдэх англи хэлтэн уншигчдад бурхны төгс лагшныг хэлж байгаа нь ухагдана хэмээн бодолцов. Энэ хэллэг орчуулагчийн “элдэв шашны нэр томъёо шүлгийн орчуулгад хэрэглэх нь англи хэлтэн уншигчдад уншихад тээртэй байх учир зайлсхийв”^{VI} гэж тайлбарласан шиг “нүдэнд орсон хог” даанч болохгүй. Тэгээд ч орчуулагч “Үлэмжийн чанар” номд тэр байтугай “гэвш, зайсан” гэх мэт үг хэллэгийг тэр чигээр нь буулгасан нь бий. Мөн орчуулагч Смитийн “миний хонгор” гэдэг илүүц үг нь ‘mirror-dear’ гэж сүүл холбох гэсэн санаатай холбоотой биз, гэхдээ ингэж утга гуйвуулж сүүл холбосноос холбоогүй нь дээр л дээ. Гэхдээ хэмнэл тааруулах, сүүл холбох зэрэг “уран” байх шалгуурын тухайд ярих нь ахин нэлээд хэдэн хуудас болох тул хойш тавья. “Сэтгэлийг булаанам зээ” гэсэн нь зөвхөн өөрийн тухайд бус, өөр бусдын сэтгэлийн тухайд ч хамсруулан өгүүлсэн тул “my soul” гэлгүй “the soul” гэж тодотгон оруулав.

Энэ шүлэг заавал ийм утгатай байх албагүй, хөөрхөн хүүхнийг дуулсан гэж мэтгэх хүн гарч магад, гүн ухааны болоод гоо үзэсгэлэнгийн тухайд аль аль утгаар нь ойлгож болох энэ шүлгийг мөн аль аль утгаар нь ойлгохоор англи хэлнээ буулгавал сая орчуулга

мөн болно гэж хэлье.

Мөн ноён хутагт энэ “таван тахилыг өргөсөн” санаагаа улам лавшруулан дэлгэрүүлж, **“Сайн бэлгэдэлт арван гурван эдийг соёрхсон зарлиг оривой”** шүлэгтээ:

Дүрс дүрсийн дундаас тув тунгалаг хиргүй

Дүрс хөрөг хязгаарлашгүй гийгүүлэгч толийг

Дүрс үзэсгэлэнт таны нүүр харах чимэг болгон

Өргөө, өлзийхутаг салиггүй ориших болтугай! гэсэн нь бий. Мөн

“...Дуу дууны дундаас тодохон

Дүнггар яйчил, Шагжаан чадагч сайшаасан дуут лавайг

Дуулиатсан үнэн үг яруу сонсголонт чимэг болгон...”,

“...Үнэртний дундаас бие сэтгэлийг амраагч үнэр

Үхэл, гурван хар өвчинг арилгагч гиваан эмийг

Үлэмж шагшабадын төрөлхийн үнэр анхилуулахын тулд...”,

“...Амттаны дундаас чихэр өвсний сайхан шимт

Алимад саран гундаа цэцэг шиг цагаан таргийг

Амины судал махбод эвдэршигүй дуслыг тэтгэхээр...”,

“...Хүрэлцэхүйн дундаас зөөлөн эелдэг сэтгэлд таатай

Хүний амь насыг бататгах дэвгэр дурвааг

Хүнлэг шударга оришихын бат бэлгэдэл болгон

Өргөө, өлзийхутаг салиггүй ориших болтугай!...” хэмээн таван тахилыг багтаан дэлгэрэнгүй сайхан ерөөл өргөж аврал одуулсан байдаг аа, уншигчид болгоох биз.

Эх шүлгийн 2-р бадаг:

Хөшүүн сэтгэлийг уяруулагч

Хөхөө шувууны эгийг шиг

Хөөрхөн эелдэг үг чинь

Хүүрнэн суухад урамтай

Хөөрхөн аальт мину зээ

Бичигчийн загвар орчуулга:

Like the singing of a cuckoo 2

That melts soul, so rigid and austere 1

Your words, so gentle and tender, 3

Are so heartening to converse 4

The gentle-natured You of Mine 5

С.Смитийн орчуулга:

Like the cuckoo's song 2

You relieve the stress in my mind 1

Your kind words are gentle, my dear 3

With such kindness you sit 4

And offer comfort. 5

Загвар орчуулгын хадмал:Хөшүүн бэрх сэтгэлийг уяруулдаг²Хөхөө шувууны донгодоо шиг¹Эелдэг, зөөлөн үгс чинь³Хөөрөлдөхөд урамтай⁴Хөөрхөн аалт минь⁵**С.Смитийн орчуулгын хадмал:**Хөхөөн дуу шиг чи¹Хамаг бодлын минь хямралыг арилгана²Найрсаг үгс чинь эелдэг юм, хонгор
минь³Үнэнхүү эе найртай сууж,⁴Ая тухтай байлгах юм⁵

1 Дуу гэдгийг донгодоо гэж буулгав.

2 Rigid - хөшүүн, хатуу хахир, austere - хүйтэн, хөшүүн, бэрх, мөн зожиг, ганцаар, хүйтэн, өөрийгөө зовоогч гэсэн утгатай тул монгол дээрхи утгыг бодолцон, мөн сүүл холбож сонгов. Угтаа энэ нь чинад учир, үнэнийг үл ухах мунхаг харанхуй сэтгэлийг сонсохуйн яруу сонсоголоор арилгах гэсэн санаа мөн

3 Heartening гэдэг нь урамших, зоригжих, ая таатай байх, онгод хөглөх утгуудыг бүгд илэрхийлдэг тул сонгов

4 Суух гэдгийг суугаад байгаа биш, тийн үйлдэхэд бахтай гэж ухсан тул ерөнхий өгүүлэв.

5 Хөөрхөн аалт гэдгийг sweet, kind, amiable, lovely аль төс үгээр хэлж болно.

Энэ бадаг нь “мунхарсан хүлээст хүмүүний сэтгэл нь нисванисыг орхиж алдарсан гайхамшигт цаглашгүйн зүрхэнд хүрсэн үедээ зөвхөн өөртэйгөө хэлцэж байж буюу тухайн үед мэдэрч буй огторгуйн цаад дахь ариун тунамал агаар мандал адил гайхамшигт түүнийгээ сонордож байж тархиндаа зураглан, энэ ертөнцөд авч ирэх агаад угтаа энэ ертөнцийн утга хэмээхээс ч хэдийнэ хагацсан эгшиглэн байдаг” гэжээ. Мөн “ноён хутагт шувууг утга уянгын бэлгэдэл болгон шүтдэг... шувуу нь өгүүлшгүйн утгыг нээж, өгүүлшгүйг үгэнд юүлэх эрдмийг дохиолдог.”^{IV} Гэхдээ гүн утга санааг энгийн үгээр шүлэглэн өгүүлсэн тул орчуулгын хувьд шашны нэр томъёо гэж толгой өвтгөх зүйлгүй, гэхдээ орчлон хорвоогийн явдал, зовлонгийн шалтгааныг таниулах үнэн үгийг хөхөөн дуутай яруу сонсголонтой зүйрлэж, үнэнээр мунхгийн харанхуйг арилгахыг хөшүүн сэтгэл хэмээсэн нь тодорхой. Саймоны орчуулгад гарсан алдаа нь “хөшүүн сэтгэлийг уяруулагч” гэж ерөнхий хэлснийг “миний бодолд байгаа алив хямралыг чи л намжаадаг” гэж өөртөө наасан, “чиний эелдэглэн суугаад байх чинь надад аятай байна” гэсэн утгын алдаа юм. Англи хэлний дүрмийн хувьд заавал “чи, та нар” гэж эзэн бие оруулж ярьдаг боловч, ерөнхийлөн өгүүлж буй тохиолдолд, тэр тусмаа гүн ухааны яруу найрагт “чи, миний хонгор” гэлгүй утгыг илэрхийлэх боломжтой.

Эх шүлгийн 3-р бадаг:

Учирмагц сэнгэнэсэн

Уран гол шиг бие чинь

Угаас хам бүтсэн

Улаан занданы үнэр шиг

Улмаар сэтгэлийг хөдөлгөнө зээ

Бичигчийн загвар орчуулгаRedolent upon meeting in coincidence,¹The lissome and elegant body of Yours,²Is like the red sandalwood fragrance⁴**С.Смитийн орчуулга:**Your elegant body²Borne upon the breeze¹Is beyond words, my dear^{*}

Formed together in substance,³
And withal moves the soul⁵

Загвар орчуулгын хадмал

Учрахад анхилсан (сэнгэнэсэн)¹

Уран гоолиг бие чинь²

Угаас хам бүтсэн⁴

Улаан занданы үнэр шиг³

Улмаар сэтгэлийг хөдөлгөнө зээ⁵

Like the scent of red sandalwood,⁴
You more and more entrance my thoughts⁵

С.Смитийн орчуулгын хадмал:

Зөөлөн сэвшээгээр зөөгдсөн (ирэгдсэн)¹

Цэвэр цэмцгэр бие чинь²

Үгээр хэлэхийн аргагүй юм, хонгор минь^x

Улаан занданы үнэр шиг⁴

Улмаар бодлыг минь ховсдох юм⁵

¹ Учирсан гэсэн нь “өлзий дэмбэрэлээр учрал тохиосон” хэмээн бэлгэдсэн утгатай гэж ухаж,

“азаар, бэлгэ дэмбэрэлээр учрахад” гэж буулгав.

² Lissome – эрхэмсэг сайхан, үзэмж гоолиг, гол шиг хэмээсэн бие махбодын сайхныг илтгэсэн үг

³ Зандан мод нь Авид буюу Цаглашгүй гэрэлт, улаан зандан нь Эсэруа тэнгэр буюу Цамбыг бэлгэддэг. Энэ мод нь алив хүсэл тачаалыг урвуулж, бясалган суухад бодол сэрэмжийг тэтгэдэг.

⁴ Угаас хам бүтсэн хэмээх шашны хэллэгийг англиар утга дүйлгэн тогтсон хэллэгээр нь оруулсан ба сүүл холбоход тохиров. Мөн буцаан буулгахад монголоороо тогтсон энэ хэлцээрээ буух буйзаа

⁵ Сэтгэлийг хөдөлгөнө гэж англиар мөн адил хэлдгийг хэвээр авч, минийх гэж оруулаагүй авч тодорхой хэлсэн хэвийг хадгалав.

Энэ шүлэгт ноён хутагт “өөрийн бие жаргалангийн бие болохыг хэлж байна. Сэтгэл тэр нь сансарын мөн чанартай бие хэмээхийн дотоодод бүтдэг тул түүнийг ухамсар төдийтнөөр мэдрээд өнгөрөх хангалтгүй, тиймээс өөрийн бие тэр мэт адил болох ёстой, мэдэрдэг байх нь хангалтгүй учир өөрийн бие цогцсоор үлэмжийн чанар болохын учрыг тайлан хэлсэн байна. Тиймээс дадуулсаар өөрийн мөн чанар, оршихуйгаа болгож төгс гэгээрлийн хутгийг олохыг ерөөсөн утга болно. “Угаас хам бүтсэн” гэж сэтгэлийн язгуур чанар хамт төрсөн болохыг бэлгэдэх ба үүнийг мөн англиар тогтсон хэллэгээр нь Together-born гэхийн адил Together-formed гэдэг болой. Харин Смит “цэмцгэр биеийг чинь хараад зүйрлэх үг алга, үнэр чинь ухаан алдуулж ховсдож байна” гэж орчуулсан нь хүмүүсийн хэлдгээр “хүүхэнд нугасгүй” халамцуу хутагтын халуурал шиг л болж дээ.

Эх шүлгийн 4-р бадаг:

Бадмын дундаас дэлгэрсэн¹

Балын амт адил²

Баясгалант ааль чинь³

Бахдаж ханашгүй⁴

Баярыг улам арвитгана зээ⁵

Бичигчийн загвар орчуулга

Like the taste of honey²

Sourced from the lotus core¹

Your joyous nature³

Bring delight so pure⁴

And thrive more the rapture⁵

Англи дээрхи орчуулга

Like the taste of honey²

Flowing from the heart of the lotus,¹

Joy in you, my dear³

Makes me ever happier,^{4x}

Happier beyond belief^{5x}

Загвар орчуулгын хадмал:

Бадмын голоос үүтгэлтэй 2

Балын амт адил 1

Баясгалантай ааль чинь 3

Шижир бахдлыг авчирна 4

Жаргалыг улам арвитгана 5

С.Смитийн орчуулгын хадмал:

Бадмын голоос урссан

Балыг амт шиг

Баясал цэнгэл чинь, хонгор минь

Баяр жаргалтай болгох юм,

Бүр итгэмээргүй жаргал авчирна

1-2 Шавар балчиг дундаас урган дэлгэрдэг ч бузар буртаг өчүүхэн төдий халдааггүй цэвэр ариуны бэлгэдлээр зовлон шаналлын дундаас амгалан сэтгэлийг олон гэгээрэхийг балын амт адил. Бадмын тоосыг боловсруулан бал гарган амтлах нь зовлонгийн үрийг бясалган гэгээрэхтэй адил.

3-4 Бахдах нь бахархах бус баярлан сэтгэл ханахыг хэлжээ.

5 Баяр жаргалыг мөн capture гэх ба сүүл холболтонд тохирох тул сонгов

Энэ бадаг нь дээр дурдсанчлан “тэр мэт сэтгэл нь балчигт ургадаг ч балчигийн хир үл халдах цагаан лянхуа адил тунгалаг ариун сэтгэлтний оюунд ургана. Нисванисын буртагт дарагдсан хүний өчүүхэн бие, нөгөө талаас арилсан гэгээнийг дадал болгон муу муухайтай тэмцэгч магад гарахыг хүсэмжилсэн үзлээс төрдөг. Товчхондоо зүрх уйлж, усан мах бодод оч харван шаталдах мэт. Баясгалангийн дээдийг мэдүүлэгч түүнийг бахдаад яав ч ханамгүй, буяны сэтгэлд урам өгдөг гайхамшиг минь” гэсэн утга болно. Өөрөөр хэлбэл “балчгаас ургах бадам, бадмаас ялгарах балын шим нь эгэл хүний бурханлаг чанарыг нээх тарнийн хувиргах зарчмын үлгэр”^{iv}. Харин С.Смитийн орчуулгад “Бадмын голоос урссан Балын амт шиг” гэсэн нь бэлэн бал бадмаас урсдаг шиг болоод, жаргалтай, бүр жаргалтай, бүүр ч их жаргалтай гэсэн гурван мөр үүсчээ. Харин эдгээр гурван мөр нь баясгалант ааль, бахдах сэтгэл, баяр жаргалан гэсэн гурван өөр утгатай, чинад санаа нь бол “Баяр баясгалан бол гэгээрлийн мөн чанар. Цэнгэл жаргал бол ариуслын жинхэнэ утга. Аугаа хайранд уусах тусам энэ цэнгэл энгүй өргөн цэлгэр болж, бодгаль бүхэн амраг хайртны хувилал болно. Хоосон чанарт нэвтрэх тусам энэ цэнгэл ёроолгүй гүнзгий болж, үзэгдэл бүхэн тунгалаг гэрлийн цацраа болно. Энэ агшинд л бид мунхгийн зузаан нойроос сэрднэ. Энэ агшинд бид өөрсдөө хутагт болно”.

Эх шүлгийн 5-р бадаг:

Хүний энэ насанд

Хүссэн хэргээ бүтээгээд

Хүсэлт тэнгэрийн эдлэл мэт

Хөлгүй жаргалангийн далайд

Хөвж хамтдаа жаргая

Бичигчийн загвар орчуулгаIn this life of human being¹We are to fulfill the deeds we wish²Like the objects of Desire realm³In the ocean of footless bliss⁴Let us together afloat rejoice⁵**С.Смитийн орчуулга:**In this human age,²To do what you wish¹Is to wish for the things of heaven³.Afloat upon the ocean of deep enjoyment⁴Let us be joyful together⁵

Загвар орчуулгын хадмал

Хүний энэ насанд1
 Хүссэн хэргээ бүтээнэ2
 Хүсэлт тэнгэрийн эдлэл мэт3
 Хөлгүй жаргалангийн далайд4
 Хөвж хамтдаа жаргацгаая5

С.Смитийн орчуулгын хадмал:

Хүссэн бүхнээ хийх2
 Хүний энэ насанд1
 Тэнгэрийн зүйлсийг хүсье3
 Гүн цэнгэлийн далайд хөвж4
 Хамтдаа жаргаж цэнгэе5

1 Хүний энэ насанд гэдгийг хүн төрлийг олсон энэ амьдралдаа гэсэн утгаар нь шууд буулгав. Монголчууд насаараа, энэ насандаа гэж хэлэх нь бүхэл амьдралыг шууд илэрхийлсэн санаа мөн.

2 Юу хүссэнээ биш, хүн болж төрөөд хүсэх, гүйцээх ёстой үйлээ бүтээнэ гэсэн санааг буулгав

3 Авидармын ёсоор сав ертөнцийг хүсэлт, дүрст, дүрсгүй орон гэж гурав хуваана. Хүсэлт орны амьтад дүрс, дуу, үнэр, амт, хүрэлцэхүй хэмээх хүслийн таван эрдэмд хэтэрхий тачаадаг учир ийн нэрийджээ. “Хүсэлт орон”-д там, бирд, адгуус, дөрвөн тивийн хүн, хүслийн зургаан тэнгэр тэргүүтэй таван зүйлийн амьтад бүгд багтана. Үүнийг англиар Desire Realm гэж оноон нэрлэдэг.

4 Хөлгүй гэхийг англиар footless гэж хэлдэг нь яг адил дүйсэн үг.

Бурхны шашны англи нэр томъёонд “баясгалангийн орон, төгс баясгалан” гэхэд ‘Land of Joy, Perfect Joy’ гэхчлэн орчуулдаг ба мөнхүү баясгалангийн тухайд оруулан ‘баясгалантай ааль’ хэмээснийг уг үгээс үүссэн “joyous” тэмдэг нэрийг авч оруулав.

“Хүсэлт тэнгэрийн эдлэл гэдэг нь хүрэх төдүйд бие, сэтгэлийн тавирал эдлүүлдэг тэнгэрийн орны хив эрдэнийн ёгт нэр. Таван мэдрэхүйн мэдрэмж, таашаалыг номын хурим болгон бясалгах “Нууцын хураангуй” тарнийн ёсонд номлосон байдаг.^{IV} Харин Смитийн орчуулгад гарч буй нь хүн болж төрснийх, юу хүссэнээ хийгээд, эх захгүй жаргаяа гэсэн шүү утгатай болсон нь буруу. Ийнхүү бадаг тус бүрээр харьцуулан үзэхэд хутагтын “Үлэмжийн чанар”-ыг магтан дуулсан нь англи дээрээ утга ч үгүй, уянга нь ч алга.

Мэргэн хутагтын айлдсан яруу найргийн эмхэтгэлийн англи орчуулгаас зөвхөн ганцыг нь жишээ дурдах, жич тайлбарлах төдий өнгөц харьцуулан үзэв. Сайн орчуулсан шүлгүүд энэ номд байгаа ч андуурсан, хадуурсан, ташаарсан, бүр тэс хөндлөн болгочихсон нь дийлэнх байна. Тэр тусмаа номын тэргүүн найраг “Үлэмжийн чанар”-ыг хүүхэн эргүүлсэн, хүсэл алдарсан, тачаалд автаж, дур хүслээ бичсэн шүлэг гэж ойлгож орчуулсан нь харамсалтай л хэрэг.

“За, больё, **“Үлэмжийн чанар”** хэцүү шүү дээ” гэе. Гэсэн ч, “Оршил”-д оруулсан Данзанравжаагийн 7 настайдаа зохиосон **“Хурмаст тэнгэр”** шүлгийн:

“Үүлэн гараад бороо орохын цагт

Үүдэн гэмээ нь хоймор юуны ялгаа?

Үйл байгаад үхэл авахын цагт

Хөгшин гэмээ нь залуу юуны ялгаа байх вэ? гэснийг

“Үүл гараад бороо орох үед гэртээ л байгаа бол

Үүд, зуухны хооронд ямар ялгаа байх вэ?

Ажлаа дуусгах цагт үхэл дайрах юм бол

Хөгшин залуугийн хооронд юуны ялгаа байх вэ?” гэснийг юу гэх вэ?.

(When the clouds fall with rain and you are inside

What difference is there between the front door and the hearth?

At the time of death, when your work is through

What difference is there between old age and youth?’)

Англи хэлтэн хэн ч гэсэн үйлийн үрийг “karma” гэдгийг мэднэ, үгүй ядаж ‘deed - үйл, үйлс’ гэсэн үгээр орчуулбал аж амьдралын ч, шашны ч үйлийг хоёуланг нь хам хэлчихэж болох байлаа. Тэрнээс “Гадаа бороо орж байхад, гэртээ л байгаа бол үүд, зуухныхаа хаана нь ч байсан яах вэ, Хийх ажлаа л амжуулсан бол хөгшин, залуу хэдийдээ ч үхсэн яах вэ” гэсэн хэгжүүрхэл болгож болохгүй. Ингэж буулгасан бол утга нь дөхөх байлаа:

‘In times when the rain falls upon cloud gathering

What difference there is between the door and the altar?

In times when the death arrives owing to one’s deeds

What difference there’s between the old and young’

Эрдэнэ мэргэн 5-р ноён хутагт Дулдуйтын Данзанравжаа нь Монголын шашин, соёл, нийгмийн сэтгэлгээний түүхэнд тодрон мөнхөрсөн билиг оюун тэгш гүн ухаантан, урлахуй бүтээхүйн үлмжийн чанар төгс сод авъяастан, асрах энэрэхүйн сэтгэлт, аг тарнийн шид увидастан, ухаарал гэгээрлийн үлгэрлэлт гэгээн хутагт байсан билээ¹¹. Хоосон чанарт нэвтэрхий хувилгаантны өгүүлсэн дуулсан бүхэн нь хорвоогийн үнэн мөнийг ил тодоор учирлан таниулсан учиртаа “догшин хутагт” гэгдсэн болой.

Баргийн хүн зориглож халдамгүй их хутагтын найргийг бөх зүрх гаргаж, оноож орчуулахад бүү хэл, жир хүний энгийн шүлгийг ч орчуулахад цаанадаж хэлэх гэсэн санаа, чинадах утгыг нь ухах, наанадаж монгол үгийг ойлгодог, ил бичсэн үгийг ойлгодог, мэддэг байх ёстой. Энэ бол зүй ёсны шаардлага, орчуулагчийн үүрэг төдий биш зохиолч, яруу найрагчдын оюуны бүтээлийг хүндэтгэх орчуулагчийн ёс зүйн асуудал юм. Ёс зүйгээс гадна бас “хариуцлага” юм.

Үгийг мэдэхгүй бол толь бичиг харж, мэддэгээс нь сурч, мэдэхгүйгээ мэдэх нь наад захын асуудал. Гэхдээ “халт мөлт, буруу зөрүү” ойлгох, нь сонирхогчийн хувьд байж болох ч орчуулагч гэсэн сэтэр зүүгчийн хувьд “тааж буудах” асуудал байж болохгүй. “Бодьсад нар” гэхэд “bodhisattva sun” гэх, эсвэл “зовлонгийн дөрвөн далай” гэснийг “дөрвөн далайн зовлон” /suffering of four oceans/ гэх, эсхүл өөр жирийн дөрвөн мөртийн орчуулгад:

“...Урин цаг ирэхэд...” гэснийг “урин дулаан, эсэргэн цаг” гэсэн утгаар нь бус “Урин хилэнт, ууртай догшин цаг ирэхэд” гэж “тольдож буудан”, нөгөө шүлгийн зүрхийг оноод нам унагачихсан мэтийн “гэмт” хэргүүд тоймгүй олон бий.

Ахиулаад яривал “Ноён хутагт “эрлэг” гэдгийг шүлэгтээ хошин маягаар оруулдаг учир “Grim Reaper” буюу хадуур барьсан хар нөмрөгт үхлийн элчийн дүрээр орчуулсан” гэжээ. Бурхдын нэрс байтугай “гэвш” цолыг түвэдээр нь ‘Geshe’ (гэвш) гэж буулгаж байж, нүгэл буяныг дэнслэгч Эрлэг номун хааныг ядаж самгаридаар ‘Yama’ гэгчихгүй дээ гэж бодох. Загалмайтны “Хадуурт”-аас Монголчуудын “мэдэх” эрлэг огтоос өөр шүү. Энэ мэтчилэн шүлэг найраг болгоныг сайтар харьцуулан төнхвөөс бүр ч төвөгтэй олныг нуршихад хүрэх тул түр зогсё. Мөн “үнэн” буусан утга санааны тухай хөнгөхөөн хэлцсэнээс “уянга”, хэлбэрийн тухай дурдалгүй шахам өнгөрлөө.

Нэгэн үе тасалдаад байсан орчуулгын бүтээл өнөө цагт олон олноор гараад, ярьж “яншиж” дуусахгүй олон олон алдаа мадаг, андуу явдалтай болоод, буруу замаар будаа тээхийн үлгэр болох нь ээ. Болохгүйг нь хэлж, бурууг нь хэлцэхгүй бол болохгүй болсон байна.

Манай аман уламжлал, уран зохиол, яруу найраг нь түүхэн хөгжил, уран зохиомж, утга санаагаараа хэнээс ч дутахгүй гэдгийг Монголынхоо уран зохиолыг харь хэлнээ бүрэн төгс, үнэн зөв, уран яруу буулгаж, шүлэглэн орчуулж, сурталчлан таниулж баймааж нь дэлхийд баталж, хүлээн зөвшөөрүүлэх билээ. Дараа дараагийн дугаарт дуун хөрвүүлэгч нарын орчуулгын талаар энэ мэтчилэн цувралаар гарах болно.

Доктор, нэрт түвдэгч Л.Хүрэлбаатар:

“Равжаагийн зохиосон “таван тахилын дуу” хэмээн алдаршсан “Үлэмжийн чанар” дуу нь хүслийн таван эрдмийн үүднээс нүдээр харах дүрс, чихээр сонсох дуу, хамраар үнэрлэх үнэр, хэлээр амтлах амт, биеэр хүртэх хүртэхүйн сайхныг магтан дуулсан... тахил өргөлийн эрхэм дээд билэгдэл болгосон... нэг талаар шашнны номын санаа, нөгөө талаар гоо сайханы... магтаал гэмээр... ертөнц хийгээд номын хоёр ёсны агуулгатай, янагуух хийгээд үнэмлэхүйн давхар далд санаатай, залах хийгээд магадлахын хоёр утгатай, гүн бодол бясалгалын уянгатай бурхны зохиол”

Нийгэм, хэл соёлын харилцаан дахь олон төрлийн орчуулга дотроос уран зохиолын орчуулга, тэр тусмаа уламжлалт яруу найраг, шашин, гүн ухааны, шүлэглэсэн бүтээлийн орчуулга нь хамгийн ярвигтай нь бөгөөд орчуулагчаас наанадаж хоёр хэлний гүнзгий мэдлэг боловсролоос гадна урлагийн мэдрэмж, гоо зүйн таашаал, нийгэм соёлын бүхий л салбар, ухааны мэдлэг, боловсролыг шаардаж байдаг. Ялангуяа, уламжлалт яруу найргийн орчуулгад соёл судлал, утга зохиол, хэл шинжлэл, сэтгэлзүй, бэлгэдэл зүй, домог зүй, гүн ухаан, угсаатны зүй, ёс зүй, хүн судлал, амьдралын хэв маяг, зан заншил, шашин шүтлэг, ер нь нийгмийн бүхий л салбарын олон талын мэдлэг мэдээллээс гадна хувь хүний байнгын

эрэл хайгуул, хөдөлмөр зүтгэл, авьяас чадвар, орчуулгын сурц, дадлага туршлага голлох үүрэгтэй.

Ашигласан ном:

- I. 'Perfect Qualities' S.W.Smith, Academy of Poetry and Culture. Ulaanbaatar 2006
- II. “Эрдэнэ ноён хутагт Данзанравжаа” Равжаа судлалын сан Улаанбаатар 2006
- III. “Халхын ноён хутагт Данзанравжаа” Улаанбаатар. 2006
- IV. “Үлэмжийн чанар”, “Агнистын гэгээ” цуврал

**ОРЧУУЛГАЗҮЙН САН
ХӨМРӨГӨӨС**

Олег цэцний орчуулгын тайлбар

Ц.Дамдинсүрэн⁹³

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Пушкиний Олег цэцний дуулал гэдэг шүлгийг орчуулж гаргахдаа уг шүлгийн тухай хэдэн үг тайлбарлан хэлэх хэрэгтэй мэт санагдана. Энэ шүлэгт Олег гэдэг Оросын нэг ван хүний яаж үхсэн тухай өгүүлнэ. Энэ сэдвийг Пушкин өөрөө зохиосон биш, Карамзины зохиосон «Оросын түүх» гэдэг номоос авсан гэнэ.

Карамзин энэ домгийг Оросын эртний оны тэмдэглэл бичгээс авчээ. Тэр оны тэмдэглэл бичигт өгүүлсэн нь:

Олег, нэг шидтэнээс аяж үхэхээ асуусанд, тэр хариуд нь «Ван гуай та өөрөө хайрлаж унадаг мориноосоо болж үхнэ» гэжээ. Энэ үгийг сонсоод Олег хайрт морио «Сайн тэжээж бай» гэж агтчинд тушааж өгөөд, ер түүнийг унахаа зогслоо. Хэдэн жил болсны хойно Олег, Грек улстай дайн хийснээс хойш буцаж ирээд гэнэт морио дурдан санаж, агтчныг дуудаж авчраад «Өнөөх морь минь ямар байна» гэвэл агтчин хариуд нь: «Таны морь хэдийн үхсээн» гэсэнд Олег, урьд мэрэглэсэн бөөг хараан хэлсэн нь: «Тэр бөө урьд намайг мориноосоо болж үхнэ гэлээ. Одоо миний морь үхээд би амьд үлджээ. Үүгээр үзвэл тэр цөм худал хэлдэг хүн байна» гээд Олег мориныхоо ясыг үзэхийг хүсэж, нөхдийн хамтаар мордон явлаа. Олег, мориныхоо ясны дэргэд ирээд толгойн ясыг гишгэмэгц, тэр яснаас хорт могой гарч ирээд ноёны хөлийг хатгасанд Олег ван хорлогдож нас эцэслэв. Олон даяар уйлан уйтгарлаж, Олег ноёны хүүрийг оршуулав» гэжээ.

Энэ домог үнэн түүхт явдал уу гэж асуувал хариулах нь: Олег гэж Оросын нэг ван есдүгээр зууны эцэс, аравдугаар зууны эхэн үед байсан юм. Гэвч түүний үхсэний тухай домог нь үнэн түүхт явдал биш, ерийн домог үг бололтой. Ийм домог газар газар явдаг мэт. Жишээлбэл: Скандинавын нэг үлгэрт гарсан нь: Орвар Одда гэдэг баатар эрд нэг удганы хэлсэн нь:

«Орвар Одда чи гурван зуун жил жаргалтай сайхан суух бөгөөд түүний хойно Факса гэдэг мориноосоо болж үхнэ» гэжээ. Орвар Одда морио алуулаад балчиг намагт хаяулж, дээр нь овоо босгуулжээ. Үүнээс хойш Орвар Одда дайн байлдаан хийж, их нэр алдаршиж, Орос газраас эхнэр аваад гурван зуун жилийн хойно буцав.

Энэ завсар Скандинав газар их хувилал болж, урьдын цэцэг ногоо дэлгэрсэн газар, хуурай хувхай цөл болж, Факса морийг хаясан балчиг намаг хуурай болж, овоолсон овоо нь нурж үгүй болоод морины толгойн яс цухуйн байжээ.

93 “Орчуулах Эрдэм-2”, УБ, 1972, 58-90 тал

Орвар Одда тэр газар ирээд морины толгойн ясыг жадаар хатгаж, Энэ Факса морины толгой юу? гэж хэлмэгц тэр яснаас нэг гүрвэл гарч ирээд баатрын хөлийг хазсанд үүнээс болж Орвар Одда үхэв гэжээ. Олег Орвар хоёрын үхсэн тухай өгүүлсэн нь ерийн хэсэж явдаг домог үг мөн гэж одоогийн эрдэмтэн хэлдэг байна.

Энэ хэдийгээр домог боловч эр хүн морио нөхөр мэт санаж, морио хайрлаж морь нь үхэвч түүний ясыг үзэхсэн гэх нь монголчуудын заншил ба сэтгэлд ойр юм.

Пушкин энэ домгийг уран сайхнаар шүлэг болгон бичсэн нь гайхамшигт сонирхолтой бөгөөд Холбоот улсад олон нийтээр сонирхон уншаар байгаа тул алдарт зохиолч Пушкиний зохиолыг монгол хэл дээр гаргах явдалд дуслын төдий ч тус больё гэж санаж орчуулав.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Шүлгийг орчуулах гэгч үг утгыг орчуулах төдий биш, түүний найруулгын хэв журам ба уран хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг бүрнээ орчуулах хэрэгтэй. Үүнд урьд орос шүлгийг монголчилж байсан туршлагагүй. Саянаас манай Монголын Нацагдорж зэргийн зарим шүлэгч нар Пушкиний шүлгээс бага сага орчуулсан ба буриад халимаг зэргийн монгол үндэстэн Пушкиний шүлгийг нилээд орчуулж байна. Гэвч дууриал болох сайн орчуулга ер ховор бөгөөд дагаж баримтлах журам гараагүй байна. Иймийн тул эрхбиш орчуулагч шүлэгч бүр янз янзаар туршиж орчуулаад шүүмжлэн хэлэлцэж, харилцан санал онолоо авалцах хэрэгтэй. Яаж орчуулснаа уншигч олны өмнө тайлбарлан гаргаж, заавар сургаалыг хүлээх хэрэгтэй. Ийм болбол сая тусыг олж болно. Би ийм санаатайгаар Пушкиний «Олег цэцний дуулал» гэдэг шүлгийг туршлага болгон орчуулсан тул одоо яаж орчуулснаа товч төдий тайлбарлан гаргаад олны шүүмжлэн хэлэлцэж, зааварлан сургахад бэлтгэе.

Нэгдүгээр бадгийг авч, орос эх, монгол орчуулга хоёрыг хянан нийлүүлэхэд мэдэцтэй болгохыг бодож, орос эхийн үг бүрд дугаар тавиад тэр үг нь монгол хэл дээр ямар үгээр орчуулагдаж, шүлгийн дотор хаана орсныг илэрхийлэхийн тулд мөн монгол үгийн дор зохих дугаарыг тавьж хойно сийрүүлэв.

НЭГДҮГЭЭР БАДАГ

Как₁ ныне₂ сбирается₃ вещей₄ Олег₅

Отмстить₆ неразумным₇ хозарам₈

Их₉ села₁₀ и₁₁ нивы₁₂ за₁₃ буйный₁₄ набег₁₅

Обрек₁₆ он₁₇ мечам₁₈ и₁₉ пожаром₂₀

С₂₁ дружиной₂₂ своей₂₃ в₂₄ цареградской₂₅ броне₂₆

Князы₂₇ по₂₈ полю₂₉ едет₃₀ на₃₁ верном₃₂ коне₃₃

НЭГДҮГЭЭР БАДГИЙН ОРЧУУЛГА

Олег_{5 17} цэцэн₄ ноён₂₇Олон₂₂ баатар₂₂ аа₂₃ дагуулан₂₁Тэнэг₇ муусайн₇ хозарын₈Тэрслэн₁₄ дайрсны₁₅ хариуд₁₃Гал₂₀ мэсийн₁₈ аюулаар_{18 20}Газар₁₂ орныг₁₀ нь₉ сүйтгэж₁₆Өшөө₆ хорслоо₆ авахыг₆Өнөө₂ завдан₃ бэлтгэж₃Хааны₂₅ хотод₂₅ хийсэн₂₅Хатан₂₅ хуягаа₂₆ өмсөж₂₄Хүлэг₃₂ морь₃₃ ио₃₂ унаад₃₁Хөдөө₂₉ тйшээ₂₈ явлаа₃₀

Ийнхүү эх орчуулга хоёрыг харшуулан үзсэнээс илэрсэн зүйлүүд гэвэл: Пушкиний «Олег цэцний дуулал» гэдэг шүлгийн эхний бадагт гурван санал буюу гурван өгүүлбэр байна. Үүнийг товчлон орчуулбал, анхдугаарт, Олег цэцэн одоо бэлтгэж байна. (Юунд бэлтгэж байна вэ гээд) хоёрдугаарт, тэнэг хозарыг дайран довтолсны хариуд өшөөгөө авахын тулд тэдний тосгон ба тариаланг аюулт илд ба түймэрт эрсдүүлэхээр тэр шийджээ. Гуравдугаарт, тэр ван ноён, олон баатраа дагуулж, хааны хотод хийсэн хуягийг өмсөж, итгэлт морио унаж, хөдөө талд явна. Энэ гурван өгүүлбэрийг монгол хэлэн дээр гурван өгүүлбэр хэвээр нь орчуулсангүй, гурван өгүүлбэрийн үг утгыг авч нийлүүлээд нэг өгүүлбэр болгож орчуулав. Миний бодоход энэ нэг бадаг хэдийгээр орос хэлэн дээр өгүүлбэрийн талаар үзэхэд гурван боловч утгын талаар үзэхэд хоорондоо маш гүн холбогдсон тул нэг өгүүлбэр болгон орчуулахад болох мэт. Нэгэнт гурван өгүүлбэрийг хавсаргаж, нэг өгүүлбэр болгосон тул гурван өгүүлбэрийн толгойлсон үг монгол орчуулгын тэргүүн мөрт цуглажээ. Орос эх дээр бол тийм биш, өгүүлбэрийг толгойлсон Олег, он, князь гэдэг гурван үг хоорондоо хол хол бөгөөд тус тусын өгүүлбэрийг толгойлон байна. Мөн үгийн дэс дараа нь их л хутгалдаж, орос бадгийн тэргүүн мөрөнд байгаа Ныне сбирается гэдэг үг монгол хэл дээр «Өнөө завдан бэлтгэж» гэдэг үгсээр орчуулагдаж, наймдугаар мөрт оржээ. Хэдийгээр үүнд гурван өгүүлбэрийг нэг болгосон боловч үүнийг ямагт ёс болгон баримталсангүй. Ер нь хэдэн өгүүлбэрийг нэгтгэхгүй, нэг өгүүлбэрийг нэг өгүүлбэр хэвээр нь орчуулахыг хичээж байсан билээ. Жишээлж үзээлбэл дөрөвдүгээр бадаг байна.

Дөрөвдүгээр бадгийг яаж орчуулснаа сийрүүлбэл:

Волхвы не боялся могучих владык

Эзэд ноёдыг хүчтэй гэж эрхэм мэргэд айхгүй.

А княжский дар им не нужен:

Хаад ноёдыг юмтай гэж хайр шанг авахгүй

Правдив и свободен их вещий язык,

И с волей небесною дружен

Тэдний хэл нь цэцэн тэнгэрийн таалалд нийлнэ.

Хэлдэг үг нь үнэн, хэний ч өмнө мятрахгүй.

Грядущие годы таятся во мгле; но

Хожим болох явдлууд, холын мананд бүрэлзэвч

Вижу твой жребий на светлом челе

Магад болох заяаг чинь, магнай дээр чинь харж байна.

Үүнээс үзэхэд энд хэдэн өгүүлбэрийг нэгтгэсэн зүйлгүй, харин нэг өгүүлбэрийг хоёр болгож, тасалсан зүйл байна. Правдив и свободен их вещий язык, и с волей небесною дружен гэдэг нэг өгүүлбэрийг «Тэдний хэл нь цэцэн тэнгэрийн таалалд нийлнэ. Хэлдэг үг нь үнэн, хэний ч өмнө мятрахгүй» гэж хоёр өгүүлбэр болгож орчуулжээ. Орос өгүүлбэрийн их вещий язык (тэдний цэцэн буюу зөнч хэл) гэдэг үгийг «Тэдний хэл нь цэцэн ... хэлдэг үг нь ...» гэж хэдэн үгээр орчуулж, хоёр өгүүлбэрт хуваан оруулав. Бас свободен гэдэг ганц үгийг ялгаж аваад орчуулбал «чөлөөтэй» гэдэг үг болно. Гэвч ингэж орчуулж болохгүй. Учир нь свободен гэдэг үг бол өгүүлбэрийн дотор орж, бусад үгтэй утгын талаар холбогдсон байна. «Хэл нь чөлөөтэй» гэсний утгыг хэлбэл, хэний ч дэргэд, хаа ч ямар дуртай үгээ айх ичих юмгүйгээр хэлдэг гэсэн утгатай тул «хэний ч өмнө мятрахгүй» гэж хэд хэдэн үг болгож оруулсан, үүний дотор «чөлөөтэй» гэдэг үг хэдийгээр ороогүй боловч «чөлөөтэй» гэдэг үгний утга багтсан тул би ингэж орчуулснаа зөв гэж санаж байна. Зарим орчуулагчид ба ялангуяа хянан засварлагчид орчуулах хянахдаа эх бичиг, орчуулга хоёрын утгыг харьцуулан үзэхгүй, харин оросын ийм үгийг монголын ямар үгээр орчуулав гэж юуны өмнө нэг нэг үгийг тулган үзэх заншил бий. Үүнийг буруушаавал зохино. Хэрэв тэгж тулгаж үзвэл энэ орчуулгын дотор тохирохгүй зүйл гарна. Дээр сийрүүлсэн дөрөвдүгээр бадгийн эцсийн өгүүлэлд байгаа грядущие годы гэдэг үгийг «хожим болох явдлууд» гэж орчуулсан билээ. Хэрэв үгчлэн орчуулах болж гэм «ирж яваа жилүүд» гэвэл зохино. Гэтэл «жилүүд» гэж үгчлэн орчуулснаас «явдлууд» гэж утгачлан орчуулбал дээр мэт санагдана.

Верный конь гэдгийг «хүлэг морио» гэж орчуулсан нь хөнгөн мөчдөөр үзэхэд утга нь нийлэлцэхгүй мэт боловч сайн бодвол харин утга нь нийлэх мэт. Верный гэдэг үгийг энэ удаа надежный гэдэг утгатайгаар хэрэглэсэн болов уу гэх тул итгэж болох бат сайн

морь гэсэн утгатай бизээ. Монголын хүлэг морь гэдэг нь даруй бат сайн морь гэсэнтэй ойр утгатай бөгөөд бас «оо» гэдэг дагаврыг анхаарах хэрэгтэй. «Оо» гэдэг дагаврыг аливаа үгэнд нэмбэл өмнөх үгэнд «өөрийн» гэдэг утгыг нэмнэ. Жишээлбэл: «Ахаа хүлээв» гэсэн өгүүлбэр бол «өөрийн ахыг хүлээв» гэсэнтэй адил юм. Тиймийн тул «хүлэг морио» гэсэн нь «өөрийн сайн морийг» гэсэнтэй ойр утгатай учир оросын верный конь гэхийг «хүлэг морио» гэж орчуулж болох болов уу гэж санана.

Нэгдүгээр бадгийн отмстит гэдэг нэг үгийг «өшөө хорслоо авах» гэж гурван үгээр орчуулав. Аргагүй болохдоо ингэж нэр үгийг хэдэн үгээр орчуулсан удаа нилээд бий.

Цареградская броня гэдэг хоёр үг нь монгол хэлэн дээр «хааны хотод хийсэн хатан хуяг» гэсэн таван үг болов. Ер орон улс ба хот балгадын нэрийг орчуулдаг заншилгүй билээ. Цареград гэдэг нь хотын нэр байтал үүнийг юунд орчуулав гэж зарим хүн намайг зэмлэх болзошгүй. Үүнд хоёр зүйлийн хариу бий.

Нэгдүгээр хариу нь: Цареградская броня- Цареградын хуяг гэхэд орос хүнд уг хуягийн сайн сайхан чанар нь даруй мэдэгдэнэ. Учир нь одоогийн Стамбул буюу Константинополь хот эртнээс их соёл боловсролын төв газар байсан учраас тэр хотод хийсэн юм гэхэд даруй түүний сайн сайхан чанар нь мэдэгдэх бий. Манайхны Бээжинд хийлгэсэн юм гэдэгтэй адил. Гэтэл манай монголчууд Цареград гэдэг нэрийг мэдэхгүй тул Цареградын хуяг гэхэд түүний сайн сайхан чанар нь мэдэгдэхгүй бүрхэгдэхэд хүрнэ. Хааны хотод гэсэн нь үгчилсэн орчуулга боловч их төв хот гэж монгол хүнд мэдэгдэх тул ийнхүү орчуулж утгыг тодорхой болгох ба хуягийн сайн чанарыг илт болгохын тулд «хийсэн хатан» гэдэг хоёр үгийг нэмж «хааны хотод хийсэн хатан хуяг» гэж орчуулсан учир тэр билээ.

Хоёрдугаар хариу нь: Аливаа газар орны нэрст орчуулагдах эсэх хоёр зүйл байдаг бололтой. Кавказ, Алтайн уулс хэл бүрд адил нэрлэгдэх байтал Хар далай ба Улаан далай хэл бүрд орчуулагдана. Үүнээс үзвэл зарим газар орны нэр орчуулагдах ба зарим нь орчуулагдахгүй байна. Цареград гэдэг үг үүний алинд багтах вэ гэвэл, Цареград гэдэг нь Константинополь хотын язгуурын нэр биш, түүнийг ингэж хуучин орос улс нэрлэдэг байжээ. Энэ үг даруй грек хэлнээс орчуулсан үг болно. Константин гэж нэг хаан байсан Поль гэж грек хэлээр хот гэсэн үг юм.

Үүнийг оросууд орчуулж Цареград гэжээ. Оросууд нэгэнт орчуулан авсан нэр тул монгол хэл дээр бас Цареград гэдэг нэрийг уламжлан орчуулахад үл болох газаргүй мэт.

Уг эхэд байхгүй үгийг орчуулахдаа хааяа нэмсэн удаа бий гэж дээр илтгэн гаргасан билээ. Жишээлбэл: броня-хуяг гэдэг үгийг «хатан хуяг» гэж орчуулж, «хатан» гэдэг үгийг нэмсэн юм. Ингэж ганц хоёр үг нэмсэн төдийгөөр барахгүй, бас зарим тэмдэг үгсийг хаясан ч удаа хааяа бий. Дээр иш татсан дөрөвдүгээр бадгийн эцсийн мөрт байгаа светлое чело гэдэг үгийг монголоор орчуулбал «гэгээн магнай» гэсэн үг байтал «магнай» гэж орчуулж «гэгээн» гэдэг үгийг орхив. Энэ үгийг хэрэггүй гэж санаж зориуд хаясан биш, мөрийн хэмжээг тэгшитгэж, шүлэг болгох, толгой холбох зэрэгт аргагүй хавчигдаж «гэгээн» гэдэг

үгийг орхисон. Гол утгад гэм болохгүй тэмдэг үг зэргийг нэмсэн хассан зүйл хааяа байвч дүндээ гол утгыг хазайлгасан зүйл үгүй болов уу гэж горьдно.

Миний санахад, үгийг нэмж хасах гайгүй хэрэг. Утгыг нэмж хасвал гэмтэй хэрэг. Үг ба өгүүлбэрт халдаж болно. Гол утгад халдаж болохгүй. «Мэргэд гарахын орон» гэдэг дохионы бичгийн шинэ хуучин дохионы бүлэгт өгүүлсэн нь номыг орчуулахад «үгэнд үл итгэнэ. Утганд итгэхийн үүднээс сайтар мэдэн оролдоно» гэжээ. Энэ нь даруй үгийг яг баримтлахгүй, утга санааг баримталж орчуул гэсэн заавар мөн бизээ.

Манай монголчууд эртнээс гадаад хэлнээс ном бичиг орчуулах хэрэгт ихээхэн санаа тавьж хүчин гаргаж явсан түүхтэй тул мөн энэ хэрэгт олсон туршлага бий юм. Энэ олсон туршлагаас одоо цагт тустайг шүүрдэн авах нь бидний үүрэг болно. Дээрх дохионы бичигт хэлсэн хэдэн үг бол даруй манай эрт дээд үеийн гайхамшигт орчуулагч эрдэмтэн нарын олсон сайн туршлага бөгөөд хойч үеийн хүмүүст үлдээсэн зөв сургаал мөн. Утгыг хайхрахгүйгээр үгийг орчуулж болохгүй гэдгийг хэн бүхэн мэдсээр хэрэг. Аливаа үг бол өгүүлбэрийн дунд орохдоо сая утгатай болж амь орох тул үгийн утгыг гагцхүү өгүүлбэрийн дотроос мэдэж болно. Орос монгол хэлний найруулга харилцан тэс ондоо болоод нэг өгүүлбэрийг нэг өгүүлбэрээр орчуулж болохгүй учир олон тохиолдоно. Мөн тэрчлэн нэг үгийг ямагт нэг үгээр орчуулахад их л бэрхтэй, хэд хэдэн үгийг хэрэглэх ба зарим үгийг ондоо үгээр орчуулах ч учир гарна. Гагцхүү утгыг алдахгүйг хичээх хэрэгтэй. Нэг талаас үгийг хэтэрхий баримталбал утгыг алдана. Бас нөгөө талаас үгийг хайхрахгүй ахул уг эхээс хэтэрхий холдож орчуулга гэж таньшгүй болно. Хэрэв үгийг огт хайхрахгүй зөвхөн ерөнхий утгыг авч монголчилбол үнэндээ орчуулга биш, харин Пушкиний шүлгийн ерөнхий утга сэдвийг авч, монгол хэлэн дээр зохиосон өөр шүлэг болоход хүрч болно. «Олег цэцний дуулал»-ыг монголчлоход надад ийм санаа огт байгаагүй. Би чухамхүү орчуулъя гэсэн зорилготой байсан. Үгийг харгалзаж, утгыг орчуулъя гэж оролдсон билээ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Одоо Олег цэцний дууллын хэв журмыг яаж орчуулав гэдэг асуултыг хариулахыг оролдъя. Орчуулж эхлэхтэй хамт монголын ямар шүлгээр орчуулах билээ гэдэг асуулт тулгаран ирэв. Үүнийг шийдэхийн тулд нэгэнтээгүүр орос эх шүлгийг хянан үзэх хэрэгтэйгээс гадна нөгөөтээгүүр монгол шүлгийн журмыг хянан үзэж тохирохы нь шилж олох хэрэгтэй байсан. Олег цэцний дуулал бол бүгд арван долоон бадаг бөгөөд бадаг бүр зургаан мөртэй. Мөрийн дотор өргөлтөт эгшиг ба өргөлтгүй эгшиг сольцолдон явна. Гэвч тэгш тоотойгоор сольцолдох биш, нэг өргөлтөт эгшгийн өмнө нэг өргөлтгүй эгшиг угтах ба нөгөө өргөлтгүй эгшиг хойно нь дагана. Үүнд жишээ болгож «Олег цэцний дуулал»-ын хоёрдугаар бадгийг авч үзье. Өргөлтөт эгшгийг $\cup$ тэмдгээр, өргөлтгүй эгшгийг $\vee$ ийм тэмдгээр тэмдэглэе.

“Орчуулгазүй” Эрдэм шинжилгээний цуврал 2014, №03

угтвар в, с, на гэх мэтийг ихэнхдээ монгол хэл дээр тусгай үгээр орчуулахаас өөр аргагүй. На верном коне едет гэдгийг «Хүлэг морио унаад явна», в броне гэхийг «хуягийг өмсөөд» гэж орчуулах мэтээр на, в зэргийн угтварыг «унаад», «өмсөөд» гэх мэтийн хэд хэдэн үетэй тусгай үг болгон орчуулахаас өөр аргагүй. Энэ нь монгол шүлгийн мөрийг улам урт болгох бас нэг зүйлийн нөхцөл болно.

Ийнхүү нэг талаас хөнгөн амархан шүлэг болгохын тулд мөрийг богино болгох хэрэгтэй. Нөгөө талаас утгыг бүрэн бүтэн орчуулахын тул мөрийг урт болгох хэрэгтэй. Энэ хоёр зүйлийн үүргийг яаж гүйцэтгэх вэ гэж бодсоор Пушкиний нэг мөрийг хоёр болгож орчуулъя гэдэг санаа төрөв. Ийм болбол нэг талаас мөр нь богино болж, шүлэг хөнгөн болохоос гадна, нөгөө талаас багтац уужим болж, нэг үгийг хоёр үг болгох, угтварыг үг болгох зэрэгт зай хүрэлцэх болно. Түүнээс гадна, Пушкиний шүлгийг монгол үндэсний хэл дээр хэн яаж орчуулсныг шүүрдэн үзвэл халимагийн шүлэгч Сайнбилэгийн Хасар Пушкиний туульсыг орчуулахдаа нэг мөрийг хоёр мөр болгож гурван үгт шүлгээр орчуулсан байна.

Энэ орчуулгыг хянан үзвэл хааяа осолдсон зүйл байх мэт⁹⁴ боловч ерөнхийдөө сайн орчуулга гэж санагдах тул үүнийг дууриахад үл болох газаргүй бизээ.

Ийм ийм учраас Пушкиний нэг мөрийг хоёр мөр болгохоор шийдээд дараа нь ямар хэмжээтэй шүлгээр орчуулахыг тогтоох болсон үүнд монголын гурван үгт шүлэг бол хөнгөн амархан бөгөөд Олег цэцний дууллыг орчуулахад тохиромжтой мэт санагдав.

Монгол ардын аман зохиолын дууны шүлэг, ихэнхдээ гурван үгт шүлэг байдгаас гадна, одоогийн шүлэгч нар их төлөв гурван үгт шүлгээр бичнэ. Үүнд баримт болгож хэдэн зүйлийн жишээг үзүүлье.

ХАЛХ МОНГОЛЫН ДУУ

Үлэмжийн /чанар/ төгөлдөр

Өнгө /тунамал/ толь шиг

Үзэсгэлэн /царайг чинь/ үзвэл

Өнгө /лагшин/ төгөлдөр

Үнэхээр /сэтгэлийг/ булаана.

Хөшүүн /сэтгэлийг/ уяруулагч

Хөхөө /шувууны/ эгшиг шиг

Хөөрхөн /елдэг/ ааш чинь

94 Жишээлбэл, Алтан тарианы үлгэрийн дотор чиний нэгдүгээр хүслийг хангая гэхийг чиний хүслийг ер нь хангаж байя гэж орчуулжээ.

Хөгжиж /суухад/ урамтай даа.
Уяруун /сэтгэлийг/ уяруулагч
Улаан /лянхуйн/ үнэр шиг
Урьхан /хонгор/ ааш чинь
Улмаар /сэтгэлийг/ хөдөлгөнө.
Бадамын /дундаас/ дэлгэрсэн
Балын /амттай/ адилхан
Баясгалантай /царайг чинь/ үзвэл
Бахдаж /ханашгүй/ сайхан
Баярыг /улмаар/ арвитгамаар даа.
Хүний /энэхэн/ насандаа
Хүссэн /хэргээ/ бүтээгээд
Хүсэлт /тэнгэрийн/ оронд
Хөлгүй /жаргалангийн/ дунд
Хөвөн /цэнгэн/ жаргая.

ТООРОЙ БАНДИ

Тоорой /бандийг/ байхад
Торгоны /сайныг/ өмслөө.
Тоорой /бандиас/ хойш
Тостой /даавуу ч/ олдохгүй.

АРВАН ТАВНЫ САР

Арван /тавны/ сар нь
Агаар /тэнгэрт/ дэнлүү
Арван /тавтай/ Шоожуу нь
Аав /ээждээ/ дэнлүү
Хорин /тавны/ сар нь
Хорвоо /ертөнцөд/ дэнлүү

Хорин / тавтай/ Шоожуу нь

Хоёрхон /биендээ/ дэнлүү.

Цахар Сүрэгийн хошууны Эрэгзэншонуугийн зохиосон монголын хувьсгалын дуу:

Эрдэм /чадлаа/ хөгжүүлээд

Эрх /ашгаа/ хамгаалаад

Эдүгээ /цагийн/ соёлд

Эртхнээ /дэвшин/ орцгооё.

Хошуу /чуулган/ хоорондоо

Холбоо /хэлхээг/ зузаатгаад

Хувьсгалын /цэргийг/ байгуулаад

Хорт /этгээдийг/ устгая.

(Энэ дуу бол 1929 онд Бээжинд байсан монгол сурагчдын хурлын гаргасан дармал «МОНГОЛ» гэдэг сэтгүүлийн гуравдугаарт хэвлэгджээ.)

ДАГУУР МОНГОЛЫН ДУУ

Харуулд /суусан/ олноор

Хаана /амарч/ чадна.

Өдөр /сарын/ удаанд

Үүрд /өөртөө/ гомдоно.

Албан /суусан/ олноороо

Алжаагаад /тэсэж/ ядна.

Дотроо /их л/ мэрсээр⁹⁵

Домог /зүүд/ завхрав.

Мэдэх /санах/ хүчүүгээс⁹⁶

Мэнэрч /эйлж⁹⁷/ ирснээс

Сүнс /ухаан нь/ төөрч

Шөнийн /нойрт/ зүүдэлнэ.

95 уйдсаар

96 нөхөр

97 салж

АЛАЙР БУРИАДЫН ДУУ

Айлшин

Улаан утаһан бэһээ
Уялгы нь нааш нь харуулыт
Уран сээжийн зугаае
Аялгы нь нааш нь харуулыт
Улаан /утсан/ бүсээ
Уялгы нь нааш нь харуулаач
Уран /цээжийн/ зоогоо
Аялгы нь нааш нь харуулаач.

Айлыш

Улаан занъя утаһы мнай
Уялгы нь харахаяа мэдээрэйш
Уран сээжийн зугааяа
Ойлгож харихаяа мэдээрэйш!

Айлынх

Улаан /зангиа/ утсыг маань
Уялгы нь /харахаа/ мэдээрэй
Уран /цээжийн/ зугаагаа
Ойлгож /харахаа/ мэдээрэй!

Айлшин

Хатиргаад ирэхэн харгаяа
Хажуушаа харан таних л бий
Ханьтан таные зугаалһаные
Гэртээ харьж шивших л би.

Айлчин

Хатиргаад /ирсэн/ харгуйгаа
Хажуушаа /харж/ таних би.
Ханьтан /тань/ зугаалсныг
Гэрт /харьж/ шивших л би.

Айлыш

Алаг морины хатирахад
 Амы нь татахдаа урамшина л ди.
 Айлшин таны зугаалахад
 Шагнаж байхдаа урамшина л ди.

Айлынх

Алаг /морины/ хатирахад
 Амы нь /татахдаа/ урамшина.
 Айлчин /таны л/ зугаалахад
 Чагнаж /байхад л/ урамшина.

Олег цэцний орчуулгын шүлэг бол хэв журмын талаар дээр иш татсан дууны шүлгүүдтэй адил болно.

Олег /цэцэн/ ноёнтон
 Олон /баатраа/ дагуулан
 Тэнэг /муусайн/ хозарын
 Тэрслэн /дайрсны/ хариуд
 Гал /мэсийн/ аюулаар
 Газар /орныг нь/ сүйтгэж
 Өшөө /хорслоо/ авахыг
 Өнөө /завдан/ бэлтгэж
 Хааны /хотод/ хийсэн
 Хатан /хуягаа/ өмсөж
 Хүлэг /морио/ унаад
 Хөдөө /тйшээ/ явлаа.

Үүнийг дээрх шүлгүүдтэй жишээлэн үзтүгэй.

«Олег цэцний дуулал»-ыг орчуулахдаа Пушкиний шүлгийн нэг мөрийг хоёр мөр болгосон боловч нөгөөтээгүүр мөрийг мөрөөр орчуулсан гэж хэлж болно. Учир нь монгол орчуулгын хоёр мөрийг нэг мөр болгон бичиж, нэг мөр болгон уншихад харшлах зүйлгүй. Тэгвэл дундаа нэг цэглэлтэй, зургаан үгт шүлэг болж, Нацагдоржийн зохиосон «Миний нутаг» гэдэг шүлэг ба зарим дууны шүлэгтэй адил болно. Зургаан үгт шүлэг болгон бичсэн нь:

Олег /цэцэн/ ноёнтон // олон /баатраа/ дагуулан
Тэнэг /муусайн/ хозарын // тэрслэн /дайрсны/ хариуд
Гал /мэсийн/ аюулаар // газар /орныг нь/ сүйтгэж
Өшөө /хорслоо/ авахыг // өнөө /завдан/ бэлтгэж
Хааны /хотод/ хийсэн // хатан /хуягаа/ өмсөж
Хүлэг /морио/ унаад // хөдөө /тйшээ/ явлаа.

НАЦАГДОРЖИЙН ЗОХИОСОН «МИНИЙ НУТАГ» ГЭДЭГ ШҮЛЭГ

Орхон /Сэлэнгэ/ Хөхүйн // онц /сайхан/ голууд
Уурхай /баялгийн/ охь // олон /уул/ даваанууд
Хуучин /хөшөө/ дурсгал // хот /балгадын/ сууринууд
Холхи /газар/ одсон // харгуй /дардан/ замууд
Энэ бол
Миний /төрсөн/ нутаг //Монголын /сайхан/ орон
Холхи /газраас/ гялалзсан // цаст /өндөр/ хайрхнууд
Хөх /тэнгэр/ цэлмэсэн // хөдөө /хээр/ цайдмууд
Холын /бараа/ харагдсан // ноён /шовх/ сардигууд
Хүний /сэтгэл/ тэнийсэн // уудам /амьсгалт/ талууд
Энэ бол
Миний /төрсөн/ нутаг //Монголын /сайхан/ орон

ХАЛХ МОНГОЛЫН ДУУ

Агт /морины/ сайныг // унаж /байж/ таних
Ах /дүүгийн/ сайныг // ханилж /байж/ таних
Хурдан /морио/ унавал // хол /газар/ ойрхон
Хортон /дайсныг/ дарвал // хол /ойр/ амар
Зүдэр /сэнхэн/ моринд // зүлгийн /ногоо/ хол
Зөрүү /хөшүүн/ хүнд // нөхөр /хань/ хол
Алт /мөнгөний/ сайхныг // арчин /байж/ таних

Аав /ээжийн/ сургаалыг // чагнаж /байж/ сонсох

Хайр /чулуу/ хагарвал // хавсрах нь /бэрх/ бий

Хайран /амиа/ алдвал // төрөх нь /бэрх/ бий.

(Позднеев «Народные песни монголов» гэдэг дэвтрийн тав дахь талд үз)

Эдгээр шүлгийг хянан үзвэл, зөвхөн толгойг холбосон талаар бага сага ялгавар бий боловч бусад үгний тоо ба журмын талаар нэг адил болно.

Зургаан үгт шүлэг, гурван үгт шүлэг гэхэд зарим хүн гайхаж болно. Олег цэцний орчуулгын мөр бүрд гурван үг байгаа гэхэд тохирохгүй мэт санагдаж болно. Жишээлбэл: мөн орчуулгын дөрөвдүгээр бадагт:

Магад болох заяаг чинь

Магнай дээр чинь харж байна

гэсэн хоёр мөр бий.

Энэ хоёр мөрний эхний мөрөнд дөрвөн үг, хоёрдугаар мөрөнд таван үг орсон мэт боловч үнэндээ тийм биш. Мөр бүрд гурваад үг бий гэж хэлж болно. Аливаа тусгай үгийн шинж нь уншихад бусад үгтэй хамтрахгүй бөгөөд өргөлтөт эгшигтэй байна. Гэтэл «чинь», «гүй» гэх мэт үг бусад үгийг дагалдан орохдоо өргөлтөт эгшгээ гэж, өмнөх үгтэй хамтад дуудагдана. Чиний аав сайн хүн. Үгүй юмыг олоход бэрх гэдэг өгүүлбэрт «чиний», «үгүй» гэдэг үгийг өргөлтөт эгшигтэй тусгай үг болгон дуудах байтал аав чинь, авахгүй гэдэг үгийг аав чинь авахгүй гэж уншина. Ирнэ, орхино гэх мэт үйл үг, бусад үйл үгийн хойно туслах үйл үг болж орохдоо бас өргөлтөт эгшгээ гэж өмнөх үйл үгтэй хамт дуудагдана. Авч ирнэ, явж орхино гэдэг үг тус тус нийлэлдэж, авчирна, явжирхэнэ, явчихна, явчина гэх мэтээр хураамжлагдан нэг үг болсон мэт буй. Иймийн тулд дээрх хоёр мөрийг унших аялгуу нь

Магад болох заяаг чинь

Магнай дээр чинь харж байна

Үүний мөр бүрд гурван үг бий гэж хэлж болох бизээ.

Дээр иш татсан «Үлэмжийн чанар» гэдэг дуу ба Олег цэцний орчуулга зэргийн шүлгийг гурван үгт шүлэг гэж нэрлэж байгаа боловч, гурван өргөлтөт шүлэг гэж нэрлэж болно. Учир нь, монголын үг бүрд нэг өргөлтөт эгшиг бий тул шүлгийн нэг мөрт хичнээн үг байвал төчнөөн өргөлтөт эгшиг байна. Үүн дээрээс шүлэгт, өргөлтөт эгшгийн тоог тэгшитгэх, үгийн тоог тэгшитгэх гэсэн хоёр үг, дүндээ очиж, нэг утгатай үгс болно. Аливаа шүлэгт эгшиг маш чухал болон холбогдоно. Шүлэг бол эгшиг дуун дээр үндэслэн зохиогддог гэж хэлж болох тулд аливаа шүлгийг хянан үзэхэд юуны урьд эгшгүүдийг анхааран үзвэл зохино. Олег цэцний дууллыг орчуулахдаа эгшгийг яаж хэрэглэснээ илтгэхийн тул, мөн дууллаас хоёр бадгийг авч үзье.

Урт эгшгийг - ийм, балархай эгшиг ∪ ийм, өргөлтөт эгшгийг v ийм тэмдгээр тус тус тэмдэглэе.

Нэгдүгээр бадгаас авсан дөрвөн мөр:

V V - V - -

Гал мэсийн аюулаар

V ∪ V - V ∪

Газар орны нь сүйтгэж

V - V ∪ - V ∪ -

Өшөө хорсголоо авахыг

V - V ∪ V ∪

Өнөө завдан бэлтгэж

Үүнээс зургийг тусгай авч сийрүүлбэл:

V / V - / V - -

V ∪ / V - / V ∪

V - / V ∪ - / V ∪ -

V - / V ∪ / V ∪

Арван долдугаар бадгаас авсан дөрвөн мөр:

V

V - - V ∪

Хэзээ яаж байлдсан

V

V - - V ∪

Хэнтэй яаж тулсан

V ∪ ∪ V - V ∪

Өнгөрсөн явдлаа дурдаж

V - V - V - ∪

Өнийн юмыг ярьцгаана.

Үүнээс зөвхөн зургийг авч сийрүүлбэл:

V - / V / V ∪

V - / V / V ∪

V ∪ ∪ / V - / V ∪

V - / V - / V - ∪

Энэ шүлгийн зургийг дээр гаргасан Пушкиний шүлгийн зурагтай нийлүүлэн үзвэл Пушкиний шүлэгт өргөлтөт эгшгүүд нь өмнө хойно нижгээд өргөлтгүй эгшгийг дагуулан явах журамтай байтал монгол орчуулгад тийм биш болсноор үл барам, өргөлтөт эгшгийг дагах өргөлтгүй эгшиг өдий төдий байна гэх тогтворгүй нэг өргөлтөт эгшгийг заримдаа гурав дөрвөн өргөлтгүй эгшиг дагах ба заримдаа өргөлтөт эгшиг гав ганцаар байна.

Гэвч үүгээр баримт болгож шүлгийн чанарыг муудуулав гэх буюу муугаар орчуулав гэж хэлж болохгүй. Учир нь юу гэвэл: Энэ нь даруй монгол хэлний тусгай шинж ба монгол шүлгийн тусгай шинжээс болсон хэрэг юм. Пушкиний шүлгийн мөр нь өргөлтгүй эгшгээр эхэлж өргөлттэй эгшгийн өмнө өргөлтгүй эгшиг угтан явна.

Монгол үгийн өргөлт нь үгийн нь эхний үед тогтмол байдаг тул өргөлтгүй эгшгээр мөрийг эхлэх арга огтгүй ба өргөлтөт эгшгийг өргөлтгүй эгшгээр угуулах арга мөн огтгүй юм. Пушкиний шүлэгт өргөлттэй ба өргөлтгүй эгшиг журамтайгаар ээлжлэн явна. Монгол үгийн өргөлтгүй эгшиг нь балархай бөгөөд заримдаа бий болох, заримдаа үгүй болох зэргээр маш тогтворгүй тул шүлэгт тусгай биеэ даасан юм болгон авч хэрэглэхэд амаргүй. Бий, үгүй хоёрын хоорондох юмыг биелүүлэн хэрэглэх гэдэг ер нь бэрхтэй. Орос үгэнд хэдэн эгшиг байгаа нь хэлэхэд даруй мэдэгдэх бөгөөд үсгээр тэмдэглэгдэх тул орос бичгийг харж нэг үгэнд хэдэн эгшиг байгааг мэдэж болно. Гэтэл монгол бичгийг харж нэг үгэнд хэдэн эгшиг байгааг тодорхойлж үл болно. Орос хэлний үг нь урт бол урт, богино бол богино, түүнийг тайрч богинотогх ба сунгаж уртатгаж болшгүй. Гэтэл манай монголын үг бол балархай эгшгээ тод болгоод урт болж чадна. Балархай эгшгээ хаяад богино болж чадна. Байлдсан гэдэг үгийг байлдсан, байлдсн гэх мэтээр балархай эгшгийг орхиж богино болгон дуудаж болно. Өнгөрсөн гэдэг үгийг өнгөрсөн буюу өнгрсөн, өнгрсн гэж богиносгож болно. Эсвэл өнгөрөсөн гэж дөрвөн эгшигтэйгээр уншиж болно. Эхний ө эгшгийг тод хэлээд дараах эгшгүүдийг байгаа, үгүй хоёрын хооронд балархайгаар дуудаж уншина. Ийнхүү урт богино болгон уншсанаас утга нь хувилахгүй. Яаж унших нь уншигчдын дур болно. Монгол үг нь сунах, агших чадалтай байтал бичдэг дүрэм нь сунах, агших чадалгүй нэг тогтмол заншлыг баримтлаж бичнэ. Ер нь бичдэг дүрмийг сунах, агших чадалтайгаар тогтоож болохгүй билээ. Иймийн тул монгол шүлгийг үсэгчлэн уншиж цаасан дээр ямар үсгүүдээр яаж тэмдэглэснийг баримталж тийм ийм гэж хэлэхэд маш бэрхтэй. Гагцхүү зөвөөр уншихыг чагнаж шинжлэн хянаж болно. Одоогийн зарим хүний шүлэг уншихыг сонсвол мөрийн доторхи богино үгийг урт болгож урт үгийг богино болгож уншаад шүлгийн хэмжээг тохируулна.

Шүлгийн үг бүрийг хэлэхэд, хэрэглэх цагийг адил болгохыг хичээнэ. Шүлгийг эрхбиш жаахан аялуулан унших тул үгийг ингэж урт богино болгоход амархан байна. Урьд цагт монголд зүгээр уншихаар зохиосон шүлэг бараг байгаагүй. Гагцхүү аялуулан дуулахаар зохиосон дууны шүлэг байсан юм. Үлгэр ба ерөөлийн шүлгийг боловч мөн аялуулан хэлдэг байсан. Одоо цагт зөвхөн уншихаар зохиосон шүлэг дэлгэрч байгаа. Үүнд, унших маяг нь урьдын аялуулан дуулах маягаас бүрэн ангижраагүй бололтой урьд дурдсан ёсоор монгол

үгний балархай эгшиг төдий л тогтвортой юм биш тул дээр нэгдүгээр, арван долдугаар хоёр бадгаас дөрвөөд мөрийг авч хэдэн эгшиг байгаа зэргийг дурсан нь даруй бараглаж бүдүүвчилсэн тэмдэглэл юм. Монгол үгний тогтвортой бат эгшиг нь үгийн эхний өргөлттэй эгшиг мөн. Энэ эгшиг бол шүлгийн гол багана, үндсэн тулгуур мэт тул би Олег цэцний дууллыг орчуулахдаа энэ өргөлттөт эгшигийг гол болгон баримтлаж, энэ өргөлттөт эгшигийг тэгшитгэн хэрэглэсэн билээ. Олег цэцний орчуулгын мөр бүхэнд гурван үг бий, гурван өргөлттөт эгшиг бий. Хэрэв бичсэн үсгийг баримталж шүүмжлэх бол өргөлттөт эгшиг нь нэг буюу хэдэн өргөлтгүй эгшигийг хойноосоо дагуулан явна. Энэ дагуулах өргөлтгүй эгшигийн тоо тогтворгүй, нэгээс гурав, дөрөв хүртэл байна. Хааяа өргөлттөт эгшиг нь дагалтгүй ганцаараа байна.

Нэгдүгээр бадагт:

«Гал мэсний аюулаар
Газар орны нь сүйтгэж»

гэсний гал гэдэг үг, өргөлтгүй эгшиггүй бөгөөд ганцхан өргөлттөт эгшиг байна.

Тавдугаар бадагт:

«Зол заяа хоёрт чинь
Зовхисын дайсан атаархана»

Зургадугаар бадагт:

«Салхи шуурга үймж
Сандрах цаг боловч»

гэсний «зол», «цаг» гэдэг үгсийн өргөлттөт эгшгүүд ганцаараа байна. Урт бөгөөд өргөлттөт эгшгийн ганцаараа орсон нь:

Наймдугаар бадагт:

«Нүүр царай нь барайн
Нүдний харц хувилан»

Арван гуравдугаар бадагт:

«Уул морио хэвээр
Унасан болоосой гээд»

Ганц өргөлттөт эгшигийг ингэж дангаар хэрэглэсэн нь гагцхүү миний энэ орчуулгад байгаа юм биш, ардын аман зохиолын шүлэг ба монгол шүлэгч нарын зохиолд өдий төдий бий.

«Позднеев. Народные песни монголов» гэдэг номын 12 дугаар талд ардын аман зохиолоос авсан нэгэн шүлэг бий. Тэр нь:

«Хөвчийн өндөр модонд

Хөхөө шувуу донгодно.

Хөөрхий авгайн гадаа нь

Эд мал нь цугларна»

Үүний дөрөвдүгээр мөрт өргөлтөт эгшиг хоёр дараагаар ганцаар байна.

Олег цэцний дууллыг орчуулахдаа ганц өргөлтөт эгшгийг дангаар мөрийн эх ба дунд оруулснаас биш, мөрийн эцэст оруулсан зүйлгүй.

Харин мөрийн эцэст аль болохоор олон үет үг хэрэглэхийг хичээж ялангуяа өргөлтөт эгшгийн дараа урт эгшигтэй үг хэрэглэхийг оролсон билээ.

Үүнд нэгэн учир бий, эрдэмтэн Владимирцовын хэлсэн нь: Олон үет үгсийн эцэст хоёрдугаар зэргийн өргөлт байх ба ялангуяа олон үет бөгөөд урт эгшиг орсон үгсийн урт эгшиг хоёрдугаар зэргийн өргөлт байна.

Улаан тугийг мандуулаад

Улсын сүрийг бадруулаад

Уравсан хулгай Найдан ванг

Уухай хийгээд дайрав хөө

гэсэн энэ дөрвөн мөрийн эцсийн эгшгүүдэд хоёрдугаар зэргийн өргөлт бий гэжээ. (Владимирцовын зохиосон монгол хэлний зүйн 36 дугаар зүйлд бий).

Жич, монгол хэлэнд өгүүллийн эцэс, тасалбар буюу цэг тавих газарт дуу жаахан чангарах мэт сонсогдоно.

Миний хичээн оролдсон нь нэг талаас мөрийн эцэст олон үет бөгөөд урт эгшигтэй үгийг хэрэглээд хоёрдугаар зэргийн өргөлтийг бий болгож нөгөө талаас мөрийг цэглэлээр төгсөөд цэглэх газрын өргөлт бий болгож, энэ хоёр дутмаг өргөлтийг нэг дор тохиолдуулан шүлгийн мөрийн жинхэнэ гурван өргөлтийн дээр, нэг зүйлийн өргөлтийг нэмэх гэсэн билээ. Хэрэв үүнийг шүлгийн өргөлтөт эгшгийн тоонд тооцох бол чухамхүү мөр бүр нь дөрвөн өргөлттэй болно. Пушкиний шүлгийн зарим мөр нь дөрвөн өргөлттэй, зарим мөр нь гурван өргөлттэй байхад монгол орчуулгын мөр бүр нь гурав буюу дөрөв шахам өргөлтөт эгшигтэй тул, өргөлтөт эгшгийн хэмжээний талаар эх ба орчуулга харилцан ойрхон болсон гэж хэлж болно.

Одоо урт эгшгийг ямар журамтайгаар хэрэглэв гэдэг асуултыг тавья. Урт эгшгийг зарим мөрд хэд хэдээр хэрэглэсэн ба зарим мөрд огт хэрэглээгүй. Жишээлбэл:

Гуравдугаар бадгийн тэргүүн мөр нь:

«Богд тэнгэрт итгэлтэн»

Арван гуравдугаар бадгийн тэргүүн мөр нь:

«Ачит нөхөр болсон»

Энэ мөрүүдэд урт эгшиггүй байна. Гэтэл эхний бадагт

«Олег цэцэн ноёнтон

Олон баатраа дагуулан»

гэдэг хоёр мөрийн хоёрдугаар мөрд гурван урт эгшиг байна. Үүн дээрээс үзэхэд урт эгшгийн тоог тэгшитгэх буюу ээлжлүүлэх зэргээр хэрэглээгүй нь илэрхий байна. Гэвч урт эгшгийг балархай эгшигтэй адил хайхрамжгүйгээр хэрэглэсэн гэж үл болно. Урт эгшгийг хэрэглэхдээ баримталсан гурван зүйлийн журам бий.

Нэгдүгээр журам нь: Мөрийн дунд өргөлтөт эгшгийн завсарт хоёр урт эгшгийг оруулахыг цээрлэв. Учир нь Владимирцовын хэлсэн ёсоор, олон үет үгийн эцсийн урт эгшигт хоёрдугаар зэргийн өргөлт бий болж гэм энэ хоёрдугаар зэргийн өргөлтөт урт эгшиг нь жинхэнэ өргөлтөт эгшгийг орлон шүлэгт орж болох билээ. Үүнийг ондоо үгээр хэлбэл шүлгийн дотор нэг урт үг нь хоёр үгний ор эзэлж болох бизээ. Миний ажиглахад ийм явдал хааяа байна. Гэвч Олег цэцний дууллын орчуулгад би, энэ хоёрдугаар зэргийн өргөлтөт урт эгшгийг жинхэнэ өргөлтөт эгшгийн оронд төлөөлөн хэрэглэсэн зүйлгүй. Нэг урт үгийг хоёр үгийн оронд хэрэглэсэн зүйлгүй тул үүнийг дэлгэрүүлэн хэлэлцэхийг байя.

Хоёрдугаар журам нь: Мөрийн эцэст өргөлтөт эгшгийн дараа урт эгшгийг оруулж байхыг оролдсон гэж дээр дурдсан үүнд жишээг үзүүлбэл:

Гуравдугаар бадаг:

«Богд тэнгэрт итгэлтэн

Бошигт мэргэн бөөтөн

Айсуй тавиланд автагдаж

Аргагүй болох заяагий минь

Хөршийн дайсныг баярлуулж

Хөдөө булагдах цагий минь

Хэлбэрэх айх юмгүйгээр

Хэлж аль шуудаар

Үнэн бүгдийг илэрхийлж

Үзэж хэлж өгөөд

Хайртай дуртай морийг

Харамж шанд нь аваарай»

Энэ арван хоёр мөрөөс есөн мөрийн эцсийн үгсэд өргөлтөт эгшгийн хойно урт эгшиг бий. Гурван мөрийн эцэст урт эгшиггүй боловч эцсийн эгшгийг өргөлтөт эгшиг болгон уншиж болно.

Гуравдугаар журам нь: Мөрийн дундах урт эгшгийг холбож хэрэглэсэн нь нилээд бий. Энэ нь шүлгийн толгой холбох журамтай адилаар тул үүнийг хэлэлцэхийн урьд толгой холбох ёсыг хэлэх хэрэгтэй.

Пушкиний «Олег цэцний дуулал» гэдэг шүлэг бол монголын шүлэгтэй адил толгой холбосон биш, харин мөрийн эцсийн үеийг холбожээ. Жишээлбэл: Эхний бадагт хоёр мөрийн эцэст нь Олег, набег гэдэг үгээр эцэслэсэн ба нөгөөх хоёр мөр нь: хозарам, пожарам гэдэг үгээр төгсжээ. Пушкиний энэ шүлэг эхнээс аваад адаг хүртэл цөм ийнхүү хоёр мөрийн эцсийн үеийг холбожээ.

Үүнийг яаж монголчлов гэвэл: Монгол шүлгийн журмыг дагаж толгой холбож орчуулав. Эхнээс адаг хүртэл осолдолгүйгээр, зэрэгцэж байгаа хоёр мөрийн толгой холбосон, Жишээ нь:

«Олег цэцэн ноёнтон
Олон баатраа дагуулан
Тэнэг муусайн хозарын
Тэрслэн дайрсны хариуд»

гэх мэт байна. Ингэж толгой холбосон учир юу гэвэл нэгд, Монгол шүлгийн эхний үгсийн толгойг холбох нь тогтсон заншил, үндсэн журам мөн. Хоёрт, монгол шүлэгт мөрийн эцсийг холбохоос толгойг холбох нь илүү чухал.

Толгой холбох ёсыг осолдолгүй хэрэглэснээс гадна, мөрийн дундах ба эцсийн үеийг аль болохоор холбов. Мөрийн дундах ба эцсийн үеийг холбоход ялангуяа урт үеийг холбовол сайн бөгөөд богино үеийг холбож болох боловч энэ нь шүлгийг уншихад битүүлгээр өнгөрөх байна. Гэвч богино үеийн дотор адилхан гийгүүлэгч дуу хэд байгаа бол нилээд хүч оруулна.

Эхний бадагт:

«Хүлэг морио унаад
Хөдөө тийшээ явав»

Хоёрдугаар бадагт:

«Харгуй замын өмнөөс
Харанхуй шугуй модноос»

Өөс, оос гэдэг дагаврыг өмнөх үгтэй хамтатган урт эгшиг болгож дуудах тул, энэ урт эгшгүүд харилцан тохиолдсон ба харгуй, харанхуй хоёр үгийн эцэс бас харилцан тохирсон байна. Энэ бол чухамдаа мөрийн эхэнд толгой холбохтой адил мөрийн дунд ба эцэст урт

эгшигт үеийг холбосон хэрэг болно. Мөрийн эцэст урт эгшгийг оруулж эс чадвал эцсийн богино үеийг аль болохоор холбосон. Үүнд жишээ болгож долдугаар бадгийг авч үзье. Холбосон эцсийг дөрвөлжин хаалтаар тэмдэглэв.

Хүлэг сайхан морь чинь
Хүчир явдлаас айхгүй
Эзний санааг мэдэж
Эргэх жолоог дагаж
Харвах сумны өмнө ч
Халшралгүй зогсох байна.
Дайн тулааны газар ч
Далдиралгүй давхих байна
Халуун хүйтэнд ажиггүй
Хавтай сайн морь гэвч
Энэ мориноос болж,
Эрхэм бие чинь сүйднэ.

Энэ бадгийг үзвэл зарим мөрийн эцсийг холбосонгүй, заримыг холбожээ. Зэрэгцэж байгаа хоёр мөрийн эцсийг холбосон ч бий. Мөр алгасан эцсийг холбосон ч бий. Нэгэн жигдгүй ба тогтсон журамгүй байна. Учир юу вэ? гэвэл: Мөрийн эхийг хошоодоор бүрэн холбосноос гадна мөрийн дундах урт эгшгийг холбож бас мөрийн эцсийг хошоодоор бүрэн холбох гэвэл гүйцэтгэх маш бэрхтэй болж улмаар шүлгийг гэмтүүлж, сайн болгох гэж оролдсоор харин муу болгож болох тул, мөрийн эцсийг, болох газарт нь холбоод түвэгтэй газарт нь холболгүй орхисон билээ.

Дээрх бадгийн дотор байгаа

« Эзний санааг мэдэж
Эргэх жолоог дагаж»

гэсэн хоёр мөрийн толгой нийлснээс гадна санааг, жолоог гэдэг хоёр үгийн урт эгшиг нийлж бас мэдэж, дагаж гэдэг хоёр үгийн эцэс нийлжээ. Энэ хоёр мөрийн толгой холбосон төдий биш бүхэл бие, судас, шөрмөсийг хүртэл холбож нийлүүлсэн гэвэл зохино.

Харвах сумны өмнө ч
Халшралгүй зогсох байна.
Дайн тулааны газар ч
Далдиралгүй давхих байна.

Энэ дөрвөн мөрийг ажиглавал нэгдүгээр мөр нь, гуравдугаар мөртэй адил, хоёрдугаар мөр нь дөрөвдүгээр мөртэй адил болжээ.

Энэ мөрийн дундах ба эцсийн урт богино эгшигт үеийн холбогдох ёс юунаас гарав? Үндсэн шалтгаан нь юу вэ? гэвэл: Монгол шүлгийн мөрийн эн зэрэгцүүлэх ёс мөн болно.

Эзний санааг мэдэж

Эргэх жолоог дагаж

гэсэн хоёр мөрийг хэлний зүйн талаар үзвэл адилхан зохиогдсон байна. Эхний мөр нь ямар бол хоёрдугаар мөр нь тийм байна. Энэ хоёр мөрийн эхний «эзний», «эргэх» гэдэг хоёр үг «ямар?» гэдэг асуултад хариу болно. Дараах «санааг», «жолоог» гэдэг хоёр үг «юуг?» гэдэг асуултад хариу болно. Эцсийн «мэдэж», «дагаж» гэдэг хоёр үг «яаж?» гэдэг асуултад хариу болно. Бас:

Харвах сумны өмнөөс

Халшралгүй зогсох байна

Дайн тулааны газар ч

Далдиралгүй давхих байна

гэсэн дөрвөн мөрийн эхний хоёр дараах хоёр мөр хоорондоо хэлний зүйн талаар адилаар зохиогджээ. Олег цэцний дууллыг орчуулахдаа монгол шүлгийн эн зэрэгцүүлэх ёсыг өргөн хэрэглэв. Бадаг бүрд эрхбиш эн зэрэгцсэн мөр бий. Зарим бадагт эн зэрэгцсэн мөр бүр ч олон бий. Арван дөрөвдүгээр бадгийн эн зэрэгцсэн мөрүүдийг хянаж үзье. Эн зэрэгцсэн мөрийг дөрвөлжин хаалтаар тэмдэглэв.

Олег цэцэн мордож

Ордноос гаран явахад

{ Игорь ноён тэргүүлэн
Итгэлт зочид дагалдав
Днепр мөрний эрэгт }

{ Дэнж довын хярд
Сайн язгуурт морины
Сайхан яс нь хэвтээд }

{ Хумхийн тоосонд булагдаж
Хурын усанд угаагдаж
{ Сахлаг өвсөнд хучигдаж
Салхи жаварт үлээгдэнэ. }

Эн зэрэгцүүлэх ёс бол монгол шүлгийн тусгай шинж болно. Дээр иш татсан «агт морины сайныг...» гэдэг дуу бол хошоодоор эн зэрэгцсэн мөртэй байна. Үүнд хэлний зүйн талаар асуултыг тавьж үзвэл нэн ч илэрхий болно.

Ямар	Юуны	Ямрыг	Яаж	Яах
Агт	морины	сайныг	унаж байж	таних
Ах	дүүгийн	сайныг	ханилж байж	таних

Ямар	Юуг	Яавал	Юу	Ямар болох
Хурдан	морио	унавал	хол газар	ойрхон
Хортон	дайсныг	дарвал	хол ойр	амар

Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл гэдэг дэвтрийн хоёрдугаарт хэвлэгдсэн «Пионерийн лагерь» гэдэг шүлгээс хэдэн мөрийг авч эн зэрэгцсэн мөрийг үзүүлэхийн тул хойно жагсаая.

Ямар	Юу	Ямраар	Яагаад
Болжмор	шувуу	гангар гунгар	жиргээд
Бутын	ногоо	арзайн бурзайн	ургаад
Хуур	хөгжим	хангир жингэр	сонсдоод
Хушийн	навч	налбас далбас	ганхаад
Хүсэл	зориг	дэвшин дэвшин	оргилоод
Хүүхэд	багачууд	инээдэс наадас	бололцоод
Самар	жимс	сагсас багсас	ургаад
Сайхан	бүгдээр	нөхөрлөн журамлан	ижилдээд ийм л сайхан тийм л соньхон

Алтан товч гэдэг зохиолын дотор Ших хутгийн хэлсэн нь

1. Хутагт төрсөн богд эзний энэ хишгийг
2. Хун галуу мэт дуугаа нэгтгэж
3. Хулан чихтэй мэт зүсээн нийлж
4. Хурсан бүгд жаргалдан цэнгээ!
5. Ачит төрсөн хаан эзний энэ хишгийг
6. Ангир галуу мэт дуугаа нэгтгэж
7. Аргаль марал мэт зүсээ нийлж
8. Амраг сайхан нөхдөө аван жаргая!

Үүнийг хянан үзвэл нэгдүгээр ба тавдугаар мөр хоорондоо адил хоёрдугаар гаравдугаар ба зургадугаар долдугаар мөр бүрэн адил бөгөөд дөрөвдүгээр ба наймдугаар мөр бас нэгэн адилаар зохиогджээ. Ийнхүү адилаар зохиогдсон хосолсон мөрийг зэрэгцсэн мөр гэж нэрлэж болно. Эн зэрэгцүүлэх ёс нь адилхан үесийг давтан хэрэглэх ба холбож хэрэглэхэд гол шалтгаан болохоос гадна шүлгийг ухаж мэдэхэд амархан болгоно.

Монгол шүлгийн ухааж мэдэхэд амархан чанар нь ганц энэ төдийгөөр зогсохгүй. Монголын шүлэг бол монгол хэлний зүйн өгүүллийн журам дээр үндэслэн зохиогдоно. Шүлгийн цэглэх газар нь өгүүлбэрийн цэглэх газартай тохиолдон нийлнэ. Иймийн тул шүлгийн мөрийн эцэст их төлөв дан буюу давхар цэг тавина. Мөрийн дунд давхар цэг байхгүй. Бас шүлгийн өгүүлбэрийн гишүүд шүлгийн дотор холилдон хутгахгүй. Харин тодорхойгоор ялгаран гарна. Үүн дээрээс бодоход, монгол хэлний дүрмийг сурагчдад заахад үргэлжилсэн зохиолыг үзүүлснээс шүлгийг үзүүлбэл дээр болно. Гэтэл оросын шүлэг тийм биш. Оросын шүлэг бол өгүүлбэрийн гишүүдтэй нягт холбоогүй. Шүлгийн мөр нь энд дуусаж байхад өгүүлбэрийн эцэс нь тэнд ондоо газарт дуусаж байна. Мөрийн дунд өгүүлбэр нь төгсөнө. Пушкиний «Олег цэцний дуулал» мөн ийм шүлэг боловч монгол орчуулга нь монгол шүлгийн журмыг дагах тул энэ талаар эх шүлгээс нилээд ондоо болов. Пушкиний «Олег цэцний дууллаас» өгүүлбэрийн гишүүдийг ялгаж олоход ийм амаргүй, эрж сурж энд тэндээс түүж олно. Гэтэл монгол орчуулгын өгүүлбэрийн гишүүдийг олоход маш амархан тус тус ялгаран гарна. Арван нэгдүгээр бадгаас хэдэн мөрийг авч өгүүлбэрийн гишүүдийг ялгахын тул асуултыг тавьж үзье.

Хэдийд?	{	Олег цэцэн өвгөрөөд
		Олон баатраа цуглуулаад
		Аяга хундага дуугаргаж
		Амттай сайхан хуримлахад
Ямар?	{	Өндөр уулын оройд
		Өглөө орсон цас мэт
Юу?	{	Цал буурал толгой нь
Яана?		Цайрч гялайж харагдав.

Монгол хэлний өгүүлбэр нь ихэнхдээ нэр үгээр эхлээд үйл үгээр төгсөнө. Жишээлбэл: «адуу хөдөө бэлчиж явна» гэх мэт байна. Шүлэг нь мөн энэ журмыг дагах тул эсхүл шүлгийн нэг мөр нь нэр үгээр эхлээд үйл үгээр төгсөнө. Эсхүл шүлгийн хоёр мөр нь нэр үгээр эхлээд үйл үгээр төгсөнө. Эсхүл шүлгийн бадаг нь нэр үгээр эхлээд үйл үгээр төгсөнө. Заримдаа нэг бадаг нь бүхлээр «юу?» гэдэг асуултад хариулах нэрийн аймаг үгнээс тогтох ба дараах бадаг нь «хаана?», «хэзээ?» гэх мэтийн асуултад хариу болох ба түүний дараах бадаг нь юу болсныг илэрхийлэх үйл үгийн аймгаас тогтох нь ч байна. Нэр үгээр эхлээд үйл үгээр төгссөн хэсэг үг бол нэг утгыг гаргахад хүрэх тул даруй өгүүлбэр болно. Жишээ болгож «Олег цэцний дуулал»-ын орчуулгын наймдугаар бадгийг үзүүлье.

Утгатай болсон хэсэг үг буюу өгүүлбэрийг дөрвөлжин хаалтаар хашив.

$$\left\{ \begin{array}{l} \text{Идэт баатар Олег} \\ \text{Инээх байдал гаргавч} \\ \text{Нүүр царай нь барайн} \end{array} \right\}$$

$$\left\{ \left\{ \begin{array}{l} \text{Нүдний харц хувиран} \end{array} \right\} \right\}$$

$$\left\{ \begin{array}{l} \text{Дух магнай нь үрчийж} \end{array} \right\}$$

$$\left\{ \begin{array}{l} \text{Дуугүй болон санааширч} \end{array} \right\}$$

$$\left\{ \begin{array}{l} \text{Ганзага шүүрэн бариад} \\ \text{Газарт шилжин буув.} \end{array} \right\}$$

$$\left\{ \begin{array}{l} \text{Сайн морин ханиа} \\ \left\{ \begin{array}{l} \text{Салахын ёсоор үдэж} \end{array} \right\} \\ \text{Хүлэг сайхан мориныхоо} \\ \text{Хүзүүг илж эрхлүүлэв.} \end{array} \right\}$$

Энэ хэдэн гишүүн бгүүлбэр хоёр анги болон хуваагдаж хоёр зүйлийн ерөнхий өгүүлбэр болжээ. Гишүүн өгүүлбэрт «хэний» буюу «хэн» гэдэг асуултыг хариулах нэр үгийг орхижээ. Хэрэв түүний оронд төлөөний нэрийг тавьж, гишүүн өгүүлбэрүүдийг тус тус биеэ даасан дан өгүүлбэр болгон салгавал ийм есөн өгүүлбэр болно.

Идэт баатар Олег
 Инээх байдал гаргана. Гэвч
 Түүний нүүр царай нь барайна.
 Түүний нүдний харц хувилна.
 Түүний дух, магнай нь үрчийнэ.
 Тэр, дуугүй болон санааширна.
 Тэр, ганзага шүүрэн барив.
 Тэр, газарт шилжин буув.
 Тэр, сайн морин ханиа
 Салахын ёсоор үдэв.
 Тэр, хүлэг сайхан мориныхоо
 Хүзүүг илж эрхлүүлэв.

«Тэр» гэдэг төлөөний нэрийн оронд «Олег» гэдэг нэрийг тавихад бас болно. Үүнээс үзэхэд монгол шүлэг ба шүлгийн мөр бол өгүүлбэр ба өгүүлбэрийн гишүүнтэй

нягт барилдлагаатай нь илэрхий байна. Монголын шүлэг бол монгол хэлний найруулга, өгүүлбэрийн зүйн журам дээр үндэслэн зохиогдоно гэж хэлж болно.

Орос эх шүлэгт, мөр, өгүүлбэр хоёрын хооронд ийм нягт барилдлагаа байхгүй. Өгүүлбэр нь нэр үгээр эхлээд үйл үгээр төгсөнө гэх хатуу журам байхгүй. Шүлгийн цэглэх газар нь өгүүлбэрийн цэглэх газартай их төлөв тохирохгүй. Эн зэрэгцсэн мөр олон байхгүй. Гэтэл монгол орчуулгад эн зэрэгцсэн мөрүүд олон байна. Эн зэрэгцсэн мөрөөс үүссэн дундах үе ба эцсийн үеийн холбоо байна. Шүлгийн цэглэх газар нь өгүүлбэрийн цэглэх газартай ямагт нийлнэ. Энэ бол монгол орчуулгын эх шүлгээс ондоо болсон үндсэн зүйл мөн. Пушкиний шүлэгт эн зэрэгцсэн мөрүүдгүй байтал монгол орчуулгад бий. Пушкиний шүлэгт үгүй юмыг монголчилж орчуулахдаа бий болгожээ. Пушкиний шүлгийг орчуулахдаа янз оруулж нэмж чимсэн гэж намайг буруушааж болох боловч нарийвчлан хянавал Пушкин «Олег цэцний дуулал» гэдэг шүлгийг зохиохдоо орос хэлний хамаг чадлыг бүрэн хэрэглэж бичсэн тул ийм уран сайхан шүлэг болжээ. Ийм сайхан шүлгийг монголчлохдоо бас монгол хэлний шүлэг зохиох хамаг чадлыг бүрнээр хэрэглэж орчуулах нь орчуулагч хүний зайлж болохгүй ариун үүрэг мөн гэвэл зохино.

Пушкиний «Олег цэцний дуулалд» хоёр зүйлийн гол арга бий. Нэгд, өргөлтөт ба өргөлтгүй эгшигийг ээлжлүүлж тэгшитгэн хэрэглэнэ. Хоёрт, мөрийн эцсийг холбоно. Гэтэл монгол орчуулгад гурван зүйлийн гол арга бий. Нэгд, өргөлтөт эгшиг ба үгийн тоог тэгшитгэн хэрэглэнэ. Хоёрт, мөрийн эхийг холбоно. Гуравт, эн зэрэгцсэн мөрийг хэрэглэнэ. Иймийн тул орос эх шүлгээс монгол орчуулга нь уран сайхны талаар доргүй болох бүрэн нөхцөл байсан гэвэл зохино. Хэрэв дор болсон бол монгол хэлний шүлэглэх чадлын дутмагаас болсон биш, орчуулагчийн чадал дутмагаас болсон хэрэг мөн. Эхээс орчуулгын муу болох нэг шалтгаан нь зохиолчийн эрхээс орчуулагчийн эрх бага байдаг. Зохиолч бол олон түмэн үгнээс аль дуртай үгээ шилж авах эрхтэй. Орчуулагч бол уг эхэд зохилдох тав гурван үгээс нэгийг нь шилж авахын төдий эрхтэй. Энэ бадагт буюу энэ мөрт ийм үгийг орчуулбал шүлэг нь сайхан болно гэж орчуулагч хүн хэдий санавч, дуртай үгээ оруулж чадахгүй. Гагцхүү уг эхэд ямар үг байвал түүнтэй нэг утгатай буюу ойр утгатай үгийг оруулах хэрэгтэй болно.

Хэдийгээр Пушкиний шүлгийг орчуулахад түүний шүлгийн журмыг дуурайж, уг шүлгийн утга, янз хоёрыг хэвээр нь монгол хэл дээр буулгахыг хичээнгүйлэн оролдох нь зүй мөн боловч үүнд бас нэг хэмжээ хязгаар байх хэрэгтэй бизээ. Орос эх шүлгийн журмыг хэтэрхий дууриавал монгол хэлний журам, монгол шүлгийн журмыг эвдэх нэг аюул гарч болно. Монгол хэлний журмыг эвдвэл монгол хүнд мэдэгдэхгүй юм болно. Монгол шүлгийн журмыг эвдвэл Пушкиний шүлгийг монгол хэл дээр шүлэг болгон орчуулсан гэх нэрийг хүлээж чадахгүй болно.

«Олег цэцний дуулал»-ыг орчуулахдаа би, Пушкиний эх шүлгийн журмыг дууриахыг чадах чинээгээр оролдсон боловч монгол хэлний журам, монгол шүлгийн журмыг эвдэхгүйг хил хязгаар болгож үүнээс давж гарсан зүйлгүй.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Ямар ба шүлэгт, ямар ба уран зохиолд хүний сэтгэлийг хөдөлгөх чадал бий. Энэ нь уран зохиолын гол сүнс болно. Ерөнхийд нь хэлбэл эрдэм шинжилгээний зохиол бол учрыг тайлбарлаж ухааныг нээгдүүлнэ. Уран зохиол бол байдлыг илтгэж сэтгэлийг хөдөлгөнө. Уран зохиолч нар яруу найргийн хүчээр хүний сэтгэлийг татна. Уран зохиолч нар хүний сэтгэлийг хөдөлгөж аль дуртай зүгтээ жолоодон одно. Уран зохиолч нарын энэ чадал нь түүний зохиолд оршиж байна. Энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг нь эрхбиш орчуулах хэрэгтэй. Шүлгийн үг өгүүлбэр ба хэв журмыг хэдийгээр нарийн нягт орчуулж чадавч энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг орчуулж эс чадвал амьд морийг үхсэн мориор арилжсантай адил болно. Морийг арилжихад зүс байдал нь тун адил боловч үхсэн мориноос сольсноос, зүс байдал нь нилээд өөр боловч амьд мориноос солих нь чухал юм. Иймийн тул энэ шүлгийн чадлыг сайнаар орчуулах нь шүлгийн үг өгүүлбэр ба хэв журмыг орчуулахаас илүү чухал зүйл юм. Энэ нь даруй шүлгийн аминд холбогдсон хэрэг мөн. Үүнийг хамгийн чухалд үзсэнээр шүлгийн бусад талд бага сага гажуудсан нарийн болж чадаагүй газар байгааг нуух явдалгүй. (Жишээлбэл: Зургадугаар бадагт пращ-дүүгүүр гэх үг орхигдсон боловч шүлэгт төдий л их гэм болохгүй болов уу гэж горьдоно). Монгол орчуулгыг монгол хүний уншихад уран сайхны талаар орос эхийг орос хүний уншсанаас доргүй байвал сая шүлгийн уран чадлыг орчуулж чадсан гэж болно. Пушкиний «Олег цэцний дууллыг» орчуулахдаа түүний уран сайхан хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг хэвээр буулгахыг чадах чинээгээр хичээн оролдсон. Чухам шүлгийн чадлыг яаж орчуулснаа тайлбарлах гэхэд тогтсон нэр томъёогүй бөгөөд нуршуудал үлэмж болж ирэх тул энэ удаад хичээв, оролдов гэх төдийгөөр зогсёе. Энэ хир би, энэ орчуулгыг олон хүнд уншиж үзүүлсэнгүй тул шүлгийн чадлыг орчуулж чадсан эссэн, ер нь сайн муу болсны тухай хэлэх баримтгүй байна. Миний энэ хичээж оролдсоноос ямар нэгэн үр гарсан эссэнийг уншигч авгай нар аяндаа толилон тогтоох бизээ.

Энэ тайлбарт монгол шүлгийн журмыг шинжлэн гаргахыг оролдсон биш, гагцхүү «Олег цэцний дууллын» монгол орчуулгыг орос эх шүлэгтэй харьцуулан үзэж яаж орчуулснаа илтгэх гэсэн билээ. Ийнхүү хэлэлцэж байгаа хэргийн хэмжээ хязгаар явцуу тул монгол шүлгийн ерөнхий журам ба олон төлөвийн тухай энд дурдсангүй орхижээ.

Нэмж хэлэх нь:

Уран зохиолын дотор шүлэг, үргэлжилсэн зохиол гэдэг хоёр их ялгавар байна. Үргэлжилсэн зохиолыг зохиоход гол төлөв утгыг чухал болгоно. Үргэлжилсэн зохиолыг засаж нэг үгийг нөгөө үгээр солих зэрэгт гагцхүү утгыг бодохоос биш тэр үгийн дотор хэдэн ямар эгшиг орсон буюу чихэнд ямраар сонсдохыг төдий л хайхрахгүй. Гэтэл шүлэгт бол тийм биш. Шүлгийг зохиох ба засахад утгаас гадна бас шүлгийн хэмжээ, уншигдах аялгууг чухал болгоно. Шүлэгт хэлж байгаа үгсийг хэсэг хэсгээр хувааж богиновтор мөр болгоно. Мөрийн доторхи дуунуудыг журамтайгаар тэнцүүлбэл зохино. Шүлгийн мөрийн толгой буюу эцсийг бас холбоно. Иймийн тул шүлэг бол үргэлжилсэн зохиолоос мөрийн

хэмжээ, холбол хоёроор ялгарна. Европ дахины шүлэг үргэлжилсэн зохиол хоёрын янз нь маш ялгавартай. Манай монголын шүлэг, үргэлжилсэн зохиол хоёр хоорондоо мөн тийм ялгавартай. Гэвч энэхүү ялгавар нь гэнэт гарах биш, улмаар ялгаран гарна.

Монголын үргэлжилсэн уран зохиол шүлэг болохын үүсэл байна. Энэ үүсэл нь аль вэ? гэвэл толгой холбох болно. Зүгээр үргэлжилсэн зохиолын дотор хааяа толгой холбосон үгс үзэгдэнэ. «Шинэ толь» гэдэг сэтгүүлд хэвлэгдсэн дөрвөн өөлдийн түүхийн доторхи Цэвээндоржнамжилын бүлгээс иш татаж үзүүлбэл: «... Үүнд Цэвээндоржнамжил хаан бол харанхуй догшин, омгорхог бардам хүн тул өнгө дарсанд орж, ужид самууныг жаргал цэнгэл болгож, өдөр бүр нохой харван алж зугаацна» гэжээ. Үүнийг хянавал шүлэг биш боловч толгой холбосон үгс байна. «Өнгө», «ужиг», «өдөр» гэдэг гурван үгний толгойг холбосон нь уг зохиолыг уншихад эвтэй болгоно. Хэрэв «өнгө дарсанд орж, самуун уждыг жаргал цэнгэл болгож хэзээд нохой харван алж зугаацна» гэвэл утга нь хувилахгүй боловч зохиолын уран чимэг хасагдаад өгүүлбэрийн урлаг дутмаг болно. Толгой холбох нь үргэлжилсэн зохиолд чимэг болоод, шүлэгт тулгуур болно. Үргэлжилсэн зохиолын дотор толгой холбосон нь үлэмж бол шүлэгт нилээд ойртож ирнэ. Монголын урт үлгэр бол их төлөв үргэлжилсэн зохиол, шүлэг хоёрын хоорондох толгой холбосон холбоо найруулга байна. Энэ нь үргэлжилсэн зохиолоос толгойг холбосноор ондоо болно. Шүлгийг бодвол бас тогтсон хэмжээгүй байна. Үүнд жишээ болгож монгол Гэсэрийн туужаас хэдэн мөрийг үзүүлэе.

«Үйл бүтээгч нэрт хөвүүн эцэг хаанд өчрүүн:

Эдүгээ манай гурвуул цөм одох дургүй бөгөөд

Үгээ юунаа сонсож одно.

Шулуунаар заагч сум чулуу

Шоо гурван зүйл төлгийг тавиулан

Хэнд тохиолдсонд

Хэлэлцэх үггүй бизээ

Гэсэнд,

Хурмаст тэнгэр эцэг

Хоёр ах цөм гэлцэж шийдэн

Наран ургах цагт

Нарийн хулсан зэвийн зурхайг тавьсанд

Үйл бүтээгчид тохиолдов.

Үдийн цагт

Дүгэрэг чулууны

Төлгийг тавиулан

Үдэш орой

Эрээн шооны төлгийг

Эргүүлсэн гурван зүйл төлөг цөм үйл

Бүтээгчид туссан...»

гэх мэт.

Дөрвөдийн Эргэл түргэл гэдэг туулиас!

«... Хий нэгтэй түшилдэж ургасан

Ташир тавин хангай

Нутаг нь дүнхийгээд байдаг

Хөвч нэгтэй авалцаж ургасан

Давхар далан Алтай

Нутаг нь ярайгаад байдаг.

Арцтай мусар товхон хангай дүнхийгээд байдаг

Аршаант

Анамал тэнгис

Арьин их далай цайлалзаад байдаг.

Тэр нутгийн дотор

Хөх сайхан зандан мод

Хөхөрч найгалзаад

Хөхөө ёл хоёр шувуу

Хөглөн жиргэн донгодоод байдаг

Өн зүйл бүрдсэн

Өндөр баян Алтай хангай нутгийн тойм товч нь тэр» гэнэ.

Ийнхүү толгойг холбохоос гадна хэмжээг журамтай болговол сая жинхэнэ шүлэг болж ирнэ.

Монголын жинхэнэ шүлэгт үгийн тоо чухал болно. Шүлгийн мөр нь хоёроос долоо хүртэл ба түүнээс дээш ч байна.

Хоёр үгт шүлэг нь:

Гандий модонд

Галуу эргэнэ.

Газрын холоос

Хүү минь эргэнэ.

Олныг хэсэж

Олгой тэжээв.

Гүрнийг хэсэж

Гүзээ тэжээв.

Гурван үгт шүлэг нь:

Манай залуучуудын эвлэлийг

Мандах нар лугаа үлгэрлэе

Магадын журмыг баримталж

Маш үнэнээр эвлэлдье. (ДУУ)

Дөрвөн үгт шүлэг нь:

Арилсан борооны эцсийн үүл

Ариун огторгуйд ганцаар хөвөлзөөд

Бараан сүүдрээ газарт буулгаж

Баярт өдрийг гутааж байна. (Пушкин, орчуулга)

Таван үгт шүлэг нь:

Хонь хотлох нэгэн мөчийн зуур

Салхин шижмээр үүл хөшиг сөхөгдөөд

Цаадах талбай уудам ихийн дунд

Үдшийн цолмон гэрэл бадарсаар мандана. (Цэвэгмид)

Зургаан үгт шүлэг нь:

Өссөн төрсөн бидний үндэсний хайртай нутаг

Өнгөлзөгч дайсан ирвэл үтэр өшиглөн хөөнө. (Нацагдорж)

Долоон үгт шүлэг нь:

Сайхан огторгуйн дунд нимгэн цагаан үүл нүүхэд

Идэр залуус алс газрыг сонирхон сураар одно (Нацагдорж)

Үүнээс цааш найм ба ес түүнээс дээш ч үгт шүлэг бий боловч төдий л элбэг биш тул энд сийрүүлэхийг байя. Бас шашны мөргөлийн уншлага зэргийн шүлгийг хянавал тусгай журамтай, төвдийн шүлгийг дууриасан төлөвтэй. Харин өргөлтөт ба өргөлтгүй эгшгийг ээлжлүүлэн зохиосон шүлэг хааяа үзэгдэх мэт боловч энэ шүлгийн журам, олны дунд ихэд дэлгэрсэнгүй тул одоо авч хэлэлцэхгүй. Монголын одоо цагийн шүлгийг үзвэл толгой холбох, хэмжээг тохируулах хоёрыг үндэс болгоно. Бас мөр зэрэгцүүлэх гэдэг нэгэн чухал

зүйл бий. Гэвч толгойг холбохгүй, хэмжээг эрхэмлэх ба хэмжээг эрхэмлэхгүй толгой холбон зохиож болно. Энэ хоёулныг хайхрахгүй, гагцхүү мөр зэрэгцүүлэх ёсыг үндэслэн зохиож бас болох мэт. Хэрэв энэ гурван зүйлийн алиныг ч хэрэглэхгүй шүлэг зохиох юм бол ийм зохиолыг шүлэг гэж нэрийдэх баримтгүй болно.

Монголын одоогийн шүлэг их төлөв эхнээс адаг хүртэл нэгэн хэмжээгээр зохиогдоно. Үүнд хэлж байгаа утгын ерөнхий төлөвийг дагуулж шүлгийн чанарыг хувируулан зохиогдох болно. Аливаа шүлэгт эгшиг дуун бол шүлгийн гол аяс болно. Дэлхий дахинд ихэд алдаршсан гурван зүйлийн шүлэг бий.

Нэгдүгээр нь: Урт эгшиг, богино эгшгийг ээлжлүүлэн зохионо. Хуучин латин шүлэг ийм байсан ба одоо иран шүлэг ийм байна.

Хоёрдугаар нь: Шүлгийн мөрийн доторхи эгшгийн тоог тэнцүүлнэ. Үүнд урт эгшиг, богино эгшиг гэж ялгаварлахгүй. Одоогийн франц, польш зэрэг хэлний шүлэг ийм байна.

Гуравдугаар нь: Өргөлттэй эгшиг, өргөлтгүй эгшгийг ээлжлүүлэн зохионо. Жишээлбэл: Орос шүлэг ийм байна. Үүний дотор хоёр эгшгийн эхний эгшиг өргөлттэй ба эсхүл эцсийн эгшиг өргөлттэй байх, гурван эгшгийн эхний буюу дундах, эсхүл эцсийн эгшиг нь өргөлттэй байх зэргээр таван зүйлийн шүлэг зохиох журам байна. Оросын их шүлэгч Пушкиний зохиолд энэхүү журмыг чанга баримталжээ. Гэтэл хорьдугаар зууны эхнээс ба ялангуяа одоогийн хувьсгалын үеийн шүлэгч нар тэрхүү тогтсон журмыг яг баримтлахгүй чөлөөтэйгөөр бичих болжээ. Баяр цэнгэлийг нэг ондоогоор, гомдол гашуудлыг бас ондоогоор тус тусад тохирсон шүлгээр бичнэ. Бас сүрчигнэх чимээг бичихдээ р үсгийг олон хэрэглэх ба уянгат чимээг бичихдээ л, н үсгийг олон хэрэглэх ч зүйл бий. Ер нь Оросын одоогийн шүлэг бол олонд сонсох, хэлэх илтгэх, ярих хэлэнд ойр болсон байна.

Шүлэг орчуулах эрдэм

Б.Ринчен⁹⁸

Дөчөөд жилийн өмнө би оросоос ганц нэг шүлгийн орчуулга хийх гэж оролдож байлаа. Тэгэхдээ орос шүлгийн бүтцийн тухай мэддэг боловч монголоор орчуулахдаа ганцхан санаагий нь л буулгахаас биш, цаад шүлэг зохиосон яруу найрагчийн шүлэглэлд хэмжээ нь ямар байсан байна европ ёсны шүлэгт шад бүрийн төгсгөлийн үгийн сүүлийг холбодог эр эм холбоц гэх мэтийг монгол болгож орчуулахдаа монгол шүлэгт огт хамаагүй юм шиг, ер нь санаагий нь л чадлынхаа хирээр аятайхан буулгахаас, бусад юм нь огт хамаагүй юм шиг боддог байлаа. Бусад гадаадын хэлээр шүлэг бараг үздэггүй, үзсэн ч сайхан шүлэг байна гэхээс ямар бүтэцтэй шүлэг байна, тэрний нь бусад хэлэнд орчуулахдаа яаж орчуулдаг байна гэдгийг анзаардаггүй байж билээ. Тэгтлээ дэлхийд нэр гарсан шүлэглэлийг орос, герман, англи гурван хэлээр үзэхэд хэмжээ байдлы нь яг хэвээр нь орчуулсан байхыг үзэвч монголоор бас чингэж болох юм ухаан санаанд ордоггүй байна.

Гучаад оны үеэс Хуушаан (Боржигон Нацагдоржийг бид Хуушаан гэж тэр үеийн монгол уншигч олонд их алдартай Жийдаан Хуушаан гэдэг архинд дуртай нэг зохиолын баатрын нэрээр нэрлэдэг юмсан) бид хоёр Шинжлэх ухааны хүрээлэнгийн дуун ухааны тасагт нэг тасалгаанд хоёулаа сууж ажиллахдаа, Пушкиныг орчуулж үзэхээр санаа нийлж үдшийн шөнөөр орчуулсан ганц нэг шүлгээ өглөө нь Хуушаан авчраад би орос эхий нь барин, Хуушаан орчуулсан нооргоо, гартаа харандаа барин дуудаж, зарим мэдэхгүй үгээ онгорхой үлдээснийг нөхөн, энэ санаа нь арай буусангүй, тэр үг арай таарахгүй байна гэж өглөөний чимээгүйд жинхэнэ албан ажлаа эхлэхийн өмнө хагас цагийн буюу нэг мөчийн төдий ном нийлж суудаг асан. Хуушаан, европ шүлгийн зохион байгуулалтыг германаар мөн үзсэн тул, Брокхаусын герман товч нэвтэрхий толь дэргэдээ тавиад хэлэлцэж суухдаа бид, монголоор Пушкиныг орчуулахдаа уг орос шүлгийн хэмжээ байдал нь ямар болохыг шүүж, хоёулаа нэр томъёоны комиссын гишүүн боловч шүлгийн нэр томъёо шаардах хүн тэр үед гараагүй бөгөөд, хоёр биедээ түүнийг тогтоох хэрэг ч үгүй, орос герман аль ч аманд буюу санаанд орсон нэрээ хэрэглэн хэлэлцэхдээ, тэр хорей ямбын зэрэг европ шүлгийн хэмжээг монгол шүлэгт тааруулж болох уу, үгүй юу? гэж ярилцдаг байлаа. Чингэхдээ монгол үсгээр бичих, уншин дуудах хоёр зарим зүйлд нийцэхгүйд яаж тааруулж, европ шүлгийн хэмжээг зохицуулах вэ? гэдэгтээ хоёулаа арга ухааны нь олдоггүй. Монгол шүлгийн тогтолцооны тухай дэлгэр нарийн шинжлэл байдаггүй. Монгол бичгийн шүлгийн тогтолцоог судалсан зүйл байхгүй. Монгол ардын аман зохиолын шүлгийн тогтолцоог судалсан зүйл бас байдаггүй. Өөрсдөө бид тэр үед судалж чадаагүй дэмий л сайхан шүлэг байна гэж утгын сонин, үгийн сайхан гоёи нь мэдэвч, чухам юундаа тэр нь байна гэдгийг

98 “Орчуулах Эрдэм-2”, УБ, 1972, 91-99 тал

нарийн шинжиж чадаагүй. Хуушаан хэмжээгий нь үгийн тоогоор тааруулах нь зүйтэй байх гэдэг асан. Тэгээд, үгийн тоогоор тааруулахдаа нүдээр үзэх бичигт үгийн урт богино нь бичигт ойролцуу харагдах үг сонгон бичдэг байлаа. Чингээд, уншин дуусахад, заримдаа бичсэн хэлбэрээс дуудах хэлбэр нь богино болж, ухагаа гэж бичсэнээ ухаан гэх мэтэд, тийм үг нэг мөр шүлэгт олон ороод, нөгөө мөрт тийм үг үгүй байлаа. Мөрийн урт богино адилгүй болдог байж билээ.

Хуушаан бид хоёрын анх шүлгийн учры нь олох гэж оролдож, орос хэлнээс Пушкины зэрэг яруу найрагчийн шүлэг орчуулан нийлж байсан тэр цагаас хойш гуч гаруй жил болж, энэ завсар орос хэл, бас бус зарим нэгэн европ хэлнээс шүлэг орчуулдаг хүн ч олон боллоо. Орчуулан гаргасан зүйл ч тэр үеийг бодвол их боллоо. Уншигч олон маань үнэхээр олон боллоо. Боловсрол нь ч нэмэгдлээ.

Зохиолын орчуулга бол, ямар уншигчид зориулсан байдаг юм бэ? гэвэл тэр зохиолын нь хэлээр нь буюу өөр нэгэн хэлэнд орчуулснаар нь уншиж чадахгүй уншигч хүнд мэддэг хэлээр нь буулган хөрвүүлж өгдөг зорилготой юм шүү дээ. Өөр хэлний зохиолыг гагцхүү өөрийнхөө эх хэлээр уншин үзэгчдийн дунд янз бүрийн боловсролтой хүн байх нь түмэн зүй. Сая бичиг үсэгтэй болоод ном бүрээс сонин юм, урьд мэдээгүй юм олж үздэг уншигч ч бий. Өндөр боловсролтой их юм үзсэн хүн бий. Гэвч тэдгээр уншигч, гагцхүү өөрийнхөө эх хэлээр унших тул утгы нь сонирхохоос цаад хэлэнд тэр сонин сайхан зохиол нь ямар байгаа, шүлгийн хэмжээ байдал зэргийн яруу найргийн онцлог нь юу байгааг мэдэхийн арга байдаггүй тул гагцхүү орчуулагчийн «Амаар будаа иддэг байна».

Олон улсын шүлэг зохиолыг монгол хэлэндээ буулгаж байгаа манай орчуулагч нар маань, одооны манай хөгжлийн энэ байдалд, дан ганц энгийн уншигч олныг үйлчлээд зогсохгүй, эх хэлнээсээ өөр хэл мэдэхгүй нэгэн хэсэг манай яруу найрагч нөхдийн мэдлэгийн хүрээг өргөжүүлж бусад улсын нэртэй сайхан уран бүтээлтэй танилцуулан сэтгэхүйн хүрээгий нь өргөжүүлэх маш чухал үүргийг гүйцэтгэж байгаагаа бодох цаг боллоов шүү. Өнөөдөр яруу найрагч болоогүй болох гэж дотор нь боловсорч яруу найрагч болох асан гэж хүсэн бодож явдаг ирээдүйн яруу найрагчийн дур слнирхол, уран авьяас, гоозүй уран сайхны хүмүүжилд нь их чухал үүрэгтэйгээ бас бодох цаг боллоов шүү! Түүнийг шүүн бодоод ирэхэд, өнөөдөр хүртэл хэрэглэсээр ирсэн орчуулгын маань дадсан хэдийн хэвшил болсон энэ гуч гаруй жилийн маань арга дадал цаашид хэвээрээ хэрэглэх арга дадал уу? Уншигч олны хөгжил шаардлаганаас хоцрогдож байгаа арга болчихов уу гэж бодууштай болж ирлээв шүү! Дадсан замаараа, сурсан дуугаа дуулаад явах нь амар боловч, ашиг тус нь ямар байна, нөхөд орчуулагч минь? гэж бодохын хамт орчуулгаар маань гадаадын зохиол уншиж, амаар маань будаа иддэг уншигч олондоо цаад улсын яруу найраг шүлэг зохиолд байдаг аргын тухай хэлж өгвөл тус болох асан болов уу гэж европ зүгийн шүлгийн бүтэц байдлын гол зүйлээс энд дурдахыг хүснэм. Тэр европ зүгийн шүлгийн бүтэц зохиолын арга нь монголоор шүлэг бичихэд бас хэрэглэж болох бөгөөд, манай шүлгийн хэлбэр байдлыг баяжуулахад ч нэмэр болох зүйл гэж бодном.

Хориод жилийн өмнө шүлэг бичихдээ нэг мөр шүлгийг гурван зэрэг шатлан тасалж, шинэ маягаар бичдэг нэг зохиолчоос та шүлгээ ингэж бичихдээ ямар ухаантай байна? гэж сонирхон асууваас Маяковский тэгж бичдэг шүү дээ гэж хариулсан билээ. Тэгээд, цааш нь мохоон асуухад, нэг мөрийг хэд таслан шатлан бичихэд шүлэг болдог юм гэхэд нь сонинд гардаг зөвлөлтийн мэдээлэх товчооны шуурхай мэдээ аваад, тэгвэл таны тэр аргаар энэ мэдээг цөмий нь шүлэг болгож орхиход тун амархан юм шив дээ.

Зөвлөлтийн

мэдээлэх

товчооны

Фронтын

шуурхай

мэдээнээс

гэвэл болчих юм байна шүү дээ! гэхэд Маяковскийн шүлгийн гаднах хэлбэрийг нүдээр үзэхэд шатлан цувуулсан байдал нь бичиг мэдэхгүй хүний нүдэнд ч гэсэн үзэгдэх боловч чингэж шатлан цувуулдагт нь орос хэлний зүй тогтоол, зөв дуудахуйн журам, орос хэлний өргөлтийн хуулийг Маяковский яруу найргийнхаа хэлбэр байдалд шинэ сонин аргаар хэрэглэсэн ухааны нь орос хэл уншин гадарлах төдийхөн идэвхигүй мэдлэгэндээ хязгаарлагдсан учир сайтар ухаарч чадахгүй гагцхүү янагуунхи хэлбэрий нь дууриаснаар шинэ хэлбэр нээлээ гэж бодож байсан түүний нь тэр гаднах хэлбэрий нь зарим манай шүлэгчид дууриасан бололтой гэж би зарим тийм маяг хэлбэрээр мөр таслан бичсэн шүлгийг үзэхдээ боддог болж зохиогчоос нь чингэж бичсэнийхээ ухаан онолы нь асуумаар санагдаж, сэтгэлд сэв ордог боллоо.

Манайд Олег цэцний дуулал гэх мэтийн аятайхан мэт үзэгдэх шүлгийн орчуулга бий. Гэвч, олон улсын орчуулгын зарчмын үүднээс үзэхэд тийм орчуулганд цаад зохиогчийн санаа нь байхаас шүлгийн зохион байгуулалт, бүтэц нь байхгүй санаанаас бусад нь цөм орчуулагчийн өөрийн зохиол бөгөөд уг зохиолчид падгүй зүйл гэхэд үл болох газар үгүй.

Орчуулагчийн тэр үеийн орос хэлний мэдлэг нь утга санаагий нь ухаарахаас цаашлаагүйн учир, орос шүлгийн ёс журмыг цаад зохиогчийн адил мэдэх хэмжээнд хүрээгүйн холбогдол үүнд бас байгаа хэрэг. Өнөөдөр бид яруу найргийг орчуулан монголчлоход орчин үеийн яруу найргийн орчуулганд тавьдаг шаардлагыг зуун хувиар тавих хэмжээндээ хүрсэн гэж бодох ёстой хөгжлийнхөө шатанд хэдийн хүрсэн байна.

Дэлхийд алдартай яруу найрагчийн уран бүтээл шүлгийг бид монгол уншигчдаа өргөн толилуулахдаа, орчин үеийн боловсон улсын тэр мэт зүйлд хэрэглэдэг бүхий л аргыг нэгэн адил хэрэглэх ёстой «цээндээ» хүрлээ.

Пушкиныг орос эхээс монгол болгохдоо, Хейнеэг германаас монгол болгохдоо Данте Аллигиерийн тэнгэрлэг жүжиг (оросоор Божественная комедия хэмээн орчуулжээ. Италиар

Дивина комедиа хэмээмүү. Коммедиа гэдэг үг нь угтаа грек хэлнээс латин хэлэнд орсон үг. Монголчилбол яг «Жүжиг» шиг үг, Франц хэлнээ XIV зууны үед Оресм гэдэг хүн анх комоди хэмээн латинаас, хэрэглэжээ. Орос хэлэнд XVIII зууны үед оржээ) эртний грекийн Хомерийн Илиад, Одиссе зэргийн даян дэлхийд нэр гарсан шүлэглэл зохиолыг орчуулж монгол утга зохиолын санд оруулахдаа манай орчуулагч нар эрдэм чадлаар олон улсын сайцуул орчуулагчтай мөр зэрэгцсэн байдлаа харуулж, олон улсын нэгэн адил, бас тэдгээрт нэрт шүлгийн санаанаас нь гадна хэлбэрий нь тэгэхдээ Маяковскийн шүлгийн хэлбэрийг гагцхүү нэг мөр шүлгийг гурав дөрөв тасалсны төдий янагуухийн байдлыг харсан үзэгдэл төдийхний хэлбэрээр бус, тэдгээр зохиолын хэлбэрийн чанар зорины нь монгол хэлэндээ яг буулгах орчуулгын эрдэм эзэмших хэрэгтэй байна.

Шүлэглэл зохиолыг монгол болгохдоо, баян элбэг үгтэй зохиолыг монгол болгохдоо маш баян монгол хэлнийхээ үгсийн сангийн эрднээс цаад зохиолын сайхан үгтэй чадал санаа эн чацуу үг хэрэглэхээс гадна, бас уг зохиогч нь цаад хэлнийхээ үгийн сангаас сонгон хэрэглэсэн үг нь судрын хэлний үг байвал, монгол судрын хэлнээс түүнтэй дүйх сайхан үг сонгон олж, номын хэлнээс хэрэглэсэн үг байвал, монгол номын хэлний зохих үг шигшин шилэн сонгож хэрэглээд бичгийн хэлний үг хэрэглэсэн байвал монгол бичгийн хэлний үг хэрэглэж, хар үг хэрэглэсэн газар, мөн түүнтэй амт санаа дүйх хар үг тэнсэн олж хэрэглээд, эх зохиолын хуучин үгий нь монгол хэлнийхээ хуучин үгээр тааруулаад уншигчийнхаа үгийг баяжуулан мэдлэгий нь агуу болгохын үүднээс тайлбар зүүлт зүүх газар нь зүүн тайлбарлаж, оюуны нь амыг нээж өгөх хэрэгтэй байна. Энэ бол сайн зохиолчийн сайхан зохиолын санаагий нь монгол уншигчдаа хүртээл болгохдоо, цаад уг зохиолч хүн, нэрд гарсан зохиолоо бичихдээ ямар зүйлийн үг хэрэглэж, тэр сэтгэлд ургасан санаагаа илэрхийлсэн байдлы нь монгол орчуулгадаа толилуулах үүрэгтэй байна.

Шүлэг гэдэг зохиол бол бас үг найруулга нь ер жирийн үргэлжилсэн үгийн зохиолоос өөр тул, монгол уншигч олныхоо өмнө соёлын хариуцлага хүлээсэн шударга журамт орчуулагч хүн орчин дэлхий нийтийн уран орчуулгын арга хэрэглэх үүрэгтэйгээ агшин зуур ч хэмээн үл умартах аваас биеийн алжаахыг үл бодон цаг хүчин үлэмжхэн орохыг үл хэмнэн, гагцхүү сайхан зохиолыг монгол болгохдоо зэрэмдэглэхгүйг нэнд хичээж, уг эх хэлнээ тэр шүлгийг ямар хэмжээ байдалтайгаар зохиосон бол, тэр бүхий л байдлыг монгол хэлэндээ бас буулган уншигч олондоо тэр яруу найрагчийн сайхан зохиолын санаагий нь сайхан үгээр нэвтрүүлэхийн хамт монгол орчуулгандаа монгол сайхан яруу гоё үгий нь бас цаад зохиолд ямар байдал хэлбэртэйгээр найруулсанчлан найруулж, шүлгийн шад гэж шүлгийн нэгэн мөрийг нэрлэдэг юм нь хэдэн үеэр бүтсэн байвал монгол орчуулганд мөн тэр л үеийн тоотой яг ижил зохион байгуулалттай байх ёстой. Жишээ нь нэг шад арван үе, дараачийн шад найман үе, түүний дараачийн шад арван үе, дараах нь найман үе байвал, монгол орчуулганд тэр бадаг шүлэг бас л уг эх шүлгийн бадаг шадын хэмжээтэй яг адил байх хуультай. Тэр эх шүлгийн хэмжээнээс илүү датуу байвал орчуулагч хүн, эх зохиолд цаад яруу найрагчийн зориуд хичээж тааруулсан хэмжээ хэвийг эвдэж яруу найргийн нэг

аргы нь гээн хаяж, монгол уншигчдаа тэр нэг онцлогий нь мэдэгдсэнгүй. Уран сайхны нь нэг хэлбэр байдлы нь хаясан болно. Зураачаар жишээлбэл: ямар нэг нэртэй зураачийн зургийг хуулан буулгахдаа өнгө будгаас нь дур мэдэн хаясан лугаа адил зүйл болно.

Үеийн тоог шад бадагт нарийн буулгахад монгол хэлнээ үл болох зүйл, таарахгүй зүйл гэж байхгүй. Хүн төрөлхтний хэлний нэгэн адил хэл бөгөөд авьяас их билэгт эртний их соёлын уламжлалт монгол ардын хэлний баялаг нь үнэхээр гайхан бахдамаар тул хэдэн мянган жилийн тэртээх грек латины одоо хүртэл европ түмнийг гайхуулдаг зохиолоос эхлэн орчин үеийн улс түмний ямар ч сайхан зохиолыг буулгахад хүний цээжинд л төрдөг, ухаан санаанд л ордог бодол хүсэл, эрцэл эрмэлзэл бүхнийг баясах юманд магнай тэнийм хорсох юманд гол харламаар илэрхийлж чадах хэл шүү. Манай ардын сайхан хэл манай баялаг сайхан бичгийн хэл! Орчуулах эрдэм төгөлдөр орчуулагчийн авьяас дээр чадал мэдлэг, боловсрол л хэрэгтэй ажаам.

Үеийн тоо хэмжээний нь андахгүй буулгахад бас, уг эх зохиолд тэр тоо хэмжээ бүхий үеэр бүтсэн шад тутам өргөлттэй өргөлтгүй үеийн найруулга зохион байгуулалт ямар байна гэж судлан таньж шинжин олоод монгол хэлнээ түүний нь буулгах ёстой. Тэр үеийн зохион байгуулалт, өргөлт бүхүй үе, өргөлтгүй үеийн дэс дараа нь ямар байгааг танин мэдэхдээ, тус тус хэмжээ нь европ зүгийн шүлэгт эртний латин шүлгийн хэмжээ уламжлалаар нэртэй болсон нь Грек латин соёлын хүрээний бүх улс түмэнд нэгэн адил хэрэглэдэг, үүнээ монгол олондоо тэдгээрийн нэр байгуулалтын тухай би дараа бичсүгэй. Үүнд орчуулагч хүн, тэдгээр шүлгийн хэмжээ найруулгыг монгол хэлнээ буулгахдаа өргөлттэй өргөлтгүй байдал нь, шад дотроо цаад эх шүлгийн яг дэсээр болгоход, монгол хэлний өргөлтийн байдал тохирч өгөхгүй нэг зүйлийн бэрхдэл тохиож болох газар байж болно. Чингэхэд орчуулагч хүн даруй грек латин соёлын хүрээний улсын шүлгийн тэр хэмжлийг латин хэлний шүлэгт журам болсон аргыг хэрэглэн өргөлтийн оронд урт эгшиг, өргөлтгүй үед ерийн эгшигт үе хэрэглэвэл цаад эх зохиолын шүлэг болгон хэрэглэсэн хэмжээний зарчим журмыг ширхгийн зөрөөгүйгээр монгол хэлнээ буулган найруулж болох байна. Үүнд өргөлттэй үе буюу түүнтэй чанар нэг гэж үздэг урт эгшигт үеийг энд хэвлэлийн дөхмийг бодож (-) ийм тэмдгээр тэмдэглээд өргөлтгүй үе буюу түүнтэй чанар нэг гэж шүлэг зүйд үздэг ерийн эгшигт үеийг х гэж тэмдэглэн нэгэн шүлгийг эх хэлэндээ ийм үеийн зохион байгуулалттай гэж үзвэл монгол болгож орчуулах хүн, түүний шад бадгийн зохион байгуулалтыг яг л тэр үеийн байдал зохиолтой адил болгон найруулж болох нь:

-X-X-X-

-X-X-X-

-X-X-X-

-X-X-X-

Европ зүгийн шүлэгт үгийн сүүлийг холбох үзэгдэл бий. Монгол шүлэгт толгой холбодог байна. Монгол орчуулганд европын сүүл холбосныг толгой холбож ч болно.

Тэгэхдээ эх шүлгийн сүүл холбосон журмы нь бас монгол уншигчдаа толилуулан уг яруу найрагчийн тэр холбох онцлогийг нь гээн хаялгүй, яруу найргийн бас нэг арга барил нь болох тул түүний нь үзүүлж, зохиолын онцлог сониныг нэвтрүүлэх хэрэгтэй. Жишээлбэл нэгдүгээр хоёрдугаар шад гуравдугаар дөрөвдүгээр шад холбоцтой бол, түүний нь бас эвдэн өөрчилж болохгүй. Салаавчилж нэгдүгээр, гуравдугаар, хоёрдугаар, дөрөвдүгээр шад холбоцтой бол түүнийг үзүүлэн холбох ёстой. Хэрэв нэгдүгээр дөрөвдүгээр шад хоёрдугаар гуравдугаар шад холбоцтой бол, орчуулгандаа мөн нэгдүгээр дөрөвдүгээр шадын толгой, хоёрдугаар гуравдугаар шадын толгой холбох зэргээр уг шүлгийн байдлыг үзүүлэх хэрэгтэй.

Шад дунд арван үеэр бүтсэн шад бол, дөрөвдүгээр шад, тавдугаар шадын хооронд цэглэж завсарлах цэглэл байдаг ёс бий. Тийм цэглэх цэглэлийг бас уудлан олж, монгол орчуулгандаа яг л тэр цэглэл байдаг газар нь цэглэх үүрэгтэй болно.

Шүлгийг орчуулсан орчуулганд энэ мэт байдлыг анхаарч эх зохиолын бүтэц байдлыг монгол орчуулганд тусган үзүүлэхийг оролдсон монгол орчуулга одоохон дээрээ өдрийн одноос цөөхөн байгаа нь яруу найргийн эдгээр онцлогийг цаад шүлэг зохиолд танихуйц сайнаар тухайн гадаад хэлийг эзэмшиж сурч чадаагүйн нэгэн зүйл, өөрийнхөө ард түмний сайхан хэлийг тийм хэмжээ зарчим хэрэглэх бүрэн бололцоотойг танихуйц сайн судлан эзэмшээгүй бас орчуулгахдаа аль л болох амар хялбархан биед зовлонгүйг гол болгож сурсны муу зуршил тэргүүтнээс болж ирсэн хэрэг. Одоо ардын соёл боловсрол нийгэм тэгш сайхан болж байхад үнэхээр учраа мэдсэн, одоо цагийн соёл боловсролын цээнд хүрсэн яруу найрагч орчуулагч хүн, урьдын боловсрол нимгэн орчуулагч нарын дадсан хэвшлийг соёл өрнөсөн цагт үргэлжлүүлж болохгүй болсныг мэдэж шадын шагналд дуртай орчуулагчинцарын дур зоригоор болгож болохгүйг хэвлэлд нь «редактор» гэж харь үгээр хачирхан сүр бадруулах дуртангууд эрхлэн гаргахдаа эрхэлсэн хүний хариуцлага уншигч олны өмнө бий гэж шүлгийн орчуулганд орчин үеийн цаг эринд зохиолдсон бөгөөд одоо цагийн олон улс нийтийн журамлан хэрэглэдэг боловсон орчуулгын шаардлага тавьж сайн шүлгийг саар шүлэгцэр болгож орчуулдаг замд хориглох тэмдэг босгож, ёстой яруу найргийн авьяаст өндөр боловсролт орчуулагчдыг эрэн хайж чадлы нь улам нэмэгдүүлэхийг ч бодох цаг болж, эрдэм их чадалтай яруу найргийн авьяаст орчуулагч ч захаас аван замаас үргэлж байдаггүй тул, хайн олж, хайрлан хүмүүжүүлж, улсын наадамд, аймаг сумын ардууд дөрвөн хөлтэй болгоноо сойдоггүй, сонгон олж барин шилж, эрийн гурван наадамд оруулдаг айргийн тавын тоонд хүргэх гэж мэрийдэгтэй адил, шүлгийн орчуулганд сэтгүүл хэвлэлийнхэн бас анхаарал тавьж сайн зохиол гутаан орчуулахгүйг хичээгүүштэй боловсролын хэмжээнд бид хэдийн хүрлээв шүү! Иймд уншигч олонд европ зүгийн шүлгийг монголоор орчуулахад, ямар ямар зохион байгуулалт хэмжээ журам байдгаас гол тоймтой хэдэн зүйлийг таниулах нь шүлгийн орчуулга үзээд, ямар шаардлага орчуулагчид тавих ёстой вэ? гэдгээ мэдэхэд нь хэрэгтэй бас муу орчуулгыг хаахын нэг зүйл болж нөгөө талаар монголоороо шүлэг бичих дуртай бөгөөд шүлэг яруу найргийг сонирхох хүнд хэрэг больюу.

ОРЧУУЛГА

Хуучин хүү

Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн байдал ороо бусгаа. Элстэй шанд, буттай цайдмыг дагаж, хааяа нэг хар гэрээс утаа суунаглана. Дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай, цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна. Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодогнон давхина. Хөлд орохоос аваад, үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ.

Гавж Жамбал хоймор сууж, бурхан ном хэмээн буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж, хууль ёс хэмээн худал үнэн ярихыг сонссоор, өдөр сарыг улируулна. Тэртээ уулыг өнгөрвөл айлгүй хэмээн бодож, тэнгэрийн хаяанаас цааш газаргүй хэмээн сэтгэсээр, түмэн хэргээс хоцорч, дэлхийн боловсролоос гээгдэнэ. Өглөө бурханд залбирч, үдэш тэнгэрт мөргөсөөр нэг нас харанхуй мананы дотор барна.

Хуучин хүү хул морин дээрээ хөндлөн сууж, хатируулсаар хүрч ирэв. Цагаан даавуу алчуураар толгойгоо ороожээ. Ширэлдсэн хар гэзгийн сэрвийсэн хэдэн үс шанаа уруу нь унжина. Урагдаж навтарсан хар ханцуйг сугалдаргалж, хиртэж сайртсан бор тохой гаргажээ. Тавхийтэл мориноосоо буун, тасхийтэл жолоогоо сойгоод, тоосонд дарагдсан урд хормойгоороо наранд шарагдсан нүүрийнхээ хөлсийг арчиж, нусаа хүрхийтэл нийгээд, гэрт оров. “Балдангийнх эсгийгээ хийж байна. Цэндийнх хонио хужирлаж байна. Дамба морь эрэхээр явсан. Гомбо хангай ороод ирсэн.” гэх зэрэг хэв ерийн хэдэн үгийг ах зах хүмүүстээ сонин болгон ярьж, гавж гуай хэмээн доогуур харан, зайсан гуай хэмээн дорой дуугарсаар, зуухны хажууд сууна. Авгай хүүхдээс аяга тараг, хэсэг хусам олж идээд, тэндээс гарч, баян Балжирынд унага татаж өгч, айраг олж уун, нэг үдийг өнгөрүүлнэ. Дэндэв тайжийнд хонь гаргаж өгч, гэдэс олж идэн, нэг үдшийг дуусгана. Хэдийгээр ухаан сэргэлэн боловч, зүүн хошууны захад хүрсэнгүй, баруун мөрний тэртээ гарсангүй, зөвхөн гурав, дөрвөн өртөө эргэн тойрон газрын дотор оршин суусан тул, юуг үзэж мэдэж, юуг сонсох ажээ.

Нас хэдийгээр залуу боловч, үгээгүй ядуу, өнчин балчир тул, нутаг сумын хэдэн айлд ээлжлэн зарагдсаар, олигтой аж амьдралын замыг нэгэнт алджээ. Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлэн, зуны халууныг хонь хариулж гэтэлгэх бөгөөд намар ичиж, хавар гарагч тарваганаас зовлонтойгоор он жилийг нөхцүүлнэ. Өтгөс, хуучид энэ хоёрын үгнээс бус үнэн юмгүй, өвөлжөө, зуслан, хаваржаа, намаржаа энэ дөрвөөс өөр явах газаргүй хэмээн санаж, хөмөрсөн тогооны доторхтой адил хөдөөгийн бүдүүлэг байдалд хүмүүжнэ. Юутай гомдолтой зэрлэг амьдрал, юутай хайрлалтай залуу нас, юунд шинэ ертөнцийг үзэхийг үл хүснэ? Хүмүүжил нь энэ гунихралтай байдлыг хуучин хүү өөрөө бас яахин мэднэ. Хуучны

феодал ба лам нарын гайг мөн хэрхэн танина. Дэмий л байдалд автагдаж, зовлон нь жаргал, зэрлэг нь цэнгэл болоод, нэг аймаг улс цөм хуучин хүүгийн адил нүдээ аньж, чихээ бөглөн, ертөнц гэгч чухам юу болохыг үзэлгүй, мэдэлгүй хөндий талд хоосоор хоцроход тулжээ.

Хайран хайран, хөөрхий хөөрхий.

Гэтэл хуучин хүүгийн нэг нөхөр нь хувьсгалын бууг тавьсан өдрөөс эхлэн, хөмөрсөн тогооны дотор гэрэл тусч, нэгэн аймаг улс сэрэв. Тэнгэрийн хаяанаас цааш газар байдгийг мэдэж, таван далай таван тивийг танин, шинэ ертөнц дээр хамт явах замыг нээв.

Хөх монгол улаан монгол болов.

Хуучин хүү шинэ хүү болов.

Юутай завшаан, юутай баяр.

1930 он

古き青年

П.Наранбаяр⁹⁹ орчуулав

田舎の様子は何かの変哲もないが、時勢は混乱の中。砂地における泉や灌木のある谷あいによって時折古びたゲルから煙が立つ。四方八方は荒涼として白い霞が漂う。真夏の灼熱がフェルトのゲルを容赦なく照らし、牧民の苛立ちを誘う。ゲルの近辺には牛の糞。子牛の群れがあたりを走りまわる。人々は物心がつく頃から白髪になるまで一本の川沿いを上流から下流へ、下流から上流へ移動し、一つの井戸の周りを転々と遊牧しながらこの世を去る。

ジャンバル僧が上座に座り、経典について無駄口をたたき、ナムジル官吏が他所から来て、法規の嘘交じりの話をするのを聞くうちに月日が経つ。遠方の山を越えれば人家無し、地平線の外に大地無し、と考えるうちに万機を逃がし、世界文明から振るい落とされる。朝は仏を、夕方は天を拝みながらその一生は黒霧の中で終焉する。

古き青年は赤毛の馬に乗って小走りで駆けてきた。白い布を頭に巻いている。絡み合ったぼさぼさした黒い弁髪は幾本かの髪が頬に垂れている。汚れて真っ黒になったぼろぼろのデールの袖をわきの下に挟み、ひびのある黒ずんだ肘を露出させている。びしっと馬を下り、手際よく馬をつなぎ、土まみれになった前すそで日焼けした顔汗を拭いて、無造作に鼻をかんでからゲルに入った。

「バルダン家はフェルトを作っている。ツェンド家は羊を塩沢地に放牧させている。ダンバは馬探しに出た。ゴンボはハンガイへ行って帰ってきた。」などのたわいもない話で目上の人に油を売り、僧侶から目をそらし、官吏の前で小声で喋りながらストーブの近くに座り込む。奥さん方にヨーグルト一杯とミルクのおこげをいただいてそこを出た。それから、金持ちのバルジル家の馬乳搾りを手伝って、馬乳酒にありついて昼を過ごす。その後は、デンデブ貴人のところで羊を屠って内臓の煮込みを食べて一晩を過ごす。

古き青年は賢い者だが、東旗の境に行ったこともなければ、西の川の向こうに渡ったこともない。半径三つ四つ駅に相当するところのみにいて生活してきたせいでそれ以上見聞を広めることもできなかった。

歳は若い、無一文の孤児で、村の各家に雇われ、人間らしき暮らしの道を早くに見失っている。厳冬の寒さを馬の番をして過ごし、真夏の暑さを羊の番をして乗り越えるが、秋に冬眠し、春に巣穴から出るプレリードッグより苦難な時を生きる。祖

99 “Шинэ Монгол” бүрэн дунд сургуулийн гүйцэтгэх захирал

先や年寄りの言葉以外に真実はないとし、春夏秋冬を営む場所以外に行くところもないと考え、まるで逆さまにした鍋の中の如き未開な田舎暮らしにつつまれて育つ。

何と可哀想で野蛮な人生、何と惜しい青春期、何ゆえ新しい世界を求めないのか。憂うべきこの状況が古き青年にわかるはずもない。封建領主、ラマたちの悪事を認識できようもない。成り行きに流されるがままに苦しみは幸福となり、野蛮は娯楽となった。皆一地方一国をあげて古き青年如き目をつぶり、耳を塞ぎ、世の中を見知ろうともせず、無知のまま草原に取り残された。

何と惜しいこと、何と可哀想なこと。

ところが、古き青年のある友人が革命の火蓋を切った日から逆さまの鍋の中に光が差し、一国は目を覚ました。天の遥かかなたに大地があることがわかり、五大陸や五つの大海の存在を知り、新世界と歩みを共にしはじめた。

青きモンゴルは赤きモンゴルに変わった。

古き青年は新しき青年に変わった。

何と幸運なこと、何と嬉しいこと。

Evvelki oğlan

Э.Энхтуяа¹⁰⁰ орчуулав

Köy halkı cahilmiş ve o çağda hayat çok zormuş. Kumlu ve çalılı yerlerin ardında kalan siyah bir evden sık sık buram buram duman tütüyormuş. Her taraf bomboş olduğu için çok sıkıcıymış. Yazın çok sıcak olduğu için “ger”¹⁰¹-de kalan çoban çok bunalıyormuş. “Ger”-in dışarısında da inek tezekleri çokmuş. Orada danalar da koşup oynuyormuş. Bebeğin yürümeye başladığı andan yaşlanıp saçlarına aklar düşene kadar geçen zamanda bir gölü dolaşarak yaşarmış ve boydan boya kadar göçermiş. Bu şekilde yaşayıp bu dünyadan ayrılmış...

Gavj¹⁰² Jambal “ger”-in baş köşesinde oturup “Burhan”¹⁰³ ve “sudur”¹⁰⁴-un hakkında boş boş konuşmuş ve bununla birlikte “Zaisan”¹⁰⁵ Namjil dışarıdan gelip halkın hakkında doğru veyanlı olan bütün şeyleri anlatacağını söyleyerek günlerini geçirirmiş. Uzaktaki dağın ötesinde insanlar, ailelerin olmadığını düşünmekle birlikte ufuktan ileride toprağın, yaşam alanının olmadığını da düşünüp cehalet içerisinde bir durumda gerçek dünyanın bilgisinden uzaklaşmış. Sabahları burhana dua ederek akşamları da göğşe dua ederek karanlık bir ortamda yaşıyorlarmış.

Evvelki oğlan “kula”¹⁰⁶ atının üzerinde yan tarafına doğru eğilip oturmuş vaziyette uzaktan geliyordu. Beyaz bir bez örtüyle başını sarmıştı. Birbirine girmiş olan saçlarının bir kısmını çenesine bırakmıştı. Yırtılmış ve buruşuk olan siyah elbisesinin kolundan elini çıkarıp kirlidirseğini gözünün önüne koymuştu. Küt dedi, attan indi ve atının “joloo”¹⁰⁷-sunu arka tarafına iyice bağlayıp tozlanmış olan elbisesinin ön kıvrımıyla güneşten kızarmış yüzünün terlerini siliyordu. Sümkürdükten sonra eve girdi. “Baldan’ın ailesi keçe yapıyordu. Tsend’in ailesi koyunlarını tuzluyordu. Damba atlarını aramak için gitti. Gombo Hangai’ya gidip geldi” diye her zamanki sıradan sözleri içeridekilere söyledi. Böylece Sayın Gavj?...diye başını eğerek... korkarcasına bir ses tonu ile Sayın Zaisan?...diyerek ateşin yanına oturdu.

Ailelerin hanımları ve çocuklarının verdiği bir kap yağurdu ve bir parça tortu yuyuyerek bir öğünü geçirdi. Dendev Taij¹⁰⁸-in koyununu kesiverip bir parça işkembe çıkarıp yedi. Böylece günleri geçirdi. Aslında o çok zekiymi ama o güne kadar doğu tarafta bulunan Hoşuu¹⁰⁹-nun kenarına hiç varamamıştı. Batı tarafındaki nehrin de yanında hiç gidememişti. Sadece kendisinin bildiği üç, dört yerlin yanında dolaşıp yaşadığı için hiçbir şey görmemiş ve duymamıştı...

¹⁰⁰ Ховд их сүргүүл, Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн

¹⁰¹ Ger: yurt, çadır, keçe çadır

¹⁰² Gavj: [Tibetçe dkah bcu; Sanskritçe krcchra, daça] On zor nesne (üzerine uzmanlaşmış kimse), yani bir terimi on farklı yolla yorumlayabilen kimse, çanid sınavlarının hepsini geçen lama’nın unvanı

¹⁰³ Burhan: Buda, Tanrı, ilah

¹⁰⁴ Sudur: Sutra, Öğüt (belli başlı Budist metinleri antolojisi)

¹⁰⁵ Zaisan: [Çince tsai- hsiang] boyun başkanına verilen ünvan, yönetimindeki bazı gruplar veya boy başları için bu söz kullanılır

¹⁰⁶ Kula, omurga boyunca kara çizgileri olan, kuyruk ve yelesi kara at

¹⁰⁷ Joloo: çılbur, ata yön vermek için tutulan deriden yapılan ip

¹⁰⁸ Taij: [Çince t’ai- tzu] hanedanın atası veya kurucusu, Moğolların soylu boyu

¹⁰⁹ Hoşuu: Mancu hanedanı zamanında Moğol boylarının teşkilatlandığı ‘sancak’ adı verilen askeri birimlerden biri, bugün İç Moğolistan’da kosun, bir oymağın bölümüdür.

O bir delikanlıydı ama aynı zamanda çok fakir ve yetim biriydi. Bu yüzden yaşadığı köydeki bazı ailelerin ev işlerini yaparak yaşamını sürdürmüştü ve bu sebeple güzel bir hayattan uzak kalarak büyümüştü. Kış mevsiminin soğuk günlerini atlara bakarak, yaz mevsiminin sıcak günlerini ise çoban olarak geçirirdi. Onun bu durumu sonbahar mevsiminde uyumaya başlayıp ilkbahar mevsiminde kalkan bir mamuttan daha zordu. Yaşlı adamların sözlerinden başka doğru söz yok diye düşünür, yine yaz, kış, ilkbahar ve sonbaharda yaşadığı yerden başka gidecek yer olmadığına inanırdı. Bu şekildetersine çevrilmiş bir tencerenin içindeymişçesine karanlık bir durumda kabaca, medeniyetten uzak büyümüştü. Ne kadar zavallı ve vahşibir hayat! Ne kadar zavallı bir genç! O adam neden dünyanın farklı yeni yerlerini görmek istemiyor? Kendinin böylesine üzücü bir durumunda olduğunun diğer evvelki oğlанда farkında değilmiş. Eski zamanların feodal yaşamı ve Lama¹¹⁰ların içerisinde bulunduğu zararları o nereden bilsin! Sakin bir durumda bu hayatı kabul ediyordu. Hareketli bir hayatise onun için mutluluk verici olup vahşi yaşamın tehlikeli durumları eğlenceli geliyordu. Böylece ulusun tüm insanları öteki evvelki oğlan gibi gözleri ve kulakları tüm dünyaya kapalı durumda, dünya ne anlama geldiğini, tam olarak ne olduğunu bilmeden yaşıyorlardı.

Canan, canan

Zavallı, zavallı

Ama öteki evvelki oğlanın bir dostu ihtilali başlattığı günden başlayarak tersine çevrilmiş tencerenin içinden dışarıdaki ışığın parladığını fark etti ve tüm ulus derin uykusundan uyandı. Ufkun ilerisinde de başka yerler olduğunu öğrenip beş okyanusun ve beş kıtanın hakkında yeni şeyler öğrenmişti. Böylece yeni bir dünyaya birlikte yol alınacak yol açılmıştı.

Kök Moğolistan o zamanlarda

Kızıl Moğolistan oldu...

Evvelki oğlan o zamandan sonra

Yeni ve bugünkü oğlan oldu...

Ne kadar güzel, ne kadar güzel bir bayram!

¹¹⁰ Lama: Budizmin öğreticisi

